

ОЛОН САНААТ

ЕРТӨНЦӨД

ҮНЭНИЙГ

ОЛОХ

An abstract background featuring a large, textured shape composed of overlapping brushstrokes in various shades of green and blue, set against a white background. The strokes are thick and expressive, creating a sense of movement and depth.

АДАМАНТ

ЛИЗА БИВЭР

НЬЮ-ЙОРК ТАЙМСЫН ШИЛДЭГ ЗОХИОЛЧ

Хонгор найз минь,

Би чамайг Бурханы уул руу дагуулж гармаар байна. Тэр газар чи үгээр илэрхийлэшгүй Бурханы үнэн, хайр дотор амьдраад зогсохгүй, Бурханы хөдлөшгүй, шийдэмгий, тууштай, адамант - бат бэх хүн болж хувирна.

Хайр, үнэн хоёроор бат бэх байх ёстой цаг гэж байдаг бол тэр нь өнөөдөр ажээ. Бурхан бол Хайр. Бурхан бол Үнэн. Хайр, үнэн хоёр нь хоёулаа үе үеийн чиг хандлага, үзэл санаанаас давсан, цаг хугацаанд баригдашгүй зүйлс юм.

Бид Бурханы дотор оршиход, бидэнд хандсан Бурханы төлөвлөгөө ил болж, тэнд л бид хэлбэршиж, бэхэждэг. Хонгор найз минь, би чамайг өөрийнхөө Булангийн чулуу болсон Христийн дотор амьдрахдаа, адамант - бат бэх дүр төрхтэй нэгэн болохын төлөө залбирч байна.

Итгэмжтэй бай, үнэн бай, хүчтэй бай.

Лиза
LisaBevere@ymail.com



MESSENGER
INTERNATIONAL
MessengerInternational.org

Бүсгүй минь,

Чи үнэнийг хайхдаа, хайрыг олж мэдэхийн төлөө би залбирна. Энэ энэрэлгүй дэлхий дээр чи цэцэглэн шиг зөөлөн, алмаз шиг хатуу байх зүрх зоригтой байх ёстой.

Итгэмжтэй л байдаг юм шүү. Үнэнээр л явдаг юм шүү. Хаттай л амьдардаг юм шүү. Өөртөө итгэлтэй л алхдаг юм шүү. Гэхдээ чи ялагдашгүй чулуунаас сийлэгдсэн учраас, бүтэлгүйтэх учиргүй.

“Бидний Хаднаас өөр амьдрал, гэрлэлт, хүсэл мөрөөдлөө барьж байгуулах найдвартай суурь үгүй. Лизагийн “Адамант” гэдэг шинэ ном нь танд Бурханыг таниулахын сацуу нөгөө талаас таныг ч өөрт чинь таниулна.”

Стивен Фуртик, Элэвэйшн чуулганы пастор,
Нью-Йорк Таймсын шилдэг зохиолч

“Манай дэлхий үнэхээр манантжээ. Хэнд, юунд итгэхээ ч мэдэх юм алга. Тиймээс л Лиза Бивэрийн “Адамант” гэдэг ном бидэнд ус агаар шиг хэрэгтэй. Лиза таныг хөдлөшгүй үнэн дээр аваачих сүнслэг аянаар дагуулах энэ номоо итгэл, тэнцвэр, нигүүлслээр амилуулжээ. Энэ бол биднийг Христ дээр суурилсан ариусал, тогтвортой байдал, үнэн рүү эргүүлсэн бас цагаа олсон төдийгүй, үеийн үед орших үнэний үг ажээ.”

Грэйг, Эми Грошел, Лайф Чуулганы пастор,
From This Day Forward номын зохиолч

“Юутай чухал, жинтэй үг вэ! Лиза Бивэр хэзээд үнэний төлөө мятрашгүй зогсдог. Тэрбээр үнэний бүрээг татахдаа, тэр Үнэн Нэргэй бөгөөд бид тэр Үнэний Нэрийг мэдэж чадахыг тунхаглажээ. Хэрэв та амьдралаа суурьлуулах бат газрыг хайж байгаа бол (бид бүгдээрээ л хайж байна), биднийг хэзээ ч хувирахгүй цорын ганц Хад - Есүс дээр аваачих “Адамант” номыг дагаад яв. Энэ номыг гар дороо байлгаж, итгэлээр цалгисан хуудсыг нь алган дээрээ дэлгээтэй байлга.”

Луи, Шелли Гиглио, Пэйшн Конференцийн үндэслэн байгуулагч

“Янзтай! Миний найз санаандаа хүрчээ: “Үнэн шингэрэх үед бид өөрөөсөө том хариулттай холбоо тасардаг. Харин тэр жинхэнэ үнэн нь бидний Хад юм. Бат бэх, цуурашгүй, хөдлөшгүй, ялагдашгүй.” Үнэн гээч нь чиг хандлагаа дагаад намирдаг болсон энэ эрин үе, соёлд Лиза ёстой л орой руу ормоор үнэнийг хэлжээ.”

Кристин Кэйн, А21 болон Пропел Вумэн хөдөлгөөний
үндэслэн байгуулагч, шилдэг зохиолч

“Манай Лиза “Адамантаа” яг л алтан утаст магнаг торго адил үнэхээрийн хамаг л зүрх сэтгэл, уян мэдрэмж, тэнгэрлэг бэлэгээ гарган байж, уран нарийн урлаад, уншигч бүрийг чөлөөлөх мэт дэлгэн намируулжээ. Энэ ном хайр, ойлголцлоор оюун санааг маань өөрчилж, сэтгэл зүрхийг маань илбэн эдгээж, сүнсийг маань Бурханы бидэнд л гэж авдартаа хадгалсан төгс төлөвлөгөөгөөр сүлнэ.”

Сара Жэйкс Робертс, *Don't Settle for Safe* номын зохиолч

“Хурц, цэцэрхэг, сэтгэлийн гүнийг онилсон ном байна. Лиза бол бэлэгтэй зохиолч, итгэмжтэй найз. Тэрбээр номоороо биднийг жинхэнэ өөрийгөө олж авах Хадан суурь - Христ рүү маань хөтлөнө.”

Шэйла Уолш, *In the Middle of the Mess* номын зохиолч

“Энэ мундаг шинэ бүтээлийн эхний хэдэн хуудсыг уншихдаа би Лизагийн хэлсэн хоёр үгийг хараад, өөрийн эрхгүй толгой дохин хүлээн зөвшөөрлөө: “Гэхдээ энэ бүх гайхамшгаа тайлах юм бол, бид эргэлзээ, харьцуулалтаа нөмөрсөөр л үлддэг.” Мөн “Үнэн шингэрэх үед бид өөрөөсөө том хариулттай холбоо тасардаг.” Энэ хоёр үг нь хүний нөхцлийг яг л онож хэлжээ. Энэ ном хүмүүсийг яаж сэгсэрч, баталгаажуулж, бадраах бол гэхээс зүрх минь догдлоно. Жинхэнэ бодит үнэнийг сарвалзсаар эрэн хайж буй энэ дэлхий дээрх эрлийн ажилд тань энэ ном цэц ухаан, ганхашгүй итгэл үнэмшил, Бурханы жинхэнэ хүүхэд байх нигүүлсэл, бусдын төлөө харанхуйг гийгүүлэх гэрэл байх зориг зүрх авчрах болтугай.”

Бобби Хьюстон, Хиллсон чуулганы пастор

“Олон номлогч, зохиолч Есүсийн төлөө жинхэнэ “*Адамант*” байх талаар ярьдаг ч, энэ нь яг юу гэсэн үг болохыг Лиза л хэлж өгчээ. Энэ ном нь Ариун Сүнсээр амьсгалагдсан бөгөөд Түүний тосолгоо ч асгарч байна.”

Хитэр Линдсэй, зохиолч, номлогч

“Лиза анх надтай “*Адамантаа*” бичих талаараа ярьж байсныг би хэзээ ч мартаггүй. Машиндаа суугаад л, нулимс бөмбөрүүлээд л, ямар чухал сэдэв болохыг нь догдлон сонсож суусан сан. Харьцангуй үнэнээр л амьсгалдаг болсон энэ дэлхийд Лиза маань дахиад л маш хүнд сэдэвтэй тун чадамгай барилдаж, тэнгэрийн асуултуудад сурамгай хариулж, насан турш түшээд ч алдахгүй Библийн бат бөх суурийг тавьж өгчээ. Тэрбээр бидний хайртай номуудыг бичиж өгөхөөс гадна, энэ бүхэн нь бидэнд хичнээн хэрэгтэй болохыг бас ойлгуулж өгдөг.”

Хавила Каннинтон, *Truth to Table* -ын үндэслэн байгуулагч

“Лизагийн шинэ ном намайг бүр догдлуулчихлаа! Тэр бидний хайртай найзаас гадна яг л цагаа олсон үгийг хэлдэг хүн дээ. Жон, Лиза хоёр бидний чин хайртай найз нөхөд. Мундаг удирдагч нар. Бурхан энэ хоёроор маань дамжуулж үнэхээр аугаа үйлсийг бүтээж байна!”

Брайн, Женн Жонсон, Бетел Мьюзикийн үндэслэн байгуулагч

А Д А М А Н Т

Лизагийн бичсэн бусад ном

Өрсөлдөгчгүй

Сэлэмтэй охид

Lioness Arising

Fight Like a Girl

Kissed the Girls and Made Them Cry

АДАМАНТ

ОЛОН САНААТ

ЕРТӨНЦӨД

ҮНЭНИЙГ

ОЛОХ

ЛИЗА БИВЭР

Adamant Mongolian by Lisa Bevere
© 2019 Messenger International
MessengerInternational.org

Originally published in English as
Adamant: Finding truth in a universe of opinions ISBN 978-0-800727-25-3

Additional resources in Mongolian by John and Lisa Bevere are available for free
download at: CloudLibrary.org

To contact the author: LisaBevere@ymail.com
This book is a gift from Messenger International and is NOT FOR SALE

“Адамант: Олон санаат ертөнцөд үнэнийг олох” зохиолч Лиза Бивэр
© 2019 Мессенжер Интернэйшнэл
MessengerInternational.org

Англиар: Adamant: Finding truth in a universe of opinions.
ISBN 978-0-800727-25-3

Жон, Лиза Бивэрийн Монгол болоод олон улсын хэл дээрх материалыг дараах
цахим хуудаснаас татаж авна уу: CloudLibrary.org

Зохиогчтой холбогдох хаяг: LisaBevere@ymail.com
Монгол хэл дээрх энэхүү номыг Мессенжер Интернэйшнэл байгууллагаас
бэлгэлж байгаа бөгөөд ХУДАЛДАХЫГ ХАТУУ ХОРИГЛОНО.

АГУУЛГА

Талархлын үгс 13

1. Адамант (Бат бэх) 15

2. Дотно Адамант (Дотно чанараар бат бэх) 31

3. Тогтвортой Адамант
(Тогтвортой чанараар бат бэх) 47

4. Хайрын Адамант (Хайраар бат бэх) 57

5. Бие биеэ хайрлахдаа адамант
(Бие биеэ хайрласан шиг хайрлах) 73

6. Үзэн ядалтад адамант
(Үзэн ядсан шиг үзэн ядах) 99

7. Үнэний төлөө адамант байх
(Үнэний төлөө бат бэх байх) 125

8. Үгээр адамант байх (Үгээр бат бэх байх) 137

9. Адамант өөрчлөлт (Бат бэх өөрчлөлт) 159

10. Ариун байдлаар адамант байх
(Ариун байдлаар бат бэх байх) 181

11. Би бол Адамант (Би бол Бат бэх) 197

Хавсралт 1: Зургадугаар бүлэгт зориулсан
нэмэлт Бичээс 209

Хавсралт 2: Сургаалт үгс, Номлогчийн үгс
номын сургамж 213

Номын зүүлт 221

ТАЛАРХЛЫН ҮГС

Б агшийн ухаан, эш үзүүлийн гэгээрлээ хайрладаг Рабби
Бриан Билечидээ,
Ухаантай байхад минь тусладаг Итгэлийн амьдралын Скот,
Линдсей хоёртоо,
Хамтын хөдөлмөрөөрөө мөрөөдлийг маань биелүүлдэг
Андреа Дориндаа,
Энэ бүхнийг биелэл болгосон Мессенжер Интернэйшнэл
багийнхандаа БАЯРЛАЛАА!



1

АДАМАНТ (БАТ БЭХ)

Та нарыг цавчиж авсан хад уруу, Та нарыг малтаж гаргасан нүхийг харагтун.

Исаиа 51:1

Би энэ ишлэлийг жил илүү эргэцүүлэн бодсон бөгөөд энэ хад, энэ чулуу... энэ *адаманы* талаарх ойлголт намайг олзлов.

Энэ нь аливаа санал, байр сууриасаа хөдлөшгүй, нэвтрэшгүй, бууж өгөшгүй гэсэн утгатай үг болохыг бид мэднэ. Шударгаар хэлэхэд, *адамант* гэдэг үг нь зөрүүд, гөжүүд гэдэг утгаараа илүү алдартай. Гэхдээ *адамант* гэдэг үгтэй холбож ойлгодог тэмдэг нэр, дайвар үгс нь тус үгийн язгуур утга биш юм. Адамант нь анх нэр үг байжээ.

Адамант гэдэг нь их эртний, түүхэн домогт ойлголт юм. Бүр анх адамант гэдэг чулуу байжээ. Яг үнэндээ бол - нэргүй чулуу байв. Энэ нь эртний Грекээс эхтэй гэж үздэг, олдошгүй эрдсийг төлөөлдөг байв. Тэр үед тооны эрдэмтэд, гүн ухаантнууд юутай ч эгнэшгүй хад, юугаар ч цуулашгүй, хагалашгүй тийм бат нягт

чулууг анх сэджээ. Ямар ч ан цав, сэтэрхийгүй энэ цул чулуу нь юутай ч зүйрлэшгүй хагуу атлаа тун үзэсгэлэнтэй юмсанж.

Энэ чулуу нь нэгэн зэрэг татаж, түлхэх увидастай ажээ. Бусдыг татах атлаа өөрөө юунд ч эс татагдана. Бусдыг соронздох атлаа өөрөө хөдлөшгүй. Бас гэрэлтэй ер бусын харилцаатай байв. Нарны туяаг өөртөө төвлөрүүлэн хураагаад, эргээд тал бүр тийш цацраана. Үүнийг гал дийлэхгүй - галаас гаргах үед хүрэхийн аргагүй хүйтэн болдог ажээ.

Тэр адамантын талаар олон янзын яриа домог явдаг ч, хамгийн гол асуудал нь үүнийг хэн ч олж илрүүлээгүй байв. Адамант газрын гавд байдаг уу? Эсвэл галаас төрж, галт уулын хэвлээс буй болсон уу? Эсвэл далайн гүнд нуугдаж байв уу? Үгүй бол, хүний алдар гавьяаг шагнасан бурхдын шагнал байв уу?

Грекээр энэ чулууг *адамас* гэх агаад энэ нь “ялагдашгүй” гэсэн үг болно. Хэдийгээр адамас жинхэнээсээ байсан үгийг хэн ч мэдэхгүй ч, хүмүүсийн хүсэл мөрөөдөл үүнийг амьдруулжээ.

Энэ эрдсээр зэвсэг хийнэ. Адамасаас тулаанд хугарашгүй илд, сүх, хутга, цавчилтад халцрахгүй бамбай хийнэ. Адамасаар урласан уян сум нь онилсон байгаа цоо хатгана. Бас хуяг дуулга хийнэ. Адамасаар хийсэн хуяг дуулгатай баатрууд дийлдэшгүй байна. Адамасын хураадаг туяа нь дайсны нүдийг сохлож, ялалтыг гэрэлтүүлэх учраас, харын хүч тэднийг зогсоохгүй.

Энэ хаданд итгэх итгэл нь хүмүүсийн сэтгэл зүрхийг байлдан дагуулж байснаараа үүний талаарх түүх домог нь Европоор дамжин Их Британид хүрчээ. Тэнд л адамас хэмээх Грек үг нь бидний мэдэх *адамант* болоод, тэндээсээ дэлхий даяар тархсан байна.

МЭӨ 400 онд хүмүүс Энэтхэгт алмазыг илрүүлэх үедээ өнө эртнээс эрэн хайсан адамантаа оллоо гэж боджээ. Алмаз ямар ч чулуутай зүйрлэшгүй хүчтэй байв. Зөөлөн галаас төрсөн ямар ч чулуу бат бэх алмазын хүч дор бут үсэрч байжээ. Энэ эрдэнэс нь бусад чулуудыг дор нь залгих, маш хүчтэй гал, даралт дор бий болж, алмазын талст хэлбэртэй нүүрстөрөгч гэсэн ганц л элемент үлджээ.

Ийнхүү хэдэн зууны турш *адамант*, *алмаз* гэдэг хоёр үгээр ялагдашгүй, хөдлөшгүй, усташгүй зүйлийг дүрслэдэг болов. Номлолын ханхүү - Чарльс Спержен, Пуританы домог - Жон

Буньяан нар Бурханы Үгд дөжир болсон, цахиур чулуунаас ч хатуу адамант зүрхний талаар уйлан гашуудсан Зехариагийн үгийг их ярьдаг байсан юм.

Тэд өөрсдийн зүрхийг цахиур мэт (*адамант*) болгосон учраас тэд, түг түмдийн ЭЗЭН Өөрийн Сүнсээр эртний эш үзүүлэгчдээр дамжуулан илгээсэн хууль болон үгсийг сонсож чадаагүй. Иймд түг түмдийн ЭЗЭНээс үлэмжийн их уур хилэн ирсэн. (Зехариа 7:12)

Энэ ишлэл дээрх *адамант* гэдэг үгийг шинэ цагийн орчуулгууд *алмаз* гэсэн байдаг:

Тэд өөрсдийн зүрхийг *алмаз* мэт болгосон учраас тэд, түг түмдийн ЭЗЭН Өөрийн Сүнсээр эртний эш үзүүлэгчдээр дамжуулан илгээсэн хууль болон үгсийг сонсож чадаагүй. Иймд түг түмдийн ЭЗЭНээс үлэмжийн их уур хилэн ирсэн.

Гэтэл 1700 онд Францын эрдэмтэн Антуан Лавуазье алмазыг гал, хүчилтөрөгч хоёроор шарахад, ууршиж алга болдгийг олж мэджээ. Үүнээс болж *адамант*, *алмаз* гэдэг хоёр үгийг салгасан бөгөөд тийнхүү мөнөөх усташгүй, хөдлөшгүй, ялагдашгүй адамантын эрэл мухарджээ. Тэгээд энэ үг нь хэзээ ч байгаагүй зүйлийн билэгдэл болон үлдэв. Гэхдээ мөрөөдөл үхэх биш. Жэй. Ар. Ар. Толкений номд гардаг ариун дагшин Аркенстон (чулуу) нь бас л мөнөөх адамантын домгийн үргэлжлэл байв. Хоёроос олон мянганы турш хүн адамантыг хайсаар л, бүтэлгүйтсээр л байжээ. Тэгээд би бодлоо...

Энэ эрэл юунаас эхлээ юм бол? Адамантын эрэл нь Бурханы суулгасан хүсэл тэмүүллийн үр байв уу? Хүн яагаад хараагүй зүйлээ эрэн хайж, мэдээгүй зүйлээ үгүйлнэ вэ? Эсвэл энэ адамант бидний дунд байсаар байгааг бид мэдээгүй юм болов уу? Адамант нь дайн, сүйрлийн биелэл байхаар бус,

◆

АДАМАНТ
НЬ БИДНИЙ
ДОТОР
НУУЦЛАГДСАН
ЗҮЙЛСИЙГ
ГАРГАЖ ИРЭХ
ЗОРИЛГОТой
БУС УУ?

харин хамгаалалт, хангамжийн биелэл байхаар оршдог мэт. Хүн төрөлхтөний хүсэл мөрөөдөл болсон тэр чулуу биднийг угтан авах учиртай бус уу?

Адамант нь бидний дотор нууцлагдсан зүйлсийг гаргаж ирэх зорилготой бус уу? Үнэн гээч нь алдартай чиг хандлага, сүүлийн үеийн соёлын довтолгоог дагаад гуйвж, гулжийдаг болсон энэ дэлхий дээр ямар нэгэн:

Бат бөх...

Барьцтай...

Хөдлөшгүй...

Ялагдашгүй...

Хувирашгүй зүйлтэй байна гэдэг сайхан бус уу?

Магадгүй энэ эргэцүүлэл нь бодит бус чулууны талаарх хөгийн бодол байж болох л доо. Эцсийн эцэст хүн төрөлхтөн чинь одоо “хөгжөөд”, эрх мэдлийн чулууг хайхаа больсон шүү дээ. Өнөөдөр бид одод бол зүгээр л нэг гэрэлтэгч хий гэдгийг мэддэг болсон. Бид хэдийнээ нүцгэн саран дээгүүр алхаж, далайн гүний харанхуй ангалыг судлаад үзчихсэн.

Гэхдээ энэ бүх гайхамшгаа тайлах юм бол, бид эргэлзээ, харьцуулалтаа нөмөрсөөр л үлддэг.

Өндөр боловсролтой хүмүүс голдуу зорилго, боломжоор хомс байдаг.

Бид хэрэглэгчээ өр зээлийн хоригдол болгохоор загварчлагдсан мөнгөний системд орооцолдсон.

Улс үндэстнүүдийг эвлүүлэн нийлүүлэх зорилгоор эцэг өвгөдийн маань бүтээсэн улс төрийн систем эдүгээ биднийг салган бутаргадаг болсон.

Бид харилцаа холбооны асар өргөн сүлжээтэй болсон ч, тэр нь жинхэнэ дотносолгүй, гүехэн харилцаа байдаг.

Бид сонгосон замаараа л замнаж яваа боловч, сэтгэл дундуур амьдардаг.

Бид технологиор дамжуулан хэзээ ч хараагүй хүмүүс рүүгээ чулуу шиддэг.

Үнэн шингэрэх үед бид өөрөөсөө том хариулттай холбоо тасардаг.

Жинхэнэ үнэн бол: Адамант. Цуурашгүй. Хөдлөшгүй. Ялагдашгүй Хад болой.

Есүс бол үнэн. Тийнхүү Есүс бол Адамант гэдгийг би хэлмээр байна.

Есүс бол Адамант

Дэлхийн ямар ч чулуу амьд Чулууны өмнө тэсэхгүй. Тэр бүх Грекүүд болон домог нь Христийн дотор л биелэлээ олдог. Тэр бидний Хад, Булангийн чулуу, хүсэн хүлээсэн Адамант маань. Христ л ганцаараа бүхнийг өөрчлөх чадалтай, өөрчлөгдөшгүй Чулуу. Эрин цагийг эзэгнэсэн тэр Хад маань бидний л дунд байжээ. Израилийн хүүхдүүд цөлөөр зорих газаргүй бэдрэх мэт тэнүүчлэх үед Мосе тэр л Хадны оршихуйг мэдэгдсэн байдаг:

Хад болсон Түүний үйлс нь төгс, зам нь үнэн. Үнэний Бурхан, хуудуу үгүй Тэрээр Зөвт бөгөөд шулуун шударга билээ. (Дэд хууль 32:4)

Цөлийн түүхэн үеийн дараа Давид чөлөөлөгдсөн өдрөө Бурхан руу:

Хүч минь болдог ЭЗЭН, Тандаа би хайртай. ЭЗЭН бол миний хад, Миний цайз, Миний аврагч, Миний Бурхан, Миний хоргодох хад, Миний бамбай, Миний авралын эвэр, Миний бэхлэлт юм (Дуулал 18:1-2) хэмээн хашхирсан билээ.

Хуучин гэрээний хад гэдэг Еврей үг нь “хүрэшгүй орогнол” гэсэн утга илэрхийлдэг. Хад нь бидний хүч бөгөөд хайргаар дүүрэн дэлхий дээрх бидний түшиг тулгуур юм. Дайсан биднийг боомилох үед Есүс л бидний бат цайз болдог. Хад маань бидний аврал, хамгаалалт, хуяг дуулга, өмгөөлөл болдог. Христ дайсны нүүрэн дээр биднийг Сүнснийхээ тосоор тослож, аварснаа зарладаг.

Бид олон талаараа энэ газар дээр өндөр, аюулгүй, ариун газрыг хайх дүүрвэгсэд шиг л явдаг. Бид замбараагаа алдсан завхралын захиргаа дороос аюулгүй байдлыг хайн сарвалздаг. Бид Египетийн мөлжигч нарын гараас мултарсан Израильчуудтай адил боловч, тархинд маань бичигдсэн тэр дарангуйллын харгис дуу хоолойг

хараахан барьж сураагүй л байна. Биднийг тэр бэлтгэл, зорилгын цөлөөр хэрэн тэнэж явахад, Хад маань бидэнтэй хамт байсан ч, бид юу ч мэдээгүй ажээ. Тиймээс энэ бол өөрийнхөө сул дорой байдлыг хүлээн зөвшөөрч, эдгэрэхийн тулд Хадан дээрээ унах (налах) ёстой цаг юм.

Хэн энэ чулуун дээр унана, тэр бутрах бөгөөд хэний дээр энэ чулуу унана, тэр нь няцарна гэж айлдав. (Матай 21:44)

Энэ ишлэл нь Чулуу ч болсон, Хүү ч болсон Есүсийн тухай үг болой. Чулуу ч, Хүү ч Бурханы тааллаар хүмүүст ад үзэгдсэн юм. Хүү нь хүний дарангуй хаанчлалыг нурааж, айсей Бурханы хаанчлалын Булангийн чулуу болохоор ирсэн Хад байв. Эн. Ти. Вraith энэ гүн гүнзгий уялдааг тодруулан хэлдэг:

Англи хэл дээр “Хүү” (Son) гэдэг үгийн бүх үсэг нь “Чулуу” (Stone) гэдэг үгд хоёр үсгийн нэмэгдэлтэй оршдог шиг, Еврей хэл дээр ч “Хүү” (ben) гэдэг үгийн бүх үсэг нь “Чулуу” (eben) гэдэг үгд нэг үсгийн нэмэгдэлтэй оршдог нь нэн сонирхолтой тохиолдол юм.¹

Гадуурхагдсан
хүмүүс
Христийн
дотор л
гэрээ олж,
бүгдээрээ
нэгдмэл нэг
болдог.

Христийн дотор бид Чулууных ч, Хүүгийнх ч болсонд би хязгааргүй баярладаг. Гадуурхагдсан хүмүүс Христийн дотор л гэрээ олж, бүгдээрээ нэгдмэл нэг болдог. Христ Бурханы уулан дээр урлагдсан боловч, хүний гар хүрээгүй Чулуу ажээ. Тэр бол газрын ямар ч хаанчлал сөрөн зогсож дийлэхгүй Хад болой. Даниел Небухаднеззар хааны нууц зүүдийг дүрслэн хэлээд, утгыг нь тайлахдаа, бидний Адаманти Христтэй тулах энэ явдлын талаар эш үзүүлсэн юм:

Аяа хаантан, үзэгтүн, асар том баримал танд үзэгджээ. Энэ дүрс агуу том, гялалзах нь ер бусын сүрлэг. Өмнө тань тэр сүндэрлэж байсан бөгөөд дүр нь хиртхийм байв. Энэхүү баримлын толгой нь шижир алтаар, цээж, хоёр гар нь

мөнгөөр, хэвлий, ташаа нь хүрлээр, хөл нь төмрөөр, тавхай нь хэсэг төмөр, хэсэг шавраар хийгдсэн бөлгөө. Таныг харсаар байхад гар хүрэлгүйгээр нэгэн чулуу цавчигдаж, тэр баримлын төмөр ба шавран тавхайг нь цохиж, хэсэг болгон буталжээ. Тэгээд төмөр, шавар, хүрэл, мөнгө, алт нь бүгд нэгэн зэрэг бутарч, зун тээрэмдсэн тарианы хальс мэт болжээ. Салхи түүнийг хийсгэж, ор мөргүй алга болгов. *Харин тэр баримлыг бут цохисон чулуу нь асар том уул болоод бүх дэлхийг дүүргэжээ.* (Даниел 2:31-35)

Христийн дотор үр нь чулуу болж, чулуу нь уул болон ургажээ. Газар дэлхийг дүүргэсэн тэр чулуу нь Сион бөгөөд тэр уулын үр болсон чулуу нь Христ болой. Хэрэв бид Чулууны хүчийг тэсч гарахгүй материал дээр мунхаглан амьдралаа босгобол, хамаг хүсэл тэмүүлэл маань цагийн салхинд үйрч, хэдэн хэсэг тараагдана. Есүс гагцхүү тогтож үлдэх үнэн зүйлийг л үлдээхийн тулд сэгсэрч болох бүхнийг сэгсэрнэ. Тиймээс чичиргээг тэсээрэй, анд минь. Тэр чамд дэндүү хайртай учраас, цаашид дутуу хагас үнэн, хаанчлалын алдаатай сууриар амьдрахыг зөвшөөрөхгүй тул зүрх чинь сэгсрэгдэх болтугай. Чи газрын төмөр, шороо байхаар бүтээгдээгүй, харин амьд чулуу байхаар бүтээгдсэн юм.

◆

Тэр чамд
ДЭНДҮҮ
хайртай
учраас,
цаашид дутуу
хагас үнэн,
хаанчлалын
алдаатай
сууриар
амьдрахыг
зөвшөөрөхгүй
тул зүрх чинь
сэгсрэгдэх
болтугай.

Амьд чулуу

Эзэнд ир. Тэр бол хүмүүст гологдсон боловч, харин Бурханы өмнө сонгогдсон, үнэт, амьд чулуу билээ. Иймд амьд чулуу мэт болсон та нар ч Есүс Христээр дамжуулан Бурханд тааламжит, сүнслэг тахилуудыг өргөх ариун тахилч болохын тулд сүнслэг байшин болон баригдагтун. (1Петр 2:4-5)

Дээрх хэсгийг Мессеж Библи дээр “Амьдралын эх ундарга болсон амьд Чулуунд морилно уу!” гэдэг. Христийн дотор бидний зүрх амьд болж, бид ч өөрсдөө зорилгоо биелүүлэхийн төлөө буй, бие доторх амьд чулуу болдог. Бид энд сүнслэг өргөө буюу ариун ордонг барьж байгуулах үйлчлэлд амь амьдралаа зориулахын төлөө байгаа юм. Бид барилгачин бус, харин Христ Өөрийнхөө чуулганыг барьж байгуулахдаа ашигладаг түүхий эд нь билээ.

Би *ариун ордон* гэдэг үгд хайртай. Энэ нь агуулах, орогнол - аюулгүй байдал, хамгаалалт, дархлагдсан хорогдох газар юм. Аюулгүй байдлын адамант болсон бидний амьдралын гайхамшигтай дүрслэл байна! Энэ бол үхмэл барилга бус. Энэ бол амь амьдрал цалгисан хорогдох газар бөгөөд энд бид яг л сүмийн тахилч нарын үйлддэг байсан шиг амьдралаа Аавдаа өргөдөг. Петр энэ дүрслэлийг цааш нь үргэлжлүүлжээ:

—◆—
Есүс
Өөрийнхөө өө
сэвтэй сүйт
бүсгүй болох
чуулганыг
гэрэлтсэн, төгс
нэгэн болтол
нь бүрэн
үнэнчээр
хайрладаг.

Энэ нь Бичвэрт “Харагтун. Сонгогдсон, булангийн үнэт чулууг Би Сионд тавина. Түүнд итгэгч нь ичгүүрт орохгүй” хэмээсэн байдаг. Тиймээс итгэгч та нарт энэ нь үнэт, харин үл итгэгчдэд “Барилгачдын голсон чулуу нь булангийн чулуу болов” гээд “Бүдрүүлгийн Чулуу, тээглэх Хад болсон юм” гэсэнчлэн болой. Тэд үгэнд дуулгаваргүй байдгаас болж бүдэрдэг бөгөөд энэ нь тэдэнд таарсан аж. (1Петр 2:6-8)

Тийм ээ, заримдаа бид цуглаанд явдаг Христэд итгэдэг хүн гэдгээ нуумаар, ичгүүртэй юм хийж, хэлэх тохиолдол байдаг. Гэхдээ бид Булангийн чулуугаасаа хором ч ичэх ёсгүй. Есүс бол төгс. Бид бол орцоосоо шалтгаалан их бага цацардаг, өө сэвтэй алмаз бол, Их Барилгачин маань бидний хамгийн сайныг тодруулж, өө сэвийг маань засч, бүрэн бүтэн болгодог.

Хүмүүс бидний итгэлийг хөсөрдүүлдэг.
Хүмүүс жинхэнэ биднийг харж чадахгүй.

Бид ч хүмүүсийг хөсөрдүүлж, бие биеэ Есүсийн нүдээр харж чаддаггүй.

Гэхдээ бид амьд буй насандаа Есүст л мөргөнө. Учир нь Тэр биднийг хэзээ ч хөсөрдүүлэхгүй. Тэр шалгагдсан боловч, нэг ч бүдрээгүй, нэг ч унаагүй. Есүс Өөрийнхөө өө сэвтэй сүйт бүсгүй болох чуулганыг гэрэлтсэн, төгс нэгэн болтол нь бүрэн үнэнчээр хайрладаг. Тэгвэл бид ч тэгэх ёсгүй гэж үү?

Исаиа ном дээр:

Тиймээс Эзэн БУРХАН “Үзэгтүн. Би Сионд нэгэн чулууг, Шалгагдсан, үнэт, бат суурилуулсан суурийн булан чулууг тавина. Түүнд итгэгч нь үл тэвдэнэ (Исаиа 28:16) гэдэг.

Үл тэвдэх гэдэг нь Еврейгээрээ зүгээр нэг яарахаас гадна “сандрах, бачимдах” гэсэн утга илэрхийлдэг. Чи бидэнд: Танд итгэдгийн улмаас Санаа бат хүмүүнийг Та амрын амар байлгана (Исаиа 26:3) хэмээн амлажээ.

Есүстэй хамт төвлөрөл маань шилжиж, гологдол (Есүс) нь гологдогсдын гэр болжээ.

Харин та нар сонгогдсон угсаа, хаан тахилч, ариун үндэстэн, Бурханы эзэмшлийн ард түмэн юм. Ингэснээр харанхуйгаас та нарыг Өөрийн гайхамшигт гэрэл уруу дуудсан Түүний хүчирхэг үйлдлийг та нар тунхаглах юм. Та нар урьд нь ард түмэн ч биш байсан бол одоо Бурханы ард түмэн болжээ. Та нар өршөөлийг хүртээгүй байсан боловч одоо та нар өршөөлийг хүртжээ. (1Петр 2:9-10)

Бид нэгэн цагт Түүнийх биш байсан бол, одоо Түүнийх болсон. Бид нэгэн цагт гологдол байсан бол, өдгөө бид Түүнийх болсон. Бид нэгэн цагт хуваагдмал байсан бол, одоо бид Христийн дотор нэг болсон.

—◆—
Бид хэн ч
биш байгаад,
Түүний дотор
бид бүх юмтай
болсон.

Чамайг... намайг... өөр олон хүнийг Бурхан сонгож, ариун хүмүүсийн тахилчийн үйлсэд дууджээ. Бид Бурханы үйлсийг амьдралаараа гэрчлэх гэрч болжээ. Бидний хуучин Түүний шинээр солигдож, бидний үхэл Түүний амиар солигдов. Бид Чулууг тэвэрч, нуранги дундаасаа Булангийн чулуундаа хандан, биднийг бүрэн дүүрэн болгохыг гуйдаг. Бид гологдмол байгаад, Христийн дотор хүлээн авагдсан. Бид хэн ч биш байгаад, Түүний дотор бид бүх юмтай болсон.

Булангийн чулуу нь өнгөрсний булшлагдсан үлдэгдэл биш юм. Есүс ч хайлсан газрын гүнээс олборлосон үхмэл чулуу биш юм. Христ бол амьд Чулуу бөгөөд бидний шинэ эхлэлийн уран барилгач юм. Тэр бол биднийг өөрчлөх хүчтэй, хувирашгүй Чулуу.

Чулуу ба Үр

Эртний уран барилгад булангийн чулуу нь бүхэл барилга сүндэрлэн босдог үүсэл үрд тооцогддог байв. Булангийн чулуу нь тулгын чулуу бөгөөд бусад бүх чулуу нь үүнийгээ л дагаж өрөгдөнө. Тиймээс булангийн чулууг зөв суурьлуулахын төлөө барилгачид булангийн чулууг луужингийн зүүний үзүүртэй эн зэрэгцүүлэхийн тулд одод эрхсийг ашигладаг байжээ. Айсуй Булангийн чулууг маань одод хүртэл тунхагласан нь юутай сайхан.

Орчин цагийн уран барилгад булангийн чулууг барилгын үр болгож ашиглахаа больсон. Өдгөө булангийн чулуу нь барилга баригдаж дууссан хойно хэзээ ашиглалтад орсныг нь тэмдэглэдэг, гоёл чимэглэлийн зориулалттай л зүйл болжээ. Эдгээр булангийн чулуу нь барилгын эд бүтцэд ямар ч үүрэггүй бөгөөд зүгээр л нэмэлт зүйл болжээ. Тэгвэл Есүс бидний амьдралын чимэглэл биш, харин үлгэр загвар бөгөөд хамаг амьдралыг маань ургуулдаг үр үндэс юм.

Тэр бидний хорогдох газар, суурийн үр төдийгүй, бидний сэргэлт билээ.

Есүс Христийн ирэлтийн тухайд, Паул Коринтын чуулганд чөлөөлөгч Хадны талаар ингэж тайлбарлажээ: “бүгд адилхан сүнслэг ундааг ууж, тэднийг дагаж байсан сүнслэг хаднаас ундаалсан ба тэр хад нь Христ байв” (1Коринт 10:4). Израильчууд цөлөөр Мосег дагаж явахдаа, тэднийг даган явж байсан хаднаас

гарсан усаар цангаагаа тайлж, сэргэжээ. Тэр хад нь Христ байв. Тэр үед ч Бурханы зөөлөн хайр, хангамж Израильтай байж, Есүс тэдний арын хамгаалалт болжээ.

Сонирхолтой байгаа биз?

Энэ хад хэдэн сая хүнийг ундаалаад зогсохгүй мөн тэдэнтэй хамт хөдлөн явж байв. Бурхан хүмүүсээ өдөр нь үүлэн баганаар, шөнө нь галан баганаар - хад мэт даган явж байжээ. Энэ нь цөлөөр явж байгаа Израилийн хүүхдүүдээ харж хандаж буй Бурхан Аавын маань тун үзэсгэлэнтэй дүр зураг билээ. Раббигийн зарим уламжлалд Тэрбээр Израилийг хөдлөх үед нь даган өнхөрч, зогсох үед нь даган зогсдог байсан, бодит хад байсан гэдэг.²

Тэр хад нь яг жинхэнэ хад байсан уу, зүйрлэл байсан уу гэдэг нь хамаагүй - гол нь тэр хад нь үеийн үед тэдний арын хамгаалалт байсан Христийг төлөөлж байсан юм. Хад нь Иммануел Бурханых буюу бидний өнөөгийн Эзэний сүүдэр байжээ. Христ одоо ч бидэнтэй хамт амьдралын цөлөөр аялж, амьд усаараа биднийг ундаалдаг Хад болой.

Тэрээр хадыг нээсэнд ус олгойдон гарч,
Хуурай газруудаар гол мэт урссан.
(Дуулал 105:41)

—◆—
Тэр угаасаа
ДЭНДҮҮ сайн
бөгөөд
өршөөнгүй
учраас л тэр
ЮМ.

Амьдралд цөлийн улирал байх бөгөөд цөл нь бидний амьдралын эх ундаргыг илчилдэг. Заримдаа хэдэн долоо хоног, сар ган гачиг нүүрлэдэг бөгөөд үүний ул мөр нь хэдэн жилээр үргэлжилдэг. Гэхдээ чиний одоогийн нөхцөл байдал ямар харагдаж, хичнээн удаж байсан ч, наад цөлөөр чинь урсаж буй нэг нууц гол бий шүү. Тэр гол чамайг сүлжиж урсаагүй, харин дотор чинь урсаж буй. Чи цангаж байгаа бол, амьдрал чинь ангаж байгаа бол, Хад руугаа хашхираарай.

Загалмай дээр Хад Есүс маань дахин нэг удаа ангайж, Түүний дотроос угаах ус, авран сэргээх цус урссан юм.

Тэр Хадны сайн сайхан бидний муу муухайг нэвтрүүлэхгүй. Адамант маань бидний өө сэвтэй нүүр тулах үед тэдгээр нь Түүний оршихуйн өмнө тоос болон сарнидаг юм. Тэр бидний алдаа зөрчлийг

мэдэхгүйдээ тэр биш л дээ. Тэр биднийг санаатай дур тачаалаараа өөрийгөө зовоож ичээж, өрөөлийг хорлож хохироож байгааг сайн мэднэ. Тэр угаасаа дэндүү сайн бөгөөд өршөөнгүй учраас л тэр юм. Тэр бол бүгдийн Аврагч, Эзэн бөгөөд сүйрсэн амьдралаа Түүний адамант өршөөл дээр тавьсан хүн бүр өөрчлөгдөнө.

Шинэ нэр

Есүс түүнд хариуд нь —Ионагийн хүү Симон оо, чи ерөөлтэй еэ! Учир нь үүнийг чамд мах цус нь биш, харин тэнгэр дэх Эцэг минь илчилсэн юм. Би мөн чамд хэлье. Чи Петр. Энэ хадан дээр Би чуулганаа босгох бөгөөд түүнийг Үхэгсдийн орны хаалга дийлэхгүй. (Матай 16:17-18)

“Чи бол Петр.”

Шинэ амьдрал шинэ мөн чанарыг шаардана. Шинэ мөн чанар нь шинэ нэрийн бэлэгийг шаардана.

Энэ тунхаглал нь Симоны сэтгэлд хайлсан байх. Насаараа өөр нэрээр дуудуулсан хүн гэнэт олноос онцлогдон, хад хэмээн дуудуулах ямар байдаг бол?

Симон. Энэ нэр зүгээр л сайхан нэр. Гэхдээ хангалттай аугаа байгаагүй. Энэ нэр нь тэр хүний хэн болохыг бус, харин хэн байсныг илтгэнэ. Бид өөрөөр ярихдаа, өөрөөр харж эхлэдэг. Петр гэдэг нь тэр хүний тэнгэрлэг хувь тавиланг илтгэсэн, шинэ нэр байв.

Симон гэдэг нь “сонсох, чих тавих” гэсэн утгатай нэр. Түүнчлэн “зэгс мэт уян мөн чанарыг” илтгэнэ. Энэ хоёр утгыг нэгтгэх юм бол, сонсохыг хүссэн зүг чиг рүүгээ чих тавин, нахилздаг хүнийг илтгэмээр. Энэ утгаараа бид бүгдээрээ л хувь тавилангийнхаа шинэ нэрийг хүлээж байгаа Симонууд билээ.

Христ Симонтой ярилцахдаа, түүний нэрийг сольсон явдал нь Христ дотор эзлэх бидний байр суурийн зөгнөл байв. Учир нь Христ биднийг гулжгар зэгснээс адамант бэхэлгээ хана болгон хувиргадаг.

Симон загасчнаас хүний загасчин болж өөрчлөгдөх шаардлагатай байжээ. Симоныг шинээр нэрлэсэн явдал нь түүний хуучин номын

хуудсыг хааж, Бурхан түүний талаар цоо шинэ ном үзэглэж эхлэсэн явдал байжээ.

Петр эхлээд шинэ нэрэндээ дасч өгөхгүй, эвгүй байсан болов уу гэж би гайхдаг юм. Эсвэл яг л насан турш хүссэн тэр нэр нь мөн байсан болов уу? Харин бид яах байсан бол? Тэнгэрт бид бүгдээрээ жинхэнэ нэр маань сийлээтэй чулуу хүлээн авна гэдгийг чи мэдэх үү? Есүс:

“Чуулгануудад Сүнс юу айлдаж буйг чихтэй нь сонсогтун. Ялагчид Би нууцалсан маннагаас өгнө. Би түүнд цагаан чулуу болон түүн дээр бичигдсэн, хүлээн авагчаас нь өөр хэн ч мэдэхгүй шинэ нэр өгнө” (Илчлэл 2:17) гэсэн.

Энэ шинэ нэр нь ялалтыг тунхаглана. Энэ чулуун дээр биднийг хэрхэн айдсаа ялан дийлж, Бурханы бүтээсэн тэр хүн болж чадсан түүх маань сийлэгдэх болно. Бидний шинэ нэр чулуун дээр сийлэгдэнэ гэхээр би хачин их догдлодог юм. Энэ нь “бидний хэн байсан маань хайлж, хэн болох маань мөнхөд тогтоно” гэж хэлж байгаатай л адил юм. Хад маань надад мөнхөд зохих нэрийг бүтээж байхад, яахаараа би *одоогийн* нэрээрээ амьдрахыг сонгох гэж? Шинэ нэрэндээ тултал өсөх амь надад бий.

Бидний талаар Есүсийн хэлсэн зүйл бидний салшгүй хэсэг болох үед дотор маань нэг зүйл хувираад л явчихдаг. Тэр эгшинд бид Бурхан биднийг мэдсээр ирснийг зэрвэс хардаг. Петр бол биднийг Булангийн чулуу руу маань урьсан хад гэдэг үнэнд би дуртай.

Энэ бол Есүсийн чулуутай ажилласан анхны тохиолдол биш. Мужаан гэхээр л бидний санаанд модоор ажилладаг хүн бууна. Харин Есүсийн үед мужаанууд нь “чулуу, төмөр, хүрэл, зэс тэгээд мэдээж модоор урладаг дархан хүмүүс байжээ.”²³ Тиймээс манай Булангийн чулуу маань чулуугаар юм хийдэг байжээ.

Газар дээр бид аав ээжийнхээ хайрласан нэрээр дуудуулдаг. Тэгвэл өнө мөнхлөлд бид гагцхүү бидний л мэддэг нэртэй болно. Үл мэдэгдэх зүйл бидэнд мэдэгдэх хүртэл бид Есүсийн нэрийн гайхамшиг дотор амьдрах завшаанаа эдлэнэ.



Шинэ
НЭРЭНДЭЭ
ТУЛТАЛ ӨСӨХ
АМЬ НАДАД
БИЙ.

Христийн дотор хад чулуунууд нь нийлж, ариун уулыг бүтээдэг.

Христийн дотор жижиг үр том мод болон ургадаг.

Христийн дотор хад чулуун зүрхнүүд амьд чулуу болдог.

Христийн дотор олон хүн нэг болдог.

Түүний дотор аюулгүй

Христ доторх байр суурь маань бидний аль зэрэг шийртэй болохоос шалтгаалахгүй. Түүний дотор нуугдах эгшинд бид Түүний хүч чадал дотор хамгаалагддаг. Бидний Хад, Адамант, Булангийн чулуу - Христийн дотор бид аюулгүй.

Саяхан би Чикаго ороод, зочид буудал руугаа цаг шахам таксигаар зорчих замд таксины маань мусульман жолооч намайг Исламдаа урвуулах гэж оролдов. Тэр надад өдөр бүр залбирч, Исламын зарчмаар аж төрөх юм бол, аз нь шовойбол диваажинд орж магадгүй гэлээ. Тэр намайг аминдаа л хадан дээр суурьтай болгох гэсэн боловч, харамсалтай нь тэр нь ямар ч амлалт - баталгаагүй хад байв. Жолооч намайг тэр хаднаас хальтраад уначихаж тун болзошгүйг ойлгохын дээдээр ойлгож байлаа. Харин би Христийнхээ дотор үлдэхийг сонгоно. Уналаа ч Түүний дотор л унана.

Бид Түүн дээрээс унаж болох ч, Түүнээс гадагш унана гэж байхгүй.

Түүний дотор оршихийн тулд Бурхан *бидний дотор* Өөрийнхөө итгэлийг тодорхой хэм хэмжээгээр суулгажээ. Бид хүнд итгэхдээ бүдэрдэг. Харин итгэл маань Бурханы дотор байгаа цагт бид хэзээ ч бүдрэхгүй. Амьдралдаа Бурханы итгэлийг нэвтрүүл, урьж оруул. Чи өөрийнхөө хүчээр баахан бүтэлгүйтсэн байх. Мөн өөрийнхөө хүчээр итгэлийн овоолсон хад руу мацаад унаж байгаа хүмүүсийг ч зөндөө харсан байх. Харагдахгүй болохоороо итгэл нь байхгүй юмуу бий болохгүй гэсэн үг биш юм. Итгэл нь илүү их зүйлд итгэхэд маань туслахаар дотор маань цогин буй найдварын далд чичиргээ юм. Итгэл бидэнд илүү ихийг асуух урам зориг, Христийн дотор бид ч хөдлөшгүй, ялагдашгүй адамант байж чадна гэдгийг мөрөөдөх зүрх зоригийг өгдөг.

Уулс

Бурхан бидэнд Өөрийнх нь мөрөөр, Өөрийнх нь хүчээр амьдралын ууланд авирах урилга өгчээ. Би саяхан дэвтэртээ ингэж бичсэн юм:

Уулс намайг хүрээд ир, чамайг би ерөөе хэмээн даллахдаа, хатан зоригтны л байлдан дагуулдаг, юутай ч эгнэшгүй нууцаараа аазгайг минь хөдөлгөнө. Гэтэл би өтлөөд өвдөг минь тамирджээ. “Яагаад ийм хожуу дуудна вэ?” Тэгтэл Тэр: “Тийм ээ, тэр уул цавчим өндөр, авирах ч амаргүй. Гэхдээ Би хүчтэй. Тавьсан замаар минь алхбаас, залуу нас чинь шинэчлэгдэнэ” гэж хэлэв.

Би уулсын дундах Колорагод аж төрдөг бөгөөд өдөржин гэрийнхээ цонхоор уулын бараа ширтэж чадна. Тиймээс Бурханыг дагаж уулд авирна гэдэг ойлголт надад шууд бууна. Чи хаана амьдардгийг би мэдэхгүй ч, нэг зүйлийг мэдээрэй - чи ч бас тэр уул руу хамтдаа авирахаар дуудагдсан юм шүү. Бэлд нь хүрэшгүй, хад асгатай Синай уул руу биш, харин амьд гайхамшиг болсон Сион уул руу!

Харин та нар Сион уул, амьд Бурханы хот, тэнгэрлэг Иерусалим уруу, баярын цугларалт дахь үй түмэн тэнгэрэлч нар, тэнгэрт бүртгэгдсэн анх төрөгсдийн чуулган, бүгдийн Шүүгч Бурхан болон төгс болгогдсон зөвт хүмүүсийн сүнс уруу ирсэн. Мөн шинэ гэрээний Зууч Есүс уруу болон Абелынхаас илүү дээр, ярьдаг, цацагдсан цус уруу ирсэн. (Еврей 12:22-14)

Энэ урилгад хөл тавин орох үед нэг зүйл болдог.

Онгон байгаль хамгаалах үйлсэд өөрийгөө зориулсан, алдарт натуралист Жон Муир нэгэнтээ: “Одоо бид ууланд, харин уул бидний дотор байж, мэдрэл бүрийг чичрээж, нүх сүв, эд эс бүрийг маань дүүргэн, сэтгэл зүрхийг маань бадраан байна”⁴ гэж хэлжээ. Тэрбээр онгон байгаль, зэрлэг ан амьтдаараа алдартай Сиера Невада уулсын гайхамшигийг ийнхүү дүрслэн бичжээ. Тэгвэл амьд уулнаа авирсан хүн яахыг бүр ч дүрслэн хэлэхийн аргагүй

АДАМАНТ

бус уу? Учир нь бид Христийн дотор байгаа төдийгүй, Христ бидний доторх найдвар юм. Бид Түүний хаанчлалыг дотроо урих үед бидний найдвар Сион уулаас ирдэг.

Эдгээр хуудас нь гологдож, айсан дүүрвэгч шиг явдаг бүгдэд хандсан урилга байх болтугай. Аялал чинь чамайг үнэний нэгдэлд хүргэж, дэлхийн үзэл, эргэлзээний урхиас зугтахад чинь туслах болтугай. Бидний Адамант бол үеийн үед бидэнтэй байсан, хөдлөшгүй Нэгэн билээ.

*Тэнгэрийн Бурхан Аав минь,
Би амьд чулуу шиг чулуу, хаанчлалын тахилч шиг тахилч
байх болно. Миний хорогдох газар, хүч, сэргэлт, найдвар
байгаач. Зүрхэнд минь миний шинэ нэрийг сийлээч.
Би өөрийн Булангийн чулуу, Адамант болсон, амийн
хөдлөшгүй, ялагдашгүй ундарга болсон Христийг түшнэ.
Миний амьдралд орж ирээч.*



2

ДОТНО АДАМАНТ (ДОТНО ЧАНАРААР БАТ БЭХ)

Бид сүнслэгээр амьдрах гэж ядаж буй хүн биеүүд биш. Бид хүний амьдралаар амьдрах гэж ядаж буй сүнслэг биеүүд юм.

Пьер Тэйяр дэ Шардин

Би амаргүй хүүхэд байлаа. Гөжүүд, дураараа. Заримдаа мэлэн хойлог, чимээгүй, сарнимтгай. Өрөөгөө цэвэрлэгэх юм бол, хэдхэн минутын дараа яах гэж өрөөндөө орсноо мартчихна. Заримдаа хаалгаа түгжиж аваад, хөгжмөө орилуулаад, төсөөлөлдөө умбана. Өрөөгөө цэвэрлэхээсээ илүүтэй, тавилгынхаа байршлыг өөрчилнө. Заримдаа урт алчуураар хүзүү толгойгоо ороож аваад, өөрийгөө Лора Ингалс Уайлдер байна гэж жүжиглэнэ. Шургуулгад минь нэг бол морь урлуулахыг хүссэн хөх баримлын шавар байна эсвэл эмээгийн маань алс газраас авч ирсэн хүүхэлдэйнүүд намайг өөрсдийг нь цэгцлэхийг хүлээнэ. Тэгээд мэдээж уншихыг минь хүлээх бөөн бөөн ном. Би өрөөндөө

ороод л цаг хугацааны мэдрэмжээ алддаг байлаа. Бүхэл бүтэн цаг арван таван минут шиг л санагдана.

Тэгээд ээжийн дуу хадах үед л би өрөөндөө нэг юм хийх гэж орж ирснээ санах боловч, яг юу хийх гэж ирснээ санахгүй. Ээж орж ирээд, намайг бахь байдгаараа байгааг харна. Өрөө маань дээрдсэн гэхээсээ илүү дордсон л байдаг байв.

Уг нь би тэрслэхийг хүсдэггүй байсан ч, дандаа л буруугаар эргэчихдэг байлаа. Миний энэ зан ээжийн минь мэдрэлийг бардаг байв. Харин би ээжийнхээ өөдөөс миний хийсвэр ертөнцийг харахгүй байгаад уурладаг байсан боловч, ээж маань өөрөө чөлөөлөгдөж чадахгүй түмэн зовлонд баригдсан эмэгтэй байв. Ээж маань завхай төдийгүй, архичин хүнтэй амьдралаа холбоод, мацаж гаршгүй сэтгэлийн тамд унаад байсан юм.

Гэтэл би ганц охин нь төдийгүй ууган хүүхэд нь байсандаа, ээжийнээ уур хилэнгийн бай болно. Би олон талаараа яг л аав шигээ авирладаг байлаа. Тэгээд ээж маань надад хэлэхийг хүсээгүй олон үгийг хэлж, хийхийг хүсээгүй олон зүйлийг хийсэн юм. Гэхдээ би тэдгээрийг аль дээр уучилсан учраас, одоо давтаж хэлмээргүй байна. Гэвч бидний зөрүүлсэн үг, үйлдлээс болж би охин хүүхэдтэй болохыг үзэн ядсан юм. Би чамд миний Есүстэй уулзсан явдал маань хичнээн нандин учрал байсныг ойлгуулах гэж л оршил болгож амьдралаа тоочоод байгааг минь ойлгоорой.

Намайг дөрөв дэхь хүүхдээ тээж байхад, хүмүүс “Яг охинтой болно!” гэж хэлдэг байлаа. Тэгээд ч дөрөв дараалж хүү төрүүлнэ гэж юу байхав дээ, тийм ээ? Би жирэмслээд удаагүй байсан бөгөөд охинтой болно гэсэн айдас намайг тамлаж байлаа.

Ээж маань надад олон ч удаа: “Чиний охин гэж яг чам шиг юм байна!” гэж хэлж байсан сан.

Би ч урдаас нь олон ч удаа: “Тэгсэн ч яадаг юм!” гэж хэдэрлэж байсан сан.

Магадгүй хэзээ нэгэн цагт би охинтой болохыг хүсч байсан байж болох ч, цаг хугацаа өнгөрөх тусам энэ хүсэл маань худлаа болохыг ойлгосон юм. Би охинтой болохыг жаахан ч хүсдэггүй байлаа. Би хэдийнээ байнга аялаад, гэрийн бараа хардаггүй нөхөртэй, гар дээрх гурван жаахан хүүдээ даргадсан, цуцсан эмэгтэй болчихоод байв. Энэ бүхэн дээр охин хүүхэд нэмэгдбэл, юу болох билээ? Би тэр охиныг чинь яахаа мэдэхгүй шүү дээ!

Тэгээд нэг удаа залбирч байхдаа, Бурхантай илэн далангүй, шууд ярьлаа.

Тэгээд би Бурханд толгойд минь шуурч байгаа айдас бүрээ шивэгнэж, надад охин өгч ёстой болохгүйг хэллээ. Би тэр охиныг ээж минь намайг гомдоосон шиг, эмээ минь ээжийг минь гомдоосон шиг гомдоомооргүй байна. Би түүнтэй дотносохгүй байх гэж айж байлаа. Би жаахан охин байхдаа, харамсмаар харамсмаар үг их хэлдэг байсан учраас, өөр шигээ охинтой болохыг хүсэхгүй байв.

Хэсэг хугацааны дараа миний үгийн урсгал татарч, сэтгэлд минь нам гүм тогтов. Би нүдээ аниатай чигээрээ гүн амьсгалаад, тэр нам гүмийг гаргалаа.

Тэгсэн төсөөлөлд минь нэгэн дүр зураг буув. Би алтан нарны гэрэлд найгах маргад эрдэнийн өвстэй, уудам цэлгэр цэцэгт нугын өмнө зогсож байх юм. Яг л юу юугүй дундуур нь зүсээд л чавхдаад гүйчихмээр нуга. Гэтэл алс хол ганц цайз үзэгдэх юм. Тийшээ ормоор санагдлаа. Цайз ганц л орцтой бөгөөд оройдоо хүртэл цагираглан ороосон олон нарийн цонх ханаар нь дүүрэн үзэгдэв. (тэдгээр нь сумны ором байсныг одоо би мэднэ) Би хаалгаар нь яваад орлоо. Гадаатай харьцуулахад, цайзын дотор бүүдгэр байсан ч, жихүүцмээр, харанхуй санагдсангүй. Гэтэл цонхны гэрэлд би оройд тултал цагираглан эргэлдсэн шат байхыг үзэв. Би шатаар авирахдаа, цонхны хажуугаар ээлжлэн өнгөрч байлаа. Гадаа хүн ч, байшин ч харагдсангүй. Цонх бүр тэр нугын өөр өөр талыг харуулж байв.

Би шатны оройд хүрээд, таазандаа цонхтой дугуй өрөө байхыг үзэв. Цаад талын хананд модон авдар харагдана. Онгойлгож үзмээр санагдлаа. Тэндээс зэвсэг, эд бараа юмуу эсвэл магадгүй ямар нэгэн эрдэнэс гарч ирэх болов уу гэж бодоод, өвдөглөж байгаад цоожийг нь тайлтал, тэнд байгаа зүйл намайг гайхшруулав. Тэр авдар миний хүүхэд насны зургуудаар дүүрсэн байлаа.

Шүдгүй даадаа байх үеийн маань зураг. Нүдтэй байсан бас нүдээ авахуулсан үеийн маань зураг. Зуны амралтын, Христмасын, төрсөн өдрийн, аав ээж маань инээмсэглэж чаддаг байсан үеийн

Нялх хүүхэд
шиг асгартал
үйлсан
намайг
Бурханы
хайр тэврэн
авсан юм.

зураг. Би олон арван жилийн өмнө манай хонгилд үерийн ус нэвтрэх үеэр алдагдсан зургуудаа барьсаар зогслоо. Гэтэл тэр зургууд өндөр цамхагт эрдэнэсийн авдарт бүрэн бүтнээрээ хадгалагдаж байдаг! Би алдсан зүйлээ эргүүлж олсондоо, магнайгаа хагартал баярлаж, ахин дахин ойртуулан харж байлаа. Нэг зураг дээр нь би ойролцоогоор таван настай л юм шиг харагдана. Нүүр, үс минь тэр чигээрээ нарны туяанд гялбажээ. Аав руугаа Попай шиг нүдээ ирмээд, жуумалзан мишээх төрхийг минь аав маань дарж амжжээ. Тэр явдал амьдаараа нүдэнд үзэгдэх шиг.

Гэнэт: “Миний хөгжилтэй, ухаантай охин” гэсэн дуу хоолой дурсамжийн “киног” маань тасалдуулав.

Эргээд хартал, Есүс байсангүй. Гэхдээ нэг л халуун дулаан, бодитой, танил оршихуйгаар нь би Түүнийг мөн гэдгийг танив. Нялх хүүхэд шиг асгартал уйлсан намайг Бурханы хайр тэврэн авсан юм.

Яг тэр эгшинд намайг өөрийгөө муу охин гэж бодоход хүргэсэн бүх үг шувуу шиг пор хийтэл нисээд одсон юм. Надад эдгэрэл авчирсан эдгээр зураг ийм нарийн нандин, хамгаалалттай авдарт хадгалагдаж байсан нь үнэхээр гайхмаар байв.

Дотно

Бидний Бурхан бидэнтэй дэндүү дотно байдаг. Тэр миний айдсыг мэддэг учраас, шууд сүнсэнд минь ярьжээ. Тэр чамтай ч тэгж ярихыг хүсдэг. Тэр чиний таг мартсан, эгдүүтэй хөөрхөн үеийг санаад мишээдэг. Тэр чиний нүгэл, ичгүүрийг таг мартаад, зөрчил бурууг чинь умартлын далайд булшилсан. Тэр чамайг эдгээж, илааршуулахаар Өөртөө ойртуулдаг.

Бид буруу дүр дүрслэлээс өөрийгөө олж авах гэж хайхдаа, жинхэнэ өөрийгөө алддаг. Бид өөрийнхөө бэлэг авъяасыг өөрийнхөө айдас, бусдын хорон үгээр булшлахдаа, чадвараа алддаг. Гэхдээ бид гүйж очоод, Бурханы дотор нуугдаж чадна. Бурхан гологдож шоовдорлогдсон хүмүүсийг Өөрийнхөө тэвэрт бүүвэйлж тайтгаруулаад, дараа нь үнэний дотор суулгахыг хүсдэг.

Чи дараах зүйлийг хэдийнээ мэддэг болсон байх аа:

Чи өөрийнхөө бодсоноос ч, бусдын бодож, хардгаас ч том хүн.

Чи өөрийнхөө мэдсэнээс ч, хийснээс ч том хүн.

Чи бусдын бодсоноос ч, өөрийгөө хайрцагласан дүр төрхөөсөө ч том хүн.

Чи өөрийгөө өөртөө байгаа юмуу байхгүй зүйлээрээ тодорхойлж чадахгүй. Чи өөрийнхөө наснаас ч том хүн учраас, чамайг хэн болохыг чиний залуу юмуу өтөл нас тодорхойлохгүй.

Чи бол өнө мөнхийн хүүхэд.

Чи зүгээр нэг ганц бие, салсан, бэлбэсэрсэн, гэрлэсэн хүн биш.

Чи зүгээр нэг хүйстэн биш.

Эдгээр чанар нь жинхэнэ чи гэдэг хүнийг бүтээдэг бүтцийн тодорхой илэрхийлэл төдий л юм. Эдгээр нь өөр хоорондоо холбоотой эрч хүч, материаллаг эзэмшил юм. Эдгээр нь биднийг нөмөрлөдөг хувцас, тээдэг биетэй адил юм. Эдгээр нь бидний амьдралын дүр төрхийг илтгэдэг боловч, хэрхэвч бидний амьдралын эх үүсвэр биш билээ.

Хэрэв би шатаж байгаа гэрээсээ эсэн мэнд гарсан бол, миний амь нас аюулгүй байна.

Сүнс

Би амьд сүнс.

Чи амьд сүнс.

Бид Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн бөгөөд харин Бурхан сүнс болой. Хэдийгээр сүнс үл үзэгдэх боловч, бодитой бөгөөд бидний амьсгалдаг амьсгал шиг л ойрхон байдаг. Гэхдээ уушгиар минь дамждаг агаараас хавьгүй гүн гүнзгий зүйл л дээ. Энэ бол бидний дотор оршин буй Бурханы чимээ юм. Хайраа илэрхийлэхэд саад хийгч бүхнийг бидний хайр, галын Бурхан залгиж л орхино.

Бурхан бол сүнс, Түүнд мөргөгчид нь сүнсээрээ, үнэнээр мөргөх ёстой. (Иохан 4:24)

Бурхан Сүнс. Бурхан үнэн. Тиймээс бид Түүнийг сүнсээр хийгээд үнэнээр хүндэтгэдэг.

Өнөөдөр бидний сүнс хүмүүн бие гэдэг энэ давчуу араам дотроо багтаж шингэх гэж зүдэрч л явна. Чөлөөтэй байх гэсэн

тэмүүлэл маань газрын баригдмал байдалтай байнга мөргөлдөх боловч, энэ мөргөлдөөн биднийг улам л том зүйл рүү тэмүүлэх хүслийг маань сэргээнэ.

Хүүхэд байхад, энэ зөрчил биднийг улам л өсөхөд хүргэдэг байв. Бидний хүрэлтээс хол давсан тэр нэгэн зүйл биднийг өнхөрч, мөлхөж сарвалзахад хүргэнэ. Хэсэг хугацааны дараа би энэ



Бурханы
дуу хоолой
амийг
ярьдаг.

хөдөлгөөндөө сэтгэл ханахаа болино. Тэгээд “би шалан дээр амьдралаа өнгөрөөмөөргүй байна” гэж бодно. Хариултын эрэлд гарсан мөлхөө жаал - бид аюулгүй байдлаа ардаа орхиод, босч зогсоно. Босч зогссоноороо бид алсыг илүү өргөнөөр харах боловч, нэг хэсэг харж байгаад, сэтгэл ханаад, буцаад онжгоороо гулгаж эхлэнэ. Гэхдээ эцсийн эцэст ингээд л хоёр хөллөөд, эргээд дөрвөн хөллөөд байхаасаа

уйдах өдөр ирнэ. Тэр өдөр бид тэр чигээрээ алхахаар шийднэ.

Хөгшин залуу хэн боловч өөрсдийг маань боомилж, хөсөрдүүлж байгаа давчуу байдалдаа гутардаг. Тиймээс хүний биет амьдрал нь хүний сүнснийг эдгээх хүчтэй гэдэгт итгэх нь утгагүй бус уу? Махан биеийн хувцас маань бидний сэтгэл мэдрэмжид хүрч, биед таашаал өгч болох ч, харин сүнсэнд маань хүрч чадахгүй.

Хэдийгээр тийм боловч Бурханы Сүнсний амьсгал л хүрч болох бүхнийг амилуулж, бидэнд эдгээрийг мэдрэх хүчин чадлыг өгдөг юм.

Түүнчлэн Иаковын: “сүнсгүй бие үхмэл байдгийн адил” (Иаков 2:26) гэж хэлснээр, сүнс л биеийг амьд сэрүүн байлгадаг.

Сүнс биеэс гармагц, бие нь анх хэлбэршин бий болсон газартаа буцна. Сүнс л биед амь, зорилго өгсөн бөгөөд үүнгүйгээр бие нь ялзрах жамтай. Гэхдээ Иаков, Паул хоёрын ярьсан өөр нэгэн төрлийн үхэл бий - үхмэл итгэл.

... түүнчлэн үйлсгүй итгэл ч бас үхмэл болой. (Иаков 2:26)

Тэр биднийг Шинэ гэрээний үсгийн бус харин Сүнсний үйлчлэгчид байх чадвартай болгосон. Учир нь үсэг хөнөөдөг бол, Сүнс амь өгдөг аж. (2Коринт 3:6)

Бурханы оршихуйгүй, хоосон шашинтай бүү хөөцөлд, Сүнсний салхи байхгүй Библийн хуудсыг бүү эргүүл. Бурханы дуу хоолой амийг ярьдаг. Хуулийн үг үсэг нь хүний хувьд дагаж мөрдөх боломжгүй хууль дүрэм байхаас гадна мөн нийгэм соёлын шаардлага нэхэмжлэлийг агуулдаг. Эдгээр нь биднийг өөртөө наагаад явахыг уриалан дэмждэг зүйл зүйлийн шошго юм.

Тэдгээр амьд шошго, үсэг нь үхмэл болохыг ухаарахаас нааш бид зөв зүйлийг буруу газраас хайсаар л байна. Бидэнд бидний санаашралын гүн рүү хандаж ярьдаг, эргэлзээг маань тайлдаг, сүнснээс сүнсэнд ярьдаг хэн нэгэн хэрэгтэй. Манай соёл худал хуурмагаар их төөрүүлж тоглодог болжээ. Хөшигний арын оператор бидний юу харж, юу сонсохыг шийдэн зохицуулж байхад, бид хий хоосон юмд хууртагдсаар л явна. Магадгүй тэр хөшигний цаана та өөрөө нуугдаад, өөрийгөө мэдүүлэхийг үнэн голоосоо хүссэндээ, бодит байдлыг тэс өөрөөр гуйвуулж байж ч мэдэх. Гэхдээ Бурхан хардаг юм.

Элин хальдаг Бурхан

Эхэнд Бурхан тэнгэр ба газрыг бүтээжээ. Газар нь хэлбэржээгүй, хоосон төдийгүй оёоргүй гүний гадаргууд харанхуй бүрхэж, Бурханы Сүнс усны мандал дээгүүр элин хальж байлаа. (Эхлэл 1:1-2)

Бидний Бурхан анхнаасаал Бүтээгч байв. Газар нь хэлбэршээгүй, хоосон төдийгүй оёоргүй гүний гадаргууд харанхуй бүрхэх дунд Бурхан ойрхон байжээ. Энэ байдалд гутарсандаа нүүрээ буруулах юмуу эсвэл хэлбэр дүрсгүй, хоосон харанхуй уснаас дөлөхийн оронд, Бурханы Сүнс элин хальж байв.

Би яг одоо түр зогсоод, *элин халих* гэдэг үгийг дүрслэх гээд оролдъё.

Элин халихыг Еврейгээр *ракаф* гэх бөгөөд үүнийг “нэгэн зэрэг маш зөөлөн, элбэрэлт байдлаар хөвөх юмуу тогтох” гэж орчуулах нь хамгийн сайхан дүр дүрслэл болно. Рабби нар элин халих гэдэг үгтэй “тагтаа мэт”¹ гэдэг үгийг хослуулдаг.

Түүнчлэн *ракаф* нь “дэвэх” гэсэн утгатай болно. Энэ үгийг дараах хэсгээс ахин харж болно:

ЭЗЭН түүнийг эзгүй зэлүүд, араатан архирах цөлөөс олжээ. Тэр түүнийг эргэн тойрч, хайрлан халхалж, Нүднийхээ цэцгий мэт хамгаалсан. Үүрээ сандан *дэгдээхэй дээрээ далавчаа дэлгэн дэвж*, дэгдээхэйгээ жигүүр дээрээ аван зөөх бүргэд мэт. (Дэд хууль 32:10-11)

Энд Бурхан Израилийн хүүхдүүдийг бүргэд дэгдээхэйгээ хамгаалах мэт хамгаалж, халамжилсан талаар өгүүлжээ. Бурхан тэднийг цөлийн газраас амлагдсан газар руу авч явахдаа, тэдэн дээгүүр Сүнсээ дэлгэн хамгаалжээ.

Зүүдлэн уйлагнах бяцхан үрийнхээ дээгүүр цээжээрээ нөмрөн, тайтгаруулах эх хүний дүр төрх санаанд буумаар. Бид сэрэхийг хүсэх үү?

Бурханы Сүнс элин хальж, халхлан хамгаалах зуураа үгээ хэлжээ. Тэрбээр үгээ машнарийн сонгожээ. Тэрбээр хэлбэр дүрсгүй гүн харанхуй гэдэг бодит байдлыг давтаж хэлээгүй. Тэрбээр хэлбэрших ёстой зүйлийг хэлбэршүүлэх зүйлийг илгээжээ. Эмх замбараагүй байдлын нүүрэн дээр Бурхан сэргэлтийг дууджээ. Бурхан харанхуй устай нүүр тулж байгаад, үүр - шинэ эхлэл - өдрийг тунхаглажээ. Бурхан гэрлийг тунхагласан.


Тэгэхэд Бурхан —Гэрэл бий болтугай! гэж айлдсанд гэрэл бий болов. Гэрэл сайн болсныг Бурхан харж, Бурхан гэрлийг харанхуйгаас салгажээ. (Эхлэл 1:3-4)

Гэрэл гарч ирсэн бөгөөд энэ нь тун сайхан байв. *Гэрэл* гэдэг Еврей үг нь Бурханаас үүсэлтэй үг бөгөөд Бурхан сүүдэргүй, гэрэл учраас, үүнд гайхах хэрэггүй. Энэ нь нарнаас болоогүй. Нар бүр хожмын үйл явдал юм. Бурханаас гаралтай энэ гэрэл нь газрын харанхуй зай завсрыг гэрэлтүүлэхээр гарчээ. Гартаа бамбар барих болон гэрэл барих нь ялгаатай юм. Бид гэрэл барьдаг. Гэтэл Бурхан *бол* гэрэл. Бурханы амьсгал нь өөрөө гэрлийг амилуулах эдтэй байв.

Тиймээс Бурхан Өөрийнхөө мөн чанарыг л газарт тунхагласан бөгөөд энэ нь ч сайн зүйл байв... *Бурхан сайн*.

Эхлэл 1 дээр гардаг *сайн* гэдэг Еврей үг нь: хүсүүштэй, үр нөлөөтэй, эелдэг, ёс суртахуунтай, үнэ цэнээр өсөх гэх мэт олон Англи үгийг багтаадаг. Гэрэл гарахад, газар дээр эдгээр тэргүүтэй

маш олон мөн чанарын үр цацагджээ. Энэ эхлэл нь газрыг оршин суугч нартай нь эелдэг бөгөөд ёс суртахуунтай, сэтгэл татмаар, үр бүтээлтэй орчин болгосон бөгөөд үнэ цэнэ нь жил ирэх тутам улам бүр өсөн нэмэгдэх байв. Бурханы сайн сайхны үлгэр загвар нь хөдөлгөөнд оржээ. Газрын гэрэл нь анх гялс хийтэл маналзаад л бий болсон уу эсвэл яг л үүрийн гэгээ татах шиг бага багаар туяарч бий болсон уу гэдгийг мэдэх аргагүй. Гэхдээ Бурхан Өөрөө тэр гэрлийн эх үүсвэр байсан бөгөөд тэр гэрэл нь харанхуйгаас салсан, сайн зүйл байв.



Бурхан
сүүдэргүй,
гэрэл.

Бурхан гэрлийг өдөр гэж нэрлээд, харанхуйг шөнө гэж нэрлэлээ. Ийн үдэш болоод, өглөө болсон нь анхны өдөр.
(Эхлэл 1:5)

Гэрэл бий болоход, юмс бий болж эхлэжээ. Дараа нь Бурхан хуримтлагдсан усыг зааглаж, хуурай газрыг, уур амьсгалтай нь, агаар орчинтой нь бүтээжээ. Хамгаалалтын орон зай тогтсоны дараа гүн харанхуйд дарагдаж, нуугдсан байсан юмс гадаргуу дээр гэрэлд гарч ирэв.

Бурхан —Тэнгэрийн доорх ус нэг дор хуримтлагдаж, ийн хуурай газар ил гартугай! гэсэнд ёсоор болжээ. Бурхан хуурайг нь газар, хуримтлагдсан усыг нь далай гэж нэрлэв. Эдгээр нь сайн болсныг Бурхан харлаа. (Эхлэл 1:9-10)

Далд байсан юмс ил болжээ. Газар тэнд байдгаараа байж л байсан боловч, гүн хар усаар хучигдан, чөлөөлөгдөх өдрөө хүлээж байжээ. Газар цэлэлзэх усан дороос амьсгаа даран, найдвар тээн хүлээж байсныг төсөөлж байна уу? Газар Бурханыг өөрийг нь дуудаж гаргаж ирэхийг хүлээн байжээ. Тэгээд газар ил гармагц, амьдрал буцлав.

Ингээд Бурхан —Газар нь ургамал ногоог буюу үрлэгч өвс ногоо, доторх үрээ газарт гөвдөг үр жимст модыг төрөл төрлөөр нь ургуултугай! гэж айлдсанд ёсоор болжээ.
(Эхлэл 1:11)

Маргааш нь өдөр, шөнийн захирагч нар болох нар, сар оддыг томилов. Энэ нь бүх амьд юмс Бурханы гэрлийн гялалзсан, дулаан гэрэл дор гэрэлтэж байжээ гэсэн үг юм. Бурхан гэрлийн эх үүсвэр байсан бөгөөд хожмын нэг өдөр буцаад гэрлийн эх үүсвэр болно.

Тэнд цаашид шөнө болохгүй. Эзэн Бурхан тэднийг гийгүүлэх учраас тэдэнд дэнгийн гэрэл ч, нарны гэрэл ч хэрэггүй болно. Тэгээд тэд үеийн үед хаанчилна.
(Илчлэл 22:5)

Нар, сарны хил хязгаар тогтоогдоход Бурхан ус, тэнгэрийн нутаг дэвсгэрт хандан загас, тэнгэрийн бүтээлүүдийг дуудан гаргажээ. Тэнгисийн гүн, тэнгэрийн уудам нь амь амьдралаар цалгив. Бурханы Сүнс нэгэнтээ элин хальж байсан тэр газраар өдгөө бүтээлүүд нисэлдэн байна. Маргааш нь дэлхий даяар байгаа ан амьтад сүрэлгэх үйл ажиллагаа өрнөв.

Бурхан —Газар дэлхий амьд биетийг төрөл төрлөөр нь буюу мал адгуус, мөлхөгчид, газрын зэрлэг амьтдыг төрөл төрлөөр нь гаргатугай! гэж айлдсанд ёсоор болжээ.
(Эхлэл 1:24)

Далай, агаар, газар нь өөр өөрийнхөө төрөл, мөн чанараар ангилагджээ. Энэ ажлыг Бүтээгч л үйлдэв.

Ийнхүү Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр хүнийг бүтээж,
Бурханы дүр төрхөөр бүтээхдээ эр эмээр нь бүтээжээ.
(Эхлэл 1:27)

Хүн төрөлхтөн Түүний дүр төрхөөр бүтээгдэв. Бид мастер Бүтээгчийнхээ тусгалаар бүтээгдсэн гэдэг завшаанаа ойлгодог үгүйг би мэдэхгүй.

Нүглээс өмнө бид бүтээл болгоныг гайхан биширдэг байв. Гэхдээ тэд чиний дотор нэхээтэй дүр төрхийг харуулж чадахгүй. Би үүнийг зүгээр нэг хэлээгүй. Би үүнийг үнэн гэдгийг мэднэ. Чи өөрийгөө жинхэнээсээ харахгүй учраас, эргэлзэж байж болох. Эрэгтэй, эмэгтэй хүн гайхамшигтай бүтээгджээ.

Тэгэхэд ЭЗЭН Бурхан газрын шорооноос хүнийг урлаад, амин амьсгалыг хамраар нь үлээж оруулахад хүн амьд биет болжээ. (Эхлэл 2:7)

Бурхан эхлээд хэлбэршүүлсэн, дараа нь амьсгал оруулсан. Энэ гэрлийн хурдтай галбарт Бурхан хүнд Өөрийнх нь амьсгалыг тээх хүчин чадлыг өгчээ. Дараа нь “Би бол Би” Бурхан маань хүний биеийн галбирт амьсгалаа үлээн оршуулахад, тэр бүрхүүл амь оржээ. Адам анх төгс бүтээгдсэн. Түүний бие ч төгс галбиртай байсан бөгөөд хүний сүнс, сэтгэл нь ч нэгдмэл байв. Адам, Ева хоёр төгс байжээ.

Миний хэлсэн үгээс бүү айгаарай. Бас үл тоож болохгүй шүү. Биднийг Хамгийн дээд Нэгэний дүр төрхийг тээгч байлгах Бурханы анхдагч сурвалжит томилгоог үүр. Адам, Ева хоёр зөрчил гаргах үед бид буцаахын аргагүй лав унажээ. Эдүгээ бид ялагдашгүй Булангийн чулуу Христийнхээ дотор нуугдахдаа, болж болох байсан бүхнийг бүдэг бадаг төсөөлөхийн сацуу бас хожмын өдөр хэн болохын сүр жавхлант алдрыг хүлээн сууна. Энэ талаар Си. Эс. Люис маш оновчтой тэмдэглэсэн байдаг:

Адам, Ева
хоёр зөрчил
гаргах
үед бид
буцаахын
аргагүй лав
унажээ.

“Та нар ноён Адам, хатагтай Ева нараас гарсан” хэмээн Аслан хэлээд: “Тийнхүү энэ нь хамгийн ядуу гуйлгачны толгойг өргөх хүндэтгэл, газрын хамгийн аугаа хааны мөрийг бөхийтэл ичээхийн аль аль нь мөн. Хангалуун бай” гэлээ².

Та нар Аавтайгаа сүнсээр дүүрэн, дотно харилцаанд дуудагдсан. Бид бол нүгэл дэлхийд шургалахаас өмнө газар шорооноос хэлбэршсэн, хөрсний хүүхдүүд. Биднийг дахин төрөх үед сүнс маань амилсан ч, оюун санаа, бие маань ариун ордон, шинэчлэлийг хүсдэг.

Гүн хийгээд нууц юмсыг Тэр л илчилдэг. Харанхуйд юу буйг Тэр мэддэг Гэрэл Түүнтэй хамт оршдог. (Даниел 2:22)

Нүглээр сэтгэл, сүнсний энэ дотно холбоо тасарчээ. Яг л байгаад байгаа мөртлөө дотроо хоосон сав шиг. Хэдийгээр хүний амьсгал нь бидний араамыг тогтоож байгаа боловч, дотроо бид ангайсан, хоосон хар нүх шиг л явдаг. Тэр амь учраас, бид амьсгалж байгаа боловч, гүехэн амьсгалдаа ханалгүй, бүр ихийг хүсэн тэмүүлдэг. *Бурханы* Сүнсгүйгээр бид амьсгалах төхөөрөмжид залгаатай хүн шиг ажээ.

Тэгэхээр одоо би яагаад бүтээлийн талаар ийнхүү өгүүлэх болсноо хэлье. Миний бодлоор Бурханы Сүнс чиний амьдралын зарим хэсэг дээгүүр элин халихыг хүсч байна. Бурхан Эхлэлийн өөрчлөлтийг авчрахыг хүсч байна. Бурхан:

Чамайг гэрлээрээ гэрэлтүүлэхийг хүснэ. (2Коринт 4:6)

Гэрлийг харанхуйгаас салгахыг хүснэ. (2Коринт 6:14)

Чиний дээгүүр хаацайлал хамгаалалтаа татахыг хүснэ.
(Ром 4:7-8)

Хар усан хөнжлийг хуу татаж, шинэ хөрсийг гаргахыг хүснэ.
(Еврей 11:29)

Чиний хөрсөн дэхь үрийг чөлөөлж, ургуулж, үр жимс гаргахыг хүснэ. (Марк 4:20)

Чиний харанхуй уснаас амьдрал, гайхамшгийг дуудаж гаргаж ирэхийг хүснэ. (Иохан 7:38)

Зүрхийг чинь айдсаас чөлөөлж, итгэлээр жигүүрлүүлэхийг хүснэ. (Матай 6:22, Марк 6:50)

Чамайг үй түмэн бүтээлийнхээ гайхамшгаар бишрүүлэхийг хүснэ. (Дуулал 19:1-6)

Нүглийн бий болгосон хориот бүс рүү амиа үлээн оруулж, чиний сүнс, сэтгэлийг дахин шинээр нэхэж, урагдаж, тасарсан бүхнийг дахин холбохыг хүснэ.
(Иохан 20:21-22, Колоссай 2:2)

Одоо ч Бүтээгч маань бидэн рүү ойртож, харанхуйгаар хучигдсан, сүүмийсэн эргэлзээ дунд байгаа хэсэг бүртэй минь нүүр тулж, гэрлээ тусгахыг хүснэ. Түүний Сүнс амьдралын маань хэлбэр дүрсгүй, хоосон хэсэг дээгүүр элин халина. Бурхан бидний зовиурыг тоодоггүй, нөхцлийг маань хайрхардаггүй нэгэн биш. Тэр биднийг эргэлзээтэй тэмцэж байгааг минь хардаг. Тэр бидний зөрчлийг үзээд нүүр буруулдаггүй. Түүний Сүнс улам ойртож, яг л айсан үрийнхээ дээгүүр нөмөрлөн тайтгаруулах ээж хүн шиг, яг л өндөгнөөсөө гарч ирж буй ангаахай дээгүүрээ дэвэн эргэлдэх бүргэд шиг эелдэг зөөлнөөр биднийг тойрон эргэлддэг. Хожим дэгдээхэй нь нисч сурах үед бүргэд ээж дахиад л дэвэн эргэлдэнэ. Энэ бол бидний эргэн тойронд байдаг, бидний дотор байдаг Бүтээгчийн маань дэндүү дотно, хувирашгүй мөн чанар юм. Дотно сэтгэлд сүүдэр байдаггүй учраас, бүү нуугд. Аав чинь жинхэнэ чамайг хардаг бас хайрладаг. Чамайг хэлбэршүүлж, амьсгалаа өгсөн Нэгэнд итгээрэй.

◆
Дотно
сэтгэлд
сүүдэр
байдаггүй.

Дотносол бүрэн бүтэн болгодог

Бурхан хэзээ ч худлаа ярихгүй.

Тэр бусдын чамд хэлсэн худлыг давтахгүй.

Тэр чиний өөрийнхөө талаар үнэн мэт хэлсэн зүйлийг хүлээн зөвшөөрөхгүй.

Тэр ямар нэгэн шошгоор чамайг хязгаарлахгүй. Түүний оршихуйд ямар ч шошго - чиний өөр дээрээ бичсэн шошго ч хуурч унадаг.

Тэр чамайг дуудуулдаг нэрээр чинь бус, харин Өөрийнхөө нэрээр дууддаг.

Тэр чамайг чиний дээгүүр элин хальдаг Сүнсний нэрээр дууддаг.

Тэр чиний гүний гүн санаашрал, хар айдастай халз тулдаг.

Тэр чиний хэлбэршиж амжаагүй байгаа хэсгийг ч хардаг.

Тэр хугарсан найдварыг чинь хардаг.

Тэр эргэлзээний чинь мананг хардаг.

Тэр хүний хямралын үймээн самууныг хардаг.
Тэр ганцаардаж, айсан нэгний уйлахыг сонсдог.
Тэр ичэж, гологдсон нэгний зовиурыг мэдэрдэг.
Тэр нүглийн урхи, ичгүүрийг хардаг.
Тэр үерлэн орж ирэхээр айлгаж байгаа их усыг хардаг.
Тэр чиний сүүдрийн судалтай, ертөнцийг харанхуйлсан
харанхуйн гүнийг нэвт хардаг.

Тэр энэ бүхнийг хараад, гэрлийг тунхагладаг.
Хүмүүс чамайг “Хөөе эмэгтэй!” гэж дуудаж болох ч, Тэр
чамайг “Миний охин!” гэж дуудаг.

Хүмүүс чамайг гетеросекс, трансжендер, э-секс, лесби зэрэг
зүсэн зүйлийн нэрээр дуудаж болох ч, Тэр чамайг “Миний охин!”
гэнэ.

Охин үр гэдэг нь зүгээр нэг хүйсээр хязгаарлагдахгүй, илүү
өндөр төвшний харилцаа юм.

Охин үр гэдэг бэлгийн чиг хандлагаас ч дотно зүйл юм.

Охин үр гэдэг нь Бүтээгчийнхээ охин гэсэн үг.

Бурхан биднийг эрэгтэй, эмэгтэй гэдэггүй.

Бурхан биднийг “Миний хүү, охин!” гэдэг.

Хүн бүрийн дотор гагцхүү Бурханы л хүрэлцэж чадах, нандин
хэсэг бий. Тэр хэсэг нь Бурханы Сүнсэнд л хариулдаг хэсэг юм. Бид
Есүс гэдэг нэрийг амьсгалах бүрийдээ, Түүний хүрэлцээг хүсдэг.

Манай гариг хар усан дорх булшаасаа гарч ирээд чангаар
хашхирсан эсэхийг би мэдэхгүй. Гэхдээ тэр үед Бурханы Сүнс
газар дээгүүр элин хальсан гэдгийг л мэднэ. Эдүгээ Бурханы Сүнс
бидэнтэй шивнээ мэт ойрхон байх бөгөөд биднийг Өөрийгөө
тойруулан улам бүр ойртуулахыг хүсдгийг би мэднэ.

Шинэ гэрээнд Бүтээгчийн зүрх сэтгэлийг Есүс үгээрээ
шивэгнэсэн байдаг:

Иерусалим аа, Иерусалим аа, эш үзүүлэгчдийг алж, өөрт
нь илгээгдэгсдийг чулуугаар нүүлгэдэг хот оо. Тахиа
дэгдээхэйнүүдээ далавчин дороо бөөгнүүлдэг шиг Би
хүүхдүүдийг чинь цуглуулахыг хичнээн ч удаа хүслээ дээ.
Харин та нар хүсээгүй. (Матай 23:37)

“Та нар хүсээгүй” гэдэг нь юутай харуусмаар үг вэ?

Бурханы Сүнс одоо ч шуургыг намжааж, зэлүүд талын улианыг намдаахаар элин хальсаар байна. Тэр биднийг хамгаалалтаараа бүслэж, далавчаараа дулаацуулахыг хүсэн, хүлээсээр байна. Харин бид хүсч байна уу? Бид Ариун Сүнсийг өөртөө ойртуулж, дээгүүрээ элин халихыг зөвшөөрч байна уу? Түүгээр хучуулахыг зөвшөөрч байна уу? Эсвэл бид өөрийгөө хучуулсан атлаа бусдыг нүцгэлж байна уу? Бид Бүтээгчээ сонсох уу?

Дотно байдал нь зүгээр л хэн нэгнийх байх гэсэн хүний гүн хүсэл юм.

Бид хэн нэгнийх байхаар тэмүүлдэг нь бид хэн нэгнийх байхаар бүтээгдсэнийх юм.

Бид дотнослыг хүсэн тэмүүлдэг нь бид дотно байхаар бүтээгдсэнийх юм.

Бид хайрлаж, хайрлуулах хэрэгтэй... учир нь бид хайраар бүтээгдсэн.

Гэтэл бид зарим зүйлийг дэндүү хялбарчлах атлаа зарим зүйлийг хэт хүндрүүлдэг. Хүйсийн тал дээр бид аль алийг нь хийдэг. Би эмэгтэй хүний бие дотор амьдарч байгаа боловч, эцсийн эцэст зүгээр л сүнс юм. Бид хүний амьдралаар амьдрах гэж зүдэрч байгаа сүнснүүд юм. Энэ дэлхий бидний гэр биш учраас, заримдаа бидний бие хачин эвгүй, хязгаарлагдмал, баригдмал санагдах нь гайхах явдал биш юм. Биднийг үхэшгүй мөнхийн биедээ орох хүртэл ялзарч, үхдэг энэ араам маань ийм л байх болно. Бид яг л задралд орох гэж байгаа үр шиг хүлээж байна. Харин тэр цагт - тэр цагт л бид өөрийгөө хэн, юу болохыг жинхэнээсээ мэднэ.

Бид бүгдээрээ эвдэрхий хүмүүс. Тиймээс өөр нэг эвдэрхий хүнд хамаатах нь яг л сексээр дотнослыг олж авдаггүйтэй адил бидний эвдэрхий засагдахгүй. Засагддаг байсан бол, янхан, хормойн донтой хүмүүс энэ дэлхий дээрх хамгийн жаргалтай хүмүүс байх байв (Гэтэл тийм биш гэдгийг бид бүгдээрээ мэднэ). Гэхдээ бидний харъяалагддаг, бидний эвдэрхийг эдгээж, дотносох хэрэгцээг маань хангадаг Нэгэн бий. Тэр бол элин хальж, биднийг дахин бүрэн бүтэн болгодог Бурханы Сүнс юм.

Даниел 2 дээр хүний гар хүрээгүй чулуу уул болсныг санаж байна уу? Энэ ойлголт нь Исаиа ном дээр ч гардаг:

Эцсийн өдрүүдэд ЭЗЭНий өргөөний уул нь Уулсын тэргүүн болж, Толгодын дээгүүр өргөгдөнө. Бүх үндэстэн түүнд цутгана. Олон ард түмэн ирээд “Ирцгээ, ЭЗЭНий уул, Иаковын Бурханы өргөө уруу явцгаая. Тийнхүү *Тэрээр бидэнд замаа зааж, бид жимээр нь алхах юм*” гэцгээнэ. Учир нь хууль Сионоос гарч, ЭЗЭНий үг Иерусалимаас гарна. (Исаиа 2:2-3)

Бурхан бидэнд ажилладаг арга замаа зааж, бид түүгээр нь алхана. Бид хамгийн гүн санаашрал маань ч хориглож дийлэхээргүй эсвэл хамгийн том айдас маань ч хориглож чадахааргүй, хөдлөшгүй, ялагдашгүй дотнослын төлөө бүтээгдсэн юм. Бид асуух юм бол, Тэр бидэнд сайн сайхныхаа гэрлийг харуулна. Одоо түр зогсоод, энэ гэрлээр өөрийгөө сэрээ:

*Тэнгэрийн Бурхан Аав минь,
Та холын, ууртай Бурхан биш, харин миний хамгийн дотно
Нэгэн гэдэгт би итгэж байна. Амьдралын маань зарим
хэсэг гүн хар усан дор живээд, надад ч харагдахаа больжээ.
Та миний амьдралд хандаж үгээ хэлээч. Гэрлээ тусгаж,
амьдралыг маань харанхуйлал, эргэлзээнээс тусгаарлаач.
Би Таны охин баймаар байна. Миний амьдралд ямар арга
замаар ажиллаж байгаагаа харуулаач. Тэгвэл би юуны
төлөө бүтээгдсэн - түүнийхээ төлөө л явах болно. Би Таны
алдрын төлөө бүтээгдсэн. Есүсийн нэрээр. Амень.*



3

ТОГТВОРТОЙ АДАМАНТ (ТОГТВОРТОЙ ЧАНАРААР БАТ БЭХ)

Есүс Христ өчигдөр ч, өнөөдөр ч бас мөнхөд хэвээрээ.

Еврей 13:8

Миний хувьд долоо хоногийн сүүлээр амарна гэдэг ховор үзэгдэл. Тийм тохиол гарбал, жинхэнэ гайхамшиг юм. Тийм боловч би нуугдсаар байснаа хүлээн зөвшөөрнө. Юунаас гээч?

Яг үнэндээ энэ номоос.

Хэдийгээр би хойшлуулахын мастер боловч, энэ номын тал дээр зүгээр нэг зугтаж, хойшлуулсан явдал биш байлаа. Би эцсийн хугацаанаас өөр нэг зүйлээс айгаад байлаа.

Би ийм их *хэрэгцээ*, чухалчлалыг урьд өмнө мэдэрч байсан эсэхээ мэдэхгүй юм. Би зөв үгээ олох гэж бачимдахаасаа гадна эдгээр үгээ зөв өнгөөр дүрслэх гэж бачимдаж байв. Тэгээд энэ зөв үг, зөв Бичээсээ зөв уншигдах төдийгүй мөн яг найзаасаа юмуу

ээжээсээ “хэмжээлшгүй хайртай шүү” гэдэг үгийг сонсож байгаа юм шиг л зөв угсрах ёстой байв.

Өнөөдөр би урьд өмнө хэд хэдэн удаа барьж аваад, хаясан зүйлээ дахин барьж авлаа. Надад ямар ч уулзалт, ажил байхгүй учраас, одоо компьютер бид хоёр л сууж



Бурхан өөрчлөгддөггүй. Тэр өөрчлөгдөх ч хэрэггүй.

байна. Өнөөдөр Хагас сайн өдөр бөгөөд ажлын газар маань хаалттай учраас, би номоо үргэлжлүүлэн бичихийн тулд зориуд гэрээсээ гараад, өөр газар ирчихээд байгаа минь энэ. Би өглөө эрт дугуйгаараа зах ороод, дараагийн хэдэн өдөр идэх шинэхэн хүнсээ цуглуулаад амжсан. Тэгээд яг одоо өглөө авсан пармезан бяслагтай, шив шинэхэн, шаржигнасан талхаа гартаа барин сууж байна. Тэгээд өглөөжин сүнсэндээ сонссон үгээсээ эхлэлээ: “Би чиний Бурхан Эзэн, Би хувирахгүй.”

Би энэ үгээр сэрсэн юм. Энэ үг өглөөжин миний чихэнд цуурайтсан болохоор, би энэ үгийг дэвтэртээ буулгаж авав. Ер нь бол аль нэг зүйлийг бичиж хүлээн зөвшөөрсөн бол, янших нь намждаг. Гэхдээ энэ үгийг бичлээ гээд, цуурай намжсангүй. Би энэ үгийг Бичээсээс хайтал, хамгийн түрүүнд Малахи номоос гараад ирэв: “ЭЗЭН Би өөрчлөгдөшгүй. Тиймд Иаковын хөвгүүд ээ, та нар сөнөхгүй” (Малахи 3:6).

Би гадаа суугаад, бүтэн талхны талыг цааш нь харуулангаа, энэ өгүүлбэрийг хэсэг хэсгээр нь задлав.

Тэгээд хамгийн түрүүнд би “Би хувирахгүй” хэмээн эхэнд сонссон үгээ нягтлав.

Бурхан өөрчлөгддөггүй. Тэр өөрчлөгдөх ч хэрэггүй. Тэр бүрэн зориулагддаг. Тэр бүтнээрээ зориулагддаг. Түүний хариулт нь биднээс бус, Түүнээс шалтгаалдаг. Хэрэв Бурхан өөрчлөгддөг бол, бид дуусаа л гэсэн үг.

Бурхан өөрчлөгддөггүйг мэдэх нь үнэхээрийн тайтгарам. Бурхан өөрчлөгддөг байсан бол, бид яадаг билээ?

Малахи нь Хуучин гэрээний төгсгөлийн ном. Энэ ишлэл нь 3-аар бүлгийн эхний таван ишлэлийн төгсгөлд гардаг ишлэл байв. Бурхан тэнд Өөрт нь цэвэршүүлэгчийн сав, угаагчийн саван шиг замыг нь бэлтгэх зарлагаа илгээх талаар өгүүллүүн. Гал хийгээд

саван нь шалгаж, цэвэрлэдэг хатуу бодис юм. Хэдийгээр Эзэн маань өөрчлөгддөггүй боловч, Тэр биднийг бүтээхээр зорьсон тэр нэгнээ болгохоор шийджээ.

Бурхан өөрчлөгддөггүй гэдэг баримт нь бидэнд өөрчлөгдөж чадна гэсэн урам болох ёстой! Бурхан тэр чигээрээ сайн бөгөөд итгэмжтэй.

Хөвгүүд маань жаахан байхдаа миний ч, өөрсдийнхөө ч тэвчээрийн хязгаарыг тэлдэг байв. Энэ нь тэд заавал дураараа авирладаг байсан гэсэн үг биш л дээ. Заримдаа тэд өөрийнхөө хүчин чадлыг мэдэхийг хүсдэг байв. “Ээж сая жинхэнээсээ хэлсэн үү эсвэл... ?” Би хүүхдүүдийнхээ бөмбөгийг жинхэнээсээ хурааж авахаасаа өмнө хичнээн ч удаа: “Дахиад гэртээ бөмбөг шидэх юм бол, ээж нь хураана шүү!” гэж хэлдэг байв даа. Би хэлсэн үгдээ хүрэх үү эсвэл зүгээр л хоосон үглээд өнгөрөх үү?

Тэгээд хэрэв би хэлсэн үгдээ хүрэхгүй бол, оролцогч талууд бүгд эргэлзэнэ. Би баяртай байхдаа нэг зүйл хэлээд л, ядрахаараа өөр зүйл хэлээд л байвал, өөр нэг байдалд орохоороо юу хэлэхийг ёстой бүү мэд болно. Би тэдний нүүрэн дээр нэг юм хэлээд, араар нь өөр юм хэлээд байвал, намайг яах гээд байгааг хэн ч ойлгохгүй. Би тууштай болохоос нааш, хүүхдүүд маань эргэлзэхээс гадна дуулгаваргүй авирлана.

Би саяхан байгууллагадаа шинээр хүмүүс элсүүлэхэд маань туслах нэгэн хүнтэй утсаар ярьж байтал, тэр хүн надаас яагаад байгууллагынхаа нэг тал дээр бүрэн итгэлтэй байгаа атлаа нөгөө тал дээр нь итгэл муутай байгааг асуув. Тэгээд энэ эргэлзээ маань тодорхойгүй байдлаас болсныг бид ухаарсан юм. Миний үүрэг юу байв? Би чухам юун дээр эрх мэдэлтэй, юун дээр эрх мэдэлгүй байгаагаа ухаарав. Чи юу хүсэн хүлээхээ мэдэхгүй бол, хэрхэн үйлдэхээ мэдэхгүй.

Бид тодорхой байх ёстой. Бурхан ч үүнийг мэднэ. Бурхан тууштай бөгөөд тогтвортой. Бурхан сайн. Бурхан сайныг үйлддэг. Бурхан бидэнд сайныг өгдөг. Бидэнд эргэлзээг хүлээн зөвшөөрч, сэтгэлгээгээ сүүдэрлэх газар байхгүй.

◆

Бурхан
өөрчлөгддөггүй
гэдэг баримт
нь бидэнд
өөрчлөгдөж
чадна гэсэн
урам болох
ёстой!

Аливаа сайн соёрхол ба аливаа төгс бэлэг нь дээрээс, гэрлүүдийн Эцэгээс бууж ирдэг. Түүнд өөрчлөлт ч, өөрчлөгдөх сүүдэр ч үгүй. (Иаков 1:17)

Иаков 1:17-гийн хоёрдугаар хагаст “Бурханд мэх, хоёр нүүрлэх явдал, тогтворгүй байдал нэг ч үгүй” гэдэг. Аав маань бидэнд нэгийг ярьчихаад, цаагуураа нөгөөг үйлдэх санаатай, мэхлэгч биш. Тэр бидний нүүрэн дээр нэгийг хэлээд, араар маань нөгөөг хийдэг нэгэн биш. Бурхан найдвартай бөгөөд бүгдэд нэг л ижил үг хэлдэг.

Өөр нэг Бичээс дээр Бурханы итгэмжтэй, тогтвортой чанарын талаар ийнхүү хэлдэг:

Бурхан бол худал хэлдэг хүн биш, Гэмшин харамсдаг хүмүүн ч бус. Тэрээр айлдчихаад, Түүнийгээ хийхгүй гэж үү? Эсвэл Тэр ярьчихаад, Түүнийгээ сайн болгохгүй гэж үү? (Тооллого 23:19)

Бурхан худлаа ярьдаггүй. Санаагаа ч өөрчилдөггүй. Түүний хэлсэн нь бүрэн биелнэ. Зарим зүйл арай өөрөөр харагдах юмуу эсвэл хождож ирж магадгүй. Гэхдээ ирэхдээ л ирнэ.

Бурхан бидний бат бэх, хөдлөшгүй уул, тогтвортой Хад бөгөөд бид Түүнд итгэдэг учраас л алсыг ширтдэг. Тэр тогтвортой, Түүний Үг, арга зам тууштай. Тэр нэг зүйл хэлээд, нөгөөг үйлддэггүй. Түүний бүх илрэл нь нэг байдаг.

Хуучин гэрээнд хэлсэн үг нь Шинэ гэрээнд өөрөөр хэрэгжиж болох ч, *сүнс* нь хэзээ ч өөрчлөгдөхгүй. Абрахамын гэрээн дор эрэгтэй хүн бүр хөвч хөндөх шаардлагатай байсан бөгөөд Сайн мэдээ Харь үндэстэнд тархах үед ийм шаардлага хэрэггүй болжээ. Паул үүнийг ингэж тайлбарлажээ:

Хэрэв та хуулийг биелүүлбэл хозлол нь тустай ажээ. Харин та хуулийг зөрчигч нь мөн бол таны хозлол чинь хозлол биш болдог. Тиймээс хэрэв хозлуулаагүй хүн хуулийн шаардлагуудыг сахивал тэрээр хозлуулаагүй ч хозлуулсан мэт тооцогдох бус уу? Хозлолыг биедээ хийлгээгүй хүн хэрэв хуулийг сахивал, хуулийн бичиг болон хозлолтой атлаа хуулийг зөрчигч таныг шүүх бус уу? Учир нь гаднах

байдлаараа иудей байх нь иудей биш бөгөөд махбодын гаднах хозлол нь ч хозлол биш. Харин доторх байдлаараа иудей байх нь иудей хүн мөн. Бичгээр бус, Сүнсээр хийлгэсэн зүрх сэтгэлийн хозлол нь хозлол мөн. Тэр хүний магтаал нь хүнээс бус, харин Бурханаас ирдэг юм. (Ром 2:25-29)

Дотоод өөрчлөлтгүй гадаад тэмдэг ямар ашигтай вэ? Тийм боловч жинхэнэ дотоод өөрчлөлтөд хуулийн гадаад зөвшөөрөл хэрэггүй. Эцсийн эцэст Бурхан хөвч хөндсөн зүрхийг л хүсдэг юм. Энэ нь Аавын зүрх, хуулийн амь хоёрыг хооронд нь сүлждэг, нарийн сэдэв билээ. Хуулийн амь нь махан биеийн шаардлагыг ямагт тэргүүнд тавьдаг бол, харин Сүнс биднийг хууль хэзээ ч хүчирхэгжүүлж чадахгүйгээр хүчирхэгжүүлдэг. Бурхан санаагаа өөрчлөөгүй. Бурхан биднийг өөрчилсөн. Тэр Мосед юу гэж хэлснийг харна уу:

—◆—
Бурхан
бидэнд
зүрхээ
харуулахаар
Есүсийг
илгээсэн.

Харин Намайг хайрлаж, Миний тушаалыг сахигчдад мянган үед нь хүртэл хайр энэрэлээ үзүүлдэг.
(Дэд хууль 5:10)

Мөн:

Тэдний зүрх хэвээр үлдэж, Надаас үргэлж эмээж, Миний бүх тушаалыг сахин тэд бас тэдний хүүхдүүд үүрд сайн сайхан байх болтугай! (Дэд хууль 5:29)

Хүн төрөлхтөний гэрээний туршид хайр, дуулгавартай байдал гэсэн хослол хэзээд ялалтад хүргэдэг байв. Хайр биднийг дуулгавартай дагах хүчтэй болгодог. Бурхан биднийг боломжгүй хуулиар зовоох бус, хөсөрдөшгүй хайраар цалгиахыг хүсдэг. Бурхан Синай уулын бэлд бидэнд хүрээд, бидний зүрхийг өөрчлөх байсан бол, хэдийнээ өөрчлөх л байв. Гэхдээ Бурхан Өөрийнхөө зүрхийг бидэнд харуулахаар Есүсийг илгээсэн юм. Биднийг гэх Түүний хайр ил болоход, гагцхүү хайрын хууль л хэрэгтэй болсон юм.

Есүс —Эхнийх нь “Сонс, Израиль аа! Бидний Бурхан Эзэн бол ганц Эзэн мөн. Чи Бурхан Эзэнээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаан, бүх хүч чадлаараа хайрла” гэсэн нь юм. “Чи хөршөө өөрийн адил хайрла” гэсэн нь хоёр дахь нь юм. Эдгээрээс илүү агуу өөр тушаал байхгүй гэлээ. (Марк 12:29-31)

Хуучин гэрээний Арван тушаал нь бидний ёс суртахууны, ёслолын, иргэний хууль дотор оршиж байсан боловч, Есүс “Энэ хоёр тушаал дээр бүх хууль ба эш үзүүлэгч тулгуурладаг юм” (Матай 22:40) гэжээ.

Би... байна

Миний нягтласан дараагийн үг нь “Би бол” гэдэг үг бөгөөд энэ нь өөрөө бүрэн төгс өгүүлбэр юм. Түүнчлэн энэ үг хүн бидний гаргаж ирдэг үй түмэн асуултад хариулна.

“Бурхан минь, Та байна уу?”

“Би байна.”

“Бурхан минь, Та туслаач?”

“Би туслана.”

Тэр бидний өнгөрсөн, одоо, ирээдүйд байдаг “Би... байна” Бурхан юм.

Тэр итгэмжтэй учраас, итгэмжтэй. Тэр итгэмжтэй байсаар ирсэн учраас итгэмжтэй байх л болно. Учир нь Тэр бол “Би... байна” Бурхан.

“Өрсөлдөгчгүй” номдоо би Хамгийн дээд “Би... байна” Бурханы талаарх бишрэлээ буулгасан. Хүмүүс Өөрийгөө хэн болохыг тодорхойлох гэж донтсон энэ үед бид байсан, байгаа, байх Нэгэний дотор өөрийгөө олж авах хэрэгтэй. Бид Түүний гүнээс л өөрийгөө олж авна. Бид хэнийх болохоо мэдбэл, хэн болохоо мэднэ.

Би “Би... байгч” Бурханы хүүхэд.

Чи “Би... байгч” Бурханы хүүхэд.

Бурхан Өөрийгөө Мосед “Би бол Би” (Гэтлэл 3:14) хэмээн танилцуулсан байдаг нь “Би бол нэг ч дутагдалгүй, нэг ч алдаагүй, бүрэн төгс Бурхан” гэж хэлэхтэй л адил юм.

“Бурхан, Мосед —Би бол «Би байгаа» юм гэв” (Гэтлэл 3:14). Бурхан байдаг учраас л, байдаг. Тэр байдаг учраас, мэддэг. Бурхан Египетийн дарлал дор байгаа үеийнхэнийхээ орь дууг сонсоод, Мосед үзэгджээ. Тэр мэдэж байсан учраас, оролцсон юм.

Явж, Израилийн ахмадуудыг хамтад нь цуглуулан “Эцэг өвгөдийн чинь Бурхан, Абрахам, Исаак, Иаковын Бурхан ЭЗЭН надад үзэгдэн «Би та нарыг үнэхээр анхаарч, Египетэд та нарт юу тохиолдсоныг харав. Тиймээс та нарыг Египетийн зовлон зүдүүрээс гаргаж сүү бал урссан нутаг болох канаан, хит, амори, периз, хиви, иебусчуудын нутагт аваачна гэж Би амлав» хэмээсэн” гэж хэл. (Гэтлэл 3:16-17)

Үүнийг уншаад, өөрийнхөө Бурханы талаар бодож байхдаа, би гурван зүйлийг харж байна: Бурхан хардаг, мэддэг, хариу үйлддэг. Энэ гурав нь нийлээд “Би мэднэ” гэж байгаа юм. Чи хаана байгааг би мэдэхгүй ч, яг одоо “Би... байна” Бурхан чамайг харж, юу болсныг чинь мэдэж, чамайг зовиур зовлонгоос чинь чөлөөлөхийг амладаг.

Тэр бол бүгд. Тэр бол эхлэл ба төгсгөл мөн боловч, Түүнд эхлэл ч, төгсгөл ч байхгүй. Тэр Альфагаас авахуулаад Омега хүртэлх бүх үсэг боловч, эдгээр үсгийг нийлүүлж бүтээсэн үй олон үгээр ч дүрслэгдэшгүй Бурхан. Тэр бол “Би... байна” Бурхан. Бурхан бол бүх учир шалтгааны шалтгаан мөн.

Бурхан бол “Би... байна” Бурхан учраас, тэр Бүтээгч Бурханаас бүх зүйл гарсан. Бидний Бүтээгч бидний эхлэл бөгөөд тодорхойлолтын эх үндэс. Энэ нь Түүний доторх бидний тодорхойлолтыг хэн ч хулгайлахгүй гэсэн үг. Бидний Адамтант болсон Христийн дотор бид жирийн төрөлтөөр бус, харин дахин төрөхийн нигүүлсэлт бэлэгээр Түүнийх болсон.

Намайг хөндсөн дараагийн үг нь “Эзэн” гэдэг үг байв.

Энэ нь “Би... байна” гэдэг нэрийг “Хамгийн дээд Эзэн” (Дуулал 7:17) гэх зэргээр дэлгэрүүлэн тайлсан нэр юм. Энэ нь мөн Иүдейчүүдийн хувьд дуудахаас ч эмээдэг ариун Иавэ нэртэй хоршдог нэр юм. Энэ ариун нэр нь Бурханы энэрэл, өршөөлөөрөө өлгийдсэн мөн чанар нь билээ.

Тийм ариун, дээд Бурхан энэрэнгүй бөгөөд өршөөнгүй байна

гэдэгт би талархдаг. Тэр Бурхан харгис хатуу дарангуйлагч байсан бол яана? Үнэндээ Тэр Бурхан учраас, намайг бүхлээр нь авах бүрэн эрхтэй Бурхан юм. Тэр өршөөнгүй энэрэнгүй учраас, хүн бүрийн амьдрал бол аялал гэдгийг ойлгодог.

Бид Түүнийг Эзэн хэмээн Түүнд захирагдахад, амьдрал маань Түүний эрх мэдлээр тэлдэг. Түүний дотор бид өөрийгөө алдалгүй, харин ч өөрийгөө олж, эрх чөлөөт нэгэн болдог. Хүний тал дээр “эзэн” гэдэг үгийг хэрэглэх хэцүү. Эрх мэдэл, хүчээ урвуулан, өөрийнхөө эрх ашгийн төлөө амьдарсан дэлхийн эздийг бид мэднэ. Хүмүүний түүхнээ байсан, ялгаварлагч эзэд нь захиргаан дорх хүмүүсээ ашиглахыг л мэддэг. Есүс энэ талаар Матай 20:25-28 дээр анхааруулсан буй:

Харин Есүс тэднийг дуудаад, —Харийнхны захирагчид тэднийг ноёрхдог бөгөөд ихэс дээдэс нь тэднийг эрхшээдгийг та нар мэднэ. Та нарын дунд бүү ийм байг. Харин та нарын дунд хэн чинь агуу болохыг хүснэ, тэр нь та нарын зарц болог. Мөн та нарын дунд хэн чинь тэргүүнд байхыг хүснэ, тэр нь та нарын боол болог. Үүнчлэн Хүний Хүү үйлчлүүлэхийн тулд бус, харин үйлчлэхийн тулд мөн олны төлөө амиа золиос болгон өгөхийн тулд ирсэн билээ гэв.

Есүсийн Эзэний эрх мэдэл биднийг доош нь зулгаах биш, харин дээш нь өргөдөг.

Есүсийн хамаг амьдрал үйлчлэл, аврал байсан.

Эзэн маань биднийг бүрэн бүтэн болгох гэж Өөрөө нүцгэрсэн.

Бидэнд амлалтыг өвлүүлэх гэж Өөрөө бүхнээсээ хагацсан.

Биднийг амьдруулах гэж Тэр үхлээс амилсан.

Дараа нь би “чиний Бурхан” гэдэг хэсгийг харлаа.

Би яагаад “чиний Бурхан” гэдэг үгийг сүнсэндээ сонссоныг мэдэхгүй. Магадгүй насаараа “Бидний Аав” гэдэг үгийг ахин дахин хэлдэг болоод тэр үү? Эсвэл цагийг эзлэсэн энэ үгийг тунхагласандаа тэр үү?

Энд гарч байгаа Бурхан гэдэг үг нь *Элохим* - Бүтээгч, Шүүгч, Дайчин Бурханыг хэлж байгаа юм. Үнэндээ би Бурханыг Бурхан гэх үед тэр Бурхан болоогүй. Тэр хэзээд миний Бүтээгч Бурхан хэвээрээ байсан. Тэр миний зөвшөөрөлтэй зөвшөөрөлгүй намайг

мэдсээр л байсан. Тэр намайг өмнө ч мэддэг байсан, намайг өөрийгөө мэдэхээс ч илүү мэддэг байсан. Тэр намайг нууц газраа шаглажээ. Тэр миний Шүүгч болохынхоо хувьд миний нүглийг зайлуулж, зөрчлийг арилгасан. Дуулал 103:10-12 дээр магтаалч:

“Хилэнцэд минь тааруулан Хандаагүй билээ, Тэрээр бидэнд Гэм буруугаар маань ч Хариулаагүй билээ, бидэнд. Учир нь тэнгэр нь газрын дээгүүр өндөрт байдаг шиг Түүнээс эмээгчдэд энэрэл хайр нь агуу их. Өрнө нь дорноос хол байдаг адил Гэмт үйлдлийг маань биднээс Тэрээр тийн холдуулсан” гэдэг.

Бурханы хайр нь хэмжишгүй, хөдлөшгүй, нэвтрэшгүй хайр бөгөөд энэ үг биднийг миний сонссон хамгийн сүүлийн “Би хувирашгүй” гэдэг үг дээр авчирна.

Бурхан хайр дээрээ бат бэх байдаг шигээ өршөөлдээрээ ч бат бэх байдаг. Тэрбээр бидний хувирамтгай мөн чанараар бус, Өөрийнхөө хувирашгүй мөн чанараар тангарагладаг. Дуулал 103:17 дээр Бурхан Өөрөөс нь эмээдэг хүмүүст хувирашгүй хайраа амлажээ. Бурхан төгс зүйлийг хайгаагүй. Учир нь бидний адамтант Булангийн чулуу болсон Христийн гадна нүгэлгүй хүн гэж байхгүй! Гэхдээ Тэр Өөрөөс нь эмээдэг хүмүүсийг хайдаг! Яагаад? Өнөөгийн бидний айж эмээхийг мэдэхээ больсон энэ цаг үед Бурханаас эмээнэ гэж юу гэсэн үг вэ?

Бурханаас эмээх нэг арга нь муугаас салах юм. Сургаалт үгс 3:7 дээр “Өөрийнхөө нүдэнд бүү мэргэн бол ЭЗЭНээс эмээ, ёрын муугаас эргэ” гэдэг. Пэйшн Транслэйшн дээр “Түүнийг хоёргүй хүндэтгэлээр биширч, буруу бүхнээс зайлсхийх үед цэц ухаан ирдэг” гэдэг.

Энэ хоёр орчуулгын утгыг нэгтгэх юм бол, бид Түүнийг бишрэн ширтэж, гайхах сэтгэлээ тээсээр байвал, аяндаа муугаас эргэжээ. Өөрчлөгдөшгүй Нэгэний гайхамшиг биднийг өөрчилдөг.



Түүний
дотор бид
өөрийгөө
алдалгүй,
харин ч
өөрийгөө
олж, эрх
чөлөөт нэгэн
болдог.

Тэр хайртай учраас бидэнд санаа тавьдаг. Санаа тавьдаг учраас тогтвортой.

*Тэнгэрийн Бурхан Аав минь,
Та намайг аймхай, итгэлгүй байхад ч, итгэмжтэй бөгөөд
хайраар дүүрэн байдаг. Энэ хувьсамхай ертөнцөд би
Таныг л хувирашгүй хэмээн ширтэнэ. Таны хувирашгүй
мөн чанар, тэвчээртэй хайрыг ойлгож чадахын төлөө
намайг өөрчлөөч. Энэ тогтворгүй дэлхий дээр би
ганхаашгүй байхыг хүснэ.*



4

ХАЙРЫН АДАМАНТ (ХАЙРААР БАТ БЭХ)

Амьдралын хамгийн том аз жаргал нь хайрлагдсан
- ямар байхаасаа үл хамааран, байгаагаараа
хайрлагдсан гэдгээ мэдэх юм.

Виктор Хюго

Гучин тав орчим жилийн тэртээ Жон надад сүйн алмазан бөгжөө өгч билээ. Тэр би түүнийх, тэр минийх болохыг албан ёсны болгохыг хүсчээ. (Гэхдээ тэр үүнийгээ бүр өмнө хүн болгонд хэлдэг байсан л даа!) Тэр бөгжийг авахын тулд Жон хэдэн сар дан төмс идэж, мөнгөө бэртэгчин шиг л хадгалсан гэдэг. 1982 оны 6-аар сарын 6-нд буюу миний 22 насны төрсөн өдөр Далласын нэгэн усан оргилуурын дэргэд байхдаа, Жон надад үзмэн ягаан өнгийн хамбан хайрцаг гаргаж барьсан юм. Түүнийг нь онгойлгохдоо миний зүрх ч, гар ч чичирч байлаа. Доторх хар дөрвөлж дотор нь энгийн алтан цагираг дээр суулгасан, дусал шиг ганц алмазан шигтгээтэй бөгж байлаа. Гэхдээ би үүнээс гоё алмаз хэзээ ч үзэж байгаагүй юм даг. Би ч нулимстай нүдээр: “Зөвшөөрч байна” гэж шивэгнээд, тэр бөгжийг хуруундаа углалаа.

Надад жаахан томдож байсан боловч, би яасан ч тайлахгүй гэж шийдэв. Тэр шөнө би хуруундаа бөгжтэй, нүүрэндээ мишээлтэй унтаж билээ. Бид сүй тавьсан байв!

Маргааш нь сэрээд, хамгийн түрүүнд бөгжөө харлаа. Өглөөний наранд гялтагнасан алмазан бөгж дүнсгэр байшингийн маань ханаар солонго татуулахдаа, өнгөрсөн шөнийн явдал зүүд биш байсныг гэрчлэв. Сүй тавихын өмнөх жил Жон бид хоёрын дунд бөөн жүжиг болсон юм. Тэгээд бид хоёр хэд хэдэн удаа салж, нийлсэнийхээ дараа харилцаа маань нэг шат ахисанд би баяртай байлаа. Жон бид хоёрыг тэр өглөө чуулганд очиход, олон хүн баяр хүргэв. Би ч гараа эргүүлж, тойруулаад л бөгжөө үзүүлэхдээ баяртай байсан боловч, хамгийн гол гайхуулж байсан зүйл маань бид хоёрын хайр сэтгэл байлаа.

Хэдийгээр би баруун гартай хүн боловч, тэр өдөр намайг хүнтэй уулзах тоолонд зүүн гар маань л оройлоод байсан юм даг. Тэр үед бид Далласт аж төрдөг байлаа. Энэ нь тэнд минийхээс том алмазан бөгжтэй хүн олон байсан гэсэн үг юм. Гэхдээ тэдгээр нь миний алмаз биш. Миний алмаз Жон бид хоёрын адамант хайрын түүхийг л илчилж байв. Бид хоёр үхэл биднийг хагацаах хүртэл сайн, муу бүх өдрүүдэд, тарчиг бөгөөд баян байхдаа, хүчтэй бөгөөд дорой байхдаа, бие биеэсээ зуурахаар амласан билээ. Ийнхүү шинэ хайрын түүх эхлэсэн юм. Бурхан бидэнтэй яг ийм хайрын гэрээг байгуулсан билээ.

Бурхан бол хайр.

Хайр бол Аавын маань мөн чанар. Тэр биднийг хайрлах ёстой учраас, хайрладаггүй. Тэр биднийг *хайрлахгүй байж чадахгүй* учраас, хайрладаг. Бурхан биднийг Хуучин гэрээнд үл тоогоод, Шинэ гэрээнд хайрлахаар шийдсэн юм биш. Есүс Аавдаа биднийг хайрлаарай гэж хэлсэн учраас, Бурхан биднийг хайрлахаар шийдсэн юм биш. Түүний хайр л биднийг аврахын төлөө бушуулахад хүргэсэн билээ. Тэр бидэнд хайртайгаа харуулахын тулд Хүүгээ бидэнд өгсөн. Бид өөрийгөө үзэн ядаад ч, Түүний хайрыг няцаагаад ч, Бурханы хайрыг үгүй хийж чадахгүй. Бурхан биднийг энэ талаар юм хэлэхээс ч өмнө хайрлахаар шийдэж, ширээндээ урьсан учраас, бид Түүнийг өөрийгөө хайрлахыг болиулж чадахгүй.

Бурханд бидэнд зориулсан хайр байхгүй. Бурхан Өөрөө бидний төлөөх хайр юм. Бурхан биднийг адамант, ялагдашгүй, тууштай бөгөөд үхлээс хүчтэй хайраар хайрладаг.

Аяа, ЭЗЭН, бурхдаас хэн нь
Тан лугаа адил
Ариун нь үлэмжийн,
Алдар нь аймшигт,
Үйлс нь гайхамшигтай вэ?
Баруун мутраа Та сунгасанд газар тэднийг залгив.
Бат хайр тань биднийгээ авран хөтлөв. Хүч чадал тань
биднийгээ ариун гэрт тань авч ирэв. (Гэтлэл 15:11-13)

Бурхан хайраар хөтлөдөг.

Түүний хайр бидний амьдралынхаа зүг чигийг олдог, жинхэнэ Алтангадас юм. Түүний хайрын баталгаагүйгээр, бид амархан замаасаа гарч, төөрнө. Эцсийн эцэст Түүний хайр л биднийг гэр рүү маань хөтлөдөг.

Мосе Египетийн олон зуун жилийн дарлалын дараа ард түмнээ гайхамшгаар гэтлүүлсний дараа Гэтлэл 15 дээрх дууллаа бичсэн юм. Бид энэ түүхийг мэднэ. Гэхдээ би энд Бурханы хайртай холбогдуулан хэлсэн *бат хайр* гэдэг тэмдэг нэрийг онцломоор байна. Энэ бол биднийг гэх Бурханы хайр хэзээ ч ганхдаггүйн баталгаа юм. Түүний хайрын дөл нь бидний аашийн салхинд унтрахгүй. Биднийг хариуцлагагүй, хариугүй таг, тэрслүү үед ч Тэр биднийг хайрласаар л байдаг. Бурхан мэдээж бидний энэ үйлдлийг ерөөж чадахгүй ч, энэ бүхэн дунд Түүний хайр бөхдөггүй бөгөөд Тэрбээр биднийг зөөлнөөр гэмшил рүү хөтлөдөг.

Бурханы биднийг хайрлах хайр нь *биднээс* шалтгаалдаггүй юм. Түүний биднийг гэх сэтгэл нь бидний авир үйлдлээс хамаардаггүй. Бурхан биднийг дандаа хайрладаг байсан, дандаа ч хайрлах болно. Бидний төлөө Бурханы хийсэн бүхнийг бид хэзээ

—◆—
Бурханы
биднийг
хайрлах хайр
нь биднээс
шалтгаалдаггүй
юм.

АДАМАНТ

ч төлж чадахгүй шигээ, Бурханаар их бага хайрлуулах гэж юу ч хийгээд нэмэргүй.

Уулс ганхаж, толгод доргивч, Энэрэл хайр минь чамаас салахгүй, Амар тайвны гэрээ минь хөндөгдөхгүй” гэж Энэрэгч ЭЗЭН чинь айлдаж байна. (Исаиа 54:10)

Бурханы хайр биднийг хэзээ ч орхихгүй. Хүмүүс ирээд, явдаг бол, Бурханы тогтвортой, адамант хайр хэзээд тогтоно. Түүний хайр хөдлөшгүй учраас, бид амар тайвны гэрээгээр өлгийдүүлсэн юм. Бидний адамант Булангийн чулуу Есүс маань амар тайвны Ханхүү билээ. Тэрбээр хамгийн дээд хүчнийхээ талбараас бидний бие дотор шуурах бүх шуурга, оюун ухаанд маань халдах халдлага бүрт амар тайвныг шивэгнэдэг. Биднийг гэх Түүний энэрэлд хязгаар үгүй. Бид өөрийг маань хайрлах Бурханы хайрыг няцааж чадахгүй учраас, амар тайван байж болно. Бурхан биднийг хайрлахаа болихдоо тулбал, Хүүгээ хайрлах хайраасаа татгалзах ёстой болно.

Биднийг гэх Бурханы адамант хайрын ачаар бид өөрсдийнхөө Адамант болох Христийн дотор аврагдан сэргээгдсэн билээ. Та “Ийм юм байх боломжгүй!” гэж хэлж болох. Тэгвэл биднийг гэх Бурханы хайрыг харж болно шүү: “Гэтэл биднийг нүгэлтнүүд байхын л Христ бидний төлөө үхсэнээр Бурхан биднийг хайрлах хайраа харуулсан” (Ром 5:8).

Хайр бол сонголт

Алмаз нь гэрлэсэн хайрын хүчин чадлаас гадна хайрын өөрийнх нь мөн чанарыг илэрхийлдэг. Алмаз шиг хайр ч гал, даралтын хэвэлд төрдөг. Хайр нь олон улирал, жил, тэр бүү хэл арван жил яг л нуугдсан үр шиг хөрсөн дор дараатай байж болно. Гэхдээ тэндээ байж л байдаг. Энэ үр олон жилийн өмнө амьдралын чинь хөрсөн доор суулгагдаад, гоо үзэсгэлэн нь харагдахгүй, гал нь мэдрэгдэхгүй байх боловч, газар дороо амьсгалсаар байна.

Хайр нь жинхэнэдээ мэдрэмж биш юм. Энэ бол сонголт. Хайр нь хүүхэд нь уйлах үед ээж хүн хичнээн ядарсан байсан ч,

дав хийж босоод, хүүхэд дээрээ давхиад очихтой л адил. Хайр байгаа учраас л аав нь үр хүүхдээ хоолтой байлгах гэж өдөржин ажилладаг. (Тийм ээ, хайрын улмаас хожим энэ дүрүүд байраа сольдог.) Гол санаа нь хайр нь хариу нэхэлгүйгээр өгдөг юм.

Хайр сонголтоо хийсэн бол, санаагаа өөрчилдөггүй.

Хайр биднийг сонгосон учраас, бид ч бас хайрладаг. Бурхан чамайг сонгосон учраас, чи хайрладаг (1Иохан 4:19). Бид хайрлаагүй үед ч Аав маань хайрладаг.

Анхны хайр

Бурхан бидний анхны хайр байсан бөгөөд байсаар ч байх болно. Тэр биднийг эхлээд хайрласан бөгөөд энэ нь хэврэг бус, харин бат бэх хайр юм. Тэр биднийг өөр нэгэн шиг болгох гэж хайрладаггүй. Тэр чамайг хэзээ ч хэнтэй ч зүйрлээгүй. Тэр чамайг байгаагаар чинь л хайрласан. Тэр биднийг хайрласан. Хэдийгээр бид анх бусдыг хайрласан ч, Тэр биднийг түрүүлж хайрласан юм. Гэхдээ эцсийн эцэст тэр хөдлөшгүй чулуу бидний анхны ялагдашгүй, бат бэх хайр байсныг мэддэг.

Магадгүй үйлдлээрээ Бурханы хайрыг өөрчилчих юм шиг санагддаг талууд чамд байгаа л байх. Магадгүй дуулгаваргүй, тогтворгүй байдаг тал чамд байгаа л байх.

Би ойлгож байна аа. Би ч Бурханы хайраас олон жил зугтсан. Тэр үед би хайрыг ойлгодоггүй байлаа. Жинхэнээсээ хайртай л бол, хүссэнийг минь өгнө гэж маргадаг байлаа. Бурханы хэн нэг хүүгийн хайр нь намайг одоо энд аз жаргалтай болгох ёстой гэж боддог байлаа. Үнэнийг хэлэхэд, би дандаа буруу хүнийг сонгодог байсан юм. Би таалагдах хэцүү бас яаж ч хичээсэн дэргэд тогтдоггүй хүмүүсийг л сонгочихдог байлаа. Гэтэл Бурхан миний хүслийг давж хараад, миний хамгийн гүн хэрэгцээнд хариулсан юм. Энэ нь Түүний хайр байв.

Тэр надад олох гэж зовдог, олсон хойноо алдагддаг хайраас ч илүү аугаа хайрыг өгсөн юм.

Би Түүний хайрыг ойлгосон өдрөө тун сайн санадаг юм. Яг л нүдний өмнө харагдаж билээ. Яг л ганц алмазны түмэн цацраг шиг хэдэн зүг цацарсаар, намайг дахин төрүүлж, Сүйт Хархүү

Есүсийнхээ өмнө зогсох тэр цаг хугацаа руу аваачих шиг болж билээ.

Чамайг гэх Бурханы хайр нь алмазнаас ч илүү бат бөх юм. Энэ хайр хурц гэрлийн вакуум дотор ууршиж алга болохгүй. Тэр чамтай бөгжнөөс ч гүн гүнзгий утгатай сүй тавьсан. Тэр тийм үнэт амлалтаа алга болчих юмуу хулгайд алдагдчихаж мэдэх зүйл дээр тавихгүй. Түүний амлалт нь чиний хамгийн нандин хэсэг дээр буюу зүрхэн дээр чинь тамга мэт нууцлагдаж, нандигнагдсан юм.

Соломоны дуун номын дараах ишлэлүүд нь хайртай хосын эцэс төгсгөлгүй холбоог магтан дуулсан яриа ажээ:

Тамга болгож зүрхэндээ намайг тавиач Гар дээрх тамгаа болгооч. Юун гэвэл хайр үхэл шиг хүчтэй Тачаал бол Үхэгсдийн орон шиг хэцүү. Түүний дөл түймрийн дөл Дүрэхийн асах галын дөл. Их усан гэвч хайрыг унтрааж эс дийлэх Үер усан гэвч үүнийг живүүлж үл чадах Хайрын тулд хамаг гэр хөрөнгөө хэн нэгэн өргөлөө ч гэсэн Хайхралыг хэрхэвч эс үзэх. (8:6-7)

Энэ хайр чамд эвгүй санагдаж байна уу? Чи өөрийгөө ингэтлээ хайрлуулах зохисгүй хүн гэж бодож байна уу? Эсвэл өөрийгөө

—◆—
Бурханы хайр
нь алмазнаас
ч илүү бат бөх

ЮМ.

ийм хайраар хариу хайрлах чадваргүй гэж бодож байна уу? Эдгээр үг нь чамайг хайранд эргэлзүүлэх юмуу эсвэл өөрийнхөө хайрлах чадварт эргэлзүүлэх гэж бичигдээгүй, харин чи ямар хайраар хайрлуулах учиртай хүн болохыг чинь л зэрвэс ойлгуулахын тулд бичигдсэн юм.

Бурханы хайрыг хүний туршлагаар хэмжих боломжгүй. Бидний цаг хугацаа үүнийг хэмжиж чадахгүй. Азтай нэг нь халуун хайр сэтгэлийн оч гялбааг мэдэрч үзсэн л байх. Харин заримынх нь хайрын гялбаа хэсэг хугацааны дараа мэхлэж, хайрын гал нь бөхөж, хүний хайрын нүүрс нь үнс нурам болж хувирсан байх.

Хүний хайрыг унтаршгүй гал гэж хэлэхэд хэцүү. Тийм боловч хүн бид хайрыг хүссээр. Ний нуугүй ярьбал, бид хэн нэгнийг

ийнхүү гал халуунаар хайрлаж хайрлуулах зүрхнийхээ хүслийн шивэгнээг хүлээн зөвшөөрөх л болно.

Би заримдаа Соломоны дуун номын гал халуун хайрыг хараад, ичэх шиг болдог. Тэгмэгцээ би энэ хайрд зүгээр л хариулах ёстой болохоос биш, учир шалтгааныг нь олох ёсгүй гэдгээ санадаг. Асуултаа хойш тавиад, Бурханы хардаж харамладаг, хүчирхэг, гал хайрыг хүлээн зөвшөөрөөд л хүлээгээд авбал, Бурханыг гэх миний хайр дүрэлзэнэ.

Энэ хэсэг нь үнэндээ Христийн бөгөөд Христийн сүйт бүсгүйн дүрслэл юм. Газрын энэ сүүдэрт талбарт бид өөрийгөө хэн нэгний зүрхэнд байдгийг мэдэх үед хайр зүгээр л дүрэлзэн урсдаг.

Бурханы хайрын галыг бөхөөх ямар ч боломжгүй. Амьдралын үер заналхийлж болох ч, биднийг гэх Бурханы хайрыг живүүлж чадахгүй.

Бурханы хайр нь зарагдахгүй. Тэр биднийг ямар ч баялгаар зарахгүй.

Хэдийгээр энэ хэсэг нь Христийн сүйт бүсгүй болох чуулганыг хайрлах Бурханы хайрын тухай өгүүлж байгаа ч, энэ хайр нь бас эхийн хайр шиг өмгөөлж, нөмөрлөдөг бас дурлалт хүнийх шиг дотно билээ. Аав маань эхлээд биднийг нэг бүрчлэн хайрлаагүй байсан бол, бүхлээр нь хайрлаж чадахгүй байх байлаа.

Тамгалагдсан

Бид хэзээ ч ийм гал халуун хайрыг хүртэх гавъяатай хүмүүс болж чадахгүй байсан учраас, Бурхан бидний өмнөөс ажиллажээ.

Христ дотор биднийг та нартай хамт бататгаж тосолсон нь Бурхан мөн. Тэр биднийг бас тамгалсан ба зүрхэнд маань Сүнснийг барьцаа болгон өгсөн аж. (2Коринт 1:21-22)

Би өөрийгөө байгуулж чадахгүй. Чи ч өөрийгөө байгуулж чадахгүй. Чуулганы гишүүнчлэл биднийг нэгтгэн, байгуулж чадахгүй. Гагцхүү Бурханы Сүнс л биднийг нэг болгодог.

Энэ хэсгийг Пэйшн Транслэйшн дээр юу гэж хэлдгийг үз дээ:

Тэгэхээр, Бурхан Өөрөө биднийг тослосон билээ. Тэгээд Тэр та биднийг Христийн дотор эв нэгдлээр тасралтгүй бэхжүүлж байдаг. Тэр бидний зүрхэн дээр хайрын тамгаа дарж, Ариун Сүнсээ айсуй ерөөлийн урьдчилгаа төлбөр болгон сүйт бүсгүйдээ өгдөг сүйн бэлзэг мэт өгсөн учраас, Тэр биднийг Өөрийнх нь болохыг мэднэ.

Чи үүнийг харж байна уу? Мэдэхгүй байсан ч, чи хэдийнээ сүй тавьжээ.

Лац гэхээр өнөөдөр бид витамин, хүнсний бүтээгдэхүүний гадуур ороолттой гялгар боодол гэж боддог. Үүгээр нь бид боодлыг нь задлаагүй гэдгийг нь мэддэг бөгөөд нөгөөтэйгүүр энэ нь амархан урах зориулалттай байдаг. Харин 2Коринт дээр ярьсан тамга нь тэс өөр юм шүү. Тэр тамгыг Грекээр *сфрагизо* гэх бөгөөд энэ нь дараах зүйлсийг багтаасан долоон талт тамга ажээ:



Эдгээр нь
харын хүчинд
биднийг
задлаж
болохгүй
гэсэн
анхааруулга
юм.

1. Аюулгүй байдлын тамга (бид Бурханы хайр дотор багтай хамгаалагдсан)
2. Үнэн болохын тамга (бид Бурханы Өөрийнх нь хэмээн тэмдэглэгдсэн)
3. Жинхэнэ болохын тамга
4. Өмчлөлийн тамга
5. Зөвшөөрлийн тамга
6. Зөвтгөлийн тамга
7. Амлалтын тамга¹

Эдгээр тамга нь зүгээр нэг бүтээгдэхүүний баталгаа өгсөн тамга биш юм. Эдгээр нь харын хүчинд биднийг задлаж *болохгүй* гэсэн анхааруулга юм. Эдгээр нь бидний дуулгавартай байдалтай бус, Христийн дуулгавартай байдалтай холбоотой учраас, нэгийг нь ч эвдэх боломжгүй юм. Эдгээр нь “хүрч болохгүй” гэсэн тэмдгээс гадна тамга нэг бүр нь Бурхантай сүй тавьсны баталгаа болно. Бид өөрсдийнхөө хүчээр эдгээр тамгыг зүрхэн дээрээ дарж чадахгүй. Хайр өөрөө хүрч ирээд, хожмын нэгэн өдөр биднийг илчлэх тэр өдрийг хүртэл биднийг тамгалчихсан юм.

Хайрын мөнхийн бэлэг

Чи бид хоёр Сүнсээр төрж, Сүнсээр тамгалуулж, Сүнсээр амьдарч, Сүнс дотор баптисм хийлгэж, Сүнс дотор нэг болж, Сүнсний бэлэгийг хүргэж, Сүнсээр үйлчлэлд томилогдсон улс юм. Бидэнд хэрэгтэй бүхнийг биднийг хязгааргүй хайрладаг Бурхан маань хангадаг.

Тиймээс л Ефес дээр бидэнд ингэж баталгаажуулжээ: Бурханы хүслээр Христ Есүсийн элч болсон Паулаас [Ефест байгаа] ариун хүмүүст болон Христ Есүс дэх итгэмжитнүүдэд. Бидний Эцэг Бурхан, Эзэн Есүс Христээс нигүүлсэл ба амар амгалан нь та нарт байх болтугай. (Ефес 1:1-2)

Тэнгэрийн Аав маань энэ үйл явцад ямар гүн гүнзгий оролцож байхыг чи харж байна уу? Бид зүрхээ өргөснөөрөө бүрэн үнэнч итгэлийн амьдралд “тийм” гэж хэлдэг. Үүнийх нь хариуд Бурхан бидний амьдралд тэнгэрлэг бүрэн эрхээрээ бүрэн дүүрэн оролцдог. Ефес дээр цааш нь:

Бидний Эзэн Есүс Христийн Эцэг Бурхан магтагдах болтугай. Тэрээр Христ дор тэнгэрлэг оршихуй дахь алив сүнслэг ерөөлөөр биднийг ерөөсөн (1:3) гэжээ.

Тэр үеийн найдвараар бид *одоо* баярладаг. Өнө мөнхийн талбарт л жинхэнэ амьдрал эхлэдэг юм. Тэнгэрийн бүх оршин суугчид Бурханы сүйт бүсгүйг хуримын мөнхийн бэлэг болгон хүлээнэ. Хэрэв чи энэ хэсэг чамайг хүлээж байгаа хайрын бэлэгийн талаар арай л хэтрүүлчихэж гэж бодож байгаа бол, Англи Стандарт Вержнийг уншаад үз л дээ:

Биднийг Христийн дотор *тэнгэрлэг газруудад сүнслэг бэлэг бүрээр* ерөөсөн Эзэн Есүс Христийн маань Бурхан Аав ерөөгдөх болтугай.

Бурхан тэнгэрийн ширхэг ч ерөөлөө харамлаагүй бас орхиогүй. Сүйт бүсгүйдээ зориулсан ер бусын бэлэг нь сүйт бүсгүйгээ хайрлах Түүний хайртай ч нийцдэг. Тэгвэл чи энэ багцад багтаж байна уу?

Бурханы сүйт бүсгүй болохынхоо хувьд чи бид хоёр Тослогдсон Христийн дотор савлагдсан. Түүний *хийсэн* нь бидний *хийснийг* шийдсэн шиг Түүний үхэл, амилал нь Түүний дотор бидний хийх үйлсийг хүчирхэгжүүлдэг. Түүний бүрэн дуулгавартай байдал нь бидний дуулгаваргүй байдлын өр, шийтгэлийг устгахын сацуу биднийг дуулгавартай байх чадвартай болгодог. Хэрэв чи үүнд итгэж байвал, Паулын захидал нь чи бид хоёрт зориулагдсан юм шүү.

Христэд итгэдэг хүмүүсийнхээ хувьд бид олуулаа ялагдашгүй булангийн Чулуу болох Ариун Нэгэний дотор нэг болсон юм. Бид Христийн дотор савлагдаад зогсохгүй, амьдрал маань мөн сайн сайхан байх нигүүлслийг олсон билээ.

Нигүүлсэл нь олон тал дээр олон арга замаар амлалтын баглааг боох тууз болдог. Бурхан биднийг зүрхэндээ тамгалсан бөгөөд бидний зүрхийг хайрынхаа бат бөх Булангийн чулуу дотор тамгалсан билээ.

Хайрлагдсан охин минь, намайг сонс. Чи Христийн дотор ухаж гаргасан хонгио шиг нүх биш юм. Чи бол бат бөх Булангийн чулуу

Христийн дотор хаа ч хүрэх эрхтэй нэгэн шүү. Чи гадны хүн биш. Чи зочин биш... харин гэр бүлийн гишүүн. Үнэндээ гэр бүлийн гишүүн гэхэд ч багадана. Бид Христийн дотор Христ Аавтайгаа нэг байдаг шиг л нэг юм. Бид Түүний бүгдийн доторх бүгдийн нэг хэсэг нь юм.

—
Харанхуйн
ханхүү
биднийг
хайрлахгүй.

Бидэндхангамжч, газарч бэлтгэгдсэн байгаа. Энэ баялаг нь Сүнсний бүх жимсийг багтаадаг бөгөөд үүнд Сүнс, амар тайван, зөвтгөл, баяр хөөрийн бэлэг ч багтана. Зүрхээ болоод эрдэнэсээ байх ёстой газар нь байлгая. Тэдгээрийг завхрахгүй, хулгайлагдахгүй дээрх юмс дээр тавья.

Энэ хайрыг мэдэж авсан хүн, энэ дэлхийгээс хайрыг хайхгүй. Агаарын хүчний ханхүү биднийг нэг ч хайрлахгүй.

Тэр биднийг дэндүү ихээр үзэн яддаг.

Харанхуйн ханхүүгийн амлалт болгон нь худлаа юм. Түүний амладаг, энэ нүгэлт, хэврэг талбартай холбоотой эрх хүч бүр нь сүйрэх тавилантай юм. Сатаны барьдаг бэлэг, авьяас бүр нь өөрөө хулгайн зүйлс юм. Тэр өгч чадахгүй, зөвхөн авдаг. Тэр хүрсэн бүхнээ бузарладаг.

Харин одоо бид түүний талбарт харъяалагдахаа больж, жинхэнэ бэлэг, сайн сайхан болгон нь Ааваас ирдгийг мэддэг болсон. Түүнчлэн биднийг юу ч Христийн хайраас салгаж чадахгүйг бид мэднэ.

Христийн хайр дотор аюулгүй

Хэн биднийг Христийн хайраас салгах юм бэ? Гамшиг уу, шахалт уу, хавчлага уу, өлсгөлөн үү, нүцгэрэл үү, аюул уу, илд үү? «Таны төлөө бид Бүхэл өдөржингөө хядуулжээ, Нядлагдах хонь мэтээр бид тооцогджээ» гэж бичигдсэн юм. Харин бид энэ бүхний дотор биднийг хайрладаг Түүгээр дамжин давуулан дийлдэг. Учир нь үхэл ч, амь ч, тэнгэрэлч нар ч, эрх баригчид ч, өнөөгийн юмс ч, ирэх юмс ч, хүч ч, өндөр ч, гүн ч, өөр ямар ч бүтээл бидний Эзэн Христ Есүсийн доторх Бурханы хайраас биднийг салгаж чадахгүй гэдэгт би бат итгэлтэй байна. (Ром 8:35-39)

Христийн бат бэх хайраас юу ч биднийг салгахгүй. Тэнд хэн гэж байхгүй, юу гэж байхгүй. Түүний хайрыг юу ч авахгүй, учир нь бид Христийн дотор суулгагдсан. Зөрчлийн харгис байдал, дайны аюул хэзээ ч Түүнийг бидний эсрэг болгохгүй. Бидний Амар тайвны Ханхүүгийн хайрыг үгүй хийх тийм хэмжээний аюул гэж байхгүй. Түүний хайр үхлээс ч баталгаатай, хайраас ч бодитой. Биднийг гэх Түүний хайр тэнгэрийн болоод чөтгөрийн талбарын эрхшээлийг ч давдаг. Биднийг Эзэн Есүс Христ доторх Бурханы хайраас салгах юу ч энэ орчлон хорвоод байгаагүй, байхгүй, байх ч үгүй. Биднийг гэх Бурханы хайр нь Есүсийг хайрладаг хайр шиг нь л бат бэх юм. Харин Бурхан Хүүгээ хэзээ ч эсэргүүцэхгүй.

Цаг хугацаанаас ч өмнө хайрласан

Түүний өмнө биднийг хайр дор ариун бөгөөд гэм зэмгүй байхын төлөө Бурхан ертөнцийн сууриас урьд биднийг Христ дотор сонгосон юм. (Ефес 1:4)

Би хүмүүст хүүхдүүдээ, бэрүүдээ, ач нараа гайхуулах дуртай. Ингэж хэлэхээр, Бурхан чамаар бүр их гайхуулах дуртай юм шиг санагдаж байна. Тэр чамайг хараад: “Энэ Миний охин!” гэж хэлдэг. Тэр чамтай сүй тавиад, чамтай өнө мөнхөд хамт амьдрах ертөнцийг бүтээжээ.

Чи Христэд итгэсэн өдрөө л сонгогдсон биш, энэ бол чиний л сонгосон өдөр. Үгүй ээ, чи Христийн дотор уул ус хэлбэршин бий болохоос ч өмнө сонгогдсон юм. Өөрчлөлтийн хүчээр Христ чиний дотор хэлбэршихийн тулд чи Христийн дотор хэлбэршсэн юм. Чиний дахин төрсөн өдөр энэ үнэн чиний хувьд амилсан юм. Бурханы Хүүгийн үхлээр дамжуулан хайр чамайг авраад зогсохгүй, энэ анхны найдвар руу сэргээсэн билээ.

Чи сүй тавьснаар барахгүй, Христтэй нэг байхаар урьдаас тохоон томилогдсон байжээ. Ийм хайрыг хэн ч дуугүй байлгаж чадахгүй!

Адам, Ева хоёр гэрэл, үнэнийг тайлж, могойн нүгэл, үхлийн нөмрөгийг нөмрөхөөс ч өмнө Бурхан биднийг бат бэх хайраараа Христийн өө сэвгүй ариун байдлаар өлгөйдсэн байв.

Би ч өөрийгөө мэддэг болохоороо, Бурхан намайг гэрэлтсэн цагаан биш, харин тас хар хувцсаар л хувцаслах байх гэж бодмоор. Коко Шанелийн: “Би хараас бараан өнгө олбол л, өмсөнө. Тэр болтол хараа л өмсье!” гэсэн үг л миний шүүгээг онож дүрслэх байх.

Хар хувцсанд толбо үзэгдэхгүй. Байсан ч хэн ч анзаарахгүй. Тиймээс л би аялахдаа, голдуу хар хувцас өмсдөг. Онгоцонд хар хувцастай хичнээн ч удаан аялсан амар байдаг. Хар цамцнаас хөлс харагдахгүй, арилдаггүй тодруулагчийг ч айлтгүй хэрэглэнэ, уйлсан эмэгтэйчүүдийг ч будаг шунхнаас нь айлгүй тас тэвэрнэ. Хар үнэхээр амархан. Харин цагаан тийм амархан биш.

Саяхан би яагаад цагаан хувцастай аялдаггүйгээ мартчихжээ. Колорадогийн урт өвөл дуусч, хавар ирэхэд, би долоо хоногийн сүүлээр аялахдаа, цагаан жинсээ углачихсан байлаа. Тэгээд л агаар

амьсгалаад л машинаасаа гарлаа. Намайг угтаж авсан найрсаг хүмүүс надад хамгийн дуртай ундааг минь барив - гурван шот бүхий, наргил модны самрын сүүтэй, шанцайтай жижиг аягатай кофе. Тэгтэл би халбагыг нь хуу татаад, кофегоо хаа сайгүй цацчихав. Ундааныхаа үлдэгдлийг кофены автомат машины өмнө зогсож байхдаа бас түрээсийн машиндаа ууж дуусгалаа. Би чуулганд ирмэгцээ кофены толбыг толбо арилгагч үзгээр үртэл, тэр хорт химийн бодис цагаан жинсний минь гуяыг цэнхэр болгочих нь тэр. Ингэж л толбо арилгадаг юм байлгүй гэж бодоод, би өмднийхээ гуяыг баахан усаар угаалаа. Гэтэл кофены хэдэн цацраг толбо чинь одоо гуяар минь нэг тархсан том нойтон цагираг болчихов. Уг нь толбо нь арилсан боловч, хатахаас өмнө юу болохыг гадарлах аргагүй байв. Тэр болтол нойтон хэсэг маань нэвт харагдаж байлаа. Би ч тэр чигээрээ тайзан дээр гарчихав.

Бурхан биднийг толбогүй амьдарч чадахгүй гэдгийг мэддэг учраас, биднийг Христийн дотор угаасан юм. Христийн дотор далд толбо байхгүй, Христийн дотор цайруулагч үзэг байхгүй, бандгар гуяыг маань илтгэх гэрэлтсэн өмд байхгүй. Христийн дотор хүч, гэрэл л гэж бий.

Тэрээр хүслийнхээ сайн тааллын дагуу, биднийг Есүс Христээр дамжсан үрчлэлд урьдаас тогтоожээ. Энэ нь хайрлагдсан Нэгэнийхээ дор бидэнд ивээж өгсөн Түүний нигүүлслийн алдрыг магтуулахын тулд болой. (Ефес 1:5-6)

Чи хаалтын үйл ажиллагаанд уригдаж байсан уу? Би мэдээж оролцож байсан. Эсвэл чи ямар нэгэн үйл ажиллагаанд уригдаж ирсэн чинь чамайг уриагүй байх тохиолдол гарч байсан уу? Би тэгж байсан! Тэгвэл энд тийм юм байхгүй. Чи бол нэмэлт эсвэл сүүлийн мөчид нэмэгдсэн хүн биш. Чи бол хэзээд хүндтэй зочин!

Бурхан биднийг бүр анхнаасаа л гэр бүлдээ үрчилж авахаар шийджээ. Тэр биднийг өрөвдсөндөө эсвэл бүгд голсон учраас, гэртээ оруулсан юм биш. Христ биднийг хэн байсныг минь биш, хэн болохыг минь хардаг учраас, таалдаг.

Би хүрхрээ гэдэг үгд дуртай. Хүрхрээ. Хүрхрөөн дор зогсож

Христийн
дотор хүч
чадал ба
алдар
оршдог.

үзсэн үү? Хэмжээлэхийн аргагүй хүчтэй их ус дээгүүр чинь асгаад л. Хэрэв ус асар өндрөөс унавал, манан үүсдэг. Тэгвэл Бурханы хайр руу ойртдог хүмүүсийг Бурханы ер бусын нигүүлслийн манан хучдаг. Энэ хүрхрээ чинь нарийхан горхи байх аа гэж бодох гэж байвал, энэ ишлэлийг үз дээ:

Түүний нигүүлслийн баялгаар бидэнд Түүний дотор цусных нь золилт, гэм нүглийн маань төлөөх уучлал бий. (Ефес 1:7)

Хүрхрээ мэт нигүүлсэл. Христээс гадуур би дусал ч нигүүлсэл, өршөөл хүртэх эрхгүй хүн. Би санах, санахгүй нүглийнхээ толбоны бүрэн жинд дарагдах л эрхтэй хүн. Түүний гадна би ийм л хүн.

Гэтэл...

Биднийг гэх Түүний хайр нь бидний татдаг амьсгал шиг л ойрхон, дэлхийг бүслүүрдэн үлээдэг салхи шиг л хол хүрдэг юм.

Биднийг гэх Түүний хайр давтагдашгүй онцгой содон юм.

Биднийг гэх Түүний хайр бүхнийг багтаадаг. Бидний нэг ч хэсэг Түүний хайраас зугтахгүй. Тэр хэнийг маань ч орхилгүй хайрладаг.

Хайр нь Бурханы мөнхийн талбартай холбогдох холбоо юм. Би Бурханы хайрыг бат бэх гэхдээ, энэ нь ганхашгүйгээс гадна мятрашгүй гэдгийг хэлсэн. Бурханы хайр биднийг мөшгиж, зогсоо зайгүй бидний анхаарлыг татдаг. Бурханы хайр үнэхээр тууштай дагадаг. Тэр үүнээсээ ч залгахгүй. Тэр бидний төлөө байдаг. Бид яаж ч дэмийрч байсан, Тэр биднийг хайрласаар л байна. Бид Бурханы хайрын эсрэг босч болно. Гэхдээ эцсийн дүнд энэ хайр ялагдашгүй шүү дээ.

Хайр ялсан

Өнөөдөр #ХайрЯлдаг гэдэг хаштагийг их хэрэглэх болжээ.

Бурхан хайр учраас, хайр ялахаас өөр яах билээ. Энэ мөнхийн ялалт хэдийнээ тогтсон учраас, #ХайрЯлсан гэвэл илүү зөв болох байх. Хайр ялдаг гэдэг нь одоо юмуу ирээдүйд бий болох ялалтыг илтгэнэ. Би яагаад энэ тал дээр ийм эрчтэй үзээд байгааг та гайхаж

байгаа байх. Гэхдээ бөмбөрцөг дээр юу болж байгааг харах юм бол, #ҮзэнЯдалтЯлдаг гэмээр л харагддаг. Би зүгээр нэг хайрын гялбаа хармааргүй байна. Гэхдээ үзэн ядалт хэзээ ч ялж чадахгүй. Яагаад гэвэл үзэн ядалт мөнхийн биш, харин хайр мөнхийн. “Хайр ялдаг” гэдэг нь хувьсамтгай үг юм. Яагаад гэвэл үнэндээ хайрын ялалт цаг хугацаанаас ч өмнө бидний төлөө тогтоогдсон юм. “Хайр ялсан” гэдэг нь биднийг бүтээгдэхээс ч өмнө, бидний оролцоогүй тогтоогдсон ялалтыг мэдэгддэг. “Ялсан хайрыг” бид хүчингүй болгож чадахгүй. Үүнийг бид хүндэтгэлээрээ баталгаажуулж болно.

Хайр биднийг хайрлахаас ч өмнө ялжээ.

“Байж боломгүй хайр” гэдэг үг л Бурханы адамант - бат бэх хайрыг дүрслэх юм уу даа:

Намайг үг хэлэхээс өмнө

Та намайг бүүвэйлсэн.

Та надад дэндүү

Сайн хандсан.

Намайг амьсгаа авахаас өмнө

Та Надад амиа үлээсэн.

Та надад дэндүү

Зөөлөн хандсан.

Үгээр хэлэшгүй, эцэс төсгөлгүй Бурханы хайр

Ерэн есөө ардаа орхиод, намайг олон олтлоо

Мөрдөн мөшгисөн хайр.

Би ингэж хайрлуулах эрхгүй

Би ингэж хайрлуулах зохисгүй ч,

Та миний төлөө Өөрийгөө өгсөн.

Ойлгохын аргагүй, энгүй Бурханы хайр.

Тантай дайсагнаж явахад минь ч

Та намайг хайрласан.

Та надад дэндүү

Өршөөнгүй хандсан.

Хэн ч биш байхад минь
Та миний өрийг төлсөн
Та надад дэндүү
Сайн хандсан.

Миний араас Та
Бүх сүүдрийг гэрэлтүүлнэ
Бүх ууланд авирна.
Бүх ханыг нураана.
Миний араас Та
Бүх худлыг бут ниргэнэ.²

*Тэнгэрийн Бурхан Аав минь,
Таны хайр үнэхээр “байж боломгүй хайр” юм. Намайг
хайр дотроо тамгалж, намайг хайрлахаар сонгож,
анхны маань амьсгалаас амьдралыг маань төлөвлөсөнд
баярлалаа. Өнөөдөр би намайг хайрласан Таны хайрыг
сонгож байна. Бидний хоорондох саад зайлтал намайг
бат бэх хайрласанд баярлалаа. Бидний хоорондох бүх хана,
худлыг нураагаарай. Амень.*



5

БИЕ БИЕЭ ХАЙРЛАХДАА АДАМАНТ (БИЕ БИЕЭ ХАЙРЛАСАН ШИГ ХАЙРЛАХ)

Дайсныг найз болгон хувиргах чадалтай ганц хүч
бол хайр юм.

Мартин Лютер Кинг Жр.

Бурхан Аавын маань дотно хайр, байнгын халамжийг зэрэг дүрслэн харуулах нэгэн түүхийг би чамд ярьж өгмөөр байна.

Би саяхан Иракт очлоо. Би Дубайд номлохоор уригдсан бөгөөд би үүнийг “Давуу хайр” гэдэг үйлчлэлийг эргэж очих сайхан боломж гэж үзэв.

Эхний өдөр би Жессика, Жерми хоёрыг Айсисийн халдлагаас болж орон гэрээ орхин зугтсан Яасиди дүүрвэгсдийн хуаранг эргэхэд нь дагалдан явлаа. Би Арабаар бас Курд аялгаар ярьдаггүй учраас, Жессикаг тэр эмэгтэйчүүд, гэр бүлүүдтэй харилцаж, саван хийхийг зааж өгөхийг нь харж явав.

Тэр сайхан хүмүүс яаж хариу хандаж байсныг би одоо ч санаж байна. Тэд Жессикаг хараад л нүүр нь гэрэлтээд л. Жессика тэдний хувьд олон талаараа найдвар нь болж, итгэлийг нь даасан хүн болжээ. Тэд Жессикагай халуун дулаанаар мэндчилж, байгаа идээ ундаагаараа дайлж байлаа. Тэд майхан дотор, блокон өрөө, контейнер, хаягдсан том машины чиргүүл дотор амьдарч байв. Хамгийн сүүлд бид шөнөөр хагас ачааны чиргүүл дотор хоног төөрүүлж байгаа 14 хүн дээр очив. Жаахан хүүхдүүд нь Жессикаг угтан гүйж ирээд, тойрч бүчээд, сурсан Англи үгсээ давтан хэлж гайхуулна.

Гэтэл тэр дунд нэг жижигхэн охин нүүрээ нуугаад л, гэдрэг ухраад л байв. Жессикаг суугаад, хэдэн дүүрвэгч эмэгтэй, хэсэг эрчүүдтэй ярьж байхад, бяцхан охид түүн дээр шавалдаж байлаа. Гэтэл нөгөө охин холхон суусаар. Түүний аав нь Айсист алуулсан бөгөөд харин ээж нь тэр үед эзгүй байгааг би олж мэдэв. Тэгээд түүнд татагдлаа. Охины талаар Жессикагаас асуугаад, тэрбээр хорт хавдраар нэг нүдээ алдсаныг нь мэдээд, зүрх маань түргэсэв. Тэгээд охиныг дуудаад, бид хоёрын яриаг орчуулж өгөхийг Жессикагаас хүслээ. Би түүнийг 7 орчим л настай байх гэж бодов. Охин олны ятгалгыг дагасан боловч, тээр шаасан байдалтай, дургүйхэн хүрч ирэв.

Би түүнийг өвөр дээрээ суулгахдаа, шал танихгүй хүнээр онцлуулан дуудуулах нь ямар эвгүй болохыг ойлгож байлаа.

Гэхдээ Сарах бид хоёр дэндүү олон талаараа адилхан болохыг Сарах мэдэхгүй байв.

Тэгээд би түүнд 5 настай байхдаа, хорт хавдраар нэг нүдээ авахуулснаа хэллээ. Тэр эргэж хараад, намайг үнэн хэлсэн эсэхийг мэдэх гэсэн шиг нүүрийг минь цоо ширтэв. Дараа нь тэнд суугаа бүх хүний нүүрийг нэг нэгээр нь шинжив. Би тэр үед түүнийг “Намайг ойлгодог хүнийг оллоо” гэж бодсон болов уу гэж би боддог юм.

Би хармаанаасаа Айпадаа гаргаж ирээд, Сарахд гэр бүлийнхээ зургийг үзүүлэнгээ чихэнд нь шивэглэсэн үгсийг маань Жессика тун хичээнгүй орчуулж өгч байлаа.

“Сарах, чи мөрөөд. Чи гэр бүлтэй болно. Сарах чи Бурханы зүрхэнд чинь суулгасан бүхнийг хийж чадна.”

Нүдээ алдсан болохоос, амиа алдаагүй гэдгийг Сарах мэдээсэй гэж би хүсч байлаа.

Түүний туулсан амьдралын дэргэд нүдээ алдах нь өчүүхэн хэрэг байсан байх. Гэхдээ л эрхтэн дутуугаасаа болоод би түүнийг өөрийгөө дутуу гэж бодоосой гэж хүссэнгүй.

Жессика намайг нэг нүдгүй гэдгийг мэдээгүй байсан болохоороо Сарахын нүдийг цэвэр байлгах ямар хэцүү байсныг учирлан тайлбарлав. Хиймэл нүд нь байнга шороогоор бохирдоно. Би түүний нүдийг зөөлөн хаах гэж үзсэн боловч, болохгүй байв. Тэр хиймэл нүд том хүнд зориулагдсан болохоор, хүүхдэд томдоод, нүдээ хаах боломжгүй болгож байжээ. Жессика Сарахд энэ нүдийг олж өгөх гэж бөөн юм болсон тухайгаа хэлэв. Тэгээд Иракаас олдсон нь л энэ байжээ.

Би буцаад машин руугаа явахдаа, Сарахын гараас хөтлөөд явж байлаа.

Бид хоёр хоёулаа чимээгүй байв.

Тэр шөнө би Кортнигийн гэрт тэр охины тухай бодоод, нойр хулжин хэвтэж байв. Би ямар ч утгагүй, тийм харгис халдлагаар аавыгаа алдахын зовлонг мэдэхгүй, би мэддэг бүхнээ орхиод явна гэж юу байдгийг мэдэхгүй. Би тэр бүх болсон явдлыг буцааж чадахгүй. Гэхдээ би түүний нүдний талаар ямар нэг юм хийж чадах юм шиг санагдаж байлаа.

Хэдэн сарын дараа би Жессикаг Америкт ирсэнийг дуулаад ярьтал, бид хоёр Калифорнид яг нэг уулзалтад оролцох гэж байв. Колорадо Спрингс дэхь миний нүдний эмч Митчел Маёо Яасиди хүүхдүүдтэй ажиллаж байсан туршлагатай бөгөөд тэдний нүдний өнгө маш түвэгтэй байдгийг мэддэг байлаа. Тэгээд тэрбээр дуртайяа Сарахд зориулж хэд хэдэн хүүхдийн хэмжээний хиймэл нүд хийж өгөхөөр болов.

Жессика бид хоёр Калифорнид уулзаад, миний видео мэндчилгээг Жессика очоод Сарахд орчуулж өгөхөөр болов.

Тэр өдөр Жессика илтгэв тавив. Тэгээд надтай уулзсан явдал Сарахын зүрхэнд яаж хүрсэн талаар ярихад, би ч уйлаад л сонсоод байлаа. Тэр гологдмол жаахан охинд анхаарснаараа, би түүнийг гүнжийн байр суурьд тавьжээ.

Бидний Эзэн ч ингэдэг бус уу? Тэрбээр харагдахыг хүсдэггүй нэгэнд хүрч, мөрөөдөх зөвшөөрлийг олгодог.

Жессика Иракт очоод, Сарахд нүдийг нь өгчээ. Энэ нүд Сарахын хувьд ямар чухал байсныг Жессика Инстаграм дээрээ

бичсэн байсныг нь би та нарт шууд хуулаад бичлээ.

Лиза түүнд хэзээ ч мартагдаагүй, үзэсгэлэнтэй, хүссэн бүхнээ хийж чадна, Бурхан түүнд маш их хайртай гэж хэлж байхад Сарах Лизаг ширтсээр байлаа! Би түүнд энэ үгийг орчуулж өгөхөд, тэрбээр асгартал уйлсан бөгөөд би түүнийг амьдралдаа хичнээн удаа “үзэсгэлэнтэй, нандин, хэзээ ч мартагдаагүй, үргэлж бодолд байдаг” гэдэг үгийг сонссон бол гэж бодсон юм.

Тэгээд Жессика Сарахын ээж нь түүний хуучин нүдийг шинээр сольж өгч байгаа зургийг тавьсан байв. Юу болохыг нь үзэх гээд, бөөн хүмүүс тойроод зогсчихсон харагдана. Нэг хамаатны ах нь тэдний бие биеэ гэх хайр, халамжийн талаар үг хэлэв. Нэг хамаатны эгч нь Сарахын бяцхан өөрчлөлтөд сэтгэл догдлон зогсоно. Сүүлийн хэдэн зураг энэ түүхийг бүхлээр нь өгүүлсэн байв: Амь насанд аюултай хорт хавдраас болж нүдээ алдаад, Иракаас олдсон болхи, хуванцар нүдтэй Сарах шинэ нүдтэй болж, гэр бүл, найз нөхөд нь түүнийг хүрээлэн баярлалдана. Жессика энэ өөрчлөлтийг ингэж тайлбарласан байв.

Энэ жаахан охин хичнээн өөрчлөгдсөнийг та нар мэддэг ч болоосой. Тэр зураг авахуулахдаа урьдынх шигээ ичэхгүй, харин тэргүүнээ бардам өргөдөг болжээ. Эсвэл өчигдөр бид хамтдаа өдрийн хоол идэхэд, яриаг хөтлөн удирдахыг нь хараад, зан авир нь тэс өөр болсон түүнийг бид бараг л танихгүй байлаа. Хайр бүхнийг өөрчилдөг. Хайр энэ жаахан охиныг бас тэр нийгмийг бүхлээр нь өөрчилжээ.

Бурхан хэзээд сайн. Түүний хайр мөнхөд нэг л янзаараа. Бурхан намайг надтай адил хорт хавдраар нэг нүдээ алдсан тэр жаахан охинтой уулзуулах гэж Иракт аваачсанд нь би Бурханд үнэн голоосоо мэхийдэг. Тэр охинд Өөрийнхөө хайрыг мэдүүлэх гэж л тэр.

Хайрын загвар

Ээж бид хоёр харилцааны асуудалтай байсан гэх нь дэндүү зөөлдсөн хэрэг болно. Миний санаж байгаагаар бид хоёрын дунд байнгын хурцадмал байдал оршдог байлаа. Сүүлийн арван жил би түүн рүү залгах тоолонд яриа маань тэр даруй заавал ямар нэгэн үл ойлголцол болж хувирдаг байв. Тийм боловч одоо би бидний бие бие рүүгээ шидэлцдэг байсан хатуу хөтүү үгсийг барагтай л санадаггүй.

Гэхдээ би хэлж амжаагүй үгсээ санадаг юм.

Би түүнд хайртай гэдгээ арай ахиухан хэлж байхгүй яв даа. Хайраа илэрхийлэх тал дээр ээж бид хоёр нэг нь Италиар, нөгөө нь Англиар ярьдаг байлаа. Харамсалтай нь би дэндүү оройтох хүртлээ Итали хэл сурахаас татгалзсан юм. Тийм ээ, ээжийнхээ амьдралын сүүлийн сар би ээждээ хэлье гэж бодсон бүх зүйлээ хэлсэн л дээ. Би ээждээ хайртай гэдгээ хэлсэн. Тэгээд зовоосон бүхэндээ уучлал гуйсан. Би эмнэлгийн орон дээр хэвтэх ээжийнхээ өөдөсхөн биеийг төмөр төхөөрөмжид залгаатай хамаг дусал энэ тэрийг нь гэмтээчихгүйхэн шиг эвтэйхэн тэвэрч хэвтэнэ. Гэтэл ээж маань намайг налаад, ганц үг шивэглэв. Тэгсэн чинь л хамаг далан нураад ирэв. Бид хоёрын хэн хэн нь өнө мөнхлөлийн наана буй энэ дэлхий дээр бие биеэ хайрлах хугацаа дэндүү бага байгааг мэдсэндээ харуусан уйлсан юм. Тэгээд сар ч хүрэлгүй хугацааны дараа ээж маань явчихаж билээ.

Бодит байдлын харууслыг өнө мөнхийн талаарх амлалт л зөөллөх юм даа. Тийм боловч харуусал гэдэг хатуу эзэн. Өмнө нь би харууслын ялыг хүлээн авч, нэг бол шалтаг тоочиж үгүй бол бусдыг буруутгаж харуусдаг байлаа. Гэхдээ цаг хугацааны явцад би тэс өөр боловч, илүү амаргүй хандлагыг үрчилж авсан юм. Би алдааныхаа эзэн болсон юм. Энэ нь шархыг шахаж гаргадаг учраас, эхэндээ илүү зовиуртай байв. Тийм боловч зоригтон минь, айлгүй хий. Эцсийн эцэст энэ чинь чамайг шаардлагагүй зовиураас аврах болно.



Гэхдээ
би хэлж
амжаагүй
үгсээ
санадаг юм.

Уг нь би ээжийгээ эртхэн л хайрлах ёстой байсан юм. Би түүнийг хайрлах хавьгүй хүчтэй байр суурьтай хүн байсан боловч, хайрлаагүй. Би өнгөрснийг өөрчилж чадахгүй боловч, цаашдаа хэрхэн амьдрахаа ойлгосон. Би харуусаад л, насан турш гунигтай амьдарч болно эсвэл алдаагаа бусдын хувьд сургамж болгож чадна. Чи алдааныхаа эзэн болж чадбал, алдаа чинь цаашид чиний эзэн байхаа болино. Чи эелдэг үг, халуун дулаан зан эсвэл өгөөмөр зангийн үйлдэлдээ хэзээ ч харуусахгүй боловч, харин хэзээ ч өгч чадаагүй хайрынхаа төлөө харуусах болно.



Чи
алдааныхаа
эзэн болж
чадбал,
алдаа чинь
цаашид
чиний эзэн
байхаа
болино.

Хөөрхөн найз минь, хайрласан шиг хайрла. Тэгвэл чи амьдарсан шиг амьдарна. Хайр бол өөрчлөгч хүчин зүйл. Биднийг дэндүү хайрладаг, тэнгэрийн Аав маань биднийг бас бие биеэ дэндүү хайрлаасай гэж хүсдэг. Бидний дайсан гэж дууддаг маш олон хүн зүгээр л хайрыг хүссэндээ бусдад хатуу ханддаг хүмүүс байдаг. Христийн дагалдагч бидэнд тэднийг хайрлахгүй байх сонголт байхгүй. Бие биеэ хайрлах нь зөвлөгөө биш, харин тушаал юм: “Би та нарыг хайрласны адилаар та нар бие биенээ хайрлагтун. Энэ Миний тушаал.” (Иохан 15:12)

“Би та нарыг хайрласан шиг” гэдэг таван үг л хамгийн хэцүү.

Есүс бидний үлгэр жишээ.

Би ээжийнхээ намайг хайрладаг хайрыг үлгэр жишээ болгосноороо алдсан. Дийлэнх амьдралынхаа турш ээж бид хоёр хоёр алхам урагшаа хоёр алхам арагшаа гэдэг хачин бүжиг хийхдээ, хэн нь ч юунд ч хүрээгүй юм. Ээж өнгөрөхөөсөө жилийн өмнө бидний хоорондох хурцадмал байдал чамаас болоогүй шүү гэж хэлж билээ. Зүгээр л тэр надтай хэзээ ч дотносоогүй гэв. Хэдийгээр ээж маань надад тус болж байна гэж бодсон боловч, ээжийн маань үг намайг өвтгөж байлаа. Ээж маань тэр үгээрээ намайг чөлөөлөх гэсэндээ л тэгж ярьсан байх.

Гэхдээ ээж хүүгийн хэврэг холбоо одоо надад хамаагүй ээ. Ээж бид хоёр угаасаа Христийн дотор холбоотой болсон.

Гэхдээ би ээжийгээ Есүс намайг хайрласан шиг хайрласан бол, энэ бүхэн хичнээн өөр байх байлаа.

Тэгэхээр загварын дагуу хийнэ гэж юу гэсэн үг вэ? Үүнд хариулахын тулд би ахлах ангид сурч байсан үе рүүгээ очмоор байна. Тэр үед бид гэр ахуйн хичээл дээр оёдол сурдаг байлаа. Бид бор цаасан эсгүүр дээр бүдүүнээр тэмдэглэсэн зураасын дагуу хайчилж, хатгана. Үндсэндээ даавуугаа хайчлахаасаа өмнө загвараа хүндээ тааруулах гэж л тэр.

Хожим би өөрөө юм оёхдоо, зааврыг нь уншиж байгаад, дараа нь аль болох хялбарчлах арга ухаан хайдаг байв. Тэгээд би хурдан дуусгахын тулд оёдлыг нь алгасдаг байлаа. Тэгээд юу болсныг ухаантай хүмүүс мэдэж байгаа байх. Хувцас нэг хэсэгтээ гайгүй харагдах боловч, төдөлгүй сэмэрч, урагдана. Хайранд ч, оёдолд ч түргэсгэх арга байхгүй, зөвхөн загвараа л баримтлах ёстой.

Бусдыг хайрлах тал дээр олон хүн харилцааны даавуугаа бэлтгэх тэр их цагийг товчлохыг хүссэндээ оёдлоо дуусгадаггүй гэлтэй. Бид ангархайг нь хаагаад л, гаднаасаа бэлэн болчихсон мэт болгодог ч, дотор талд нь баахан урт утас, овоорсон даавуу байж байдаг. Бид товчлохыг хүсэхдээ “Би Христэд итгэдэг гэр бүлд өсөөгүй, би хайрлахыг мэдэхгүй, чадахгүй” гэж шалтаг тоочдог.

Гэхдээ Есүс чамайг хайрласан шиг хайрла гэсэн. Заримдаа жаахан хийсвэр санагдана. Өдөр бүр шууд дагаад явчих Библийн тодорхой жишээг олох хэцүү. Гэхдээ би нэг зүйлийг сурсан юм: Хэрэв би өөрөө хүн намайг хайрлаасай гэсэн шигээ бусдыг хайрлах юм бол, дэндүү буруудна гэж байхгүй.

Бид аав, ээжийнхээ хайраар хязгаарлагдахгүй. Энэ бол сайн мэдээ. Эцсийн эцэст ээж, аав маань бидний хайрын үлгэр загвар биш, харин Есүс бидний үлгэр загвар юм. Харин түүний үлгэр загвар бидэнд бүгдэд маань нээлттэй. Есүс хүмүүсийг хайрлахдаа үнэнийг хэлдэг байсан. Тэр үнэнээр амьдарч, хүмүүсийг чөлөөлж, өвчтэйг эдгээж, хаа очсон газраа Аавынхаа зүрх сэтгэлийг харуулдаг байсан.

Хайрлахдаа үнэнийг ярих

Хайрлах гэдэг нь хүнд алдааг нь хэлж өгөх гэсэн утга илэрхийлэх үе бий. Бид өөрсдөө харж чадахгүй ан цав, үл үзэгдэх хэсэг бидэнд бий. Есүсээс асуух юм бол, Тэр бидний зүрхийг үнэн байлгахын тулд бидний талаарх үнэнийг хэлнэ.

Нэгэн нэр нөлөө бүхий, баян хүн Есүсээс мөнх амьдрахын тулд юу хийх ёстой вэ гэж асуухад Есүс:

“Есүс түүнийг ширтэн харж, хайрлан —Чамд нэг л юм дутаж байна. Явж, өөрийн гэсэн бүхнээ зарж, ядууст өг. Тэгвэл чи тэнгэрт эрдэнэстэй болно. Тэгээд ирж, Намайг дага” (Марк 10:21) гэжээ.

Тэр “ганц зүйл” нь тэр хүний хувьд бүх зүйл нь байжээ. Тэр хүний хүлээстэй зүрхэнд юу хэрэгтэйг Есүс мэдэж байжээ. Тэгвэл



**Хайр
СОНСОГДОХЫН
ТУЛД ЯРЬДАГ.**

чамд хэрэгтэй ганц зүйл нь хэн нэгнийг уучлах юмуу чи Бурханд хамаатай гэдэгт итгэх явдал байж болно. Тэр нь юу ч байлаа гэсэн, Ариун Сүнс чиний зүрхийг хэрхэн тайлахаа мэднэ. Бидэнтэй л адил тэр залуу баян захирагч хүчин чадлаар дүүрэн боловч, эрдэнэсээ буруу газраа хадгалсан байжээ. Тэрбээр эрдэнэсээ зүрхнийхээ байх ёстой газар буюу өнө мөнхлөлд хадгалах ёстой байжээ. Есүс түүнийг хараад, зүрхнийх нь хашхирааг сонсоод, хайрлаж, үнэнийг хэлсэн юм.

Хайр бидний үгээр харагддаг. Хайр бидний үгээр ч, дуугүй өнгөрөхөөр шийдсэн зүйлээр ч харагддаг. Хайр бидний дууны өнгөөс л харагддаг. Бид зөв зүйлийг буруу сүнсээр хэлдэг. Тэр бүү хэл, буруу зүйлийг зөв сүнсээр хэлсэн ч, энэ нь ялгаагүй л буруу байна.

Хайр сонсогдохын тулд ярьдаг.

Заримдаа хайр нь зүгээр л шивэгнээ байдаг бол, заримдаа үнэн голоос гарсан хашхираа байдаг. Хайрладаг хүн дууныхаа өнгийг олдог.

Хайр бусдыг өргөдөг

Заримдаа хайрлах гэдэг нь Аавын маань үгс, санааг шашин яаж мушгин гуйвуулсныг илчлэхийг хэлнэ. Лук 13-аар бүлгийг харъя:

Есүс Амралтын өдөр нэгэн синагогт сургаал зааж байлаа. Үзэгтүн, сүнснээс болж арван найман жилийн турш өвчтэй байсан нэгэн эмэгтэй тэнд байв. Тэр бөгтөр болсон учир ер цэх зогсож чаддаггүй байжээ. (10-11)

Арван найман зовлонг жилийн дараа тахир татуу сүнс тэр эмэгтэйг бөгтийлгөсөн байв. Тэр өөрийгөө ч бөгтөр гэдгийг мэддэг байжээ. Магадгүй түүнд улам хичээ, сайн залбир, нүглээ гэмш гэж хэлсэн байх л даа. Тэгээд тэр ичсэн байх. Тэр өөдрөг байхыг хүссэн ч, яагаад ч өөдрөг болсонгүй. Тэрбээр арван найман жил синагогийн удирдлагын тав тухыг алдагдуулж байгаагаа мэдэж байсан ч, хүрээд л иржээ. Түүний хувьд Бурхан л цорын ганц найдвар нь байв. Магадгүй түүний мэдрэмж чамд танил байх.

Гэтэл залуу рабби Есүс сургаалаа зааж байв. Эмэгтэй хэдийгээр биеийн байдлаасаа болоод Түүнийг сайн харахгүй байсан ч, ямар ч байсан Түүний үгийг сонсов. Есүсийн үг түүний сэтгэлд хүрч... хацраар нь нулимс урсав. Эмэгтэй өөрөө мэдэхгүй байсан ч, Хайр өөрийг нь анзаарчээ. Юу болсон бэ? Есүс тэр эмэгтэйд хандаж ярьсан уу? Эмэгтэй Түүнийг харахаар хоёр тийшээ өнгөлзөв.

Есүс түүнийг хараад, дуудаж —Эмэгтэй, та өвчнөөсөө чөлөөлөгдлөө гээд түүн дээр мутраа тавихад даруй тэр цэх болж, Бурханыг алдаршуулж эхлэв. (12-13)

Есүс эмэгтэйгээс чөлөөлөгдөхийг хүсч байгаа эсэхийг асуугаагүй. Бас шашны удирдагч нараас ч зөвшөөрөл аваагүй. Есүс эмэгтэйн бөгтөр нуруунд хүрэхэд, эмэгтэйд эрүүл мэнд нь эргэн ирж, зүрхнийх нь цохилт түргэсэв. Цээж нь онгойж, түгжирсэн нуруу нь дахин цэх болж, тэрбээр бүтэн тэнийгээд, хоёр гараа тэнгэр өөд сунгажээ. Тэгээд уруулаас нь өөрийн эрхгүй магтаал урсав.

Хайр түүнийг хараад, дуудаж, түүн дээр эрх чөлөө, чөлөөлөлт,

найдварыг тунхаглаж, түүнд хүрчээ. Есүс Аавынхаа хэлснийг л хийдэг байсан учраас, энэ эдгэрэл нь Аавын үзэсгэлэнтэй үзүүлэн байв. Харамсалтай нь түүний баяр хөөрийг бүгд хуваалцаагүй юм.

Есүс Амралтын өдөр эдгээсэнд зэвүүцсэн синагогийн захирагч хурсан олонд хандаж —Ажил төрлөө амжуулах ёстой зургаан өдөр байдаг. Тиймээс Амралтын өдөр биш харин өөр өдрүүдэд л ирж эдгээлгэ гэхэд... (14)

Эмэгтэй баярлаад л, удирдагч чарлаад л. Ажил төрөл өө? Эдгэрэл нь хэдийдээ хүний ажил болчихоов? Эдгэрэл хэзээд Бурханы л ажил байсан. Синагогоос өөр эдгээх шилдэг газар бий гэж үү? Хайр тэдний шашны үлгэр загварыг эвджээ. Тиймээс Есүс хариу галлав:



ҮЙЛСГҮЙ
ИТГЭЛ НЬ
ҮХМЭЛ
БАЙДАГ
ШИГЭЭ,
ХАЙРГҮЙ
ҮЙЛДЭЛ НЬ
УТГАГҮЙ ЮМ.

Эзэн түүнд —Хоёр нүүртнүүд ээ, та нарын хэн чинь Амралтын өдөр үхэр, илжгээ саравчнаас нь гаргаж, услахаар дагуулан явдаггүй вэ? Абрахамын охин энэ эмэгтэйг Сатан арван найман жилийн турш хүлээтэй байлгажээ. Тэгвэл энэ эмэгтэй Амралтын өдөр тэрхүү хүлээснээс ангижрах ёсгүй болж байна уу? гэв. (15-16)

Бурханы охины чөлөөлөлт шашны хориг дээр шударга ёсыг тогтоожээ. Бурхан үр хүүхдээ үхэр, илжгээс дор үзнэ гэж байх уу даа? Саббат нь амралт, сэргэлтийн төлөө буй. Алив төрлийн дарамт бүр нь Саббат өдрийн Бурханы зорилгын эсрэг байдаг! Тэр Абрахамын охин байсан. Бурхан хүүхдүүдээ чөлөөлөхийн төлөө бат бэх байдаг учраас, зүрх сэтгэл нь үйлдэл болжээ.

Түүнийг ийн айлдсанд эсэргүүцэгчид нь бүгд ичгүүрт оров. Харин ард олон Түүгээр үйлдэгдэж буй гайхамшигт бүх зүйлсэд баярлацгааж байлаа. (17)

Харамсалтай нь хүнийг ч, шашныг ч нэгэн зэрэг хайрлах хэцүү байдаг. Хэрэв та энэ уулзвар дээр байгаа бол, доктриноос илүү хүнийг хайрлаарай. Хайр нь худлыг байлдан дагуулж, мэхлэлийг ялан дийлж чаддаг бол, үзэн ядал, шүүх нь хүнийг түлхдэг. Итгэл нь хайраар л ажилладаг. Хайр нь заримдаа үнэнийг хэлэх бол, заримдаа үнэн байх юм. Энэ хэсэгт Есүс аль алийг нь хийжээ. Энэ хүлээстэй охиныг чөлөөлснөөрөө Есүс хүний шашны бодлого, үйлдлийг ниргэн, Бурханы хайрыг харуулсан билээ.

Үйлсгүй итгэл нь үхмэл байдаг шигээ, хайргүй үйлдэл нь утгагүй юм.

Хайргүй үйлдэл

Хэрэв би хүмүүсийн болон тэнгэрэлч нарын хэлээр ярилаа ч надад хайр үгүй бол би хий нүргэлэх харанга, хангинах цан аж. Хэрэв би эш үзүүлдэг мөн бүх нууц болон бүх мэдлэгийг мэддэг байгаад, уулыг нүүлгэх бүрэн итгэлтэй байлаа ч, надад хайр үгүй бол би юу ч биш. Хэрэв би бүх өмч хөрөнгөө тараан өгч, биеэ шатаахаар тушаасан ч надад хайр үгүй бол энэ нь надад ямар ч ашиггүй юм. (1Коринт 13:1-3)

Энд хэлсэн олон сайхан зүйл нь хайр гэдэг хүчин зүйлгүйгээр бүрэн гүйцэт болохгүй. Тэдгээрт дуу хоолой, мэдлэг, итгэл, өгөөмөр зан орно. Бидэнд байгаа аливаа бэлэг, талант нь хүмүүсийг бидэн рүү биш, Эзэн рүү дагуулах ёстой юм. Чи орон сууц, машин гэх мэт хамгийн сайхан бэлэг хүлээн авах юмуу эсвэл хэн нэгэн чиний коллежийн төлбөрийг бүрэн төлсөн бол, түлхүүрээ гардаж авахдаа эсвэл төлбөрөө төлсөн гэх баримтаа хүлээж авахдаа яах вэ? Бэлэг өгсөн хүнийхээ гарыг атгаад, тэврэх биш үү? Тэгвэл бидний сайн сайхан болгон Бурханаас биш гэж үү? Бүгд Бурханаас. Тиймээс л бид байгаа бүхнийхээ төлөө, тэр бүү хэл амь амьдралынхаа төлөө Бурхандаа талархах ёстой юм. Хайргүйгээр бидний бэлэг ямар ч гавьяагүй болно.

Паулын нэрлэсэн бэлгүүдийг нэг бүрчлэн авч үзье.

Дуу хоолой

Өнөөдөр бид маш эрч хүчтэй, үнэмшил төрмөөр, байлдан дагуулагч хүмүүсээр дүүрэн эрин цагт аж төрж байна. Тэд янз бүрийн хэлбэр, үйл ажиллагаатай; өнөөдөр олон талбар дээр маш олон дуу хоолой бидний анхаарлыг татах гэж тэнхээгээрээ хашхичиж байна. Энэ бүх яриа, бичиг, нэвтрүүлгийн цаана юу байгааг мэдэх хэцүү. Ялгах ажиллагаа маань зүрхнийхээ хөрсийг боловсруулахаас эхлэнэ. Бид ярихдаа, өөрөөсөө зарим нэг хэцүү асуултыг асуух хэрэгтэй.

“Би хайргүйгээр зүгээр харагдаж, сонсогдохын тулд ярьж байна уу?” Бид бүгдээрээ л харагдаж, сонсогдохыг хүсдэг. Сонсогдох ч эрхтэй. Гэхдээ зовиур, бардамналаар эсвэл алдар нэрийн төлөө ярьж байвал, хүмүүсийн сонорт хүрэх нь өөрөө шагнал нь болдог.

Зүрхээ харж хандах гэдэг нь хайрласан сэдэл заавал хүмүүст хүрдэг гэсэн үг. Паул хичнээн сайхан үг ярьсан ч, хайрлахгүй бол, үг маань зүгээр л чихэнд чийртэй чимээ болно гэсэн.

Бурхан биднийг ямар санаагаар яриад байгааг мэднэ. Түүнчлэн бидний гадаад төрхийг нэвтрлэн, зүрхийг маань хараад, үгээс цаадахыг нь сонсдог... Бурхан тэр үгийн эх ундаргын дуу чимээг сонсдог. Тэр бидний хэлж байгаа уянгалаг эсвэл таагүй өнгө дууг сонсдог. Хайраар эгшиглэх хамгийн энгийн өгүүлбэр нь найрал хөгжим болдог. “Намайг уучлаарай!” гэх хоёр үг Түүний сонорт дэндүү сайхан сонсогддог бол, бардамналаар гарах хамгийн уран илтгэл нь хумсаараа самбар зорохтой адил хяхтнадаг.

Үйлс 12-аар бүлгийн дараах хэсэг нь сайн жишээ болно:

Товлосон өдөр Херод сэнтийдээ хааны хувцастай заларч тэдэнд үг хэлж эхлэв. Ард олон —*Хүний дуу биш, бурхны дуу байна* гэж хашхирч байлаа. Бурханд алдрыг өргөөгүй тул түүнийг тэр даруй Эзэний тэнгэрэлч цохижээ. Тийнхүү тэр өт хорхойд идүүлж үхэв. (21-23)

Муухай! Хүндэтгэл нь Бурханых юм. Ганган хээнцэр хувцастай Херод Бурханы алдраас хуваалцах гэж оролдоод дуусчээ. Нүд ирмэхийн зуур тэнгэрэлч түүнийг нам цохиж, тэрбээр өтний хоол болжээ. Ямар харамсалтай! Эмч нар дийлэнх хүмүүс их бага

хэмжээний шимэгч хорхойтой байдаг гэдэг. Энэ үнэн бол, түүний дотор харагдахгүй байсан зүйл нь гаднаа гарч иржээ. Тиймээс л элч нарыг бурхадтай андуурах үед тэд тэр даруй хувцсаа урдаг байсанд гайхах хэрэггүй. Үйлс 14:14-15 дээр энэ тухай ярьдаг:

Харин элч Паул, Барнаб нар үүнийг сонсоод, хувцсаа хүү татаж, ард олон уруу яаравчлан гарч очоод хашхиран Эрчүүд ээ, та нар юунд ингэнэ вэ? Бид та нартай адил жирийн хүмүүс шүү дээ. Та нарыг энэ дэмий хоосон зүйлээ орхиж тэнгэр, газар, тэнгис хийгээд тэдгээрт орших бүхнийг бүтээсэн амьд Бурхан өөд эргээсэй гэсэндээ бид та нарт сайнмэдээг тунхаглаж байгаа юм.

Үйлс 12 дээрх хэдхэн ишлэлийг харах юм бол, Херод мундаг үг хэлснээр барахгүй, сайн санааны үйлсээ зарлажээ. Херод Тир, Сидоны хүмүүстэй таарахгүй байсан учраас, сүүлдээ тэдний хүнсний хангамжийг зогсоосон байдаг. Тиймээс Тир, Сидоны төлөөлөгч нар энх тайвны хэлэлцээр хийхээр ирээд, Херодын туслах Бластыг урвуулан татжээ. Тэр хоёр хот хоол хүнсний хомсдолд ороод хэцүүдэж байв. Харин Херод үгээрээ эвлэрлийг тунхаглажээ. Энэ нь энх тайван, хоол хүнс гэсэн үг. Херод үгэнд нь орсон боловч, санаа нь цэвэр байсангүй.

Мэдлэг

1Коринт дээр дурьдсан дараагийн зүйл нь ирээдүйг урьдчилан хэлэх, амьдралын нууцыг тайлах, бүх мэдлийг эрхшээх юм. Энэ бэлэг нь дэлхийд гайхалтай бөгөөд ашигтай байж болох ч, хайр байхгүй хүнд огт тусгүй юм. 1Коринт 8 дээр хайр, мэдлэгийн зөрчлийг дүрслэжээ:

Мэдлэг ихэрхүүлдэг бол хайр босгодог. Хэрэв хэн нэгэн өөрийгөө ямар ч зүйлийг мэддэг гэж боддог бол тэрээр мэдэх ёстойгоо мэдээгүй л байна. Хэн Бурханд хайртай байна, тэр Түүгээр танигдсан. (1-3)

Би энэ зөрчлийн талаар нуршаад байлгүй, дээрх ишлэлийг ТиПиТи Библиэс шууд толилуулмаар байна:

Бид өөрийнхөө үзэл санаанд хичнээн амархан бардана вэ!
Гэхдээ хайр нь бидний шинэ амьдралын бүтцийг босгодог.
Өөрийгөө бүхнийг мэддэг гэж боддог хүн байгаа бол,
түүнд сурах зүйл бас л их байна. Гэхдээ хүн Бурханыг
үнэн голоосоо хайрладаг бол, тэрбээр Бурханы мэдлэгийг
эзэмшинэ.

Бидний мэдлэг бусдыг байгуулахгүй бол, санаа сэдлээ шалгах цаг болжээ. Ихийг мэдэх нь илүү их хайрлах боломж гэсэн үг. Бурханыг сайн мэдэх нь хэзээд бусдыг хайрлах хайр гэж ойлгогдох ёстой.

Сүүлийн хэдэн жил би хэд хэдэн сүнслэг охидтой болсон билээ. Тэд надтай танилын хүрээгээ тэлэх гэсэндээ бус, харин хайр, амийн үгийг заалгах гэсэндээ харилцаа холбоо тогтоожээ. Тэд миний гаргасан алдааг давтах ямар ч шаардлагагүй юм. Тэр үед л би тэднийг илүү өндөрт өргөснөөрөө өөрөө “хожиж” байгаагаа ойлгосон юм. Хайр толгойг дэлбэлэхгүйгээр, зүрх сэтгэлийг өргөдөг. Боловсрол хийгээд туршлага нь бусдыг өөрөөсөө дорд гэж үзэх зөвшөөрөл биш юм. Фарисайчууд, хуулийн багш нар мэдлэгийг яг л ингэж зүүдэг байжээ. Хайр байхгүй мэдлэг нь маш хязгаарлагдмал юм.

Бид бусдыг өргөхдөө, өөрийгөө Бурханы дотор илүү таньдаг. “Мэдэх ёстойгоо мэдэх нь” хүмүүсийг Христийн хайраар хайрлах гэсэн үг юм.

Хайр хэзээ ч доош нь хийдэггүй.

Хайр хэзээ ч гайхуулдаггүй.

Хайр хоригдлыг хорих бат цайзыг нураадаг.

Хайр хоригдол руу дайрдаггүй, харин чөлөөлөхдөө дуртай байдаг.

Бид хайрлахгүйгээр, хайрын тухай мэдэж болно. Яг л хүмүүсийг хайрлахгүйгээр, хайрын тухай ойлголтыг хүлээн авдаг шиг.

Бид хүмүүсийг хайрлахаар дуудагдсан. Бид дуртай хүнээ л хайрлахаар дуудагдаагүй. Бид санал нийлэхгүй хүнээ ч хайрлахаар дуудагдсан. Энэ нь итгэлдээ буулт хийх юмуу бусдыг үйлдлээрээ эргэлзүүлнэ гэсэн үг биш юм. Өнөөдөр манай соёл хайрыг зөвшөөрөлтэй хутгах болжээ. Гэтэл заримдаа жинхэнэ хайр нь хайраар үл зөвшөөрөх явдал байдаг. Энэ бол бидний өдөр бүр дээгүүр нь тэнцвэртэй алхах ёстой олс юм. Бид өдөр бүр хүмүүст мэдрэг хандах ёстой.

Хайрыг ярих биш, харин харуулах ёстой. Хайрыг харах үед таних амархан. Хайр нь сайхан мэдрэмж биш, харин амьдрах арга зам юм. Хайр нь олон талаараа хүн бүрийн хөгжүүлж чадах хамгийн мундаг дадал хэвшил мөн.

Шинэ өдөр
бүр нь
хайрлах
боломж
билээ.

Хуулийн багш нарын нэг ирж, тэдний маргалдахыг сонсоод, Есүс тэдэнд сайн хариулсныг мэдэж, Түүнээс —Ямар тушаал бүхний эхэнд байх вэ? гэж асуулаа. Есүс —Эхнийх нь “Сонс, Израиль аа! Бидний Бурхан Эзэн бол ганц Эзэн мөн. Чи Бурхан Эзэнээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаан, бүх хүч чадлаараа хайрла” гэсэн нь юм. “Чи хөршөө өөрийн адил хайрла” гэсэн нь хоёр дахь нь юм. Эдгээрээс илүү агуу өөр тушаал байхгүй гэлээ. Хуулийн багш Түүнд —Тийм ээ, Багш аа, Тэр бол Ганц бөгөөд Түүнээс өөр байхгүй гэж Та үнэнээр айлдлаа. Түүнийг бүх зүрх, бүх оюун ухаан, бүх хүч чадлаараа хайрлаж, хөршөө өөрийн адил хайрлах нь бүх шатаалт тахил хийгээд нядлах тахилаас ч илүү чухал юм гэв. Түүний ухаалаг хариулахыг Есүс хараад түүнд —Чи Бурханы хаанчлалаас холгүй байна гэлээ. Үүнээс хойш хэн ч дахиж Түүнээс юм асууж зүрхэлсэнгүй. (Марк 12:28-34)

Өнөөдөр ч бид олон талаараа Бурханы хаанчлалаас холгүй байна. Бид хаанчлалыг зайнаас хардаг ч, бидний итгэл, чуулганы үйлдэл хоёрын хооронд гүн ангал байх. Хайр нь энэ бүх асуултад цэг тавина. Хайр бүх асуудлын шийдэл юм.

Нэг нэгэндээ хайртай байхаас өөрөөр хэнд ч, ямар ч өргүй бай. Бусдыг хайрладаг хүн хуулийг биелүүлсэн хэрэг.
(Ром 13:8)

Хайр хуулийг биелүүлдэг. Хайр нь биднийг сэтгэл зүйн, биеийн, нийгмийн өрөөс чөлөөлдөг. Тэгээд бидэнд үнэгүй авсан зүйлийн буюу хайрын л өр үлдэнэ.

Сэрэмжтэй бай. Итгэлдээ бат зогс. Эршүүд бай, хүчтэй бай.
Бүх юм чинь хайр дотор хийгдэг. (1Коринт 16:13-14)

1Коринтын энэ хоёр ишлэлийн гол санаа нь хоорондоо холбоотой юм. Бүхнийг хайраар хийхийн тулд бидэнд төлөвшил, итгэл, тууштай байдал, сэрэмжтэй байдал, хүч хэрэгтэй.

Хайр биднийг үйлдэл рүү дагуулдаг. Надад концерт дээр Компэйшн байгууллагаар дамжиж хүүхэд дэмжих боломж олдсон юм. Ер нь манай байгууллага өнчин хүүхдийг дэмжих тал дээр бусадтай байнга хамтран ажилладаг. Гэхдээ энэ удаа би хувиараа дэмжих хэрэгтэй юм шиг санагдав. Тэгээд би гараа дэлгээд нэгэн багц хүлээн аваад хартал, яг надтай адилхан өдөр төрсөн жаахан охины зураг байлаа. Тэгээд яасан? Одоо тэр охины зураг миний компьютер дээр байнга байдаг. Тэр хайрын үйлдэл нь яг л миний хацар дээр Аавын маань шоп хийсэн үнсэлт шиг санагдсан юм.

Шинэ өдөр бүр нь хайрлах боломж билээ.

Бурхан хүмүүст хайртай учраас, бидний эрх чөлөө хүмүүст хүргэх Түүний хайранд садаа хийхийг зөвшөөрөхгүй. Хайр биднийг хүмүүст ухаантай нөлөөлөхөд хүргэдэг. 1Коринт 8 дээр Паул шүтээн юу ч биш гэдэг илчлэлийг тайлбарлаад, тийм боловч шүтээнд өргөсөн хоол ундыг идэх нь энэ илчлэлийг хүлээн аваагүй шинэ хүмүүсийг бүдрүүлэх аюултай гэдгийг хэлжээ. Тэрбээр 11, 12-аар ишлэлд энэ тухай тайлбарласан байна:

Тэгэхээр үндсэндээ, эрх чөлөөнийхөө ойлголтыг хэрэгжүүлснээрээ та нар Христийн амиа зориулсан, тэр сул дорой итгэгчийг сүйрүүлжээ. Тийнхүү та нар өөрөөсөө сул дорой итгэгчийг гомдоосноороо, та нар бас Тослогдсон Нэгэнийг гомдоож байна. (1Коринт 8:13)

Энэ ишлэл нь бусдын *төлөө* яаж амьдрахыг сургаж байна. Мэдлэг нь дангаараа “Шүтээн юу ч биш учраас, би хүссэнээ л иднэ. Үүнээс болж хэн нэг нь бүдэрч байвал, тэр л биз” гэж хэлдэг. Харин хайраар хавсарсан мэдлэг нь бусдын амьдралыг хэрхэн сайжруулахаа боддог. Энэ хослол нь “Шүтээн юу ч биш гэдгийг би мэднэ. Гэхдээ ах эгч дүүсийн маань хувьд энэ нь юу ч биш биш ээ. Би өөрийнхөө эрх чөлөөнөөс илүү ахан дүүгийнхээ төлөө санаа тавина. Би өөрийнхөө эрх чөлөөний үйлдлээр тэднийг эрсдэлд оруулж зүрхлэхгүй” гэдэг. Хайр нь бусдыг байгуулахын төлөө өөрийгөө хязгаарладаг.

Гэхдээ хайр нь бусдын айдас, саналд *хянуулна* гэсэн үг биш юм. Харин үүний оронд хайр нь сэрэмжтэй амьдардаг. Шүтээнд өргөсөн махыг идэх асуудал өнөөдөр бидэнд тулгардаггүй боловч, анхны чуулганд энэ нь маш мэдрэг, бодитой асуудал байжээ. Грекийн шинэ итгэгч нар хуучин ёс жаягаа шинэ амьдралтайгаа хослуулахыг зөвшөөрч чадахгүй байв. Цорын ганц үнэн Бурханыг мэдсэн хүмүүсийн хувьд хайрлах нь бусдын эмзэг талыг хүндэтгэх явдал байжээ. Хайр нь эрх чөлөөгөөрөө далайлган бусдыг шархлуулдаггүй.

—◆—

Хайр нь эрх
чөлөөгөөрөө
далайлган
бусдыг
шархлуулдаггүй.

Итгэл

Си. Эс. Люис хэлэхдээ, “Хөршөө *хайрлах* уу байх уу хэмээн төвөгшөөж цагаа бүү үр. Харин яг хайртай юм шиг үйлд. Үүнийг хийж чадсан хүн төд удалгүй хамгийн аугаа нууцыг тайлна. Та хэн нэгэнд хайртай юм шиг үйлдэхдээ, түүнийг жинхэнээсээ хайрладаг болно”¹ гэжээ.

Биднийг итгэлээрээ бас итгэл дотор хайрлах үед шаналсан дэлхий Аавын зүрхийг олж хардаг. Хайрлуулахаас хайрлах нь илүү чухал юм. Итгэлийн жинхэнэ хэмжүүр бидний хэрхэн хайрлуулснаас биш, харин хэрхэн хайрласнаас харагддаг. Тийм ээ, бид хайрлуулахыг л хүсдэг. Бид Аавынхаа биднийг гэх бат бэх хайрыг хүлээн авахдаа, Түүний дотор бусдыг хайрлах чадалтай болдог. Ингэж хайрлахад итгэл хэрэгтэй. Итгэл нь найддаг зүйлсийн

биелэл гэдгийг бид мэднэ. Бид бүгдээрээ л хайрлаж, хайрлуулахыг хүсдэг ч, итгэл байхгүй хайр гэж юу болохыг бидний хэн маань ч мэддэггүй. Галат 5:6 бидэнд: “Хозлуулахуй ба эс хозлуулахуйн аль нь ч Христ Есүс дор хүчингүй, харин *хайраар дамжин ажиллаж буй итгэл* л чухал юм” гэдэг.

Итгэл, хайр хоёрыг салгах арга байхгүй ... тэдгээр нь мөнхөд нягт холбоотой. Христийг дагаад, хажуугаар нь өөрийнхөө хүч, чадлаар хайрлана гэж байхгүйг Бурхан мэддэг учраас, бидэнд нэг бүрчлэн тодорхой хэмжээний итгэл өгчээ. Хайр нь хариугүй зүрхэнд тохирох зүйл биш юм. Харин итгэл нь хайр мэдрэхгүй байсан ч, хайрладаг.

“Хөршөө хайрла, дайснаа үзэн яд” гэж хэлснийг та нар сонссон. Харин Би та нарт хэлье, дайснуудаа хайрла, та нарыг хавчигчдын төлөө залбир. (Матай 5:43-44)

Анх харахад, Хуучин гэрээний: дайснаа үзэн яд, хөршөө хайрла” гэдэг хандлага нь маш утга төгөлдөр санагддаг. Гэхдээ арай жаахан лав ухаж үзье. Чи гэр бүлтэй болоод жилээс илүү болсон бол, хань ижлээ хайрлахад итгэл хэрэгтэй гэдгийг мэднэ. Жон, бид хоёр дөнгөж гэрлээд байхдаа, хар шөнөөр хачин инээдтэй юмнаас болж маргалддаг байлаа. Тэгээд ядраад, орондоо орохдоо бие биеэсээ аль болох дөлж хэвтээд: “За яахав, би чамайг итгэлээр уучилъя” гэдэг үгээр өдрийг өндөрлөнө.

Заримдаа энэ нь “Би чамайг уучлах ёстойгоо мэдэж байгаа ч, одоохондоо жаахан зуумаар байна. Тиймээс үүнийг итгэлээр үйлдье” гэсэн үг болдог. Би итгэлийг хэрэгжүүлэлгүй, зүгээр л шашинлаг ёслол хийж, зөв зарчмыг буруу зүрхээр хэрэглэж байжээ.

Хэн нэгнийг итгэлээр уучлах нь ирээдүйг итгэл найдвараар хараад, саналаа өгч байгаа хэрэг юм. Энэ нь мөн бууж өгсний үйлдэл мөн. Бид уучлалыг итгэлээр хүлээн авдаг. Тиймээс бид бас итгэлээр ч уучилж чадна.

Та гэр бүлтэй байж үзсэн бол, заримдаа ах дүүгээ итгэлээр хайрлах ёстой эгшин гэж бий. Та чуулганд явдаг бол, тэнд итгэлээр хайрлахаас өөр аргагүй хүмүүс заавал байдгийг мэднэ. Би найз нөхдөө итгэлээр хайрладаг! (Тэд ч намайг тэгдэг нь юутай сайхан) Гэхдээ Есүсийн хайр нь бидний хөршөөр хязгаарлагдахгүй.

Есүс хэцүү байдлаас хол даваад, ямар ч боломжгүй юмны үүдийг дэлгээд, бидэнд дайснаа хайрла гэж айлдсан юм.

Бидэнд дайсан бий. Байхгүй байсан бол, хичнээн сайхан. Гэтэл дайсан нь амьдралын баримт билээ. Гэхдээ ингэлээ гээд тэднийг хайрлах амархан болчихгүй. Дайсныг хайрлахад итгэл заавал хэрэгтэй. Дайсан чамайг дахиад алгадах гэж байхад, нөгөө хацраа барих хэцүү. Эхний удаа гэнэдээд алгадуулчихсан байж болох ч, дахиад алгадуулна гэдгээ мэдсээр байж нөгөө хацраа тавьж өгөх нь над шиг цөс ихт, хагас Сицили хүнд байж боломгүй зүйл.

Атаархлаас болж чамайг харааж, хорлож, шүүмжилж байгаа хүнийг ерөөнө гэдэг чухам итгэлээр л үйлдэх зүйл. (Эдгээр зарчим нь олон нийтийн сүлжээнд хамаатай бус, харин бодит амьдралд хамаатай шүү) Итгэлтэй байж л чамайг үзэн яддаг хүнд сайныг үйлдэнэ. Итгэлтэй байж л чамайг ашиглаж, хавчиж байгаа хүний төлөө чин сэтгэлээсээ залбирна. Би чамайг хүчирхийлэгч нарыг давруулаад бай гэж хэлээгүй шүү! Үүнийг хэрхэв ч зөвшөөрч болохгүй. Би чамд тийм хүмүүсийг алсаас залбирлаар дамжуулан итгэлээр хайрлаарай л гэж байна. Есүс бүгдийг хайрласан. Гэхдээ хайрыг найдахтай бүү хутгаарай.

Бид үзэгдэх зүйлтэй бус, харин үл үзэгдэх, харанхуй хүчтэй тэмцэлдэж байгаа. Түүнчлэн энэ нь мөн биднийг ганцаараа барилдаагүйгээ мэдэхэд тусладаг.

Логос софтверийнхээ цэц ухааны ачаар би *agape* гэдэг Грек үгд агуулагдах хайрын тун оновчтой тодорхойлолтыг олсон юм: Энэ нь хайрлуулах ямар ч зохисгүй, гавьяагүй, дээрээс нь хэнд ч хэрэггүй, урагшгүй нэгнийг хайрлахыг сонгох явдал ажээ. Хайр нь бидний дуртай, дургүйгээс үл хамааран, бие даан ажилладаг юм. Энэ тодорхойлолт нь хайрын суурь юм.

Хүнийг хайрлах үед хүн мэдэрдэг бөгөөд бидний хайр хүмүүсийн зүрхийг Бурханд нээдэг. Хүмүүс биднийг үнэхээр хайрлаад байна уу эсвэл зүгээр л өөрчлөх гээд байна уу гэдгийг мэдэрдэг. Ааваасаа ийм бат бэх хайрыг хүлээн авсан болохоор, бид хайрлуулсан шигээ л хайрлах ёстой юм.

Айдасгүйгээр хайрлах: хайранд айдас байхгүй.

—◆—
Бидний хайр
хүмүүсийн
зүрхийг
Бурханд
нээдэг.

Амиа бодолгүй хайрлах: хайр амиа боддоггүй.
Гомдолгүй хайрлах: хайр амархан гомддоггүй.
Ялгууснаар хайрлах: хайр хэзээ ч хөсөрдүүлдэггүй.
Дуусашгүй хайрлах: хайр бол мөнхийн.

Хэрэв улс үндэстнүүд хөршөө өөр шигээ хайрладаг байсан бол, нэг нэгнийхээ өөдөөс босохгүй байх байв. Ямар ч дайн, дайны сураг чимээ ч гарахгүй. Бидний хамаг зовлон Энхийн Ханхүүгээс тусдаа энх тайвныг тогтоох гэж үзсэний гайгаар л болдог.

Улс үндэстэн маань арьс өнгөөр ялгаварлагч сүнсний зугаа болоод уджээ. Бүх буруу шүүлт нь уур, хайхрамжгүй байдал дээр л цэцэглэдэг боловч, үүний ард байгаа сүнсийг тэнэг гэж бүү бодоорой. Энэ сүнс холын зорилготой бөгөөд бүр Еден цэцэрлэгээс эхтэй буюу. Адам, Ева хоёр алдаа гаргахдаа, төрөл төрлийн хуваагдлыг эхлүүлжээ. Үүний нэг нь ахан дүүс бие биеийнхээ эсрэг босох явдал юм. Арьс өнгөөр ялгаварлах үзэл нь могойн урхи мөн. Үүнийг зөвшөөрч эвсэл хайхрахгүй өнгөрч хэрхэв ч болохгүй. Газар газрын Христэд итгэдэг хүн бүр бүх төрлийн арьс өнгөөр ялгаварлах үзлийг хүчингүй болгож, үүнийг цэглэхийн тулд хийж чадах бүхнээ хийх ёстой.

—◆—
Бурханы бат
бэх хайр
л бидний
үйлс бүхний
тулгуур байх
ёстой.

Өгөөмөр байдал

Эцэст нь 1Коринт 13:3 дээр Паул ядуу хүнд бүх хөрөнгөө өгөхөөс авахуулаад итгэлийнхээ төлөө аймшигтай яргаллыг үзэн, биеэ шатаалгах ухаан санаанд багтамгүй эрс тэс өгөөмөр байдлыг нэрлээд, эдгээр нь хайрын сэдэлгүй бол, өгч байгаа хүндээ ямар ч нэмэргүй.

Тэгэхээр Паул үүнийг л хэлжээ:

Бүх юм - Хайр = Тэг

Хайр үгүй бол, бид юу ч биш.

Хайр үгүй бол, бид юу ч нэмэхгүй.

Бурханы бат бэх хайр л бидний үйлс бүхний тулгуур байх ёстой. Энэ бол бас л зог тусмаар дүрслэл шүү. Энэ тал дээр гагцхүү өнө мөнх л бидний санаа сэдлийг жинхэнэ дүрээр нь харуулна. Миний амьдрал мөнхийн үнэ цэнэгүй үг, үйлдлээр дүүрэн байгааг би шууд л хүлээн зөвшөөрнө. Тиймээс чи миний алдаанаас сурах л хэрэгтэй. Хурц төвлөрөлтэй халуун, хүчилтөрөгч хоёрын нөлөөгөөр ууршдаг алмаз шиг бидний ажил үйлс ч нэг өдөр Бурханы оршихуйн хурц гэрэлд шарагдаж, цаанаас нь санаа сэдэл маань цухуйн гарч ирнэ.

Алмаз мөнхөд байхгүй

Түлхүүрээ авахаар гараа явуулах үед зүүн гарт минь өөр нэгэн алмазан бөгж зүүлттэй бий. Хүн итгэхийн аргагүй адармаат амьдралынхаа дэгэн догон дунд би яаж яваадыг бүү мэд - ямар ч байсан эхний бөгжөө эвдчихсэн юм. Тиймээс миний дөчин найман насны төрсөн өдрөөр Сицилид байхад, Жон надад дахин гэнэтийн бэлэг барьж, зуйван хэлбэртэй алмазан бөгж бэлэглэж билээ.

Миний нөгөө дусал хэлбэртэй алмазан бөгж цуурчихсан юм. Тэгээд даатгалын компанид аваачиж өгөх үед сууриасаа юу юугүй салж унах гэж байлаа. Тийм боловч миний хувьд тэр бөгж дэндүү нандин байсан учраас, би үйрсэн чулуунуудаа өөртөө авч үлдсэн юм. Нэг өдөр би тэр үйрсэн чулуунуудыг эвлүүлэн засч янзлаад, цоо шинэ түүх эхлүүлээрэй гээд ач охиндоо өгнө гэж бодож явдаг юм.

Гучин таван жил гэрлэнэ гэдэг урт хугацаа шүү.

Би нөхрөө төгс хайрласан гэж худлаа ярихгүй. Би тэгж чадаагүй.

Бид хоёр хоёулаа ямар ч найдваргүй санагдах хэцүү үе бидэнд байсан. Хайр маань яг л хагархай алмаз шиг санагдам хатуу харгис үгтэй, уйтай цаг үе байсан. Хайр маань ёрдойсон хатуу үзүүрээс өөр ямар ч гэрэл, амлалтгүй байх үе байсан. Гэхдээ бид цөхрөөд үхээгүй ээ. Бид цөхөрсөн ч, амьдарсаар, ургасаар байсан.

Бид одоо ч төгс төгөлдөр биш боловч, хүчтэй бөгөөд эрүүл болсон. Бид хоёр бие биеэ бат бэх хайрлахаар шийдчихсэн. Бид арга ухаан хуримтлуулахын тулд тусламж гуйдаг, зөвлөгөө авдаг.

Энэ нь бид алдаа гаргахдаа, үүнээсээ суралцах алхмыг сонгодог гэсэн үг. Бид төлөвшихдөө, харилцаагаа зөрчлөөр нураах биш, харин бие биеэ хайрлахыг шийддэг. Бид өр бүртгэж, бие биеэсээ төлбөр нэхэх үед хэн ч хожихгүй.

Энэ олон жилийн хугацаанд бид алдаанаасаа сургамж авахыг сурсан. Ямар ч харилцаанд байдаг шиг заримдаа Жон, заримдаа би илүү буруутай байв. Харилцаа гэдэг бие биеийнхээ алдааг жин хэмжүүрээр тооцдог зүйл биш. Бид бие биеэ арай л хэтэртэл хайрласан даа гэж хэмждэг билүү? Хайрын тал дээр бие биедээ өсөх орон зай өг.

Би нөхөртөө дурлахаасаа илүүтэй нөхрөө хайрлахыг хүсдэг. (Тийм ээ, дурлах ч бас сайхан) Би мэдрэмжээрээ үйлдлээ хянуулж болдоггүйг сурсан. Бидний мэдрэмж үйлдлийг маань уяатай нохой шиг дагаж сурах хэрэгтэй. Энэ нь хайр бол сонголт гэсэн үг юм.

Жон намайг хайрлахыг хүсдэг. Жон, бид хоёр бие биеэ хайрлах хайраараа Бурханыг хайрлах хайраа харуулахыг хүсдэг. Үүнийг би ч хүсдэг. Гэхдээ энэ нь бие биеэсээ тулган шаардана гэсэн үг биш юм. Би үүнийг залуудаа сурсан билээ.

Манай аав ээж хоёр тун амаргүй харилцаатай байлаа. Хичээлээсээ ирэхэд, хөргөгчин дээр баахан купон, хичээлийн цагийн хуваарь, хийх ажлын жагсаалтын дунд бичгэн гэрээ байдаг байсныг би санаж байна. Энэ нь ээжийн зүгээс аавд тавьсан шаардах бичиг байв. Ээж маань үл хөдлөх хөрөнгийн мэргэжилтнийхээ чадвараар хууль ёсны бичиг баримт үйлдэхдээ, тэр авир үйлдлийг гүйцэтгэсэн байх шаардлагатай огноог ч тавиад, аав, ээж хоёр маань хоёулаа гарын үсэг зурсан байлаа. Ээж маань туйлдаа хүрсэн бөгөөд түүний тавьсан шаардлага ч эрүүл гэрлэлтийн амьдралд байх л ёстой зүйлс байв. Гэхдээ тэр гэрлэлт дэндүү гүн шархадсан байлаа. Аав маань архичин дээрээс нь жинхэнэ Сицили гар байсныг би хэллүү? Тэр баримт бичиг хамаатан садан, найзуудыг маань ирэх үед ч байж л байдаг байлаа.

Би ч тэр цаг хугацааг хүлээсэнгүй. Би 12 настай байхдаа л, аав маань тэр нөхцлийг нь зориуд биелүүлэхгүй учраас, ээж маань түүнд хариуцлага тооцож, эцэстээ тэр хоёр хайр байхгүй гэрлэлтээс зугтана гэдгийг мэдэж байлаа. Тэгээд цаг явж эхлэсэн бөгөөд хэдхэн сарын дараа аав, ээж хоёр маань салсан юм.

Хайр байхгүй бол, маш тодорхой харилцаа ч биелэхгүй. Хайр нь нөхөрлөлд ч, гэр бүлд ч, гэрлэлтэд ч өршөөл, нигүүлслээр л ажилладаг. Хууль нь Бурханы бидэнд тавьсан шаардлага, найдварыг маш тодорхой танилцуулсан боловч, бид хөсөрдүүлсэн. Тийм боловч, хуулийн үг үсгийг давж, Бурханы сайн сайхныг үзсэн хүмүүс байж л байв. Рахаб, Рүт тэргүүтэй эмэгтэйчүүд, Давид, Абрахам тэргүүтэй эрчүүд хэдийгээр амьдрал нь төө дутсан ч, Бурханы хуулийг зүрхэндээ сахих чадвартай байв. Тэдгээр нь итгэлийн баатрууд байсан нь ч тохиолдол байсангүй. Учир нь итгэл хайраар ажилладаг.

Хайр нь
ойр дотно
байдлыг
шаарддаг.

Найдвар нь биднийг гонсойлгодоггүй. Учир нь бидэнд өгөгдсөн Ариун Сүнсээр дамжин Бурханы хайр зүрхэнд маань цутгагдсан байдаг (Ром 5:5).

Бид хайрлах үед энэ нь зүгээр нэг сонсогдох биш, харин харагддаг.

Хайр гараа сунгадаг

Чи дуудлага хүлээдэг үү? Би хүмүүсийн дуудлагыг, тэдний дуу хоолойны өнгө будгийн өөрчлөлтийг хүлээдэг. Би саяхан нэг хүн рүү ярихдаа, тун их сэтгэл хөдлөв. Тэр бол надтай хамтарч конференц хийх гэж байсан үзэсгэлэнтэй залуу бүсгүй байлаа. Тэрбээр утсаа аваад л уйлахыг нь би мэдрэв. Бид ярьж бас залбирлаа. Тэр эгшинд түүнд амьсгалдаг, амьд хүн хэрэгтэй байжээ. Хэрэв би зүгээр л олон нийтийн сүлжээг харсан бол, түүний зовиурыг хэзээ ч мэдэхгүй байв. Хүний зургаас уйлж байгаа зүрхийг нь хэзээ ч харахгүй шүү дээ.

Олон нийтийн сүлжээ бол сүлжээ юм. Үүгээр хүний амьд хүрэлт, яриаг нөхөж чадахгүй. Үүгээр харилцаагаа орлуулах биш, харин дэмжиж өг.

Олон нийтийн сүлжээгээр олон хүнд хандсанаараа нүүр тулсан яриаг хайхрахгүй байж болно гэсэн үг биш юм. Хоёуланг нь хийх хэцүү. Хэрэв чи аль нэгийг нь сонгох болбол, харагдаж байгаа

хүмүүстэйгээ ярилц. Бид олон хүнийг гадна үлдээсэн, виртуал ханыг байгуулдаг алдар нэрийн хийсвэр соёл байгуулж байгаа юм шиг надад санагддаг юм.

Тэгвэл ханын оронд хашлага барьвал ямар вэ? Энэ нь хориг тогтоох биш, харин хязгаар тавьж өгнө гэсэн үг. “Сайн хашлага сайн хөршийг бий болгодог” гэдэг үг нь бие биеийнхээ газар, сүрэг, эзэмшлийг хүндэтгэнэ гэсэн үг юм. Хашлага нь хүнд биш, амьтанд зориулсан эд. Төмөр хашлага нь цаад юмыг нь чөлөөтэй харуулах атлаа талбайг хувааж өгдөг. Олон нийтийн сүлжээний хувьд бид торон хашлага хийж өгөх хэрэгтэй. Заримдаа бид дээгүүр нь юмуу доогуур нь нэвтлээд гарчихаж болох ч, нөгөө талаас биднийг зэрлэг амьтнаас хамгаалдаг хашаа хашлага гэж бий.

Тиймээс хүнтэй нүүр тулж харилцах чадвараа гээтлээ олон нийттэй харилцахгүй байя. Хэн нэгэн рүү ярь. Хаалгыг нь тогш. Хэн нэгнийг тэвэр.

Танихгүй хүмүүстэй ярь... Чи олон нийтийн сүлжээгээр ярьдаг биз дээ? Гэхдээ дэлгүүр хоршоонд явж байхдаа, жинхэнэ бодит хүнтэй ярь. Гараас нь барь. Нөхрөө, хүүхдээ, ач зээгээ тэврээд үнс, үнэрлэ. Гижигд. Айпад утсаа тавихад хүргэ. Зурагт үзье гэвэл, гадуур хамтдаа алх. Хүмүүсийн нүд рүү хараад, тэднийг ажигла. Холоос үзэн ядах амархан ч, хайр нь ойр дотно байдлыг шаарддаг. Есүс бол бидний үлгэр жишээ. Тэгээд тэр хэзээ ч ойртохоос айгаагүй.

Хайраар бат бэх байх

Энэ маш урт ишлэл гэдгийг би мэднэ ээ. Гэхдээ доор бичсэн Ромын хэсэг нь бусдыг хайрлахын шилдэг тойм юм шүү. Хайртай, хүндэтгэлтэй, халуун, найдвараар дүүрэн, тэвчээртэй, тууштай, өгөөмөр, зочломтгой бай, өсөрхөлгүй мэдрэг, даруу, амар тайван байж, дайсныхаа хэрэгцээнд мэдрэмжтэй бай. Бурханаар хайрлуулсан шигээ Бурханы хайраар Бурханы тусламжтайгаар хайрла.

Ром 12-аар бүлгийг гаргаад, зүрх маань аль талаараа тайлагдах хэрэгтэй байгааг Ариун Сүнснээс асууцгаая.

*Тэнгэрийн Бурхан Аав минь,
Би Тан шиг хайрлахыг сонгож байна. Би Таны үгийн дагуу
байхыг сонгож байна:*

Ах дүүсийн хайраар бие биенээ хайрла. Бие биеээ өөрсдөөсөө дээгүүр дээдлэн хүндэл. Хичээл зүтгэлд бүү хойрго бай. Эзэнд үйлчлэн сүнс дор шат. Найдвар дор баярла, зовлон дор тэвчээртэй бай, залбиралд өөрсдийгөө зориул, ариун хүмүүсийн хэрэгцээнд хандивла, зочломтгой байхыг эрмэлз. Та нарыг хавчигч нэгнийг ерөө. Ерөө, харин бүү хараа. Баяр хөөр болж буй хүмүүстэй хамт баярла, уйлж буй хүмүүстэй хамт уйл. Өөр хоорондоо нэг санаатай байцгаа. Ухаан бодолдоо ч бүү ихэрх. Харин төлөв даруу байхыг эрхэмлэ. Өөрөө өөрийгөө ухаалаг бүү болго. Хэнд ч хэзээ ч мууг муугаар бүү хариул. Бүх хүний өмнө юу нь зөв болохыг л харгалзан үзэж бай. Та нарын зүгээс боломж байгаа бол бүх хүнтэй эвтэй байгтун. Хайртууд минь, хэзээ ч өөрийн өшөө хонзонг бүү ав. Харин Бурханы уур хилэнд зай гарга. Учир нь «“Өшөө авалт нь Минийх, Би буцааж төлнө” гэж Эзэн хэлэв» гэж бичигджээ. «Дайсан чинь өлссөн бол хоолло, цангасан бол түүнийг ундаал. Ингэснээр чи түүний толгой дээр галтай нүүрс овоолж байгаа хэрэг.» Мууд бүү дийлд, мууг харин сайнаар дийл. (Ром 12:10-21)



6

ҮЗЭН ЯДАЛТАД АДАМАНТ (ҮЗЭН ЯДСАН ШИГ ҮЗЭН ЯДАХ)

Бид Бурханы үзэн яддагийг үзэн ядалгүйгээр
Бурханыг хайрлана гэж байхгүй.

Чарльс Спержен

Энэ маш хэцүү гэдгийг би мэднэ. Энэ үг биднийг үнэхээр барьц алдахад хүргэдэг боловч, бид Бурханы үзэн яддагийг үзэн ядахгүйгээр, Бурханыг хайрлана гэж байхгүй. Үүнийг би яаж амьдрал дээр сурснаа чамтай хуваалцмаар байна. Намайг өмнөх бүлгийг дөнгөж бичиж дуусгаад байтал, Ариун Сүнс надад “Лиза, Би бас бат бэхээр үзэн яддаг” гэж хэлсэн юм. Зүрхний минь цохилт алгасах шиг л болов.

Хайрын Бурхан яаж үзэн яддаг билээ?

Тэгээд үүнд хариулах шиг Сургаалт үгсийн нэг хэсэг толгойд орж ирэв: “Эзэн зургаан зүйлийг үзэн яддаг...” Тэгэхээр, энэ миний хариулт байв. Би энэ хэсгийг байнга үзээд байдаггүй учраас, Библийн софтвэйрээ нээгээд, Сургаалт үгс 6-аар бүлгийн тус ишлэлийг шинэ документ нээн, копи паст хийгээд “өдөр” гэж нэрлэв.

Бидний 11 хүн хүн Флоридад ганц байшин дотор чихцэлдэн, амарч явсан учраас, би утсаа орхичихоод, найзынхаа чиргүүлэн байшин дотор бичиж байлаа. Тэгээд намайг байшинд орж иртэл, хэд хэдэн мессеж ирчихсэн байв.

Нэг нь миний найз Рабби Брианаас ирсэн байлаа. Тэр надад бичихдээ, Ариун Сүнс түүнд намайг номоо бичиж байгааг харуулаад, тэр өдөр надад харваж орж ирсэн цоо шинэ бодлын хөвөрлөө үргэлжлүүлэхийг сайшаан дэмжсэн байв. Тэрбээр Ариун Сүнс надад ямар санаа өгснийг мэдээгүй боловч, “тэр санаа нь чуулганыг Бичээсийн ариун цэц ухаанаар тэтгэх бус,

харин дэлхийн мэхлэлээр утаж байгаа хорыг тайлагч мөн” болохыг хэлсэн байв. Тэгээд цааш нь “Энэ амин чухал, ноцтой цаг үед бид хэнтэй адил байхаа Бурханы *дүр төрхөөр* шийдүүлж, энэ дэлхий дээр хэрхэн байх, хэрхэн ажиллахаа Бурхантай *адил чанараараа* шийдүүлэхийн оронд, дэлхийд таалагдахын төлөө юмуу эсвэл итгэгч хүн хэн байх, хэрхэн байхыг хэлж өгдөг нийгмийн гажуудсан тодорхойлолтод нийцэх гэсэн хэврэг хэрэгцээнд өдөөгдөж өртөж явах цаг алга” гэсэн байлаа. Өө за за, ойлгомжтой.

—◆—
Бурхан
хайрыг
үгүй хийдэг
бүхнийг үзэн
яддаг.

Маргааш өглөө нь би суугаад, Бичээсийг нягтлахаасаа өмнө “Тэнгэрийн Бурхан Аав минь, Та надтай яриач. Би хайрын Бурхан Таныг үзэн ядалттай огт эвсэхгүй гэж бодож байсан ч, Та үзэн яддаг зүйлээ Сургаалт үгс дээр маш тодорхой хэлжээ. Түүнийгээ надад зааж өгөөч. Есүсийн нэрээр, амень, амень” гэж залбирлаа.

“Амень” гэж хэлж дуусмагц, Ариун Сүнс надтай ярьж эхлэв. Би хэлсэн үг бүрийг нь бушуухан шиг бичиж эхлэв. Тэгээд дараах байдлаар тоймлон гаргасан бөгөөд эдгээрийг бид энэ бүлгээрээ судлана:

Бурхан хайрыг үгүй хийдэг бүхнийг үзэн яддаг.

Бурхан Өөрийнх нь хайртай зүйлсийг үгүй хийж, сүйд хийдэг зүйлсийг үзэн яддаг.

Бурхан Өөрийнх нь дүр төрхийг үнэгүйдүүлдэг, бидний жинхэнэ чанарыг сүйтгэдэг зүйлсийг үзэн яддаг.

Товчхондоо Аав маань хайрыг завхруулж, гуйвуулдаг зүйлсийг үзэн яддаг. Бурхан хүмүүст хайртай. Бурхан эвдэрхийд хайртай. Бурхан хүлэгдсэнд хайртай. Бурхан нүгэлтэнд хайртай. Бурхан Өөрөө хайр. Хайр хэзээ ч хүмүүсийг үзэн яддаггүй. Учир нь Бурхан хүмүүст хайртай юм.

Бурхан *бүх хүнд* хайртай. Гэхдээ Бурхан *бүх юмд* хайртай биш.

Эхлэл дээрх бүтээлд Бурхан бүх зүйлийг сайн сайхан болгож бүтээсэн. Харамсалтай нь өнөөдөр бид төгс төгөлдөр Едений хөрсөн дээр алхаагүй. Бидний хөл доорх газар сэргэлтийн төлөө орь дуу тавин уйлж байна. Яг үүнтэй адилхан, хүн болгоны зүрх жинхэнэ үнэн, шударга, гоо үзэсгэлэнгийн төлөө орь дуу хадаан үгүйлж байна. Бид амьдралын тал бүр дээр хайр цалгихыг харахыг хүсч байна. Бид энэ бүх явц дундаа хайр биш юмсыг хайр хэмээн дуудаж, хайрыг шүтээн болгочихсон байж болох уу? Үйлдэл маань хайрын бус байсаар байтал, бид хайрлаж байна гээд бодчихсон уу? Бурхан бол хайр, гэхдээ хайр бол Бурхан биш ээ. Бид Бурханыг хүндэтгэдэг болохоос биш, хайранд мөргөдөггүй. Христ Есүсийн дотор юу ч биднийг Бурханы хайраас салгаж чадахгүй (Ром 8:39). Гэхдээ бид хайрыг Бурханы параметрээс салгах үед аюул болдог.

Бурхан бол хайр (1Иохан 4:8). Бурхан бол залгигч гал (Еврей 12:29). Түүний дотор бид амьдардаг (Үйлс 17:28). Эдгээр үнэнийг авчихбал “Бид Бурханы хайрын залгих гал дотор амьдарч байна” гэж хэлж чадахгүй.

Яагаад үзэн ядах гэж?

Үзэн ядалт гэдэг нь сэтгэл мэдрэмжээр цэнэглэгдсэн сөрөг үг. Үзэн ядалтад ямар ч найраа байхгүй. Энэ үг надад “үзэн ядалтаас үүдсэн гэмт хэрэг” гэдэг үгийг санагдуулдаг юм. Надтай хамт энэ үгийг судлахын тулд чи өөрийнхөө үзэн ядалтын туршлагыг хойш тавиад бас энэ үгийг хүмүүсээс тусад нь авч үз гэж хэлмээр байна. Энэ бүлгээс үнэнийг олохын тулд үзэн ядалтын бүх дүр төрх, үйлдлийг хойш тавь. Хайрын тодорхойлолтыг нийгэм ч, хүн ч эвдсэн гэдэгтэй чи санал нийлэх үү? *Хайр* гэдэг үгийг буруугаар хэрэглэдэг болсон гэдэгтэй чи санал нийлэх үү? Хүмүүс ямар ч

— ◆ —
 Бурхан
 хайрыг
 доош хийдэг
 бүхнийг үзэн
 яддаг. Учир
 нь хайрыг
 доош хийдэг
 бүхэн нь
 биднийг
 доош хийдэг.

үйлдэл, бүрэн зориулалтгүйгээр *хайр* гэдэг үгийг ярьдаг болсон. Үгийг хэтэрхий их хэрэглээд байхаар, утгынх нь үнэ цэнэ буурах юмуу бүр алдагддаг. Би Бурхантай адил хайрлахын тулд Түүний үзэн яддаг зүйлийг хайрлаж чадахгүй.

Хайрыг Бүтээгчийн мөнхийн үзэл бодлоос салгаж тодорхойлж болдоггүйтэй адил үзэн ядалтыг тодорхойлохын тулд бид мөн л Бичээсийг харах хэрэгтэй. Тэгэхээр, бүгдээрээ үзэн ядалтын *турилагаа* хойш тавиад, энэ үгийн жинхэнэ *утгыг* харцгаая.

Нэр үгийнхээ хувьд энэ нь хорлол, зэвүүцэл, жигшил, гутамшиг гэсэн утгаас ч гүн утгатай үг ажээ. Үйл үгийн хэлбэр дээрээ нүд үзүүлэх, жигших, эсэргүүцэх, ой гутах гэсэн утга илэрхийлнэ.

Анх харахад, эдгээр чанар нь хайрлахыг л мэддэг, Өөрөө ч хайр болох Бурхантай огт эвлэхгүй мэт. Тийм боловч би Бичээсийг ухаад, дараах зүйлсийг илрүүлэв. Аав маань:

“...үнэн, шударга ёсыг уландаа гишгэсэн бүхнийг бэлбэсэн, өнчин, харь хүмүүсийг дарлахыг ахмад настай хүмүүсийг дээрэлхэж, гэр бүлээ үл хайхрахыг
 Түүний сайн сайхныг завхруулж, бэлэгийг нь сэвтүүлдэг бүхнийг
 хайр амиа бодсон явдал болон хувирч, найзууд дайсан болохыг
 Түүний дүр төрхийг өөрчилж, бидний дүр төрхийг сүйтгэхийг
 мууг сайн гэж, гэмгүйг алж, хайхрамжгүй байдал бардамналд унахыг” үзэн яддаг ажээ.

Эдгээр нь бүрэн гүйцэт жагсаалт биш бөгөөд маш ерөнхийлсэн бичиг юм. Товчхондоо Бурхан хайрыг доош хийдэг бүхнийг үзэн яддаг. Учир нь хайрыг доош хийдэг бүхэн нь биднийг доош хийдэг.

Би Бурханы үзэн яддаг зүйлсийг олж мэдэхээр, Бичээсийг нягтлаж байхдаа, хайрын барьж байгуулахыг хүсдэг зүйлсийг нураадаг юмстай холбоотой гурван мянга давсан үг байгааг олж үзээд, гайхаж билээ.

Хайрыг доош хийх үед хайр болох Бурханы талаарх ойлголт маань тун харуусалтайгаар үнэгүүддэг. Бурханы талаарх ойлголт эрэмдэг болох үед Аавыгаа хайсан хүүхдүүд самуурч хоцордог. Эцсийн эцэст Бурхан хайртай зүйлээ хамгаалах гэж л үзэн яддаг юмсаа үзэн яддаг юм. Би үүнд яагаад гайхсан бэ? Үр хүүхдэд нь хор хохирол учруулах гэсэн бүхнийг аав, ээж нар үзэн яддаг. Хуучин гэрээ нь ууртай Бурханы үг биш, харин үр хүүхдэдээ хамгийн сайн сайхан амьдралыг хүссэн, хайраар дүүрэн Аавын анхааруулга юм. Есүс Шинэ гэрээнд Бурханы санааг өөрчлөөгүй. Есүс Аавынхаа зүрхийг л илэрхийлэхээр ирсэн юм.

Үр хүүхдэдээ зовлон хүсдэг аав ээж байхгүй. Тийм боловч зөрчил, асуудал нь бидний туйлын дайсан биш юм. Газрын бэрхшээл нь Бурханы хүүхдүүдийг даруугаар залбирахад хүргэдэг. Бэрхшээл нь биднийг Бурханы Үгийг цоо шинээр унших нүдтэй болгодог. Бидний жинэхэнэ дайсан нь илүү нарийн мөн чанартай байдаг. Тэдгээр нь шунал, бардамнал, буулт, ёс бус явдал, шүтээн шүтлэг, завхрал зэрэг үйлдэл юм. Амьдралын эдгээр эрэмдэглэл нь Бурханы хүүхдүүдэд Бурханд ч, энэ дэлхийн системд ч зэрэг үйлчилж болно гэж худлаа ярьдаг.

Үнэнийг хэлэхэд, энэ үеийнхэн цөлд ихэд өлсөж цангаж явна. Тэд гэрлэлт, засгийн газар, тэр бүү хэл хүндэтгэлийн газарт итгэл алдарч, эртний замаар ахин дахин эргэлдэнэ. Өлсгөлөнгийн энэ үед дайсан тэднийг ашиглаж, тэднийг өндөр газар аваачаад, зүгээр л өөрт нь мөргөбөл, энэ дэлхийг тэдэнд амладаг. Манай соёл амар тайван байхгүй атал амар тайван гэдэг, ариун бус атал ариун гэж давтдаг. Манай соёл оюун ухаанд л таалагдах юмстай хөөцөлдөж, “байхгүй болсон Бурханы хуучирч хоцрогдсон үгсийг” няцаахад уриалан дэмждэг.

◆
ҮНЭНИЙГ
ХЭЛЭХЭД,
ЭНЭ
ҮЕИЙНХЭН
ЦӨЛД ИХЭД
ӨЛСӨЖ
ЦАНГАЖ
ЯВНА.

Гэрлийг үзэн ядах

Гэрлийг жинхэнээсээ хайрлахын тулд бид харанхуйд нүд үзүүрлэгдэхээсээ айхгүй байх ёстой. Дэлхийгээр хайрлуулахын тулд бид дэлхийн хайрлагдгийг хайрлах ёстой болно. Гэхдээ бас болоогүй ээ. Бид аль алийг нь хийхгүй бол бас л үзэн ядагдана. Бид хажуугаар нь дэлхийн үзэн яддагийг үзэн ядах ёстой. Аль алийг нь хийхгүй бол бас л таалагдахгүй. Бид дэлхийн дэмждэгийг дэмжихгүй бол, тэд: “Алдаа!” гэж хашхирдаг.

Тэрхүү яллалт ийм билээ. Хүмүүсийн үйлс муу муухай тул гэрэл ертөнцөд ирэхэд тэд харанхуйг гэрлээс илүү хайрласан юм. Муу муухайг үйлдэгч бүр үйлс нь илэрчих вий гэсэндээ гэрлийг үзэн ядаж, гэрэлд гарч ирдэггүй. Харин үнэнийг үйлдэгч, үйлс нь Бурханы дотор үйлдэгдсэн гэдгийг ил харуулахын тулд гэрэлд гарч ирдэг гэлээ. (Иохан 3:19-21)

Ил гарахаасаа айхдаа, харанхуйг хайрлаж, бүхнийг илчлэгч гэрлийг буруутгах амархан. Зарим нь бүр харанхуйг гэрэл ч гэдэг. Би ойлгож байна аа. Заримдаа нэрээ дуудуулах сайхан биш ч, ямар ч байсан эрүүл юм. Эцсийн эцэст харанхуйд нуугдсан бүх юмс гэрэлд гарах л болно. Тиймээс сүүдэртэй газар бүрийг Ариун Сүнсээр эртхэн илчлүүлсэн нь дээр. Бүү ай. Түүний хувьд харанхуй ч гэрэл юм гэсэн баталгаа бидэнд бий.

Хэрэв би “Харанхуй үнэхээр намайг нөмөрнө.
Намайг хүрээлэгч гэрэл нь шөнө” гэвэл
Харанхуй ч Танд харанхуй биш бөгөөд
Шөнө ч өдөр мэт гэрэлтэнэ.
Гэрэл харанхуй адил юм.
(Дуулал 139:11-12)

Ариун Сүнс бидний замыг гэрэлтүүлж, замд маань бидэнд зөвлөж чадна. Айдсаа тахимдах ганц зам нь амьдралынхаа тал бүр дээр гэрлийг урих. Бид сэтгэлийг сүүдэрлэдэг бүхнийг үзэн ядаж, гэрлийг тэвэрч авах үедээ гэрлийн ил гаргасан бүхнээс

эргэх болно. Хуваагдалгүй цул зүрхэнд хайр цэцэглэж, тийнхүү Бурхан бидний зүрхийг хуваадаг зүйлсийг үзэн яддаг. Эртний чуулган үүнийг мэддэг байж. Есүсийн дүү элч Иаковын сэтгэл зүрхний гуйлтыг сонсогтун:

Завхай эмс ээ, ертөнцтэй найзлах нь Бурханы эсрэг дайсагнал гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Тэгэхлээр хорвоотой ходий хэн боловч өөрийгөө Бурханы дайсан болгож байгаа юм. Эсвэл Бичвэр дэмий хоосноор “Бидний дотор Түүний нутаглуулсан сүнс нь атаархан хүсдэг” хэмээсэн гэж та нар бодож байна уу? (Иаков 4:4-5)

Эдгээр үгс нь өнөөдөр хүчингүй гэж маргах хүн байгаа л байх. Тэд хүн төрөлхтөнийг илүү хөгжсөн гэж үздэг. Гэтэл би эргэн тойрноо харах болгондоо, хүн төрөлхтөн ямар доошоо орсныг хардаг. Тэнгэрийн үнэлгээний систем газрынхаас тэс өөр юм. Тиймээс биднийг дэлхийн системтэй сээтэгнэж ч болохгүй хэмээн анхааруулсан билээ.

Би манай хайрын Бурхан юуг үзэн ялдагийг судлаж байхдаа, Сургаалт үгс 6-гаас эхлэсэн учраас, одоо үүнийг бүрэн эхээр нь уншицгаая:

ЭЗЭНий үзэн яддаг нь зургаа агаад
Тийм ээ, Түүний сэтгэлийн жигшүүр нь дараах долоо билээ.
Дээгүүр хардаг нүд,
Худал хэлдэг хэл,
Гэмгүйн цусыг урсгагч гар,
Гэм хортой санааг сэдэгч зүрх,
Ёрын мууд яаран гүйгч хөл,
Гүжирддэг хуурамч гэрчлэгч болон
Ах дүүст зөрчлийг тараагч нар ажээ. (16-19)

Харин одоо долдугаар зүйлийг нь нягтлан үзэцгээе:

—◆—
Тэнгэрийн
ҮНЭЛГЭЭНИЙ
СИСТЕМ
ГАЗРЫНХААС
ТЭС ӨӨР ЮМ.

Бардамнал

Бардамнал хайрын өөрчлөгч хүчийг эсэргүүцдэг учраас, Бурхан бардамналыг үзэн яддаг. “Бурхан бардмыг эсэргүүцэж харин дарууд нигүүлсэл өгдөг (Иаков 4:6) болохыг Иаков бидэнд хэлжээ.

Си. Эс. Люисийн “*Mere Christianity*” гэдэг номд “Бардамнал нь сүнсний хорт хадвар юм. Энэ нь хайр, сэтгэл хангалуун байдал, тэр бүү хэл эрүүл саруул ухааны бүх боломжийг иддэг”¹ гэжээ. Мэдээж Аав маань бидний өөрчлөлтийн ийм аюулт дайсныг үзэн ядалгүй яахав.

Сургаалт үгс 6:17 дээр бардам харцыг “дээгүүр хардаг нүд” гэж дүрслэжээ. Ийм харц бусдыг үзэн ядаж, доош хийдэг. Пэйшн Транслэйшн дээр “бусдыг доош хийж, өөрийгөө дээр гэж бодох” хэмээн илүү дэлгэрэнгүй хэлдэг. Гэтэл бид ийм дүр төрхийг бүх төрлийн загварын сэтгүүл, зар суртчилгаан дээрээс хардаггүй гэж үү?

Бардамналын сүйтгэгч үр дүнгийн талаар бас дараах ишлэлүүд дээр хэлдэг:

ЭЗЭНээс эмээхүй нь ёрын мууг үзэн ядах явдал юм.

Бардамнал, ихэмсэг зан, ёрын муу зам хийгээд гажсан амыг би жигшдэг. (Сургаалт үгс 8:13)

Бардамнал нь эцэстээ бидний хэл яриаг завхруулан, ёрын муугийн замаар уруудуулдаг.

Ихэмсэг харц, бардам зүрх нь буруутын дэнлүү бөгөөд нүгэл ажээ. (Сургаалт үгс 21:4)

Муу ёрын хүмүүсийн ойлголтыг харанхуйлагч бардамналын сэхээрлийн ард нүгэл байдгийг энэ ишлэл хэлжээ.

Басамжлагчийг залруулваас

Үл хүндлэлийг хураана.

Буруутыг зэмлэвээс

Өө толбыг хүртэнэ.

Басамжлагчийг бүү зэмлэ,
Тэр чамайг үзэн ядна.
Мэргэнийг зэмлэ,
Тэр чамайг хайрлана. (Сургаалт үгс 9:7-8)

Бардамнал биднийг хамгаалалттай, хурц болгож, жинхэнэ байдлыг харах нүдгүй болгодог. Амиа хичээсэн зан, хайхрамжгүй зан нь бардамналтай хамт хажуулдаг. Бардамнал нь заавар бүрийг доромжлол гэж үздэг. Засвар хэзээ ч сайхан байдаггүй ч, бид засвараас “цэц ухаан” гэдэг нэг сайхан үр жимсийг хүртэнэ.

Аавынхаа хайртай зүйлийг хайрлахын тулд бид эхлээд сүйрэлд хүргэдэг бардамналын үүдийг хаах ёстой.

Худлаа ярих

Худалч хэлд худлаа ярих болон хов жив тараахын аль аль нь багтана. Найз минь, манай энэ эрин үе, өдрүүдэд бид хэлэх, давтах, нийтлэх зүйлдээ хэт болгоомжтой байна гэж байхгүй шүү. Тоглоом тохуу нь “тоглоом” биш, харин маш бодитой шоглоом болчихоод байна. Тэдгээр нь хэдийнээ гүүрэн доор нуугдахаа болиод, хурдны замаар мэдээллийг цацаж, зөрчил, хуваагдлыг тарихдаа, хүмүүсийн сайн нэрийг хугалж байна.

Тэгэхээр нэг зөвлөгөө өгье: мэдэхгүй зүйлээ зүгээр л өнгөрөө. Бурхан санаатай гүтгэлгэ, худлыг үзэн яддаг. Сургаалт үгс 12:22 дээр “Худалч уруул ЭЗЭНд жигшүүр. Хуудуугүй загнагсад Түүнд таалал” гэдэг. Тэгэхээр худлаа хэлэх нь итгэмжгүй байдалтай адил болохыг үүнээс харж болно. Бурхан үнэний зохиолч бөгөөд үндэслэгч. Бид худлаа ярихдаа, үнэн байхгүй, хуучин захирагч, худалчдын эцэг Сатантай адил авирладаг. Худлаа ярих нь хайрыг хараадаг. Худлаа ярих нь хайрлахгүй байгаа явдал. Тэгээд худлаа ярихын хамгийн аймаар нь бид худлаа хэлсээр байгаад, сүүлдээ үнэнээс тасраад, өөрийгөө мэхлэж эхлэдэг.

Худлаа
ярих нь
хайрлахгүй
байгаа
явдал.

Гэмгүй цусыг урсгах

“Гэмгүй цусыг урсгадаг гар” гэдэг үг нь гэмгүй хүнийг хөнөөх санаатай, төлөвлөгөөтэй аллагыг дүрслэж байна. Сургаалт үгс номын үед энэ нь тухайн үед Израиль даяар газар аваад байсан Баал-Молах, Ашерагийн мөргөлчдийн хүүхдээр тахил өргөх үйлтэй холбоотой байв (1 Хаад 14). Энэ хүндэтгэлд мөн нийтээрээ бэлгийн харилцаанд орох явдал багтаж байлаа. Энэ үйлдлээр олдсон хүүхдүүдийг Молахт тахил болгон шатааж, хүүхдүүдийн зүрх зүсэм чарлааныг шүтээний тахилч нарын бөмбөрийн нижигнээн дардаг байжээ. Ээж хүн амьд хүүхдээ галд хаяна гэдэг санаанд багтамгүй боловч, эш үзүүлэгч Исаиа энэ үйлдлийн талаар өгүүлдэг:

Царс моддын дунд,
 Ногоон мод бүрийн доор
 Шүтээнүүдтэйгээ дүрэлзэн шатаж,
 Гуу жалганд, хавцлын ан цавд хүүхдүүдээ алдаг биш үү? ...
 Өндөр, сүрлэг уулан дээр чи ороо засаж,
 Тахил өргөхөөр тийшээ гарсан.
 Хаалга хагавчнуудын ард чи
 Тэмдгүүдээ тавьжээ.
 Үнэндээ Надаас эргэн чи биеэ нүцгэлж
 Дээш гарч, ороо өргөгсөн
 Тэдэнтэй тохиров.
 Чи тэдний оронд дуртай,
 Чи тэдний нүцгэнийг харсан.
 (Исаиа 57:7-8)

Бид ор дэрээ завхруулж, шүтээнээ шүтчихээд, гэмгүй хүүхдийнхээ амиар төлөөсийг нь төлдөг үү?

Өнөөдөр бөмбөр, агуй байхгүй. Энэ тал дээр бид арай соёлжжээ. Гэхдээ эхийнхээ хэвэлд байгаа хүүхдийг чимээгүй хороож, гэмгүй цусыг урсгасаар л. Энэ “үйл явц” дундуур ээж нь сэрүүн эсвэл унтаа байхаа өөрөө шийддэг. Хэвлийдээ буй хүүхдээ үр хөндөх аргаар хөнөөх аав, ээж хүүхдийнхээ үхлийг нүдээрээ

үзэхгүй. Ийнхүү манай улс өргөн дэлгэр “үр хөндсээр” тавин жил болжээ. Үр хөндөлтийн өмгөөлөгч нар үүнийг “эмэгтэйчүүдийн ариун ёсон”, “билэгдэл” гэдэг. Тэр бүү хэл “шашны эрх” ч гэдэг. Бурхан минь, бидэнд туслаач. Бид хүмүүсийг нь бус, үйлдлийг нь үзэн ядахыг сонгож байна. Хайр нь амь өгөхийг сонгосон зоригт залуу бүсгүйчүүдийг дэмжиж бас гэмгүй цусыг урсгасан хүмүүсийг авран сэргээхийн төлөө ажилладаг.

Муу ёрын төлөвлөгөө сэдэгч зүрх

Муу ёрын төлөвлөгөө сэдэгч зүрх гэдэг нь бусдыг хорлох санаатай, бэлтгэлтэй хуйвалдааныг хэлнэ. Бурхан бидний амьдралд төлөвлөгөө зэхдэг. Энэ нь хорлох биш, харин сайн сайхан төлөвлөгөө юм. Тиймээс л бидэнд биднийг хүчирхийлж, муу муухай хандсан хүмүүсийг хараах бус, харин ерөөгөөрэй гэжээ. Бид бусдад ёрын мууг хүсэхдээ, тэдний ч, бидний ч амьдралд зэхсэн Бурханы төлөвлөгөөг эсэргүүцдэг.

Муу муухай руу гүйдэг хөл

Ёрын муу нь угтаж гүйх биш, харин зугтаж гүйх зүйл гэдгийг Библи маш тодорхой хэлдэг. Пэйшн Транслэйшн дээр Сургаалт үгс 6:18-ыг: “хараажийн буруу зүйлд баярладаг” хүмүүс хэмээн маш энгийнээр тодорхой хэлдэг. Зарим хүмүүс баригдаагүйдээ баясдаг. Тэд баригдаагүй бол, өөрсдийгөө сэргэлэнд тооцдог. Гэхдээ дэлхийн бүх нүд харахгүй байлаа ч, түүнийг харж байгаа Нэгэн байдгийг тэд мэддэггүй.

Гэхдээ
дэлхийн
бүх нүд
харахгүй
байлаа ч,
түүнийг харж
байгаа
Нэгэн
байдгийг тэд
мэддэггүй.

Худлаа гэрчлэх

Би Сургаалт үгс 6 дээр Бурханы үзэн яддаг зүйлст худалч хэл, худлаа гэрч хоёрыг хоёуланг нь оруулсан байгааг хараад гайхаж билээ. Энэ хоёр адилхан биш үү? Гэтэл ялгааг нь сурвалжилтал, худалч гэрч нь тангараг өргөж байгаад худлаа ярьдаг хүн ажээ. Тэд хүнд төдийгүй, Бурханд худлаа ярих бөгөөд үүгээрээ шударга ёсыг завхруулдаг. Бидний шударга Бурхан шударга бус явдлыг үзэн яддаг. Тиймээс л Америкийн шүүх дээр бид: “Миний гэрчлэл нь үнэн - бүрэн үнэн бөгөөд гагцхүү үнэн байхыг би тангараглаж байна. Тиймээс Бурхан надад туслах болтугай” хэмээн тангараг өргөдөг. Бурхан туйлын Шүүгч. Тиймээс бид худлаа гэрчлэлээрээ шударга ёсыг завхруулбал, бүгдэд хандсан Бурханы шударга ёсны төлөвлөгөөний суурийг дорд үзнэ (Гэтлэл 18:21; Сургаалт үгс 17:15-ыг үзнэ үү).

Ахан дүүсийнхээ дунд эвдрэлцлийг тарих

Бурхан мөн ахан дүүсийнхээ дунд эвдрэлцлийг тарих явдлыг үзэн яддаг. Сургаалт үгс 6 дээр “ахан дүүс” гэж хэлэхдээ, давхар эгч дүүсийг ч багтаасан гэдэгт би итгэлтэй байна. Эвдрэлцлийн эсрэг үг нь эвлэл юм. Энэ нь зөвшилцөл, зохицол, нэгдэл гэсэн үг. Эвдрэлцлийн завхарсан хараал дор орсон хүмүүст Давид хаан арга ухааныг зааж өгчээ:

Хуурмаг хүмүүстэй би суудаггүй.
 Дүр эсгэгч нартай хамт ч би явахгүй.
 Ёр мууг үйлдэгчдийн чуулганыг би үзэн яддаг.
 Буруутантай хамт би суугаагүй.
 Зэмгүй цэврээр би гараа угааж,
 Таны тахилын ширээг тойрно, ЭЗЭН.
 (Дуулал 26:4-8)

Бид Бурханыг, Бурханы гэрийг хайрласнаараа худалч, хоёр нүүртэн, ёрын мууг үйлдэгч нараас хол байна. Биднийг цуглах үед талархлын хандлага маань нэмэгдэж, Бурханы итгэмжтэй

байдал болон гайхамшиг тунхаглагдана. Бурханы тухай ярих нь биднийг цэвэрлэж, бусдыг дүүргэдэг.

Ийнхүү Сургаалт үгс 6 дээрх жагсаалт төгсөх боловч, Бурханы жигшдэг зүйлс үүгээр дуусахгүй.

Бэлгийн ёс бус явдал, цэвэр бус байдал, шүтээн мөргөл

Садарлагч, бузрыг үйлдэгч, шунахайрагч тухайлбал шүтээн шүтэгч аливаа хүнд Христийн болон Бурханы хаанчлалд өв байхгүй гэдгийг та нар мэд. Хэн ч та нарыг хоосон үгсээрээ бүү мэхлэг. Учир нь эдгээрээс болж Бурханы уур хилэн дуулгаваргүй хөвгүүд дээр буудаг юм. (Ефес 5:5-6)

Өөртэй нь дотно байхад саад хийж, биднийг мэхлэж, завхруулж, бохирлож, устгадаг зүйлсийг Бурхан үзэн яддаг. Бэлгийн ёс бус явдал (бүгд Библийн заасан зарчмын эсрэг бэлгийн үйл), цэвэр бус байдал (бохир, бүдүүлэг, зохисгүй хэл яриа, үйлдэл), шүтээн мөргөл (шунал ба сувдаглал) нь бүгдээрээ нягт холбоотой. Өнөөдөр бидний зугаа цэнгэл гэж нэрлэдэг зүйл дотор энэ гурав нь битүүдээ байж л байдаг.

Нэгэн хүн Лос - Анжелес хотоос Сидней хот хүртэлх 14 цагийн нислэгийн турш “*Хаадын тоглоом*” гэдэг киног тасралтгүй үзэхийг би харсан юм (Тэгэхэд л би анх удаа шахуу ганц нүдтэйдээ талархаж билээ). Би толгойгоо эргүүлэхдээ бас ариун цэврийн өрөө орохоор түүний хажуугаар зөрөхдөө, харсан зүйлдээ үнэхээр ой гутаж билээ. Тэр хүн бүр ухаанаа алдчихсан байлаа. Иймэрхүү зүйл нь сайхан баглаа боодолтой үзэгдсээр байгаад, яваандаа хэвийн зүйл болж хувирдаг. Тэгээд бид тэр зугааг биширч эхлэдэг нь үнэхээр харамсалтай.

Шунал

Бичээс шуналыг сувдаглал буюу шүтээн мөргөл гэдэг. Мөнгөнд хандах эрүүл бус хандлага (сувдаглал) нь тун аюултай. Учир нь мөнгө биднийг өөрөө өөртөө бурхад шиг санагдуулах увидастай гэдэг. Бид өөрсдийгөө хүчтэй, хүссэн бүхнээ авч чадна гэж төсөөлдөг. Эрх мэдлийг худалдаад авчихаж байхад, Бурхан ямар хэрэгтэй? Шунал, сувдаглал нь бодитой чанар шиг харагддаг учраас, олон нийт амархан хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ бүү мэхлэгдээрэй. Шунал нь хүмүүсийг өөрийгөө эрх чөлөөтэй гэж бодоход хүргэдэг, харгис олзлогч юм (Илчлэл 3:7-18). Шуналын хоригдлууд нь эд хөрөнгө, байр суурьтай тогтоох харилцаагаа хүмүүстэй тогтоох харилцаанаасаа ч дээгүүр үнэлдэг. Өгөөмөр байдал, даруу зан нь сувдаглал, шүтээн мөргөлөөс цэвэр байх хор тайлагч юм.

Есүс дагалдагч нартаа “Ямар ч зарц, хоёр эзэнд үйлчилж чадахгүй. Тэр нэгийг нь үзэн ядаж, нөгөөг нь хайрлах болно эсвэл нэгээс нь зуурч, нөгөөг нь зэвүүцнэ. Та нар Бурхан, эд баялаг хоёрт зэрэг үйлчилж чадахгүй” (Лук 16:13) гэж анхааруулсан.

Мөнгө бол хэрэглэх ёстой зэмсэг болохоос, хайрлах ёстой эд биш. Хүмүүсийг ашиглах бус, хайрлах ёстой юм. Харин энэ үг биднийг дараагийн санаан дээр авчирч байна.

Салалт

Учир нь Би салалтыг үзэн яддаг” гэж Израилийн Бурхан ЭЗЭН айлдаж байна. “Хувцсаа хүчирхийллээр бүрдэг хүнийг ч бас адил” гэж түг түмдийн ЭЗЭН айлдаж байна. “Өөрийн сүнсээр өөрийгөө хамгаалж, итгэлээсээ урвахгүй байгтун.” (Малахи 2:16)

Салалтын шарх маш эмзэг бөгөөд зовиуртай байдаг. Тиймээс л Бурхан үүнийг үзэн яддаг. Бурхан салсан хүмүүсийг нь үзэн яддаггүй ч, салалтын урагдлыг үзэн яддаг. Малахийн үед эмэгтэйчүүд салах эрхгүй байжээ. Тиймээс хайрлана байх гэж найдсан хөвгүүдийнх нь эсэргүүцээд, хаяад явсан гэрээнийхээ

хайртай охидын шарх, гомдлыг үзээд Бурхан Аавд ямар байсныг төсөөлж байна уу? Ийм явдал голдуу харийн эхнэрүүдээс болдог байв. Бурхан охид дээр нь ирсэн хүчирхийлэл, ичгүүрийг үзэн яджээ. Нью Интернэйшнэл Вержн дээр гэргийгээсээ салдаг эр “хамгаалах ёстой нэгэндээ хүчирхийлэл үзүүлж байгаа юм” гэдэг (Малахи 2:16).

Харин өнөөдөр эмэгтэйчүүд нөхрөөсөө салдаг болсон. Заримдаа урвалт, итгэл алдах, хүчирхийллийн зовиураас болж үр хүүхдийнхээ аюулгүй байдлын төлөө юмуу эсвэл өөрсдийнхөө төлөө салах нь хамгийн дээр арга зам гэж эхнэр нь юмуу нөхөр нь үздэг. Энэ тохиолдолд салалт нь Бурханы үзэн яддаг өөр нэг зүйлээс буюу гэрлэсэн боловч хайрлуулаагүй эмэгтэй болохоос хамгаалах хангамж болдог (Сургаалт үгс 30:23). Илүү нарийн судлаад үзбэл, Бурхан бидний хатуу харгис үйлдэл, бие биедээ хандах зүй бус хандлагаас болж л салахыг зөвшөөрсөн байдаг.

Гэрлэлтэд Бурхан хоёр хүнийг Сүнсээр нэг болгон сүлждэг:

Гэвч өчүүхэн ч гэсэн Сүнстэй хэн нь ч тэгэхгүй. Тэр Бурхантай үр удмыг хайж байхад тэр нэгэн юу хийж байсан бэ? Тиймд сүнсэндээ анхаар. Хэн ч залуу насныхаа эхнэрийн эсрэг бүү тэрслэг. (Малахи 2:15)

Гэрлэлтийн нэгдэл нь Христ, Түүний сүйт бүсгүй хоёрын нэгдлийг төлөөлөн харуулж байгаа юм. Амиа бодсон зан, итгэмжгүй байдал, үл тоосноос болж үүдсэн салалт нь биднийг хэзээ ч хаяхгүй Бурханы дүр зургийг зэрэмдэглэдэг.

Бурхан биднийг бат бэх хайрандаа эргэлзүүлэхийг хүсэхгүй. Тэр бидэнтэй байгуулсан гэрээгээ хөсөрдүүлэх ямар ч санаагүй. Тэр биднийг хэзээ ч хойш тавихгүй, хатуу харгис байдлаар айлган сүрдүүлэхгүй. Бид Түүнийг хичнээн хөсөрдүүлсэн ч, Тэр биднийг хэзээ ч хөсөрдүүлэхгүй.

Хэдийгээр хуулийн дор салахыг зөвшөөрсөн ч, бидний Бурхан бол сүйт бүсгүйдээ итгэмжтэй нөхөр болой. Салалт нь Сүйт хархүү болох Христ, сүйт бүсгүй болох чуулганы дүр зургийг гутаадаг. Тэр бол биднийг урваж байсан ч, бидэнд итгэмжтэй үлддэг Нэгэн.

Салалтаар гэр бүл, зүрх урагддагийг Бурхан ч, бид ч мэднэ. Бурхан урвалт, хаялтын харгис хүчирхийллийг үзэн яддаг учраас, салахыг зөвшөөрсөн ч, салалт нь Түүний гэрлэлтийн гэрээнд зориулсан анхдагч найдвар хэзээ ч байгаагүй юм.

Давхар жишиг хийгээд хоёр нүүртэй байдал

Дэнс хуудуутай аваас ЭЗЭНд жигшил.

Туухай төгс болбоос

Түүнд тааламж. (Сургаалт үгс 11:1)

Худал туухай ЭЗЭНд жигшил.

Хуурмаг дэнс сайн зүйл бус. (Сургаалт үгс 20:23)

Хоёр нүүрт Фарисайчууд Есүсийг байнга хоргоодог байлаа. Тэд хүний хаанчлалын хуулийг хэрэгжүүлээд завгүй байх хойгуур, Есүс Аавынхаа тэнгэрийн хаанчлалыг байгуулах ажлаа хийгээд завгүй байв. Тэд өөрсдийнхөө баримтлаж чаддаггүй өндөр жишгийг хүмүүст тулгадаг байжээ. Тэдний энэ давхар жишиг нь тунгалаг байх ёстой усыг булингартуулж байв. Тэд Саббат өдөр эдгээх хориотой гэж үздэг байсныг бид өмнө үзсэн. Нэг нь гэрээний тэмдэг байсан бол, нөгөө нь гайхамшгийг харуулсан. Матай 23:2-4 дээр Есүс дагалдагч нартаа анхааруулдаг:

Мосегийн сууринд хуулийн багш нар ба фарисайчууд сууж байна. Тиймээс тэдний хэлсэн болгоныг та нар үйлд, сахь.

Харин тэдний үйл хэргийн дагуу бүү үйлд. Тэд ярьдаг ч түүнийгээ эс үйлддэг. Тэд, үүрэхэд бэрх хүнд ачаа баглаж, хүмүүсийн мөрөн дээр тавьдаг атлаа *өөрсдөө үүнд хуруугаа ч хүргэхийг хүсдэггүй.* (Матай 23:2-4)

Бид бусдыг *өргөхийн* тулд бус, харин бусдад *харагдахын* тулд үйлсгүйгээр номлож байвал, өнгөрлөө л гэсэн үг. Шашныхан дайснуудаа дарамтлахын тулд бардамнал, хоёр нүүртэй байдалд идэгдсэн байдаг. Хоёр нүүртэй удирдагч нар бусдыг доош нь

хийснээрээ өөрсдөө өргөгдөнө гэж санадаг. Энэ нь Бурханы хаанчлалын эсрэг ажиллагаа юм. Биднийг Бурханы өмнө бөхийхөд, Тэр биднийг өргөдөг. Харин бид өргөгдсөн бол, бусдыг өргөхийн төлөө дахин бөхийдөг. Үнэндээ би хүмүүс миний “амжилт” гэдэг зүйлээс гэхээсээ илүү миний алдаанаас сураасай гэж хүсдэг юм.

Бүгдээрээ бусдын хоёр нүүртэй байдлыг уралдан муулахаасаа өмнө эхлээд бидний дотор ийм ул мөр байгаа эсэхийг Ариун Сүнснээс асууцгаая. Хоёр нүүртэй байдал нь маш зальжин аргаар хүн бүрт нэвтэрдэг. Тиймээс гагцхүү Бурханы Үг л үүнийг үндсээр нь сугалдаг болохыг би олж мэдсэн билээ. Үгийн үнэний гэрэл нь бидний сэдлийг хуваагаад, биднийг мэдээ ч үгүй байхад, гулгаж орсон алив харанхуйг илчилдэг. Энэ дайснаас сэрэмжтэй байгаарай. Энэ бол хорт дайсан шүү. Хоёр нүүртэй байдал нь шударга үнэнийг үзэн яддаг учраас, зориуд өөрийгөө үнэнийг хэлдэг хүмүүсээр хүрээлүүл. Зөвт хүмүүстэй нөхөрлөж, тэднээс шударга оролцоог хүсэн хүлээ. (Уучлаарай, гэхдээ фэйсбүүк дээр ингэх боломжгүй шүү)

Цэц ухааныг эсэргүүцэх

Цэц ухаан: чи үүнийг нэг бол үзэн ядна үгүй бол хайрлана). Цэц ухаанд дурлах арга нь нөгөө үзэн ядаад байдаг сахилга батаа хайрлахаас л эхлэнэ дээ. Цэц ухааны үгийг сонс:

“Гэнэнчүүд ээ та нар хэдий болтол
Гэнэдэл мунхаглалаа хайрлах вэ?
Хэр удаан, басамжлагсад басамжлалаа бахдаж,
Мунхагууд мэдлэгийг үзэн ядах вэ?
Гэгсгээлтэд минь эргэн ханд
Тэгвэл, би сүнсээ та нар дээр бялхуулна,
Үгээ би та нарт мэдүүлнэ. (Сургаалт үгс 1:22-23)

Цэц ухааны цутгалан өнөөдөр шиг хэрэгтэй үе байгаагүй байх аа! Би л хувьдаа хэзээ ч асууна гэж бодож байгаагүй асуултдаа

хариулт эрдэг болсон. Орвонгоороо эргэсэн дэлхий дээр бид бидний амь амьдралын суурь болсон Бичээс рүү дахин эргэх хэрэгтэй.

Сургаалт үгс 8 дээр цэц ухааны дуу хоолой нь Бурханаас эмээж, мууг үзэн ядах тухай дүрслэн ярьжээ: “ЭЗЭНээс эмээхүй нь ёрын мууг үзэн ядах явдал юм. Бардамнал, ихэмсэг зан, ёрын муу зам хийгээд гажсан амыг би жигшдэг” (13).

Дуулал 34:

Хүүхдүүд ээ, та нар ирж, Намайг сонс.
Та нарт ЭЗЭНээс эмээхүйг Би зааж өгье.
Амийг хүсэмжилдэг бөгөөд
Сайныг харахаар өдрүүдээ хайрлагч хэн бэ?
Хэлээ муу муухайгаас,
Уруулаа худал хэлэхээс сахин хамгаал!
Муугаас салж, сайныг үйлд,
Амар тайвныг хай, мөшгө! (11-14)

Завхарсан яриа, бардамнал гэдэг хослол нь муу ёрыг авчирдгийг энд хэлжээ.

Иов ном дээр Эзэнээс эмээхүй нь цэц ухаантай хослосон байдаг: “Үзэгтүн, Эзэнээс эмээх нь мэргэн ухаан бөгөөд Нүгэл муугаас хол явах нь ухаарал юм” (Иов 28:28).

Өөр нэг газар Эзэнээс эмээхүйг Түүний Үгд чичрэх явдал гэдэг. Миний бодлоор Эзэнээс эмээхүй нь бас Бурханы ариун чанарын илчлэлийн өмнө өөрийнхөө ариун бус байдлыг үзээд, Бурханы нигүүлслийн мутарт өөрийгөө үг дуугүй даатгах даруу байдал юм болов уу.

Есүс ч Эзэнээс эмээхийн жаргалыг эдлэсэн. Бурханы Сүнс Есүсийн амьдралд хэрхэн оршихийг Исаиа эш үзүүлэхдээ:

ЭЗЭНий Сүнс,
Мэргэн ухааны ба ухаарлын сүнс,
Зөвлөгөөний ба хүч чадлын сүнс,
Мэдлэгийн хийгээд ЭЗЭНээс эмээхүйн сүнс
Түүн дээр оршино.

Таалал нь ЭЗЭНээс эмээхүйд.
Тэр нүдэндээ үзэгдсэнээр шүүхгүй,
Чихэндээ сонсогдсоноор шийдэхгүй (Исаиа 11:2-3) гэжээ.

Ёрын муу

Хайр нь хоёр нүүргүй байг. Муу муухайг жигш, сайнаас зуурч ав. (Ром 12:9)

Хайрлах, үзэн ядах нь зориудын сонголт юм. Бүх хүнийг хайрлах хэцүү боловч, Бурхан байхад боломжтой. Харин бүх юмыг хайрлах нь тал зассан, боломжгүй зүйл. Өнөөдөр муу ёр газар сайгүй байна. Би үүнийг мэднэ. Гэхдээ энэ нь бид ёрын мууд автагдаад, дуугаа хураах ёстой гэсэн үг биш юм. Өнөөдөр саармаг байх цаг биш.

Бид ядуусыг хайрлахдаа, ядуурлыг үзэн ядах ёстой.

Бид дайныг үзэн ядахдаа, бэлбэсэн, өнчин, дүүрвэгсдийг хайрлах ёстой.

Мууг үзэн яд гэдэг нь бүгдийг үзэн ядаад бай гэсэн үг биш юм. Бид алан хядагч нар биш... бид Христэд итгэдэг хүмүүс. Бид мууг сайнаар ялахаар тослогдсон хүмүүс. Тиймээс бид худлаа ярьдаггүй бас мууг сайн гэж нэрлэдэггүй. Бид зүгээр л үгээр байлдаад явдаггүй. Бид үнэнээр амьдарч, үнэнийг хэлж, үнэний төлөө тэмцэнэ.

Чуулган үүнийг хийсэн шиг хийж чадаагүй.

Би ч үүнийг хийсэн шиг хийж чадаагүй. Гэхдээ би үүнийг хийсэн шиг хиймээр байна.

Бид олон жил хэний (Есүсийн) төлөө, юуны төлөө зогсдоогоосоо илүү юуны эсрэг зогсдоогоороо л илүү алдартай явжээ. Тиймээс чуулган энэ жинг тэнцвэртэй болгох гэсэндээ дэлхийн юм болгоныг дэмжих чиг хандлагыг өвлөөд, бүхнийг “хайр” гэж нэрийдэх болжээ. Тийм ээ, бид хүмүүст хайртай. Гэхдээ бид тулаан дунд байгаа учраас, юм болгоныг хайрлаж чадахгүй гэдгээ



Бурханы
ӨМНӨ
БӨХИЙХӨД,
Тэр биднийг
ӨРГӨДӨГ.

ойлгох ёстой. Чарльс Спержен “Бид дайснаа хайрлах ёстой ч, Бурханы дайсныг хайрлах ёсгүй юм. Бид тэр дайснуудад бүрэн ялагдлыг хүсэх ёстой ч, хүнд нь Бурханы уучлалыг хүртэж, Түүний найз, дагалдагч, зарц болохын төлөө нигүүлсэлт итгэлийн өөрчлөлтийг хүсэх ёстой.”²³ гэж бичжээ.

Бид шүүмжлэгч гэж хэлүүлэхээсээ айсандаа, таг дуугүй болжээ. Бид нөхөртэйгээ анх ам мурийснаасаа болоод, цаашид хэл амаа олж, харилцаагаа улам сайн сайхан болгохын төлөө хичээхийн оронд таг дуугүй болоод, харилцаагаа таслалчдаг эхнэр шиг байж болохгүй. Энэ эхнэрийн дуугүй байдал нь алсдаа тэдний харилцааг муутгаж, өсөх аргагүй болгоно. Өнгөрснийхөө алдаагаар өөрийгөө боомилохын оронд үнэнээр, даруугаар давшиж, барьж байгуулах ёстой зүйлээ барьж байгуулья.

Бид хайр дотор үнэнээр амьдарч эхлэхэд хүмүүс тэр хайраар ярьсан үнэнийг сонсож эхлэнэ. Энэ маш чухал. Учир нь үнэн байхгүй хайр нь худал юм.

Яагаад үзэн яддаг вэ?

Магадгүй чи айдаг зүйлээ үзэн яддаг байх. Би могой, аалз, хилэнцэт хорхойд дургүй. Бүгдийг нь үзэн яддаг боловч, могойг бүр ч үзэн яддаг. Би хилэнцэт хорхой харбал, алж л орхино. Миний бага хүүг дөрөвтэй байхад нь нэг муу хилэнцэт хорхой хатгаснаас хойш би тэр муутай мөнхийн дайсан болсон юм. (Анхааруулга: муусайн юмнууд чинь үхчихсэн царйлж жүжиглэдэг учраас, тун болгоомжтой байгаарай) Аалзнууд жаахан хэцүү. Хөдлөж байгаа нь ёстой балиар. Тиймээс би Жоноор юмуу хөвгүүдээрээ л алуулна. Гэр эр хүн байхгүй байвал, өөрөө үзнэ дээ. Могойн хувьд тэс өөр. Могойг гутлаараа ална гэж байхгүй. Ямар ч байсан би л тэгж бодож байна. Гэхдээ би оролдож үзээгүй л дээ.

Би хонгилын өрөөнийхөө буланд суугаад бичиж байна. Ширээн дээрх саван дотор том балиус байна. Би дэндүү олон удаа айснаасаа болоод, намайг гэртээ ганцаараа байхад, могой гараад ирбэл, би балиусаа бариад дайрахаар шийдсэн юм. Балиусаа гартаа бариад, чанга чанга залбирсаар, тэр мууг алаад өгнө! Яагаад гэвэл могой гэрт минь орж ирээд, өндөглөхийг би хэрхэвч

зөвшөөрөхгүй учраас, ийм “гэмт хэрэг” үйлдэхээс өөр аргагүй байна. Яагаад? Яагаад гэвэл би гэрийнхэндээ хайртай.

Надад үзэн яддаг өөр олон зүйл бий. Бидэнд заналхийлдэг юмс. Би хүүхдийн бэлгийн хүчирхийллийг үзэн яддаг. Би хүн хулгайлж, албадан биеийг нь үнэлүүлэх явдлыг үзэн яддаг. Тэгээд ч энэ хоёр асуудлыг жигшдэггүй хүнтэй би хэзээ ч таарч байгаагүй. Эдгээр үйлдэл нь хохирогчийг ч, араатныг ч алдгийг бид мэднэ. Үүний харгислал, завхрал нь үүнд гар бие оролцсон бүгдийг дотор гадаргүй сэглэж хаядаг. Бид хүмүүст хайртай учраас, эдгээрийг үзэн ядах нь ч аргагүй. Гэхдээ эдгээрийг үзэн ядах хангалтгүй. Бид порнографийг үзэн ядах ёстой.

Яагаад?

Яагаад гэвэл бэлгийн хүчирхийлэл, хүний наймааны цаад гол эзэн нь порнограф юм. Бид порнод дурлаж, хайрлаж, тоглоом шоглоом болгож ч болохгүй. Бид бэлгийн хүчирхийлэл, хүний наймааг үнэн голоосоо үзэн ядах ёстой. Хүчирхийлэл, наймааны хохирогч нарыг үнэхээр хайрлахын тулд бид үүний цаана байгаа эзнийг нь буюу порног үзэн ядах ёстой. Бид зөвөөр хайрлахын тулд хүмүүсийн сэтгэлийг хүүхэд, эмэгтэйчүүдийн хүчирхийлэгч болгон хувиргадаг зүйлийг нь үзэн ядах ёстой.

Порно хайрыг доош хийж, дотно байдлыг үгүй хийж, Бурханы маш нарийн нандин, гайхамшигтай бэлэг болох бэлгийн харилцааг гутаадаг. Порно нь Бурханы чөлөөлөхийг хүссэн хүмүүсийг боол болгодог. Тиймээс би бүх төрлийн порног (ном, кино, хэвлэмэл, дэлгэцийн) үзэн ядахыг сонгосон юм.

Порно хайрыг яадгийг би мэднэ. Яагаад гэвэл үүний үйлдэл нь мууг хайрладаг. Порно гэрлэлтийг яадгийг би мэднэ. Олон эмэгтэй надад нөхөр нь түүнд ойртохгүй байгааг гайхаж яддаг байснаа ярьж билээ. Тэгээд “Би хэрэггүй болжээ, би илүү сайхан байсан бол...” гэж бодоход хүрсэн боловч, үнэндээ тэдний харилцааг хийсвэр сексийн хий үзэгдэл гэдэг дайсан сөнөөснийг хожим олж мэджээ. Нөхрүүд нь хэзээ ч бодитоор хүрэхгүй дэлгэцийн дүрсэд сэтгэлээ өгсөн байжээ.

Хамгийн харуусалтай нь эмэгтэйчүүд ч олноороо энэ урхинд орж байна. Саяхан нэгэн судалгаа гурван эмэгтэй тутмын нэг нь долоо хоног тутам порно үздэг талаар хэлжээ.⁴ Түүнчлэн

The Huffington Post сонин дээр “Порно сайтаар зочилж байгаа хүмүүсийн тоо нь Нетфлекс, Амазон, Твиттерийг нийлүүлснээс ч давж байна.”⁵ гэсэн байдаг. Мөн “Шинэ хар тамхины эсрэг” байгууллага “Өнгөрсөн жил л гэхэд Порнхаб дээр 91,980,225,000 видео тоглуулагджээ. Энэ нь манай гариг дээрх хүн бүрт 12.5 видео ноогдож байна гэсэн үг”⁶ гэжээ.

Муухай!

Порно бол хайр биш. Порно нь Бүтээгчийнхээ гоо үзэсгэлэнгээр бүтээгдсэн хүнийг эд материал болгосноороо, бидний ухаан санааг хүчинддэг. Тэгээд энэ дүр дүрслэлийн олзонд орсон хүн ичгүүрт баригддаг. Бид олзны хүмүүсийг хайрлахдаа, биднийг сэм сэмээр лав гэгч нь урхидаж байгаа үйлдвэрлэлийг үзэн ядах ёстой.

Бид муу ёрыг үзэн ядахгүй бол, хайр маань худлаа болно.

Ром 12:9:

Хайр нь хоёр нүүргүй байг.

Муу муухайг жигш, сайнаас зуурч ав.

Бид муу
ёрыг үзэн
ядахгүй бол,
хайр маань
худлаа
болно.

Амаа үдэх өдөөлт нь дарамттай байж болно. Бид дуугарснаараа “туйлшрагчаараа” ч дуудуулж мэднэ. Намайг энэ асуудлаар дуугарах бүрийд “хувь хүн хувьдаа юу хийх нь тэр хүний хувийн асуудал” гэж дайрах Христэд итгэдэг хүмүүс заавал гарч ирдэг. Тэдний зөв л дөө. Гэхдээ би порногийн цаад талыг харсан учраас, дуугүй байж чадахгүй. Би хүний наймааны хохирогч болсон, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдээс авахуулаад, эрэмдэг болсон гэрлэлт, бэлгийн гаж донтон болсон хүмүүсийг харсан. Намайг энэ талаар ярих үед миний хуудсыг хакердаж, бөөн бөөн порно видео, зургаар бөмбөгддөг.

Бид ёрын муу руу холоос хараад мишээгээд байж болохгүй. Бид үүний оршихуйд татагдаж, харц хаяж болохгүй. Бид асуудлаас айсандаа дуугүй өнгөрч болохгүй. Урхинд орсон бол, тусламж гуй. Хайрыг хамгаалах тал дээр бид дуугүй өнгөрч болохгүй. Бид хүлээн зөвшөөрсөн баг зүүж болохгүй.

Үлгэр жишээ болсон Есүсээ дага

Чарльс Спержен: “Бид Есүсийн хайрладгийг хайрлаж, Есүсийн үзэн яддагийг үзэн ядаж, Есүсийн хайдгийг хайж, Есүсийн сэрэмжилдгээс сэрэмжилнэ. Хоёр биед нэг зүрх байгаа цагт ийм жинхэнэ нөхөрлөл боломжтой”⁷⁷ гэжээ.

Спержений хэлснээр, хайранд ч, үзэн ядалд ч Есүс бидний үлгэр жишээ мөн. Есүс юунд хайртай вэ? Хүмүүст. Есүс бүх алдагдсан хүмүүсийг хайж олоод аврахыг хүсдэг. Есүс дайснаа хайрлаж, тэднийг найз гэж дуудсан. Бурхантай нөхөрлөх нөхөрлөлд хүмүүсийг үзэн ядах сэтгэл багтахгүй.

Есүс юуг үзэн яддаг вэ? Есүс хайрын дайсныг үзэн яддаг... Хамгийн дээр, цорын ганц байх гэсэн хоёр нүүрт шашныг үзэн яддаг. Би хоёр нүүрийн талаар судлахдаа, өөрийнхөө хоёр нүүртэй талыг ч олж харсан юм. Би хүмүүсийг аврахаасаа илүүтэй зүгээр л харилцаа тогтоохыг хүсчээ. Зарим талаараа би хайртай гэхээсээ илүү дуугүй өнгөрдөг. Заримдаа би хурдхан шиг эргээд явчихын оронд холоос аальгүйтээд зогсдог. Одоо миний үзэн ядахгүй зүйлс үр ач нарын маань амьдралд хэвийн л зүйл болно.

Жи. Кэй. Честертон: “Хүлцэнгүй байдал нь итгэл үнэмшилгүй хүний чанар юм” гэж хэлсэн байдаг. Бидний хүлцэж өнгөрөөхөөр сонгосон зүйл маань хожим биднийг сүрдүүлэн заналхийлэхээр ирнэ гэдэгт эргэлзэх юм алга. Бид ямагт хүндэтгэлтэй, эелдэг байх ёстой ч, хүлцэнгүй байдлын үг дуугүй үйлдэл нь тэр дороо хөхүүлэн дэмжлэг болон хувирах чадалтай.

Есүс юуг хайна вэ? Есүс бидэнд “Гагцхүү эхлээд Бурханы хаанчлал ба зөвт байдлыг хайгтун. Тэгвэл энэ бүхнийг та нарт нэмж өгөх болно” гэж айлдсан (Матай 6:33).

Есүсийн сэрэмжилдгээс сэрэмжилнэ гэж юу гэсэн үг вэ? Есүс юунаас сэрэмжилдэг вэ? *Сэрэмжлэх* гэдэг үг нь аль нэг зүйлээс эргэж, зайлсхийх гэсэн үг. Энэ талаар бид өмнө үзсэн. Бид муутай суугаад, ирмэлцэж, шал дэмий зүйлсийн талаар яриа дэлгэдэггүй. Паул үүнийг сайтар дүрслэсэн байдаг:

тэдний нүдийг нээлгэж, тэднийг харанхуйгаас гэрэл өөд,
Сатаны эрхшээлээс Бурхан өөд эргүүлэхийн тулд юм.

Тэгснээрээ тэд Надад итгэх итгэлээр ариусгагдагсдын дунд нүглийн уучлал ба өв хүртэх болно.” (Үйлс 26:18)

Бид хүмүүсээс зугтдаггүй. Бид тэднийг сэтгэлийг нь харлуулагч зүйлээс эргэхийн төлөө залбирдаг.

Би дахин төрөхөөсөө өмнө Христийн нөхөр гэхээсээ илүү дайсан байв. Миний хатуу зүрх махан зүрх болох үед Есүсийн зүрхийг юу өвтгөдгийг би мэдэрсэн юм. Есүсийн амьдралын хэв маягийг дагахдаа, бид тас зуурдаг байсан юмсаа тавьж, Түүний нандигнадаг юмсыг барьж авдаг.

Нэгэн зууны өмнө Чарльс Спержен: “Өнөөдөр бид Аврагчийг хайрладаг хүнийг улайрагч, муу ёрыг үзэн яддаг хүнийг туйлшрагч гэж хэлдэг, тийм л нимгэн ухамсартай болжээ”⁸ гэж хэлж байжээ.

Тэгвэл өнөөдөр тэр юу гэж хэлэх бол? Манай соёлын ухамсар нимгэрээгүй, харин завхарчээ.

Бид хүмүүсийг чөлөөлдөг үнэнийг хайрлаж, хүмүүсийг хүлдэг худлыг үзэн ядах ёстой.

Бурхан ямар ч харанхуйгүй гэрэл шигээ, ямар ч муугүй, сайн юм. Төгс сайн Бурханд ширхэг ч муу байхгүй. Гэрэл, харанхуйн эвсэл гэж байхгүй, зөв буруугийн түншлэл гэж байхгүй, чөтгөрийн шүтээн Бурханы сүмд харъяалагдахгүй. Тэгвэл Есүсийн тухайд? Дуулал 45:6-7 дээр хэлсэн Давидын эш үзүүллийг Еврей ном эш татсан байдаг:

харин Хүүгийн тухайд “Бурхан минь, Таны сэнтий мөнхийн мөнх. Үнэн зөвийн очирт таяг нь Таны хаанчлалын очирт таяг мөн. Та зөвт байдлыг хайрласан бөгөөд Ёс бусыг үзэн яджээ. Тиймээс Бурхан, Таны Бурхан, Нөхдийн тань дээгүүр Таныг баяр баяслын тосоор тослов” гэжээ. (Еврей 1:8-9)

Есүс зөвийг хайрлаж, мууг үзэн яддаг. Түүний дагалдагч бид өөр байж болох уу? Тэгэхээр хавчлага бол бидний амьдралын нэг хэсэг болохыг бид санах ёстой.

Хүний Хүүгээс болж хүмүүс та нарыг үзэн ядаж, гадуурхан, доромжилж, нэрийг чинь ёрын муу мэтээр үзэж, үл ойшоох

цагт та нар ерөөлтэй ээ! Тэр өдөр баярла, баясан цовхч. Юу гэвэл, харагтун, тэнгэр дэх шагнал чинь агуу билээ. Тэдний эцэг өвгөд эш үзүүлэгчдэд ч тэгж хандсан юм. Харин баячууд та нар золгүй ээ! Та нар тайвшралаа дүүрнээр хүлээн авсан. Эдүгээ цаггалан буй та нар золгүй ээ! Та нар өлсөх болно. Эдүгээ инээж буй та нар золгүй ээ! Та нар гашуудан уйлах болно. Бүгд та нарын тухай сайнаар ярих цагт та нар золгүй ээ! Тэдний эцэг өвгөд хуурамч эш үзүүлэгчдэд ч тэгж хандсан юм. (Лук 6:22-23)

Ялгах хараа

Чарльс Спержен: “Ялгах хараа нь зөв, буруугийн ялгааг мэдэхгүй байх явдал биш, харин зөв буруугийн ялгааг мэдэх явдал юм”⁹ гэдэг.

Яг зөв сонсдох мөртлөө буруу мэдрэгддэг зүйл зөндөө бий. Өнөөдөр бид Ариун Сүнсний удирдамжтай хавсарсан, Бичээсийн нягт мэдлэг хэрэгтэй цаг үед аж төрж байна. Бичээс араамыг нь зангидаж, Хамгийн дээд Бурханы Сүнс бидэнд амийн үгийг өгнө. Бид Ариун Сүнсээр Бурханы Үгийг гэрэлтүүлж байж л хэнийг хэрхэн хайрлах, юуг хэрхэн үзэн ядахыг мэдэх болно. Би энэ бүлгээ Бичээсийг лав түшиж байж л бичлээ. Оруулах Бичээс олон байсан учраас, би номынхоо ард “Нэгдүгээр хавсралт” гэсэн хэсэг дор заримыг нь нэмж оруулсан байгаа шүү. Тэдгээр нь чиний хувийн амьдралд хэрхэн хэрэгжихийг Ариун Сүнснээс залбиран асуухыг хичээнгүйлэн хүсье. Би чамд юу гэж бодохыг чинь хэлж өгөхийн оронд, чамайг Ариун Сүнсээр хөтлүүлмээр байна. Дараагийн бүлэгтээ орохоосоо өмнө хамтдаа залбирах уу?

*Тэнгэрийн Бурхан Аав минь,
Би Таны хайрладгийг Таны хайраар хайрламаар байна.
Би хоёр нүүртэй баймааргүй байна. Би хайхрамжгүй
баймааргүй байна. Амьдралд маань Таны хайр цэцэглэхийн
тулд Надад үзэн яддаг зүйлээ зааж өгөөч.
Ариун Сүнс минь, эдгээр Бичээсийг амилуулж, амьдрал*

АДАМАНТ

*дээр минь буулгаач. Хүмүүсийг чөлөөлдөг үгээрээ дуугүй
байдлаа эвдэх зүрх зоригийг өгөөч. Есүсийн нэрээр. Амень.*



7

ҮНЭНИЙ ТӨЛӨӨ АДАМАНТ БАЙХ (ҮНЭНИЙ ТӨЛӨӨ БАТ БЭХ БАЙХ)

Би үнэнийг олохдоо, үнэн болох Бурханаа олсон юм.
Ариун Августин

Бид бүгдээрээ л худлаа ярьдаг ч, сэтгэлийн гүнд маань үнэний төлөөх санаашрал оршиж л байдаг. Үнэнгүйгээр бид бүгдээрээ доктрины салхи, сэтгэл мэдрэмжийн ааш бүрээр сэлүүргүй завь шиг л туугдсаар, сүйрэх тавилантай. Бид үнэнийг мөшгих юм бол, үнэн бидэнд зам гаргаж өгнө. Үнэн бол “юм” биш, “хэн” юм.

Юу үнэн болох талаар маргахын оронд үнэн яагаад чухал болохыг бид санах ёстой. Харин нэгэнт санаж байгаа бол, үнэн амьд учраас, бид үнэнээр амьдрах ёстой. Бид сэтгэлээ Аврагч Эзэндээ өргөхдөө үнэнээр амьдардаг. Тэр бидэнд “Зам, үнэн, амь

бол Би байгаа юм. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй” (Иохан 14:6) хэмээн айлдсан буюу.

Энэ мэдэгдэл үнэн аваас, утга бүр нь өөр хоорондоо холбоотой юм. Есүс *олон* замын нэг нь бус, харин *яг зам* нь мөн юм бол, Түүгээр дамжилгүйгээр хэн ч Аавд хүрэхгүй гэдэг нь үнэн болж таарна. Харин хэрэв Есүс Өөрийнхөө талаар худлаа хэлсэн байгаад, Тэрбээр Аавд хүрэх олон замын нэг нь байвал, Тэрбээр Үнэн байж чадахгүй. Тэрбээр Үнэн биш бол бас Амь байж чадахгүй.

Есүс нэг бол яг хэлснээрээ *бүгд мөн* эсвэл *нэг нь ч биш*. Аль аль нь байх боломжгүй. Бенжамин Франклин: “Хагас дутуу үнэн нь голдуу маш том худал байдаг” гэсэн. Хагас үнэний дотор худлын үр явж байдаг. Есүс үнэхээр зам нь мөн юм бол бас үнэн бөгөөд амь байх ёстой.

◆
Есүс нэг
бол яг
хэлснээрээ
бүгд мөн
эсвэл *нэг нь*
ч биш.

Гэхдээ бидний соёл туйлын гэдэг зүйлээс татгалздаг. Бид туйлын зүйл нь дэндүү хязгаарлагдмал, хатуу гэдэг итгэлд хүрчээ. Үнэн нь худлыг тасар татдаг ч, үүнийгээ хөдлөшгүй, зөөлөн арга замаар хийдэг. Үнэн нь өнгө дууны хувьд зөөлөн, зарчмын хувьд орлуулагдашгүй, туйлын байх ёстой. Туйлын гэдэг нь суурь юм. Харин суурь нь хөдлөдөггүй. Ийм туйл нь чанга харгис, барьж хорьдог биш, харин хамгаалдаг. Туйлгүйгээр буюу хэзээ ч хувирашгүй үнэнгүйгээр бид элсэн дээр л байшингаа барина. Туйл нь биднийг хамгаалдаг зарчим, амьдралын шуурга шуурч, өдөөлт урхихдах үед хөтлөдөг итгэл үнэмшил юм.

Бүх зам Ромд хүргэхгүй

Эрт дээр үед хүмүүс “Бүх зам Ромд хүргэнэ” гэж ярьдаг байжээ. Учир нь тэр үед Ром нь Ромын замын системийн төв байв. Гэвч цаг хугацаа улирч, Ромын эзэнт гүрэн нурсаны дараа энэ үг хэрэгжихээ больж, зүгээр л бүх зам эцэстээ нэг л газарт хүргэнэ гэсэн утгатай хэлц үг болон хувирчээ. Тэгвэл Ромын талаарх энэ үгийг Бурханы хаанчлал дээр хэрэгжүүлж болохгүй.

Бурханы үнэн нь хүний эрх мэдэл, сэтгэлгээний өөрчлөлтийг дагаж хөдлөх ч үгүй, өөрчлөгдөх ч үгүй. Энэ нь цаг хугацаагүй... мөнхийн зүйл юм. Бурханы зам нь Есүс Христ гэдэг хаалганаас эхлэдэг. Өөр арга зам байсан юм бол, Бурхан цорын ганц Хүүгээ илгээх шалтгаан юун? Есүс зүгээр л хамгийн шилдэг сонголт нь байсан юм бол, Түүнийг илгээх шаардлага юун? Би л хувьдаа хөвгүүдийнхээ нэгийг ч өгөхгүй - цорын ганц арга зам л биш бол. Есүс ганцаараа л бидний төлөө зовсон. Тиймээс авралд хүргэх олон зам бий гэж бодох нь үхлийн алдаа юм шүү. Гэхдээ яахав, бүх зам Есүстэй учрах учралд хүргэж болно оо. Бичээс:

Тиймээс ч Бурхан үлэмжийн дээдээр Түүнийг өргөмжилсөн бөгөөд Алив нэрээс дээд нэрийг Түүнд соёрхов. Энэ нь Есүсийн нэрд Тэнгэр, газар дээр, газрын доорх бүгд өвдөг сөгдөж, Бурхан Эцэгийн алдрын төлөө Есүс Христ бол Эзэн гэж Хэл бүхэн хүлээн зөвшөөрөхийн учир ажээ. (Филиппой 2:9-11) гэдэг.

“Газар доорх” гэдэг нь чөтгөрийн ертөнцийн талаар хэлжээ. Хожмын өдөр тэд Есүсийн дээд чанарыг хүлээн зөвшөөрөх боловч, хэзээ ч аврагдахгүй юм. Би туйлын үнэний талаар ярихдаа, *чиний* хувьд биш, *өөрийнхөө* хувьд үнэн байж болох зүйлсийн талаар яриагүй шүү. Жишээлбэл би Сицили эмэгтэй. Бас гэрлэсэн эмэгтэй. Бас ээж, эмээ хүн. Эдгээр нь бүгдээрээ үнэн боловч, хүн бүрийн хувьд үнэн биш юм. Тиймээс эдгээр нь туйлын үнэн биш, зүгээр л үнэн юм. Нөгөөтэйгүүр, арван жилийн өмнө миний хувьд үнэн байсан зүйл, өнөөдөр үнэн биш байж болно.

Үнэн боловч, “үнэн” биш өөр нэг зүйл нь манай гэрийн цонхоор Колорадогийн цэв цэнхэр тэнгэр харагдаж байна. Тиймээс би “Тэнгэр цэнхэр!” гэж итгэлтэй хэлж чадах бөгөөд энэ маань хэдэн цагийн турш үнэн хэвээрээ байна. Гэхдээ энэ нь үнэн хувирашгүй байх ёстой гэсэн параметрийг зөрчих учраас, туйлын үнэн биш юм. Нар жаргах үед тэнгэр цэнхэр байхаа болино. Тиймээс өдөр үнэн байсан зүйл, үдэш үнэн байхаа болино. Бид олон талаараа хүний сэтгэл бөхдөг үе дээр яваа юм биш байгаа гэж би айдаг.

Бидний амьдралын хандлага, улирал, талууд үнэн байж болно. Амьдралын нэг улиралд үнэн байсан зүйл дараагийн улиралд

үнэн байх албагүй. Ийм төрлийн үнэн нь бидний амьдралын тодорхой нэг хэсэгт орших бөгөөд өөрчлөгддөг. Нэг хэсэгт л хамааралтай аливаа зүйл нь туйлын үнэн байх боломжгүй. Үнэн зүйл харьцангуй байж болох ч, “үнэн” хэзээ ч харьцангуй байж болохгүй.

Бид үнэнд болгоомжтой хандахгүй бол, өнөөгийн энэ соёлд үнэн маш хэврэг зүйл болжээ. Тиймээс л бид үнэнийг нийгмийн үзэл санааны давалгаа, тухайн асуудлын талаарх мэдрэмжийнхээ савлагаанаас тусдаа авч үзэх ёстой. Үзэл бодолтой холбоотой үнэнийг *харьцангуй үнэн* гэдэг. Харьцангуй үнэн нь өөр, өөр юмс нь өөр, өөр хүн, цаг хугацаанд үнэн, зөв байж болно гэж үздэг. Энэ тодорхойлолтоор бол үнэн байнга хувьсах ажээ.

Харьцангуй үнэн нь үнэний амин утгыг завхруулдаг. Үнэн жинхэнэ үнэн байхын тулд хэзээд үнэн байх ёстой. Тийм байж чадахгүй бол, хүн худлаа ярьчихаад л, дараа нь “*миний хувьд үнэн*” гэж хэлж чадна. Үнэнийг хүлээн зөвшөөрлөөр тодорхойлж болохгүй. Тэгдэг байсан бол, бид бүгдээрээ л өөр өөр линзээр харна. Бидэнд Бүтээгчийн маань үзэл санаа руу сэтгэлийг маань чиглүүлэх хөдлөшгүй Адамант хэрэгтэй.

Христэд итгэдэг хүмүүс үнэнийг харьцангуй гэж итгэж болохгүй. Яагаад гэвэл бид бидний ах, Булангийн чулуу, Эзэн, Адамант болсон Есүс Христ - Үнэнд итгэдэг. Харьцангуй үнэн биднийг хүлээн зөвшөөрдөг бол, Бурханы Үг (Есүс Христ) биднийг өөрчилдөг.

Үнэн нь үнэнээ хэлэх юмуу эсвэл өөрийгөө зөв дүрслэхээс тэс өөр юм. Бид чин үнэнээ хэлж болох ч, тэр нь жинхэнэ үнэн *биш* юм.

Бид үнэнийг хэлж чадна.

Бид үнэн амьдарч чадна.

Бид үнэнийг хайрлаж чадна.

Бид үнэнийг үзэн ядаж чадна.

Бид үнэнийг няцааж чадна.

Бид үнэнд итгэж чадна.

Гэхдээ гагцхүү Христ л Өөрийгөө үнэн *хэмээн* мэдэгдэж чадна.

Будда олон сайхан үнэн үг хэлсэн ч, өөрийгөө үнэн *хэмээн*

мэдэгдэж чадаагүй юм. Будда өөрийгөө үнэний эрэлчин гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Үүнтэй адил Мухамед ч, олон үнэн зүйл хэлсэн боловч, өөрийгөө үнэн хэмээн мэдэгдээгүй юм.

Есүс “Би үнэний эрэлчин”, “Би бол олон үнэний нэг” гэж хэлээгүй. Есүс “Би бол үнэн” гэж хэлсэн билээ. Тиймээс бид бүх зам Ромд (авралд) хүргэдэг гэж хэлснээрээ, Есүсийг худалч болгож байгаа юм.

Үнэн гэж юу вэ?

Үнэн гэж юу вэ? Цаг хугацаа эхлэснээс хойш хүн төрөлхтөн энэ асуултыг тавьсаар иржээ. Гэтэл Иоханы Сайн мэдээн дээр Есүс үүнд хариулсан байдаг: “Үнэнээр тэднийг ариусгаач. Таны үг үнэн мөн.”

Энэ ишлэлд Үг дотор үнэн бий гэж хэлээгүй (мэдээж Бурханы Үгд үнэн бий), харин Бурханы Үг *өөрөө* үнэн гэжээ. Есүс бол махан биеэр ирсэн Үг учраас, Тэрбээр амьд Үнэнийг илэрхийлж байв.

Биднийг Бурханы ариун зорилгын төлөө тусгаарлахын тулд үнэн биднийг ерөөж, тусгаарладаг. Үнэн болох Есүсээс гадуур ариун байдал байхгүй. Бурханы Үг үнэн, Есүс махан биеэр ирсэн Үг юм бол, Есүс үнэн байх ёстой. Эцсийн дүнд үнэн нь субъектив биш боловч, хожмын өдөр бид бүгдээрээ үнэнд захирагдана.

Бурханы үг бүр тунгаагдсан байдаг
Өөрийнх нь дотор хоргодогсод Тэрээр бамбай
Түүний үгэн дээр бүү нэм,
Тэгвээс Тэр чамайг илчлэн зэмлэж, чи худалч болох вий.
(Сургаалт үгс 30:5-6)

Хүмүүс өөрсдийгөө их л цэцэн цэлмэг, учир шалтгааны илүү дээд мэдлэгтэй болсон бөгөөд одоо Бичээсийг цоо шинээр орчуулах цаг нь болсон гэдэгтээ итгэдэг. Гэхдээ дэлхий оронгоороо эргэчихээд байхад, бид яаж ингэж бодож чадна вэ? Бид өдөр бүр хүний ухаан санаанд багтамгүй хэрэг сонсож байна.

Бид цэц ухааны хэмжүүр юм бол, харин ч дэлхий биднийг хэмжээд, олон төрлийн гачаалд оруулсан мэт. Бид өөрсдийгөө соёорсон, гэгээрсэн гэж дэмийрэхийн оронд Бурханаас гэрлийг гуйвал, яасан юм?

Гэрэл ба үнэнээ илгээж, Намайг тэднээр удирдуулаач, Ариун уул ба орших газартаа Намайг тэднээр авчруулаач!
(Дуулал 43:3)

Гэрэл, үнэн хоёр нь итгэмжтэй хөтөч. Бурхан бол бүх үнэний эх үүсвэр болсон гэрэл. Гэрэл гэгээрүүлж, үнэн оршдог. Үнэнийг замын тэмдэг, гэрлийг замын гэрэлтүүлэг гэж үзэж болох. Харин тэмдгийг нь авчихбал, хүмүүс замаасаа төөрнө.

Хавчиг хаалгаар ор. Учир нь сүйрэлд хөтөлдөг хаалга нь уужуу, зам нь өргөн юм. Олонх нь түүгээр тийш ордог. Амь өөд хөтөлдөг хаалга нь хавчиг, зам нь нарийн юм. Цөөнх нь түүнийг олдог. (Матай 7:13-14)

Есүс бол амь руу хөтлөх нарийн хаалга. Тэр баталгаатай боловч бэрх зам. Хүмүүс хайрын Бурхан бүгдийг аврах л учиртай гэж маргадаг. Бурхан үнэхээр бүгдийг хайрласан. Бүгдийг урьдаг. Зам ч гаргаж өгсөн боловч, аль замаар явахаа бид өөрсдөө л шийднэ. Есүс биднийг нарийн үүдээр хүчээр чихэхгүй. Тэр энэ замаар явахын үнэ төлөөсийн талаар худлаа ярихгүй. Тэр амархан гэж худлаа хэлэхгүй. Тэр эхлээд Өөрөө явсан учраас, биднийг ч дууддаг: “Хэн нэг нь Миний араас дагахыг хүсвэл тэр өөрийгөө үгүйсгэн, загалмайгаа үүрч Намайг дага” (Марк 8:34).

Матай 7:13 дээр өөр нэг хаалганы талаар хэлжээ. Тэр нь өргөн хаалгатай, амархан бөгөөд өргөн зам ажээ. Энэ зам дээрх үгс нь биднийг өөрийнхөө төлөө, мөрөөдлөө хөөж амьдрахыг урамшуулан дэмжинэ. Өргөн хаалга нь биднийг хичнээн л бол хичнээн зүйл чирээд орохыг зөвшөөрнө. Энэ нь сүйрэлд хүргэх маш алдартай хаалга ажээ.

Энэ талбар дээр бид яг л харанхуй толинд харахтай адил байдаг учраас, бид Бурханы дуудсан дээд, ариун амьдралаар амьдрахын

тулд бидэнд гэрэл, үнэн хэрэгтэй. Гэрэл нь биднийг өөрийнхөө ойлголтын сүүдэрт талбарт амьдрах үед ирдэг харанхуйг хөөдөг.

Үнэн таагүй бөгөөд алдаргүй байлаа гээд үнэн байхаа больчихгүй. Үнэн нь мөнхийн бөгөөд Хамгийн дээд Бурханы Үг, хуульд оршдог. Үнэн санал асуулга, алдрын тэмцээнд захирагддаггүй.

Үнэний ортой зүйл зальжин шүү

Бид бүгдээрээ л худлаа ярьж явсан. Зарим маань өөрийгөө үнэн хэлж байна гэж бодоод худлаа ярьсан бол, зарим нь санаатай худлаа ярьсан. Бас бидэнд ч худлаа ярьдаг. Бидний л нэгэн адил тэр хүмүүс ч санаатай бөгөөд санаандгүйгээр бидэнд худлаа ярьсан.

Бид худлаа ярьж, яриулахаас гадна бас бүгдээрээ худалд итгэсэн. За яахав, би өөр дээрээ л ярья л даа. *Би* худалд итгэсэн.

Худлаа хэлэх түм буман шалтгаан байна аа. Заримдаа хүнийг гомдоохгүй гэж худлаа ярьдаг. Айхаараа худлаа ярьдаг. Алдахаас айсандаа худлаа ярьдаг. Хүмүүс харилцаа, эзэмшил, байр сууриа алдахаасаа айсандаа худлаа ярьдаг. Тийнхүү эдгээрийг олж авахын тулд худлаа ярина аа.

Чи үнэний төлөө бүтээгдсэн. Тиймээс тухайн үедээ хичнээн аймаар байсан ч, бид ямагт бусдад үнэнээр хандах ёстой. Өөртөө худлаа ярих нь тухайн үедээ амар. Гэхдээ миний амьдралд л гэхэд өөрөө өөртөө олон жил худлаа ярьсан талууд байлаа. Тиймээс эцсийн дүнд үнэн биднийг хамгаалж үлдэнэ гэдгийг бид санах ёстой.

Би өөрийнхөө талаарх худлыг хүлээн зөвшөөрөхөөр барахгүй, бусдын талаарх худлыг ч сонсдог байжээ. Үнэн гэдэгт итгээд, хожим худлаа болохыг нь мэдсэн удаа надад олон байсан.

Хэрэв би тэр чигээрээ үлдсэн бол, учир шалтгааныг тогтоох хүчин чадал маань учир зүйн ухаан, сайтар эргэцүүлээр эхлээд, яваандаа сэтгэл хөдлөл рүү шилжээд, эцэстээ хачин хөгийн байдлаар төгсөх байв. Мэдрэмж маань миний ялгаж салгах

◆
ҮНЭНИЙГ
ХЭЛЭХЭЭС
НААШ ХУДАЛ
ТАРХСААР
БАЙДАГ.

мэдэрхүйг байнга дээрэмдэж, өөрийнхөө худлын хорионд байлгадаг байсныг би ний нуугүй л хэлье. Худлыг нуувчаас нь гаргаж, үнэний гэрлээр шарахаас нааш, худал тэндээ ургасаар л байдаг. Үнэнийг хэлэхээс нааш худал тархсаар байна.

Үнэн дотор амьдрах

Есүс Өөрт нь итгэсэн иудейчүүдэд —Хэрэв та нар үгэн дотор минь байвал үнэхээр Миний дагалдагчид байна. Тэгээд та нар үнэнийг ойлгож, үнэн та нарыг чөлөөлнө гэв. (Иохан 8:31-32)

Бид Бурханы Үг болох үнэн дотор амьдрахдаа, үнэнтэй дотно танилцдаг бөгөөд амьдрал болгосон үнэн маань л биднийг чөлөөлдөг. Бид худал дотор амьдрахдаа хүлэгддэг шигээ, үнэн дотор амьдрахдаа хүлээсээс мултардаг. Есүс биднийг үнэн рүү урьж, бүгдийг маань хуримын зоогт урьдаг.

Тиймээс та нар гол гудамжаар явж, тааралдсан болгоноо хуримд морилон ирэхийг урь” гэхэд тэр зарц нар гудамжинд гарч, тааралдсан сайн муу бүгдийг цуглуулав. Хуримын танхим зочдоор дүүрчээ. Хаан зочдыг харахаар орж ирээд, хуримын хувцас өмсөөгүй нэгэн хүнийг харж түүнд “Анд минь, чи хуримын хувцасгүйгээр хэрхэн энд орж ирэв?” гэхэд тэр үг дуугүй байв. Тэгтэл хаан албат нартаа “Гар хөлийг нь хүлээд гаднах харанхуйд хая. Тэнд уйлаан, шүд хавирах нь буй” гэжээ. Учир нь дуудагдсан нь олон ч сонгогдсон нь цөөхөн гэж ярив. (Матай 22:9-14)

Хүн бүхэн үнэн дотор амьдрахаар дуудагдсан боловч, тийшээ зохих хувцастай хүмүүс л орно. Бид таар шуудайтайгаа навсайсаар биш, Христийг болоод Түүний зөвтгөлийг өмсөж орох ёстой. Хурга бидний хуримын хувцас, бидний бат бэх зам, биднийг хорогдуулах Булангийн чулуу юм.

Үнэн гомдмоор байж болно. Томас Пэйн “Гомдоохоос айдаг хүн шударга байж чадахгүй” гэсэн. Миний хувьд өнө мөнхлөл рүү

худлын замаар орж байснаас, гомдсон минь дээр. Яг үүнтэйгээ адилхан хүмүүсийг хуурч байснаас, гомдоосон минь дээр.

Есүс дотны дагалдагч нараа гомдоож л байсан. Иоханы Сайн мэдээнд:

Тэд үүнийг сонсоод, дагалдагчдын олонх нь —Энэ чинь хэцүү үг байна. Хэн үүнийг сонсож чадах вэ? гэцгээв. Харин Есүс үүний тухай дагалдагчдынхаа гүнгэнэлдэхийг мэдээд, тэдэнд —Энэ та нарыг бүдрүүлчихэв үү? (Иохан 6:60-61) гэдэг.

Тэд яагаад гомдов? Есүс дөнгөж сая нилээд хүчтэй үнэний бөмбөг хаячихжээ. Хэдхэн ишлэлийн өмнө Есүс “Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Хэрэв та нар Хүний Хүүгийн махыг идэж, цусыг нь уухгүй л бол та нарын дотор амь байхгүй” (Иохан 6:53) гэж хэлсэн байдаг.

Тэгэхээр энэ бол дагалдагч нарын хувьд янж нь даахгүй үг байв. Өөрийнх нь үг тухайн үед дагалдагч нарт ямар ч утга илэрхийлэхгүй боловч, хожим тэдэнд маш утга төгөлдөр болохыг Есүс мэдэж байв. Тэгэхээр бид өөрөөсөө “Би ойлгохгүй байсан ч, Есүсийг (үнэнийг) дагаж чадах уу?” гэж асуух ёстой болж байх шиг байна.

Энэ асуултад бид олон төвшинд хариулах ёстой. Аав ээжийнхээ хувьд, найз нөхрийнхөө хувьд, хань ижлийнхээ хувьд, удирдагч хүнийхээ хувьд, хэрэглэгч хүнийхээ хувьд тэгээд мэдээж хамгийн чухал нь амьд Бурханы зарц хүнийхээ хувьд.

Жишээлбэл, хэрэв би эрүүл бус харилцаа тогтоосон атлаа үүнийгээ цэгцлэхгүй бол, би эрүүл бус үйлдлийг дэмжинэ. Христэд итгэдэг хүн чимээгүй байх нь эргэлзээ үүсгэдэг. Хүн эрүүл саруулаар нүүр тулан ярилцахдаа, өсөх боломжтой болдог. Хэрэв юу ч дуугарахгүй байгаад л байвал, дургүйцэл өсч, хүний хувьд хэзээ ч хүсэн хүлээгээгүй гэнэтийн цууралт үүсдэг. Муу хувь нэмрээр сайн үр дүн гарахгүй. Тэгвэл ямар ч хувь нэмэргүй үнэн ч ялгаагүй юм.

◆

“Би
ойлгохгүй
байсан ч,
Есүсийг
(үнэнийг)
дагаж чадах
уу?”

Аливаа зүйлийн талаар таг байна гэдэг нь үүнийг дэмжсэнтэй л адил юм. Бид аливаа зүйлийн талаар дуугарахгүй бол, энэ нь “Надад чи ч хамаагүй, чамтай байгуулах харилцаа ч хамаагүй” гэж хэлэхтэй л адил юм. Анхаарал халамж тавьдаг хүн хуваалцдаг. Анхаардаг хүн ирээдүйнхээ төлөө харилцааны зөв зүйтэй суваг байгуулах замаар харилцаж, ярьдаг. Бид Христийн биед үнэхээр анхаардаг бол үйлдлээрээ, үгээрээ, чимээгүй байдлаараа ямагт үнэнийг хүндэтгэх ёстой.

Урамтай бөгөөд үнэмшилтэй амьдрах

Бурхан бидэн дээр мутраа тавьж байгаа нь бидэнд илэрхий харагддаг. Бурханы Үгийг зоригтой номлох төдийгүй, итгэл үнэмшилтэйгээр хэрэгжүүлэх үед өөрчлөлтийн уур амьсгал бий болдог. Шилжилт хөдөлгөөн өрнөдөг. Бид үнэнийг сонсох төдийгүй... үнэнээр амьдардаг. Ариун Сүнс биднийг ёвроход, бид анхаарлаа хандуулж, цэх зогсож, бидний тээж яваа үнэн үнэхээр ариун нандин зүйл болохыг улам ухаардаг. Бидний амьдралаар Бурханы Үг тунхаглагдахад, Ариун Сүнс бидний итгэл үнэмшилд төмөр суулгадаг.

Чихтэй нь үнэнээр амьдрах цэц ухаан, урам зоригийг хүлээн авна. Бурханы Үг сайн хөрсөн дээр унаж, нэн түрүүнд бидний амьдралд ургац авчирна. Энэ явдал эхлээд бидний дотор өрнөж, дараа нь *биднээр дамжин* өрнөнө.

Би саяхан өөрийнхөө маш зоригтой, хөөрхөн, залуу итгэлийн охинтой мессежээр харилцсан юм. Тэр надаас маш мундаг сүнслэг бэлэгтэй олны танил хүмүүс амин хувьдаа аймшгийн замбараагүй амьдралтай байдаг асуудалд хэрхэн ханддагийг маань асуусан юм. Тэдний хувийн амьдрал завхайрал, архидалд, санхүүгийн журамгүй амьдрал зэрэг асуудалд нэрвэгдсэн байдаг. Тэгэхээр нь би түүнд бидний амьдрал бэлэгээс илүү чанга номлодог гэдэгт итгэдэгээ тайлбарлаж хэлсэн юм. Бурханы бэлэг нь Сүнсний үр жимсээр хүрээлүүлэх ёстой бөгөөд Сүнсний үр жимс нь үнэнээр амьдрахад л төрдөг юм.

Үнэнийг мэддэг хүн үнэнийг хайхрахгүй амьдарч чадахгүй. Харин үнэнийг мэдэхгүй бол, үнэнийг хайх ёстой. Бид үнэнийг

Бурханы Үгээс хайж, Есүсийн амьдралаас харах ёстой. Тэгээд олсон бол, цаашид худал хуурмагийн хоригдол болсон соёл доторх үнэний дуу хоолойд таг дүлий царайлж чадахгүй. Эрх чөлөө гэж бодож явсан зүйл нь гинж байсныг одоо ч хүмүүс олж мэдсээр л байна. Хуурамч дэлхийд Есүс бидний үнэн болой.

Үнэн нь арслан ч, хурга ч мөн.

Үнэн нь худал нэвтрэшгүй, бат бэх бөгөөд цаг хугацааны аясаар хувирахгүй.

Үнэн шивэвгнээ дунд хашхирч, хашхираа дунд шивэвгнэдэг.

Үнэн хүмүүсийн санаа бодлоор бэхэждэг ч үгүй, сулардаг ч үгүй.

Үнэн хатуу боловч харгис биш.

Үнэн маргадаггүй. Учир нь үнэн бол эцсийн үг юм.

Үнэн цаг хугацаанаас давсан, өнө мөнхийн зүйл.

Үнэн итгэл үнэмшлийг бэхжүүлдэг.

Бид үнэний Үгээр амьдарснаараа үнэнийг доош нь хийсэн бүхэнтэй зоригтой тулдаг. Үнэн бидний хувийн амьдралд илэрхий байх ёстой. Олон хүн худлын таагүй байдал дотор амьдарч байхад, бид чимээгүй байдлын тав тух дотроо үлдэж болохгүй.

Тэнгэрийн Бурхан Аав минь,

Таны үнэн миний амьдралд илэрхий байх болтугай. Та

надад итгэл үнэмшил дотроо урам зоригтой алхах,

Таны үнэнийг хэлэх, Таны үнэнээр амьдрах хүчийг өгөх

болтугай. Миний үг хатуу биш, зөөлөн байх болтугай.

Амьдралын маань тал бүр Таны үнэнийг хайраар

илэрхийлэх болтугай.



8

ҮГЭЭР АДАМАНТ БАЙХ (ҮГЭЭР БАТ БЭХ БАЙХ)

Чулуу шидчихээд, буцааж болдоггүй ч, та чулуу аваад, шидсэнийхээ төлөө хариуцлагатай. Учир нь үйлдлийн үүсгүүр нь таны дотор байж.

Аристотел

Бидний үг дэлхий гэдэг далайд хол хаясан чулуу шиг л дуу чимээ бүтээдэг. Бусдын зүрх, чихэнд нэвтрэх эрх маань лавшрах тусам, хариуцлага, цэц ухааны хэрэгцээ маань ч өснө.

Би саяхан Номхон далайд аварга том хогон эргүүлэг үүссэн талаар сонсов. Зарим мэдээн дээр Мексикээс том гэсэн бол, зарим эх сурвалж дээр Техас мужийн дайтай гэсэн байв. Үүнийг “Номхон далайн хогийн сав” гэж нэрлэдэг аж. Энэ хогон эргүүлэг нь сая хавтгай дөрвөлжин милл нутаг дэвсгэрийг хамрах бөгөөд бараг 8.3 тэрбум метр тонноор хэмжигдэх ажээ. Далайд хаясан асар их хэмжээний хуванцар далайн түрлэгээр шидэгдсээр, ийнхүү бөөгнөжээ. Хуванцар задарч алга болоход дөрвөн зуун жил шаардагддаг учраас, 2050 он гэхэд далай дахь хуванцрын

хэмжээ нь далайн амьдралын бүрэн жинг давна гэсэн бодитой айдас байгаа юм.

Хуванцар жижиг хэсэг болон бутрахдаа, цахлай зэрэг далайн амьтдын идэш болох аюултай. Тэгээд загасны хоол болохоороо, эцэстээ эргээд хүний хоол болно гэсэн үг. Тиймээс далайн амьтдыг устгаад зогсохгүй, хүнийг хорлох аюултай энэ хорт бодис нь нэг л өдөр далайн ертөнцийг бүхлээр нь сүйрүүлэх аюултай. Гол санаа нь хуванцар хэзээ ч устаж алга болохгүй, цаг хугацаа өнгөрөх тусам үүний эд эс нь танихын аргагүй бөгөөд амь насанд аюултай болно.¹

Гамшгийн хэмжээнд тулсан их хэмжээний хуванцар, бидний амнаас гардаг хог шиг хорт үгийг санагдуулах.

Леонардо да Винчи ч Аристотелийн ухааныг давтан хэлдэг:

Цөөрөмд чулуу шидбэл...долгионууд нь эрэгтээ тулаад эргээд чулуу унасан газар руугаа чиглэх. Тийм боловч өөд өөдөөсөө зөрөлдөх долгионууд хэзээ ч бие биеийнхээ замд саад хийхгүй. ... Жижиг цөөрөмд унасан ганцхан дусал урагшлах хийгээд ухрах олон, олон хөдөлгөөнийг үүсгэх.²

Урагшлах хийгээд ухрах. Бидний үгс Христийн үйлсийг урагшлуулж байна уу эсвэл хүмүүсийг ухрахад хүргэж байна уу? Бидний чулуу жижиг цөөрмөөр хязгаарлагддаг байсан бол ч яахав. Гэтэл харуусалтай нь тэд унаад ертөнц гэдэг усан санд долгио үүсгэдэг. Өнөөдөр бид хичнээн хол чулуу шидсэн ч, үр нөлөө нь манай эрэг дээр ирдэг тийм л цагт аж төрж байна. Хэрэв бид Бурханы хайрын итгэл үнэмшлийг дамжуулж байгаа бол, олон олон сайн сайхан зүйлс хөдөлгөөнд орно гэсэн үг. Харин хэрэв бид хов жив, гүтгэлгийн чулуу шидэж байгаа бол, яг л тийм маягийн долгио эргэж ирнэ.

Үг нь Бүтээгчээс эхтэй ариун нандин итгэмжлэл юм. Хэн ч мэдэрсэн зүйлээ хүссэн цагтаа санал бодлын далайд шидчихээд, бусдыг буруу ойлголоо гэж дайрах эрхгүй. Энэ чинь хог хаяхаас ялгаагүй юм. Бидний үг амнаас гараа л бол, бид л өөрсдөө хариуцлагатай болно. Үүнд бичсэн, ярьсан, нийтлэсэн, дахин нийтлэсэн үгс багтана. Шинэ гэрээний анхааруулгыг нигүүлсэл хүчингүй болгохгүй. Иаковын үгсийг л сонс:

Ах дүүс минь, багш нар бид үлэмж хүнд шүүлтэд орно гэдгийг мэдэн, та нараас олноороо багш бүү бол.
(Иаков 3:1)

Багшлахад дамжуулах, харилцах, тайлбарлах, үзүүлэх, зааварлах, гэгээрүүлэх, тодруулах, биеэр харуулах зэрэг үйлдэл багтана. Энэ ишлэл нь зөвхөн багш нарт хандсан үг биш юм. Бид эдгээр зүйлийг хийдэг бол, энэ анхааруулга бидэнд хамаатай л гэсэн үг. Олон нийтийн сүлжээ, блог, нутгийн чуулганд заах зэрэг үйлдэл нь үнэний, цэц ухааны сүнсээр, харилцаа холбоотой, теологийн хариуцлагатай үйлдэгдэх ёстой. Бидний бичиж, зааж, хэлж байгаа бүхэн Бичээсийн зөвлөгөөтэй хамтрах ёстой.

Санал бодол хийгээд итгэл үнэмшил?

Үгээр бат бэх байхын тулд санал бодол, үнэний ялгааг мэдэх хэрэгтэй. Санал бодол нь хачин амархан бий болдог ч, дотроо хадгалахад хэцүү зүйл. Болгоомжтой байхгүй бол, санал бодол хэлж, хүлээж авах нь сүүлдээ дон болно шүү. Өнөөдөр хүмүүс юм л бол, юу гэж бодож, мэдэрч байгаагаа илэрхийлэх болсон. Үүнийхээ хажуугаар бид ямар ч санал бодлоо нүд ирмэхийн зуур санал бодлын далайд хаядаг болсон. Хүмүүс юу гэж бодож байгааг сонсох сайхан байж болох - ялангуяа яг бидэнд хандаж ярьж байх үед. Гэхдээ яг энэ талаар би чамд анхааруулга өгмөөр байна: танихгүй хүмүүсийн санал бодлыг толгой дээрээ бүү гарга.

Танихгүй хүмүүсийн хайхрамжгүй үгийн сумд оногдох вий. Виртуал нийгэмд бодитой нийгмээсээ илүү үүд хаалгаа дэлгэх хэрэггүй. Чи ууланд мацахаар бүтээгдсэн болохоос биш, утсаа маажихаар бүтээгдээгүй. Чи эможи харж баясах биш, амьд хүнтэй харилцахаар бүтээгдсэн. Бурханы үг дээр лайк дарж, репост хийгээд байх биш, харин Бурханы үгийг ярь. Мэдээж эдгээр нь буруу биш. Гэхдээ бас хангалттай биш. Чи гар бие оролцохоор бүтээгдсэн хүн.

◆

Санал
бодол
нь хачин
амархан
бий болдог
ч, дотроо
хадгалахад
хэцүү зүйл.

Харьцуулалтын урхинд орох вий! Гүнийхээ гүнд чи илүү том зүйлээр өлсөж цангаж л байгаа. Чи Бүтээгчтэйгээ байнгын холбоотой байгаа. Хамгийн дээд Бурхантай дотночлон ярих боломжтой байсаар байтал, яагаад танихгүй хүмүүсийг сонсох гэж? Бурхан чамайг Өөрийнхөө оршихуйд урьсан шүү дээ. Тэнд л чи харьцуулалт, садаанаас чөлөөлөгдөж, Ариун Сүнс чам руу амиа үлээхэд, чи цэх зогсоод, Түүний Үгээр амаа дүүргэнэ. Бурханы Сүнсийг амьдралдаа оруул.

Бид санал бодол нь итгэл үнэмшлээсээ давамгайлсан үед амьдарч байгаа нь тун тоогүй. Санал бодол биднийг татаж, түлхдэг бол, итгэл үнэмшил биднийг газардуулдаг. Итгэл үнэмшил нь итгэлийн системтэй холбоотой байдаг. Санал бодол нь яг л далайд хөвөх хуванцар сав шиг ийш тийш хөвдөг. Санал бодол нь хүн, юм, нийгэм соёлын чиг хандлагын урсгалыг дагадаг. Христэд итгэдэг хүнийхээ хувьд бид Бичээсээр хэлбэршсэн итгэл үнэмшилтэй байх ёстой бөгөөд эдгээр итгэл үнэмшил маань бидний санал бодлыг хэлбэршүүлэх ёстой юм. Санал бодлоороо итгэл үнэмшлээ бүү үгүй хий.

Шийдэмгий

Сэрэмжтэй бай. Итгэлдээ бат зогс. Эршүүд бай, хүчтэй бай.
(1Коринт 16:13)

Шийдэмгий байх гэж юу вэ? Бат бэх байх юм. Хөдлөшгүй, найрашгүй, ялагдашгүй байх.

Над шиг сэтгэл хөдлөлтэй, санаачлагч, мэдрэг, мэдрэмтгий гадагшаа зан чанартай хүнд шийдэмгий байх хэцүү байдаг. Би өөрийнхөө болоод бусдын мэдрэмжийг амьдралынхаа жолооны ард суулгачих гээд байдаг сул талтай. Би хүн бүрийг сонсож, багтааж, тэдэнд зөв гэдгийг нь мэдрүүлж, зөв байлгаж, аз жаргалтай болгохыг л хүсдэг. Нөгөөтэйгүүр би өглөөний эспрессо гэх мэт маш энгийн зүйлээс авахуулаад нийгмийн шударга ёсны асуудал хүртэлх зүйлсийн талаар яс санал бодолтой, улайрсан сэтгэлээр хандаж чадна. (Тийм ээ, үнэхээр ядармаар!) Бурханы Үг байгаагүй бол, би ч дуусах байсан л даа. Бурханы Үг байхгүй бол, би яг л

нэг харахад тэнгэрт дүүлж яваад, дахиад харахад газар уначихдаг цаасан шувуу л болно. Тиймээс би албан хүчээр санал бодлоо итгэл үнэмшлийнхээ дор барьж байх ёстой болдог. Ингэж барьж байхгүй бол, би аль нэг алдартай соёлын аашинд үрэгдэж дуусна.

Олон нийтийн сүлжээ нь бидний сул дорой чанарыг ч, хүч тэнхээг ч томруулдаг. Хэдэн жилийн өмнө би Фэйсбүүкийн дондогмаа болсон юм. Би өөрийгөө хүмүүст хангалттай сайн ойлгуулахгүй байх шиг байна, тиймээс илүү тодорхой тайлбарлаад өгөх юм бол, надтай маргалдаад байгаа хүмүүс гэрэлд гарна гэж бодохдоо, бөндөгнөж гардаг байлаа. Гэхдээ тэд надаар зүгээр л даажигнаж байсан учраас, мэдээж би юунд ч хүрээгүй юм (Би тэднийг бодитой гэж хэлсэн шүү дээ!)

Тэгтэл нэг хүү маань миний байдлыг анзаарч мэдээд, өөрийнхөө утсыг аваад: “Ээж, наадуул чинь ойлгохыг хүсэхгүй. Наадуул чинь зүгээр л олон хүмүүсийн өмнө тантай маргалдахыг хүсч байна. Зүгээр л таны орон зайг ашиглан, тан руу дайрч байгаа байхгүй юу. Тиймээс ярихаа боль! Зүгээр л блокло!” гэж тайлбарлаж өгөх үед л би энэ бүхнээ зогсоосон юм.

Би хүнийг блоклож болж байна уу, үгүй юу гэж гайхлаа. Арай л харгис биш үү? Гэхдээ үгүй юм аа. Энэ тохиолдолд блоклох нь өөрийнхөө орон зайг бөгөөд миний орон зай руу орж байгаа хүмүүсийг хамгаалсан үйлдэл байв. Олон нийтийн сүлжээ, дайсагналын сүлжээнд их ялгаа бий.

Ямар ч байсан би илчлэл хүлээж авсан юм.

Тэдний яриад байгаа зүйл нь өнө мөнхийн чанартай чухал зүйл биш байв. Энэ нь бат итгэл үнэмшлийн асуудал биш, харин санал бодлын асуудал байсан юм. Хүмүүс олон нийтийн сүлжээгээр аль нэг асуудлын талаар маш хурдан бөөгнөхийг бид хардаг. Үүний үр дүнд би хатуу итгэл үнэмшилтэй, зөөлөн санал бодолтой байхыг сурсан билээ.

Олон нийтийн сүлжээ нь хамгийн их бөөгнөрөл үүсгэдэг газар. Та нийтлэхихээд л, яваад өгнө. Үгийн бэлэгээ бэхжүүлж, хүчирхэгжүүлж, урамшуулж, хөтлөхөд хэрэглэ. Яг ингэдэг хүмүүсийг дага. Баталгаажуулахад зохистой зүйлийг баталгаажуул, эрүүл саруул зүйлтэй харилц, хүндэтгэлтэйгээр асууж бай. Гэхдээ хүмүүст биш, Бурханд таалагдахаар амьдар. Бичээс бидэнд:

Эцсийн өдрүүдэд хэцүү цаг ирнэ гэдгийг мэдэж ав (2Тимот 3:1) хэмээн анхааруулсан байдаг.

Яг энэ ишлэлийг Кинг Жэймс Вержн Библи дээр “Үүнийг мэдэж ав” гээд, “эрсдэлтэй” цаг үеийг дүрслэдэг. Англи Стандарт Библи дээр “Бэрх цаг ирнэ... гэдгийг ойлго” гэсэн байдаг. Мессеж Библи дээр “Бүү гэнэн бай. Өмнө чинь бэрх цаг байна” гэдэг.

Миний бодлоор тэр хэцүү цаг нь эхлэхээд байна. Уруудан доройтол нь ямагт үнэнийг болоод бүтцийг системтэйгээр доош хийхээс эхлэдэг. Бид Зам болох Есүсийн үнэн дотор бат бэх болохдоо, итгэл үнэмшил дээрээ суурилсан үг дотроо бат бэх байж сурна. Эртний чуулганд хандсан Паулын үгийг өөр дээрээ тусгаж үзье:

Бурханаар хайрлагдсан ах дүү нар аа, та нарын сонгогдсоныг бид мэднэ. Учир нь бидний сайнмэдээ та нарт зөвхөн үгээр бус, мөн хүч ба Ариун Сүнс дор бүрэн баталгаагаар очсон. Тэрчлэн бид та нарын төлөө дунд чинь ямар байсныг та нар мэднэ. Та нар үлэмж зовлон дор Ариун Сүнсний баяр хөөртэйгөөр үгийг хүлээж аван биднийг болон Эзэнийг дуурайгчид болсон. (1Тесалоник 1:4-6)

Бидэнд Үгийнхээ завшааныг өгсөн Нэгэнийг сонсох бас дагах цаг нь болжээ. Бабел цамхаг дээр хүмүүсийн хэлийг хутгасан тэр Нэгэн бидний амыг үдчихэж чадах боловч, тэгэлгүй, харин бидэнд хэл ярианы бэлэгээ зөв хэрэглэхийг зааварлажээ.

Би “*Өрсөлдөгчгүй*” номоо бичихдээ, хүйсийн талаар дундыг баримтлах боломжгүй талаар бүтэн бүлэг бичсэн билээ. Тэгээд ноорог дээрээ өөр нэгэн удирдагчийн дургүй хүрмээр саналын үг бүртэй нүүр тулж, чулууг чулуугаар хариулахаар шийдсэн юм. Миний мөрдлөгө наашаа цаашаа эргэлдсээр, сүүлдээ би санал бодлын ойд төөрснөө ухаарсан учраас, тэр бүлгээ үнэнч найддаа илгээв.

Гэтэл найз маань миний үгийг бослого тэмцэлд дуудсан уриалга болж хувирсныг эвтэйхэн хэллээ. Бичих явц дундаа би бичих биш, хашхирч эхлэсэн бөгөөд үүгээрээ сонсогч нараа бослогод уриалсан байв. Тэгээд найз маань аль хэсгийг нь хасахыг

заатал... бүлгийн тэн хагас нь болж таарав. Би ч сонссоор байлаа. Тэгээд хаслаа. Тэгсэн нь ч болсон юм. Санал бодлын ертөнцөд хэн ч төөрөх эрсдэлд орж болохгүй. Хүн бүрийн амьдралд сонсох хүсэлгүй үгийг нь хэлж өгч байх хүн хэрэгтэй. Тэд бидэнтэй харилцаа холбоотой, утас шөрмөсийг маань мэддэг, зориулалттай хүмүүс байх ёстой. Тийм ээ. Бид эрх мэдлийн дор байхгүй бол, бидэнд ямар ч эрх мэдэл байхгүй гэсэн үг. Бидэнд хэдэн тооны дагагч нар маань бус, харин хариуцлагатай ойрын хүрээнийхэн маань л эрх мэдэл олгодог.

Бид танихгүй хүмүүсийг ч, найз нөхдөө ч ямар ч хараа хяналтгүй санал бодлоор шүршиж, үгээр пуужин мэт харвадаг цаг үед амьдарч байна. Энэ нь Иаков ном дээрх анхааруулгатай (сонсохдоо түргэн, ярихдаа удаан, уур уцаарыг хойш тавь 1:19) зөрчилдсөн үйлдэл юм. Хүмүүс юу ч мэдэхгүй суугаа дэлхий рүү хаа хамаагүй үгээрээ харвадаг. Амархан үйлдэж, ямар ч хариуцлага хүлээдэггүй энэ цагт бид үгийнхээ үр нөлөөний цар хүрээг хэмжих арга байхгүй. Бид хэмжиж чадахгүй зүйлээ тээж чадахгүй.

Бичээс бидэнд “Харин мунхаг, утгагүй зөрчилдөөнүүд нь мөргөлдөөн бий болгодгийг мэдэн татгалз” (2Тимот 2:23) гэж анхааруулдаг учраас, би зарим төрлийн форумас холхон байдаг. Би тэр талаар сайн мэдэхгүй бол, хол байсан нь дээр. Би хариуцлагагүй бол, заавал хариулах шаардлагагүй. Хэн нэгний, ямар нэг юмны талаарх миний санаа бодол мэдрэмжийг маань даган унаж, босч болно. Тиймээс би аливаа зүйлийн талаарх санал бодлоо итгэл үнэмшлээсээ давуулахгүй байхыг хичээдэг (аль болох).

Санал бодлоор бус, харин үнэнээр хөдлөхийн тулд бид Бичээст буй үнэнтэй танил байх ёстой бөгөөд заримдаа бидэнд үүнийг ялгаж салгахад маань тусламж хэрэгтэй. Нэг найз маань нэгэн бүтээлийг зөвхөн зохиолчийг нь хүндэтгэдэг гэдэг шалтгаанаар уншаад л байсан боловч, түүнд нэг л биш санагдаад байжээ. Тэгэхээр нь нөхөртөө уншуултал, нөхөр нь мөр мөрөөр нь нэг

◆

Бид Зам
 болох
 Есүсийн
 ҮНЭН ДОТОР
 бат бэх
 болохдоо,
 ИТГЭЛ
 ҮНЭМШИЛ
 ДЭЭРЭЭ
 СУУРИЛСАН
 ҮГ ДОТРОО
 бат бэх
 байж
 сурна.

Хүн бүрийн
 амьдралд
 сонсох
 хүсэлгүй
 үгийг нь
 хэлж өгч
 байх хүн
 хэрэгтэй.

бүрчлэн уншиж байгаад, яг хаанаа Библийн үнэнээс хүний туршлага руу шилжсэн байхыг нь олжээ. Элч Паул харь хүмүүсийн дунд нэг янзаар, Иүдейчүүдийн дунд нэг янзаар амьдардаг Петртэй нүүр тулсан байдаг шүү дээ. Бидэнд үнэнийг хэлдэг хүн хэрэгтэй.

Үгийн хүч

Үг нь амь, үхлийг бүтээх чадалтай үр юм. Үг нь байгуулж бас алж чадах чулуу юм. Бичээст хайртай гэхихээд, өөрөөр амьдрахаа больё. Үг нь нандин бөгөөд аюултай.

Ойрх Дорнод яллагдагчийн үхэлд хэнийг ч буруутгахгүйн тулд олон нийтийн дунд чулуугаар нүүлгэж алах ёсыг хэрэгжүүлсээр ирсэн юм. Тэгвэл чулуугаар нүүлгэх энэ шийтгэл нь манай Баруунд ч байдаг. Зүгээр л жаахан өөр хэлбэртэй. Бид чулуугаар бус, үгээр нүүлгэдэг. Тэгээд энэ ажилд олон хүн оролцох тусам, бид бага ял зэм мэдэрдэг. Хүн бүр ямар нэг юм хэлж байвал, хэн ч буруугүй, тийм үү?

Манай соёл ийм л шалтаг хэлдэг ч, бид ингэж болохгүй. Бид илүү өндөр төвшний зорилго, жишигт хариулдаг. Бид энэ дэлхийн иргэд биш. Бид мөнхийн хаанчлалын элч нар. Дэлхий мэдэхгүй байсан ч, бид үгийн хүчийг мэднэ. Бид илүү мэддэг учраас, бусад руу чулуу нүүлгэж болохгүй. Учир нь илүү мэддэг хүмүүс илүү сайныг хийж чадна.

Энэ санал бодлын ертөнцөд Бурханы Үгийн дэнлүү, Ариун Сүнсний удирдамж ус агаар шиг хэрэгтэй. Эргэлзээний бүтээлэг дор худал хуурмаг бэхжиж байдаг. Надад бүх хариулт байхгүй бас би чиний тохиолдолд яах ёстойг зааж өгч чадахгүй. Би чамд хэрхэхийг чинь хэлж өгөх биш, харин чиний сонсож, сурах ёстой эх сурвалж руу чинь л чиглүүлж өгье.

Хов жив

Хэлж байгаа үгээ бодож, Бурханыг өвтгөхөө больё. Хов жив хэзээ ч Бурханыг алдаршуулдаггүй. Заримдаа олон нийтийн сүлжээ тэр чигээрээ л хов жив байдаг. Би анх Ариун Сүнснийг гомдоохдоо үүнийгээ шууд мэдэрч билээ. Надад хүнээр хэлүүлэх шаардлага байсангүй. Би юу хэлснээ санадаггүй ч, юу мэдэрснээ санадаг. Гэнэт л хэвлийд маань айсуу аюулын анхааруулга шиг таагүй чичирхийлэл бий болж билээ.

Яг л хүүхэд байхдаа аав, ээждээ худлаа хэлэх үед тэгдэг байсан сан. Тийм мэдрэмж төрөлгүй олон жил болжээ. Үнэндээ би сүүлийн хэдэн арван жил хүссэн үгээ л хэлсээр иржээ. Тэгээд намайг нэг хүний талаар таагүй үг хэлэх хүртэл зүгээр л байдаг байв. Би бусдаас сонссон эсвэл харсан зүйлээ давтчихсан уу? Миний бүх нүгэл уучлагдсан байтал, надад яагаад ийм мэдрэмж төрнө вэ?

Гэтэл би нэг зүйлийг ойлгоогүй байжээ. Би Христийн замаар алхаж эхлэхдээ Ариун Сүнснийг бүх зүйлийнхээ зөвлөх байлгахаар урих тэр үед бүх зүйл өөрчлөгдсөн байжээ. Тэр ажлаа үнэн голоосоо хийсэн байв!

Дийлэнх хүмүүс бусдыг санаатайгаар дээрэмдэж, алж, хараадаггүй ч, хов живээс болж бид энэ гурван нүгэлд гурвууланд нь яллагддаг. Тийм ээ, миний бүх эд эрхтэн дундаас ам маань л надад хамгийн их асуудал тарьсныг би мэднэ. Тэгээд миний хэлсэн үг бусдад гай тарьсан нь тун харуусалтай. Би ингэж хэлмээргүй байгаа боловч - өөрийнхөө бодлогогүй үгээр хань ижлээ дэндүү их өвтгөсөн гэдгээ хүлээн зөвшөөрөхөөс өөр арга надад алга. Бас хэт хатуу бас хэт зөөлөн үгээрээ хүүхдүүдээ зовоосон. Би ярих эрхгүй зүйлийнхээ талаар том том дуугарсан. Би дуугарах ёстой үедээ амаа үддэг байсан. Түүнчлэн бусдын үг надад бодсоноос минь илүү асуудал тарьсан.

Эдгээдэг үг

Үг нь энэ дэлхий дээрх эвлүүлж бас нураадаг хамгийн хүчтэй зүйл. Хүмүүсийн үг намайг шархлуулдаг бол, Бурханы Үг намайг эдгээдэг. Хүмүүс Бурханы Үгийн үнэнээр миний амьдралыг услах үед эдгэрэл өрнөдөг. Түүнчлэн Бурхантай уулзаж, залбирч байхад Библийн нэг хэсэг юмуу ишлэл гэнэт намайг тэвэрч авах үед эдгэрэл ирдэг. Тэр эгшинд бүх зүйл хөшиж, нүд маань нээгддэг. Бүтээгчийнхээ цэц ухааныг сонсож, үүнд итгэхдээ бид зөв зүйлийг амархан аргаар сурдаг.

Бурхан ба Эцэгийн өмнө цэвэр бөгөөд бузартаагүй сүсэглэл бол өнчин хүмүүс, бэлэвсэн эхнэрүүдийг зүдрэхэд нь эргэж тойрон, өөрийгөө ертөнцөөс бохирдуулалгүй хамгаалах нь ажгуу. (Иаков 1:27)

Бид энэ ишлэлд хайртай. Гэхдээ бид өмнөх ишлэлийг нь хэр их эш татдаг бол?

Хэн нэгэн нь өөрийгөө сүсэгтэй хэмээн боддог хэдий ч хэл амаа хазаарладаггүй бол зүрхээ хуурч буй бөгөөд сүсэглэл нь ашиггүй ажээ. (Иаков 1:26)

Новшийн үг

Хийсэн зүйлээ хэлсэн үгээрээ битгий хөөдөөрэй. Иаков биднийг зөв зүйл хийсэн атлаа буруу юм яриад байвал, шүтлэг маань худлаа хоосон болно шүү гэжээ. Яагаад? Яагаад гэвэл бидний зүрхний нөхцлийг үг хэл шиг маань илчилдэг зүйл байхгүй.

Уучлаарай найзууд аа, бидэнд хийх ажил байна.

Иаков ном цааш нь:

Учир нь бид цөмөөрөө олон юман дээр бүдэрдэг. Үгэн дээрээ бүдэрдэггүй нэгэн байваас, тэрээр бүх биеэ хазаарлах чадвартай төгс хүн болой. Морьдыг залахын тулд бид амыг нь амгайвчилж, бүх биеийг нь жолооддог (3:2-3) гэжээ.

Есүс бол Аавынхаа хэлснийг л хэлдэг цорын ганц төгс хүн байжээ. Есүсийн дүү Иаков энд маш сонирхолтой дүрслэл хэрэглэжээ. Бидний хэлдэг бас хэлдэггүй үгс, бидний амьдралын зүг чигийн хооронд харилцаа холбоо байдаг ажээ. Тэгээд Иаков аян замаас далайн замын дүрслэл рүү шилжжээ.

Мөн усан онгоцуудыг хар. Тэдгээр нь хэдийгээр агуу том болоод зогсохгүй хүчит салхинд туугддаг боловч жижигхэн залуураар залуурчийн хүссэнээр жолоодогддог. (3:4)

Салхи шуурга тавьж, амьдрал аймаар санагдаж байсан ч, бид энэ шуурга дундуур Бурханы Үгийг тунхагласаар туулаад л гарна.

Түүнчлэн хэл ч гэсэн биеийн жижиг эрхтэн атлаа агуу том зүйлсээр сайрхдаг ажээ. Харагтун, өчүүхэн гал ч ямар их ой модыг түймэрддэг билээ. (3:5)

Байр байшингаа шатаачихгүйхэн шиг, өөрийгөө юмуу ах эгч дүүсээ замаас нь гаргачихгүйхэн шиг байя.

Дэлхийн хоёрдугаарт дайны үеэр дэл сул яриа аминд халтайг хүмүүст сануулахын тулд “уруулаа нээвэл, онгоц живнэ” гэж ярьдаг байжээ. Хүмүүс дайсандаа нууцаа алдахгүйн тулд хэл амаа мэдэж байх ёстой байв. Дайны цагаар биднийг хэн сонсож байгааг мэдэх аргагүй.

Амьдралд чинь Бурханы босгох гэж байгаа зүйлийг чи үг яриагаараа живүүлэх гэж байгаа юм биш биз? Тэр бөгтөртэй морьхоноо буруу тийш нь залаад байгаа юм биш биз?

Хүссэн боломж, дэвшлээ хаагаагүй биз?
Харилцаагаа эдгээж, сэргээхэд саад хийгээгүй биз?
Хүлээсэн залбирлаа үг, үйлдлээрээ хориогүй биз?
Сонсох ёстой улиралдаа байгаа юм биш биз?
Өнгө дуу чинь буруу байгаа юм биш биз?

—◆—
Хийсэн
зүйлээ
хэлсэн
үгээрээ
битгий
хөөдөөрэй.

Буруу хүмүүстэй зөв яриа эхлүүлээгүй биз?
Сурах ёстойгоо сурахгүй яваа юм биш биз?
Хариултаасаа илүү асуулттай яваа юм биш биз?

Матай 12:36-37 дээр бидэнд “Би та нарт хэлье. Бодлогогүй хэлсэн үг бүрийнхээ төлөө хүмүүс шүүлтийн өдөр тайлагнах болно. Учир нь чи үгсээрээ зөвтгөгдөнө мөн үгсээрээ яллагдана” гэж амласан.

Бид Есүсийн үгийн хариуд юу хэлсэн, хэрхэн хэлснээрээ шүүгдэнэ. Би үгээрээ Түүний амьдралыг хүндэтгэхийг хүсч байна. Эцсийн эцэст би шашны жуулчдыг биш, дагалдагч нарыг бий болгохыг хүснэ.⁶

Зөв асуулт, буруу сонсогч

Би баахан эрчүүдтэй амьдардаг учраас, зурагтын удирдлагыг гартаа оруулах маш хэцүү байдаг. Бид саяхан гэр бүлээрээ амарч явахдаа, бүгдээрээ үзчих аятайхан юм хайж байтал, удирдлагыг гартаа авсан хүн “Загалмайлсан эцэг” киноны нэг үзэгдэл дээр түр зогсоочихов. Сицили угсаагаараа огшиж явдаг хүнийхээ хувьд би бидний сайн мэдэх тэр киноны нэгэн үгийг хуваалцмаар байна: “Гэр бүлээсээ өөр хүнд юу бодож явдгаа хэзээ ч бүү хэл!”

“Хэзээ ч” гэдэг үг магадгүй мафийн хүрээнд л хэрэгждэг байх л даа. Гэхдээ л энэ үгд цэц ухаан бий шүү. Эрүүл саруул гэр бүл л бидний бодлоо хуваалцах газар. Төгс гэр бүл гэж байхгүй, харин гишүүн бүрээ өсгөхийн төлөө явдаг эрүүл саруул гэр бүл л гэж бий.

Магадгүй чи “*Байзаарай Лиза, манай гэрт Христэд итгэдэг хүн байхгүй*” гэж хэлмээр байна уу? Тэгвэл гэр бүл гэдэг ойлголтоо арай том хүрээгээр аваад үз. Чи итгэлийн гэр бүл дотроо хэлж ярьж болно шүү дээ. Гэр бүл гэдэг чинь чиний төлөө байгаа хүмүүс шүү дээ. Чамтай хамт хүндэтгэдэг, жижиг бүлэгт чинь байдаг эсвэл чамтай хамт ажилладаг Христэд итгэдэг хүмүүс. Олон нийтийн сүлжээ гэр бүл ёстой биш шүү. Олон нийтийн сүлжээ хувь нэмэрт л хэрэгтэй болохоос биш, хамаг юмаа уудлах газар биш шүү.

Тэр кинон дээр бас “Тэр бүлийнхээ эсрэг хэзээ ч, хэний ч талд бүү ор!” гэдэг.

Манай итгэлийн гэр бүлд олон асуудал бий. Чуулган эмэгтэйчүүдийг дэмжих тал дээр өсөх ёстой юу? Тийм ээ! Энэ асуудал дээрдэж байгаа юу? Тийм ээ! Бидэнд ярилцах ёстой өөр сэдэв байгаа юу? Тийм ээ! Гэхдээ бид Бурханы сүйт бүсгүйн эсрэг зогсоод хожих уу?

Саяхан эмэгтэйчүүдийг чуулганыхаа удирдагч нартай гашуудлаа хуваалцаад, тэд эмэгтэйчүүдийн асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар ярилцахыг уриалсан жиргээ дэгдэв. Энэ ярианд маш олон эмэгтэй дуу хоолойгоо өргөсөн бөгөөд энэ асуудал бүр олон нийтийн асуудал болсон юм. Гэхдээ чуулганы талд орж байгаа хүмүүсийг хасаад байгааг би анзаарав.

Ийм яриа хэрэгтэй байсан уу? Тийм ээ. Хэдийгээр энэ нь шийдэл олох сайн дурын зөв ажил мөн боловч, олон нийтийн сүлжээ ийм асуудлыг шийдвэрлэх зөв газар мөн байсан гэдэгт би эргэлздэг юм.

Хэрэв чамд хариулт байгаа бол, олон нийтийн сүлжээний дээвэр дээрээс хашхир! Гэхдээ зүгээр л гомдоллож, шүүмжилж, стратеги зохиох гэж байгаа бол, зөв хүмүүсийнхээ л анхаарлыг татаарай. Олон нийтийн сүлжээний хувьд танай ширээнд хэн хэн суусныг мэдэх боломжгүй шүү. Зөв асуудлын талаар зөв хүмүүстэй л ярья.

Олон нийтийн сүлжээ, олон нийтийн форум дээр чуулганыг гутаах яриа хөтлөх нь яг л сүйт бүсгүйнхээ муу муухайг илчилж ичээхтэй ижил юм. Биднийг үзэн яддаг дэлхийн систем гэж байдгийг Бичээс хэдийнээ хэлчихээд байхад, ийм зүйл хийх тустай гэж үү? Бидний яриатай ямар ч холбоогүй хүмүүсийн шийдвэр бидэнд ямар нэг тус хүргэх үү?

Олон нийтийн тал дээр бид өөрийгөө даруу болгож, сайн хайрлаж чадаагүйгээ хүлээн зөвшөөрч болно. Тэгвэл бид хамтдаа босоод, хийснээ хүчингүй болгох бус, харин болгож болох зүйлийнхээ талаар ярих хэрэгтэй. Бид буруу хүмүүстэй л зөв зүйлийн талаар яриад байдаг. Ингэх нь үнэндээ шал тэнэг юм.

Халдвар

Онлайнаар ямар нэг зүйл тархахад, хүмүүс нөлөөлөх биш, харин нөлөөлөгдөх нь илүү. Тиймээс бид нийтлэгчээ алдаршуулдаг

◆
Нураадаг
биш,
барьдаг
хүмүүс
байя.

биш, харин урт настай өөрчлөлт авчирдаг зүйл л нийтлэхдээ анхаарья. Хүмүүсийн барьж байгуулсан зүйл рүү, хэрхэн барьж байгуулсан зүйл рүү дайрч давшихаа азная. Нураадаг биш, барьдаг хүмүүс байя. Би ч бас эмэгтэйчүүдийг онилсон, ул үндэсгүй гүтгэлгийн бай болж үзсэн. Би одоо жар дөхөж яваа ч, зарим хүмүүс намайг хэт чанга, хэт анхаарал татмаар байна гэж дайрдаг. Би цөөн хэдэн хүний сэтгэгдэлтэй байлдаад,

барьж босгож байгаа ажлаа зогсоохгүй. Би шүүмжлэх биш эш үзүүлэхээр, нураах биш босгохоор тослогдсон. Чи ч ялгаагүй!

Зөв хариулт олохын тулд бид ширээндээ зөв хүмүүсийг цуглуулах ёстой. Энэ нь бид яриандаа нас насны, үндэстэн үндэстний эмэгтэйчүүдийг урих ёстой гэсэн үг. Жинхэнэ хүмүүсийн дунд ярилцлага өрнүүлэх үед бид охидын асуултаас, ээжүүдийн туршлагаас, эмээ нарын цэц ухаан, үзэл бодлоос суралцдаг. Энэ бол амархан тасардаггүй, гурамсан сур билээ.

Үгээ жинлэх

Олон нийтийн сүлжээ маш сайн сайхан зүйл авчирдаг. Бид хурууныхаа үзүүрээр л урам хайрлаж чадна. Мэдээлэл маш хурдан тархдаг. Хувийн бөгөөд улсын хэмжээний зэрэг бүх төрлийн залбирлын хүсэлт тавьж болно. Намайг энэ номыг бичиж байхад, та нар миний төлөө сэтгэл гарган залбирсан. Олон нийтийн сүлжээ нь олон талаараа тустай, урамтай, бэрхтэй, мэдээлэлтэй, соён гэгээрүүлсэн байж чадна.

Би олон нийтийн сүлжээг хууль ёсны хүрээнд ашиглах завшаанд нухацтай ханддаг. Заримдаа би үгээ бодож цэнээгүйгээсээ болоод алдаа гаргадаг. Гэхдээ нөгөө талаас сайтар бодож боловсруулаад хэлсэн ч, буруу ойлгогдох боломжтой байдгийг би бас харсан. Учир нь миний үг хэнд хүрэхийг би мэдэхгүй. Харин энэ нь үр

нөлөөтэй харилцааны түлхүүр юм. Хүн бүр өөр өөр шүүлтүүрээр сонсож, хардаг.

Би л хувьдаа намайг амьдралдаа оруулах хүндэтгэл, боломжийг надад олгосон хүмүүст л олон нийтийн сүлжээгээр дамжуулан үйлчлэхийг эрмэлздэг. Миний зарим нийтлэл инээдтэй, наргиантай байдаг бол, зарим нь тун ноцтой байдаг. Энэ бол амьдралын хэмнэл юм. Зарим өдөр би олон нийтийн сүлжээнд илүү сайн бүжиглэдэг бол, зарим өдөр тааруу бүжиглэдэг. Тиймээс хэдийгээр надад санал бодол зөндөө байдаг ч, би санал бодлоо хязгаарлаж сурсан билээ. Би Бичээстэй юмуу эсвэл миний амьдралтай сөргөлдсөн зүйлийг аль болох хэлэхгүй байхыг хичээдэг. Би ямар нэг зүйлийн талаар сайн зүйл хэлж чадахгүй бол, чимээгүй өнгөрдөг (ингэх хэцүү шүү).

Зүрхээ хамгаалах хамгийн шилдэг арга нь амьдралдаа хаа хамаагүй үгсийг оруулахгүй байх явдал юм. Заримдаа хүмүүс маш харгис хатуу байдаг. Чи бас олон нийтийн сүлжээн дээр дээрэлхүү, бүдүүлэг хүмүүстэй тулгарч байсан л байх. Би нэг өдрийн дотор эрслэн ээжээс авахуулаад дуугүй байхдаа таарсан буруу номын хүүхэн гэж дуудуулж болох (Энэ бас гайгүй нэр ус нь шүү). Энэ бүхэн дунд би ширэн нүүртэй, зөөлөн зүрхтэй байж сурсан билээ.

Олон нийтийн сүлжээнд нээлттэй үй олон сэтгэл мэдрэмж дунд би амьдралд маань нэвтрэх үүдийг тайлж өгөх боломжтой хувийн жүжгийг зориуд хязгаарладаг. 2Тимот 2:23-26 дээрх үгийг өнөөгийн байдал дээр буулгаж үзье:

Харин мунхаг, утгагүй зөрчилдөөнүүд нь мөргөлдөөн бий болгодгийг мэдэн татгалз. Эзэний боол мөргөлдөөнд оролцох ёсгүй. Харин бүгдэд эелдэг зөөлөн, заах чадвартай, тэвчээртэй байж, зөрчилдөгсдийг дөлгөөнөөр сургамжил. Магадгүй, Бурхан тэдэнд үнэний мэдлэгт хүргэх гэмшлийг соёрхвол, тэд ухаан орж, хүслээ үйлдэхээр тэднийг олзолсон диаволын урхинаас чөлөөлөгдөх буй за.

Хүн бүрт, юм бүрт хариулах шаардлагагүй. Заримдаа хариулт тэнэг байдлыг л илтгэдэг. Бид ямар шударга бус байдалд байгааг хүн бүр мэдэх шаардлагагүй. Бид үүнээс том шүү. Бид зовлонгоо

нэр нүүргүй дээрэмчдэд биш, харин Аавынхаа дээд шүүхэд аваачих ёстой.

Алдартай юу, нөлөөтэй юү?

Саяхан Ариун Сүнс надаас “Лиза, чи алдартай баймаар байна уу, нөлөөтэй баймаар байна уу?” гэж асуух шиг болов.

Би ч “нөлөөтэй” л гэж хариуллаа.

Энэ олон ургальч үзлийн ертөнцөд зүг чигээ олохын тулд бид өөрөөсөө байнга “алдартай юу, нөлөөтэй юү?” гэж асуух хэрэгтэй. Магадгүй, чи сайны төлөөх нөлөөлөгч байхаар дуудагдсан учраас л, энэ номыг уншиж байгаа байх. Зарим үед чи ямар ч гавъяа нэргүй зүйлийн төлөө зогсох ёстой болно. Илүү нарийн ойлгохын тулд эдгээр нэр томъёог тодорхойлж, ялгааг нь харъя.

Алдартай гэдэг нь дурламаар, давуу, хүлээн зөвшөөрөгдсөн, загвартай, нийтлэг, сүүлийн үеийн гэсэн үг юм. Алдар нэрдээ толгойгоо мэдүүлчихгүй л бол, алдартай байхад ч буруу юм байхгүй л дээ. Алдартай байх нь өөрийн гэсэн давуу бөгөөд сул талтайг ахлах сургуульд сурсан бүх хүн мэднэ.

Алдар нэр нь нөлөөллөөс хурдан бий болж бас унтардаг. Бид хүмүүсийг байлдан дагуулж, алдар нэрийг бий болгож болно. Бид хүмүүст хүссэн зүйлийг нь хэлээд, алдартай болж болно. Бид хүмүүст сонсох ёсгүй зүйлийг нь хэлж, алдартай болж болно.

Тэгвэл нөгөө талаас нөлөөлөл нь хүчирхэг, чухал, ятгангуй, үр дүнтэй, хүчтэй, удирдагч гэсэн утгатай юм. Бүхий л практик зорилгын төлөө бид нөлөөтэй боловч, олон түмэнд нэг их алдаргүй байж болно. Тэнгэрт очих үед тэндхийн хамгийн нэр нөлөө бүхий хүмүүс нь дэлхий дээр харьцангуй олонд танигдаагүй хүмүүс байна гэдэгт би итгэдэг. Тэд селфи авахын оронд нууцаар тариалж, Бурхантай цагийг өнгөрөөдөг байсан хүмүүс байна. Тиймээс би л хувьдаа нөлөөтэй хүн байхыг хүснэ.

Мэдээж болдог бол аль аль нэг байх нь төгс юм. Надад энэ ярвигтай бүжгийг аль алийг нь төгс бүжиж чаддаг хэд хэдэн найз бий. Гэхдээ тэд хэзээ ч алдартай болохоос ажлаа эхлээгүй юм. Тэд зүгээр л итгэмжтэй байхыг л хүсчээ. Христийн гэрч байхыг хүсдэг хүн бүр үүнээс л эхлэх ёстой. Итгэмжтэй бөгөөд

нөлөөтэй байх нь хэлж ярих эрх чөлөөгөө нүгэл үйлдэх лиценз болгож ашиглахыг бус, харин нигүүлслийн үнэт бэлэгээр үгээ болгоомжтой сонгохыг хэлнэ.

Хэдийгээр засгийн газар маань бидэнд хүссэн үгээ чөлөөтэй хэлэх эрх олгодог ч, эцсийн дүнд бид илүү өндөр хаанчлалын өмнө хариуцлага хүлээнэ. Бидэнд Хамгийн дээд Бурханы цэц ухаан, гэгээрэлд нэвтрэх дуусашгүй эрх байсаар байтал, бид яагаад хувийнхаа санал бодлыг чөлөөтэй гаргах ёстой гэж? Бурханы Үг нь ямар ч санаагүй бодол биш, харин бурханлаг бодол, санаа юм. Би өдий наслахдаа, “үгийн урсгал дунд буруу тийш авч одоход бэлэн эргүүлэг байдаг” гэсэн утгатай дараах үг үнэн болохыг амьдрал дээрээ батлан харсан билээ.

Үг олшроход гэмт үйлдэл зайлшгүй.

Хэлээ захирагч хэрсүүгээс зайлбаргүй. (Сургаалт үгс 10:19)

Олон нийтийн сүлжээ эрүүл бус, дээрээс нь бидний гэр бүл биш гэдэгтэй чи санал нийлэх байх аа. Эндээс бид хүмүүсийн харуулахыг хүссэн зүйлийг л харж болно. Энэ нь заримдаа бид шилдгийг нь, заримдаа адгийн талыг нь хардаг гэсэн үг. Заримдаа тэдний хэлдэг, харуулдаг бүхэн худлаа байдаг. Хичнээн хүн миний нэрийг барьж, огт байхгүй өнчин хүүхдийн асрамжийн газарт мөнгө хандивлахыг гуйсан байдгийг би хэлж мэдэхгүй.

—◆—
Алдартай
ГЭДЭГ НЬ
ХАРИУЦЛАГАТАЙ
ГЭСЭН ҮГ БИШ.

Виртуал хийгээд бодитой

Үнэндээ бодитой хүмүүст өгч байснаас, виртуал нийгэмд өгсөн нь амархан байдаг. Ухаалаг утас дээрээ өгүүлбэр биччих нь гэр бүлийнхэн, найзуудтайгаа ноцтой яриа өрнүүлэхээс амархан. Блог нь бидэнд маш түргэн анхаарал, эерэг хариу авчирдаг бол, бодитой нийгэм дэхь жинхэнэ яриа нь тэс өөрөөр урсдаг учраас, биднээс асар их тэвчээр шаардана.

Виртуал нийгэм нь сайн юмуу муу, эрүүл юмуу хүчирхийлэлтэй

байж болно. Эрүүл виртуал нийгэм нь бидний бодитой нийгэмтэйгээ тогтоосон харилцаа, тавьсан сүйг урамшуулан дэмждэг. Чи яг ингэж байгаа бол, эдгээр нь сайн зүйлс юм.

Өнөөдөр мундаг, мундаг байлдан дагуулдагч, блоггерууд олон болжээ. Би эрүүл хооллох, удирдлагын ухаан зэрэг хэд хэдэн тодорхой блоггийг дагадаг. Ингэж хэлснийх, би ер нь хэний нөлөөнд орох тал дээрээ тун болгоомжтой ханддаг шүү. Тэр хүмүүс хэн нэгний өмнө эсвэл ямар нэг зүйлийн өмнө хариуцлага хүлээдэг хүмүүс байх ёстой.

Бид ганцаардах юмуу зөрчилдөх үедээ өөртэйгээ адилхан ганцаардсан юмуу зөрчилдсөн хүмүүст амархан татагддаг. Магадгүй бид төрөхийн дараах депресс юмуу буруу хооллох өвчинтэй зөрчилдөж байж болох. Тэр үедээ бид өөртэйгээ адилхан хүмүүстэй холбогддог. Биднийг ойлгодог, бидэнтэй адилхан хүмүүсийг мэдэх нь сайн хэрэг юм. Эдгээр холбоо нь биднийг эрүүл мэнд рүү, жинхэнэ хүч чадлын маань эх ундарга руу чиглүүлж байгаа нөхцөлд, эрүүл бөгөөд илааршуулах чанартай байна. Харин биднийг бусдын толгойгоор сэтгэхэд хүргэж байвал, иймэрхүү холбоо харилцаа нь ноотой юм.

Магадгүй бидний хэн нэгэнтэй тогтоосон онлайн харилцаа их сайхан эрүүл саруулаар эхлэсэн байж болох. Тэдний эгдүүтэй зан ааш, мэдрэмжтэй чанар, гайхмаар чин сэтгэл нь биднийг татсан байж болох. Хүмүүсийн бодож ч зүрхлэхгүй зүйлсийг зоригтой хэлж байгаа нь бидэнд таалагдсан байж болох. Тэдний мэдрэмж дүүрэн үгсд бид ховх сорогдсон байж болох. Гэхдээ бид Бичээсээс, ойр дотны хүмүүсээсээ зуурч байхгүй бол, төдөлгүй өрөөлийн мэдрэмжийг өвлөж мэдэх. Бид хариултаа хаанаас хайхаа мэдэж л байгаа бол, тэдний асуулт бидний асуулт болох нь зүгээр юм.

Жишээлбэл, нэг эмэгтэй нөхөртэйгээ секс хийхдээ сэтгэл дундуур байна гэхээр нь бид тэр даруй өөрийнхөө бэлгийн харилцаанд эргэлзэж эхлэдэг үү эсвэл илүү дотно сайхан болгохын төлөө явдаг уу?

Магадгүй дагадаг блоггериин чинь гэрлэлт эцэслэжээ. Тэрбээр энэ тухайгаа найраглан хэлээд, дээрээс нь шинэ эхлэл, шинэ хайрынхаа тухай бичсэн байв. Блоггер салалтаа хоёр сэтгэлийн хагарал гэж үзэхийн оронд, үнэн, хайрын төлөөх ялалт мэт үзжээ. Бид өөрийнхөө нөхөртэй биш, тэр виртуал хүнтэй сэтгэлийн

холбоотой болохоороо, өөрийнхөө гэрлэлтийг тэдний туршлагаар харж эхлэнэ. Тэгээд нөхрөөсөө салах нь үнэхээр шударга бөгөөд зоригтой үйлдэл байж болох уу хэмээн эргэцүүлнэ.

Хөөө хөөө, түр зогсоорой. Үнэнээсээ ярьж байна уу?

Гэрлэлт чинь Бурханы өмнө байгуулсан гэрээ шүү дээ. Гэрлэлт чинь таалагдахгүй байгаа бол, гэрлэлт дээрээ ажилла. Утсаа тавиад, компьютераа хаагаад, харьцуулалтын худлыг хойш тавь. Хамтдаа цаг өнгөрөө.

Үр хүүхэд чинь эрсдэлд байгаа нөхцөлд эсвэл итгэмж журамгүй хань ижилтэй тохиолдолд салахгүй байгаад бай гэж би хэзээ ч ухуулан ятгахгүй. Би чамд “мэдрэмж төрөхгүй” байгаа нөхцлийн талаар л ярьж байна. Энэ тохиолдолд харилцааны төлөө хөдөлмөрлөж байснаас, хаяад явчих нь хавьгүй амархан санагдаж болох. Гэхдээ Бурхан биднийг хүмүүсийг хайрлаж чаддаг, бат бэх, хөдлөшгүй, ялагдашгүй хүмүүс болгохоор ажиллаж байхдаа амархан замыг сонгодоггүй юм. Бурхан биднийг үг, хүч дотор байгуулахыг хүснэ.

Олон нийтэд бүү дэлгэ

Христийн бие доторх үл зөвшилцөл нь цоо шинэ зүйл биш юм. Паул Коринтод бичсэн анхны захидалдаа ингэж бичиж байжээ:

Та нараас хэн нэг нь хөршийнхөө эсрэг заргатай бол тэрээр ариун хүмүүсийн өмнө бус, харин зөвт бус хүмүүсийн өмнө шүүлгэхийг зүрхэлнэ гэж үү? Эсвэл ертөнцийг ариун хүмүүс шүүнэ гэдгийг та нар мэддэггүй юм уу? Ертөнц ч та нараар шүүгдэх байтал та нар багахан хэргийг шүүх чадваргүй юу? (6:1-2)

Өнөөдөр хэн нэгнийг шүүхэд өгөх нь хувийн асуудлыг нийтийн болгохтой л адил юм. Тэгэхээр, Бичээс бидэнд дараах үлгэр загварыг тогтоож өгчээ: бид биднийг хохироосон хүмүүс дээр очоод, эхлээд хоёулханаа ярина, дараа нь найзыгаа дагуулж очоод ярилцана. Бид даруу байдлаар харилцах ёстой бөгөөд яриа маань сэргэлт, үнэнд хүрэх ёстой. Олон нийтийн сүлжээг

шударга ёсны систем болгож ашиглах нь Библийн бус явдал, хар дарсан зүүд юм. Бүлэглэлд гэм зэмгүй хүмүүс, тэр бүү хэл үнэн ч падлийгүй юм.

Паул Тимотод бичсэн захидалдаа үнэн бол манай цаг үеийн амин чухал мессеж болохыг хэлжээ.

Эцсийн өдрүүдэд хэцүү цаг ирнэ гэдгийг мэдэж ав. Учир нь хүмүүс аминч, мөнгөнд дурлагч, сагсуу, их зантай, доромжлогч, эцэг эхдээ дуулгаваргүй, үл талархагч, ариун бус, үл хайрлагч, үл эвлэрэгч, гүтгэгч, биеэ хянадаггүй, хэрцгий, сайныг үзэн ядагч, тэрслэгч, бодлогогүй, биеэ тоодог, Бурханыг хайрлагч байхаас илүү зугаа цэнгэлийг хайрлагч болох болно. Тэд итгэл сүсэгт дүртэй ч хүчийг нь үгүйсгэдэг. Чи тэднээс хол бай. (2Тимот 3:1-5)

Танил сонсогдож байна уу? Амиа хоохойлсон, мөнгөнд өлөнтсөн. Тийм. Өөрийгөө дөвийлгөсөн, хамраа сөхсөн. Тийм. Аав, ээждээ хүндэтгэлгүй, дээрэнгүй, бүдүүлэг, бохир. Тийм. Үүнээс ангид хүн байхгүй байх аа. Ийм соёл хэв хэмжээ болох үед ямар эрсдэл гардгийг Паул дараа нь Тимотод хэлжээ:

Айлд гэтэж ороод, нүгэлд автагдаж зүсэн бүрийн тачаалдаа хөтлөгдсөн гэнэн эмэгтэйчүүдийг олзлогчид ч тэдний дунд бий. (2Тимот 3:6)

Энэ нь нэн ялангуяа эмэгтэй хүнд хэцүү үг юм. Паулын анхааруулгыг ойлгохын тулд бид гүн амьсгаа аваад, Ариун Сүнсээр хөтлүүлэх ёстой. Энэ ишлэл нь эрүүл нийгэм, Бурханы өгсөн зорилгоос ангид амьдарч байгаа эмэгтэйчүүдийг дүрслэсэн гэвэл буруудахгүй байх. Эрэгтэй, эмэгтэй ямар ч хүн тусгаарлагдаж, хэнд ч хэрэггүй санагдах үедээ хэн нэг ашигч хүний амархан идэш болдог.

Бид зүгээр л нэг амьсгаатай байхаар бүтээгдээгүй. Уйтгар, депресс нь биднийг бусдын амьдралаар амьдрахад хүргэдэг. Бид блог дээр сэтгэгдэл үлдээж, олон нийтийн сүлжээнд олон цаг өнгөрөөж, өөрийнхөө биш бөөн хэрэгт орооцолддог. Яг үнэндээ залбирахын оронд сэтгэгдэл үлдээх нь амархан байдаг. Бид ямар

нэг зүйл байгуулахаар төрснөө мэдэрдэг ч, боломж олдохгүй байх үедээ оппортунист хүний идэш болдог.

Нөгөөтэйгүүр, заримдаа бид ажилдаа дарагдаж, сэтгэлээ хаягдуулахаараа, тогтворгүй, өлөн болж хувирдаг. Хичнээн олон аугаа амьдралтай эрчүүд, эмэгтэйчүүд туйлдаа хүртэл ядарснаасаа болоод, онлайнар өөр хүнтэй болсон тухай сонссоноо би хэлж мэдэхгүй байна.

Ийм юм сонсохоороо би хамгийн түрүүнд “Хэнд тэгж явах цаг байдаг байна аа? Бидэнд чинь хань ижилтэйгээ ч ярилцах цаг олддоггүй байтал, танихгүй хүнтэй зохион бичлэг бичилцэнэ гэж байдаг аа?” гэж боддог байлаа. Гэвч дараа нь би тэдний хувьд онлайн харилцаа нь зугтах ганц арга нь болдгийг ойлгосон юм. Энэ бол тэдний ямар ч хариуцлага хүлээхгүй, зохиомол газар юм. Тэд орон зай гаргахын төлөө амьдралаа цэгцлэхийн оронд өөрийгөө хорлон сүйтгэх ажиллагаа явуулдаг ажээ.

Тэгэхээр, энэ бол гэр бүлийн чухал ярианы цаг. Компьютераа хаа. Утсаа унтраа. Хүүхдүүдтэйгээ ярь. Хань ижилтэйгээ харилц. Найзтайгаа уулзаад, кофе уу. Утсаар ярь. Бодит зүйлд хөрөнгө оруулах цаг гарга.

Тийм ээ, чуулган охидынхоо хэрэгцээг сонсох ёстой. Эмэгтэйчүүд шархлаж байна. Жил тутмын эмэгтэйчүүдийн чуулга уулзалт сайн боловч, хангалтгүй байна. Эмэгтэйчүүд надад сураад л сураад, хэзээ ч үйлддэггүй байдлаасаа залхаж байгаагаа хэлдэг ч, энэ гутралаа онлайнар илэрхийлэх нь тун буруу юм. Бүтэхгүй байгаа юмсыг хүчингүй болгох нь хангалтгүй. Христийн биеийн төлөөх эрүүл саруул дэд бүтцийг байгуулах нэгээхэн хэсэг болцгооё. Хамтдаа идэж, сурч байсан Есүсийн анхны дагалдагч нарын мөрөөр явъя. Даян дэлхийг байлдан дагуулж, дагалдагч бэлтгэх ажил нь бидний жижиг ертөнцөөс л эхлэнэ.

Олон чуулган эмэгтэйчүүдэд зөвшөөрөл л олгодог болохоос биш, байр суурь олгодоггүй. Үүнийг өөрчлөхийн тулд бид суугаад, зөв хүмүүстэйгээ зөв яриа дэлгэх хэрэгтэй. Онлайн нийгэмлэгүүд

◆

Даян
дэлхийг
байлдан
дагуулж,
дагалдагч
бэлтгэх
ажил нь
бидний
жижиг
ертөнцөөс л
эхлэнэ.

сайн боловч, бичээч, влоггер, Фэйсбүүкийн “найз” чинь чиний нүд рүү харж чадахгүй. Твиттерийн од чамайг элгэндээ нааж, энгэртээ тэврэхгүй. Бидэнд жинхэнээсээ ойр дотно хүмүүс хэрэгтэй. Бид дэндүү олон үгээр, Есүсээр дутаж яваа дэндүү олон хүнийг “бөөндөж” байна.

Энэ бүлэг дээр ажиллаж, үгээр бат бэх болоход маань Сургаалт үгс, Номлогчийн үгс ном гол хөтөч минь болсон билээ. Би чамд амьдралынхаа араамыг зөв зангидахад чинь тус болох болов уу гэсэндээ үгээ зөв сонгож, тархиндаа юу оруулахад чинь туслах үүднээс Хоёрдугаар хавсралт дээрээ 50 сургаалт үгийг багтаалаа.

*Тэнгэрийн Бурхан Аав минь,
Би амаа цэц ухаанаар нээж, хэлд минь эелдэг сургаал
ориших болтугай (Сургаалт үгс 31:26). Надад тээж,
зовниж явдаг асуудлынхаа талаар тэнгэрийн амьсгалтай
яриа өрнүүлж чадах гэр бүлийг минь харуулаач. Та Сүйт
бүсгүйгээ угааж, бэлтгэж байгаа гэдгийг мартсанд
уучлаарай. Би үгээрээ нураах биш байгуулж, шархлуулах
биш эдгээж, шүүмжлэх биш эш үзүүлнэ. Амень.*

АДАМАНТ ӨӨРЧЛӨЛТ (БАТ БЭХ ӨӨРЧЛӨЛТ)

Хүндэтгэл гэдэг нь бүх мөн чанараа Бурханд өргөх явдал юм. Түүний ариун байдлаар ухамсар маань эрчилж, Түүний үнэнээр оюун санаа маань ундаалж, Түүний гоо үзэсгэлэнгээр төсөөлөл маань цэвэршиж, Түүний хайранд зүрх маань нээгдэж, Түүний зорилгод хүсэл маань захирагдана.

Виллиам Темпл

Би саяхан ач нартайгаа гэрийнхээ ойролцоо интоор түүлээ. Би ганцхан нүдэндээ хараатай учраас, гурван жаахан хүүхэдтэй хөөцөлдөнө гэж юу байдгийг мартчихсан байв. Тэгээд ч тэр даруй нэг нь яг л аюулд орохоо дөхөв. Би интоорын мөчрийг Софиагийн гар хүрэх өндөрт буулгаж өгж байтал, Софиа гудамжны зүг рүү заагаад: “Лиззи!” гэж хашхирлаа. Би ч гудамжаар тэнэж яваа, хоёрхон настай Лиззи рүү эргэж хараад, мөчрөө хаячихаад, хар эрчээрээ түүн рүү гүйлээ. Лиззи рүү машин ирж явав.

Намайг “Лиззи, зогс, нааш ир!” гэж хашхиртал, Лиззи над руу эргэж харахад, яг л нэг хэрэг тарих гэсэн санаа нь илт үзэгдэв. Лиззи жогтой мушилзсанаа, цаашаа замаараа алхлав. Тэр чоно тарвагадаж байна гэж бодсон болтой. Би ч гараа савсаар, ирж байгаа машины жолооч Лиззигийн бондгор жижигхэн хэлбэрийг харахгүй байх гэж айсандаа, машины урдуур гүйж ороод, жолоочид зогсоорой гэсэн дохио өглөө. Угаасаа Лиззи зогсох ямар ч санаагүй байв.

Лиззи хоёр дахь замаа гатлахын даваан дээр би түүнийг хоёр замын голд “баривчиллаа”. Тэгээд тэврээд, гулжигнасан биеийг нь хар хурдаараа цохилох зүрхэндээ лавхан шиг наалдуулав. Бид хоёр машинуудыг өнгөрүүлээд, ах эгч хоёр дээр нь очихоор зам гарлаа.

Лиззигийн хувьд энэ бүхэн том адал явдал байсан учраас, тэр их бах нь ханасан янзтай үргэлжлүүлэн хөхөрсөөр байлаа. Хоёр настай хүүхэд машинтай мөргөлдөнө гэж юу байдгийг яаж

ч мэдэх билээ дээ? Лиззигийн таван настай эгч София хэзээ ч замын хөдөлгөөний дүрэм “зөрчиж” байгаагүй боловч, энэ тун буруу гэдгийг мэдэж байв. Буруугаар барахгүй аюултай бөгөөд аминд халтай гэдгийг би бол бүр мэдэхийн дээдээр мэдэж байлаа. Тэр өдрийн сүүлийн хагасыг Лиззи миний гар дээр өнгөрүүлсэн гэдгийг та нар бараг гадарласан байх аа.

— ◆ —
Бид
хоригдлуудад
эрх чөлөөг
тунхаглахаар
амьдарч
байна.

Лиззиг чанга тэвэрч, гараасаа буулгаагүйд та нар намайг буруутгахгүй байх. Машин хүнийг яаж чадахыг бид бүгдээрээ мэднэ. Би үүнийг мэддэг учраас л, ирж байгаа машиныг үл хайхран, Лиззиг өөрөөс нь аврах гэж гүйсэн юм.

Энэ бүлгээрээ би дахиад л явган хүний аюулгүй замаасаа гараад, хоёр урсгалтай замын гол руу амь биеэ үл хайхран гүймээр байна. Чи миний зүрхийг сонсоно гэдэгт би үнэхээр найдаж байна. Учир нь хэрэв бид сэтгэх, амьдрах, хайрлах арга замаа Эзэнээр өөрчлүүлэхгүй бол, хүмүүс бидний амьдралаас Бурханы хайрыг олж харахгүй нь байна. Бид Фарисайчууд шиг амьдраад, өөд нь татахын төлөө юу ч хийгээгүй үеийнхэнээ баахан ачаагаар

дарамтлахыг хүсэхгүй (Матай 23:4).

Өнөөдөр бид цэц ухаан, энэлэл хайр хэрэгтэй цаг үед амьдарч байна. Бид хоригдлуудад эрх чөлөөг тунхаглахаар амьдарч байна. Бид чөлөөлөлтийн элч нар. Бид хэнийг суллахаа сонгож шийддэг шоронгийн хамгаалагч, хуяг, шүүгч биш. Бид шорон бол эрх чөлөөний газар биш гэдгийг эргэлзэж самуурсан хүмүүст хэлж өгөх үүрэгтэй.

Хавтан

Бүү шүү, тэгвэл шүүгдэхгүй. Та нар хэрхэн шүүнэ, түүнчлэн шүүгдэнэ. Өөрсдийнхөө хэмжсэн хэмжээсээр та нар хэмжигдэх болно. Нүдэн дэх дүнзээ анзаараагүй атлаа юунд чи ах дүүгийнхээ нүдэн дэх үртсийг харна вэ? Эсвэл, нүдэнд чинь дүнз байгаа атал ах дүүдээ “Нүднээс чинь тэр үртсийг аваад өгье” гэж чи яаж хэлж чадна вэ? Хоёр нүүрт чи, эхлээд өөрийнхөө нүднээс дүнзээ авч хая. Тэгвэл чи ах дүүгийнхээ нүднээс үртэс авч хаяхдаа сайн харах болно. (Матай 7:1-5)

Татвар хураагч агсан Матай бусдаар шүүгдэнэ гэдгийг яс махаараа мэддэг хүн байв. Энэ хэсгээс *шүүж болохгүй* гэдгийг л ойлгох ёстой. Тийм ээ зөв, гэхдээ бүрэн гүйцэт биш байна. Энд яг юу хэлсэн байгааг дахиад нарийн харцгаая. Би Христэд итгэсэн хойноо итгэл нэгт ахан дүүсээсээ шүүмжлэл сонсохоороо, асуудлыг хариу шүүх маягаар шийдэх гэж оролддог байлаа. Жишээлбэл, хүмүүс миний хос цоолбортой чихийг өөрийгөө зэрэмдэглэсэн, байж боломгүй зүйл гэж үздэг байв. Тэгэхээр нь би урдаас нь тэднийг шашны бүлэглэл гэж дайрна. Тэр үед блог энэ тэр байгаагүйд Бурхандаа талархъя! Тэдний нэр хоч миний тархинд үлдсэн. Тэгээд хэнийх нь шүүх илүү хатуу харгис байв? Минийх илүү хатуу байжээ.

Миний хос цоолбортой чих тэднийг эргэлзүүлсэн бол, намайг ялласан хүмүүсийг би ялласан.

Тэдний нүдэнд үртэс байсан бол, миний нүдэнд бүхэл бүтэн соёлын төв барьчихаар их дүнз овоолгоотой байжээ. Тэр их

дүнз надад тэдний үртсийг олж харахад тээг болжээ. Үүнийг өөрчлөхийн тулд хэд хэдэн зүйл болох ёстой байв. Нэгдүгээрт - би өөрийнхөө дүнзийг хүлээн зөвшөөрөх ёстой байв.

Нүдэндээ хавтантай хүн яг л нүдээ боосон хүн шиг, бусдаас дандаа л харыг нь олж харна. Тэгвэл жаахан лавшруулж үзье. Нүдээ боочихсон хүнээр хэн ч мэс засал хийлгэхгүй. Бусдыг өвтгөөд л байхын оронд бусдад туслаж чаддаг болохын тулд нүднийхээ боолтыг аваад, өөрийнхөө асуудлыг цэгцлэх үү?

Матай 7 дээрх манай шүүгч найз нэг талаараа зөв байв: түүний ахан дүүгийн нүдэнд үнэхээр авах ёстой үртэс байжээ. Гэхдээ Есүс түүнийг өөрийнхөө байдлыг харахгүй сохор атлаа бусдын бурууг өөлж гоочлоод байгаад нь дургүйцэж, хоёр нүүрт гэж хэлжээ. Энэ нөхцөлд бусдад туслах нь харилцан тустай зүйл. Чуулган дэлхий рүү зааж байхад, Бурхан Үгээрээ бидний цээж рүү хүчтэй дэлсэхийг хүсч байна.

Муугийн төлөө гашуудлаа гээд бид юунд хүрч гийгүүлэв?

Бид нуруугаа цэх болгох үед өөрчлөлт гарч эхлэдгийг Библи тодорхой хэлжээ.

Миний нэрээр минь дуудагдсан Миний хүмүүс өөрсдийгөө даруу байлган залбирч, нүүрийг минь эрэлхийлж, хорон муу замуудаасаа эргэх аваас, Би тэнгэрээс сонсож, тэдний нүглийг уучлан, тэдний газар нутгийг эдгээнэ. (2Шастир 7:14)

Бурхан хүмүүсийнхээ зогсолтыг хардаг. Энэ хэсэг нь хүндэтгэл, гэмшлийн хандлагын талаар ярьж байна. Хайр байхгүй бол, дэндүү зөв атлаа аймшигтай буруу байж болно.

Газар нутагт маань эдгэрэл хэрэгтэй байна.

Энэ эдгэрэл биднээс эхлэнэ.

Энэ бүхэн нь Бурханы хүмүүс өөрсдийгөө даруусгаж, залбирч, Бурханы царайг хайж, нүгэлт муу замаасаа эргэхээс эхлэнэ. Энэ ямар хүчтэй болохыг ойлгож байна уу? Эрх мэдэлд хэн байх нь хамаагүй. Ямар хууль тогтоомжоор гарсан нь хамаагүй. Бид хүн бүрийг ёрын муугаас нь эргүүлэх шаардлагагүй... бид зүгээр л өөрсдийнхөө үртсийг аваад, дараа нь зүй ёсоор үйлдэхэд л болно.

Бид асуудалдаа эзэн болж, үнэнээр амьдрахыг сонгох

үед өөрчлөлт эхлэдэг. Өөрчлөлт нь бидний мэддэг үнэнээр хэмжигдэхгүй, харин бидний амьдардаг үнэн дотор тусдаг. Өөрчлөлтийн үйл явцын гол түлхүүр нь хайр юм. Итгэл, найдвар, хайргүйгээр өөрчлөлт боломжгүй. Ариун байдал, өөрчлөлтөөс салах болсны үндсэн шалтгаан нь чухам хайрын хомсдол байжээ.

Түүнчлэн хайрын хомсдлоос болж өнөөдөр хүмүүс бурууг буруу гэж хэлэхээ больсон. Чуулган ч “Туйлын зөв гэж байхгүй, миний хувьд буруу байгаа зүйл чиний хувьд зөв байж болно” гэх мэтээр дундыг баримтлаж, бөөрөнхийлсэн үзлийг хүлээн авсан. Энэ хангалтгүй юм. Итгэл үнэмшилгүй үеийнхэн ямар ч өөрчлөлт үзэхгүй.

Би өөрчлөлтийг хүсч байна. Энэ дэлхий надаас өөрчлөлтийг хүлээж байна. Шинэ өдөр болгон нь Есүсийг дагах, Түүнтэй адилхан болох боломж юм. Бурхан намайг ичгүүрээс чөлөөлж, зөвт байдлын нөмрөг өмсүүлсэнд би талархдаг. Есүс миний ичгүүртэй үйлдлийг зөв хэмээн дуудаж, хүлээсийг маань батлан зөвшөөрөөгүй. Мөн Тэр миний бохир хувцсыг цэвэрхэн гэж хэлээгүй - харин Үг дотроо угаасан юм.

Ичгүүр нь бид өөрсдөө биш, харин заримдаа бидэнд төрдөг мэдрэмж билээ. Заримдаа бидний үйлдлийг ичгүүртэй гэхээс өөрөөр хэлэх аргагүй байдаг. Бид ичгүүртэй үйлдэл хийдэг. Би ч ичгүүртэй үйлдэл хийсэн. Гэхдээ энэ нь намайг ичгүүрт хүн болгохгүй. Зүгээр л Лиза гэдэг хүн ичмээр зүйл л хийсэн гэсэн үг. Бид ичгүүрээсээ болж Бурханаас эргэхдээ, өөрийгөө инжрийн навчсаар ороогоод, эргэн тойрныхоо хүмүүсийг буруутгадаг. Бид ичгүүрээсээ болж Бурханаас холдож болно эсвэл харанхуйгаас эргэж Түүний гэрэл, хайраар Бүтээгчтэйгээ улам бат бэх холбогдож болно.

Бурхан хайр, ариун байдлынхаа гэрэл дор эцэстээ бидний ичгүүрийг зайлуулдаг.

Би өөрийнхөө тааруухан зан авир, нүгэлд шалтаг тоочсоноороо, ичгүүрээ зайлуулахгүй. Би нөхцөл байдлаараа бамбай хийн,



Бид
асуудалдаа
эзэн болж,
үнэнээр
амьдрахыг
сонгох үед
өөрчлөлт
эхлэдэг.

өөрийнхөө ичгүүртэй үйлдлийг хүндэтгэлтэй үйлдэл мэт тас гүрийж болохгүй. Би худал хуурмаг амьдралаас эргэж, үнэнээр амьдрахыг сонгох үед миний ичгүүр зайлуулагдсан билээ.

Өөрчлөлт бидний нүцгэн шалдан байдлыг няцааж, худлаа ярихгүй.

Өөрчлөлт нүцгэн байдлыг хувцастай гэж худлаа хэлэхгүй.

Өөрчлөлт Бурханы өөрчлөлтөөс инжир модны навч, модны ард нуугдахгүй.

Өөрчлөлт биднийг нүцгэн байдлаа хүлээн зөвшөөрөхөөс эхлэнэ.

Өөрчлөлт нь бидний өөрийгөө инжрийн навчсаар халхлах гэсэн газрын бүтэлгүй арга - урхийг илчилдэг.

Ийм аргаар бид үнэндээ хэзээ ч өөрийгөө нуун халхлаж чадахгүйг өөрчлөлт бидэнд хэлдэг.

Өөрчлөлт нь хүний арга оролдлогыг хойш тавьж, Ариун Ааваас маань биднийг үнэнээр хувцаслахыг гуйдаг.

Бид Христийн Эзний эрх мэдэл дор орохдоо, дур мэдэн үйлдсэн, ичгүүрээ хойш тавьж, гэрлийн хүүхдүүд шиг алхдаг. Энэ өөрчлөлтийг Ефес 4:21-25 дээр дүрслэжээ:

Үнэн Есүст байдагчлан, та нар үнэхээр Түүнийг сонсож,
Түүгээр сургагдсан юм бол, амьдралын чинь урьдын
хэв маягт хамаарах заль мэхийн тачаалын дагуу ялзарч
буй хуучин хүнээ тайлж, оюун санааныхаа сүнс дотор
шинэчлэгдэж, үнэний зөвт байдал ба ариун чанар дор
Бурханы дагуу бүтээгдсэн шинэ хүнийг өмс. Тиймд худал
хуурмагийг хойш тавьж, хүн бүр хөршдөө үнэнийг ярь. Учир
нь бид бие биендээ эрхтнүүд юм.

Бүгдийг нь хая! Нигүүлслийн Ариун Сүнс биднийг өөрийгөө зөвтгөсөн өмнөх нүгэлт мөн чанар, бохир бүтээлгээ үхлийн бүтээлэг мэт тайлах хүчтэй болгодог (Үнэндээ ч үхлийн бүтээлэг юм). Хэн ч хуучин хувцсан дээр шинэ хувцас өмсдөггүй. Эрт орой хэзээ нэгэн цагт шороотой хувцасны маань толбо, өмхий үнэр шинэ хувцсыг маань нэвт идэн гарч ирэх болно. Хэн ч давхарлаж өмсөж дийлэхгүй. Бид хуучин хувцсаа хуучин үлгэр загвартай нь тайлж, бурханлаг бөгөөд ариун байдлын зүг оюун санаагаа

шинэчилдэг.

Бид илүү дээрийг *мэдэж* авсан бол, илүү дээрийг л *хийдэг*.

Бид үнэнийг (Есүсийг) мэдсэн бол, үнэнийг хийх чадалтай болно.

Тачаал цаашид бидний санаашралыг үгүй хийх эрхгүй. Баялгийн шунал, мэхлэл цаашид бидний оюун санааг халхлах эрхгүй. Бид хуучныг шинэ гэж дуудах биш, харин жинхэнээсээ шинэчлэгдэнэ.

Хүлцэнгүй байдлыг дахин нэг харахад

Хүлцэнгүй байдал нь дангаараа их хүнлэг сонсогддог. Гэхдээ бидний хүлцэнгүй хандаж байгаа зүйл нь хэзээ ч өөрчлөгдөхгүй, харин зориудаар үл хүлцдэг зүйл л өөрчлөгдөнө.

Би саяхан хүүгийн дээ зочилтол, нэг ач маань (нэрийг нь нууцлая) гар ариутгагчийг өөр зүйлд ашиглахаар шийджээ. Тэр дүүдээ идүүлтэл, нөгөөх нь дургүйцсэн болтой. Тиймээс ач маань энэ тухай аавдаа хэлжээ. Аав нь энэ тухай сонсоод, хүлцэнгүй суусан гэж бодож байна уу? Тэдний хооронд тэр даруй гар ариутгагчийн хэрэглээний талаар хайр дээр үндэслэсэн, хатуу яриа өрнөжээ. Тэгээд манай бүсгүйг цаашид гар, ам хоёроо андуурахаа болих хүртэл гар ариутгагчийн хэрэглээг нь хорьсон байна.

Аав нь хатуу хандсан уу? Мэдээж үгүй! Бидний гарын гадаргыг *хамгаалдаг* зүйл бидний бие доторхыг *хордуулж* мэдэх. Аав нь гэр бүлээ аюулгүй байлгахыг л хичээжээ. Ач охин маань сайн мэдэхгүй байсан бол, аав нь сайн мэдэж байжээ. Бид илүү сайн мэдэх үедээ бусдад зааж өгдөг. Гоё үнэртэй шингэнийг идэж болохгүйг хүүхэд цаанаасаа ойлгох арга байхгүй. Бид эхлээд тэдэнд зааж өгбөл, тэд цаашид сайн мэдэх болно.

Ийм үед зоригтой байж, үнэнийг бусдын ойлголтоор сэтгэж

—◆—
Бидний
хүлцэнгүй
хандаж байгаа
зүйл нь хэзээ ч
өөрчлөгдөхгүй,
харин
зориудаар үл
хүлцдэг зүйл л
өөрчлөгдөнө.

болохгүй шүү. Өөрийгөө үнэнээр сайтар бүслэ.

Чи амьдралдаа юуг хүлцэж, юутай эвлэрээд байна?

Чи ирээдүйд амьдралынхаа аль хэсэг дээр арай бага хүлцдэг юмуу эсвэл бүр огт хүлцдэггүй болмоор байна?

Энэ өөрчлөлтөд чинь юу саад хийж байна?

Дотно Бурхан

Ефес 5 бидэнд ийнхүү анхааруулжээ:

Иймд хайрлагдсан хүүхдүүдийн хувьд Бурханыг дуурайгчид бай. Христ та нарыг хайрласан бөгөөд Өөрийгөө бидний төлөө Бурханд анхилуун үнэрт өргөл ба тахил болгон өргөсний адил хайр дор яв. (1-2)

Энэ ишлэлийг Пэйшн Транслэйшн дээр орчуулсан маягт би илүү дуртай:

Бурханы хийдэг бүхнийг үйлс бүхэндээ даган дууриа. Тэгж байж л та нар Аавыгаа хайртай хөвгүүд, охид шиг нь төлөөлөх болно. Мөнчлөн Христийн ер бусын хайранд захирагдсаар бай. Учир нь Тэр амиа бидний төлөө золиос болгон өргөсөн юм. Биднийг гэх Христийн аугаа хайр нь Бурханд бишрэлийн анхилам үнэр - тэнгэр, газар дахь эдгээгч ялдам үнэр мэт таатай байв.

Эхний хоёр ишлэл нь жаахан маргаан агуулжээ. Паул дөнгөж сая эелдэг байдал хичнээн чухал болох талаар ярьж дууслаа. Бид Бурханы Хүү Есүс Христ шиг байснаараа тэнгэрийн Аавыгаа дууриахыг хүснэ. Энэ нь нэн бөгөөд хамгийн түрүүнд хайр дотор явах юм. Есүс хайрын хамгийн цэвэр илэрхийлэл байсан ч, Есүсийг даган дууриах нь цэвэр байдал, дуулгавартай байдал, захиргаа дотор алхана гэсэн үг юм. Тэгвэл хууль бус, цэвэр бус явдлаар дүүрсэн ийм үед бид ямар зан авиртай байх талаар дараагийн ишлэлд нь хэлжээ:

Харин ариун хүмүүст үл нийцэх аливаа садар самуун, бузар булай, шунал нь та нарын дунд бүү дурдагддаг. Садар булай, шалиг балай эсвэл самуун балиар яриа нь зохимжгүй. Харин оронд нь талархалаа өргө. (Ефес 5:3-4)

Заримдаа чуулганы хүмүүс үнэхээр харгис сүнстэй байдаг. Тэд Бичээсээр өөрийгөө цэвэрлэхийн оронд тэр үгээр бусдыг дарамтладаг. Хайрын хил хязгаар, хариуцлага бүдгэрч баларчээ. Энэ байдал нь голдуу Христэд итгэдэг хүмүүс хайраа гээж, үнэн дотор амьдрахаа больсноос бий болдог. Чи үүнийг өөрчлөхийг хүсч байгааг чинь би мэднэ.

Бидэнд хайрлаж, үнэн дотор амьдрахад маань туслах Ром номын гурван санааг би чамд хэлж өгье:

1. Бурханы бодит чанар
2. Өнөөдрийн бодит байдал
3. Бидний бодит байдал

Судлалынхаа дийлэнх хэсэг дээр би гурав дахь санааг нь тодруулж ярих болно. Тэр хэсэг дээр л бид зүрхээ шалгаж, хавтангаа авч хаях болно.

Тэгэхээр эхлээд Бурханы бодит чанарыг авч үзье.

Бурханы бодит чанар

Учир нь Бурханы тухай мэдэж болох зүйл тэдний дунд илэрхий байдаг агаад Бурхан тэдэнд үүнийг ил болгосон юм. Ертөнц бүтээгдсэнээс хойш Түүний үл үзэгдэх чанарууд, Түүний мөнх хүч ба бурхан чанар нь бүтээгдсэн зүйлсээр дамжиж ойлгогдож, илэрхий харагдаж байгаа тул тэдэнд шалтаг байхгүй. (Ром 1:19-20)

—◆—
БҮТЭЭГДСЭН
БҮХЭН НЬ
БҮТЭЭГДЭЭГҮЙ
НЭГЭНИЙГ
ИЛЧИЛДЭГ.

Бидэнд харагдах бүхэн үл үзэгдэх Бурханыг тунхагладаг. Бүтээл нь Бурханы гайхамшигт чанар, хязгааргүй бүтээлч чанарыг илчилдэг. Бүтээгч байдгийг бидэнд хэн ч хэлж өгөөгүй байсан ч, байгалийн найрал хөгжим нь бидний харааг Бурханы оршихуй руу татна. Бүтээгдсэн бүхэн нь бүтээгдээгүй Нэгэнийг илчилдэг. Бидний Бурхан ганцаараа аугаа. Тэрбээр ганцаараа бүхний дээр орших чиний Бурхан Эзэн болой. Хамгийн дээд Бурханыг Дуулал номд маш гайхалтай дүрслэн өгүүлдэг:

Учир нь ЭЗЭН аугаа бөгөөд агуу ихээр магтагдах Нэгэн. Мөн бүх бурхдаас дээгүүр Түүнээс эмээгтүн! Учир нь хүмүүсийн бүх бурхад нь шүтээнүүд юм. Харин ЭЗЭН, тэнгэрсийг бүтээсэн билээ. Түүнд яруу алдар ба сүр жавхлан бий. Түүний ариун газарт хүч чадал, үзэсгэлэн би. (Дуулал 96:4-6)

Мөн:

Түүний өмнө гал гарч, Эргэн тойронд өстнүүдийг нь шатаана. Түүний аянга цахилгаан ертөнцийг гэрэлтүүлнэ. Газар дэлхий үүнийг хараад чичрэв. Бүх дэлхийн Эзэний өмнө, ЭЗЭНий өмнө уулс лааны тос адил хайлав. (Дуулал 97:3-5)

Энэ үгийг уншаад, бишрэхгүй байх арга байхгүй.

Өнөөдрийн бодит байдал

Амьсгаа аваад, өнөөдрийн бодит байдлын талаар бодохоор: “Аав аа, юу болчихсон юм бэ?” гэсэн асуулт надад зогсоо зайгүй төрдөг. Ром номыг цааш нь уншихаар, энэ өөрчлөлт яаж бий болсныг өгүүлдэг:

Тэд Бурханыг мэдсэн атлаа Бурхан гэж Түүнийг алдаршуулсан ч үгүй, Түүнд талархал өргөсөн ч үгүй. Тэгээд ч тэд бодол санаандаа хоосорч, ухваргүй зүрх нь харанхуй болжээ. Өөрсдийгөө мэргэн гэж хэлдэг атлаа тэд мунхаг

болсон бөгөөд... (Ром 1:21-22)

Бид Бурханыг үл хүндэтгэж, бидний амьдралд эзлэх байр суурийг нь доош хийхдээ, ямар ч бичиг үсэггүй хар амьдрал руу өнхөрдөг. Энэ нь бид уншаад байгаа хэрнээ хэзээ ч ойлгохгүй гэсэн үг юм. Энэ бодит байдлыг бүх бүтээл тунхаглаж байхад, Бүтээгч байхгүй гэж хэлэх аргагүй боловч, Бурханы *тухай* мэдэх нь Бурханыг *хүндэтгэхээс* тэс өөр билээ. Бурхан байдгийг хүлээн зөвшөөрөх нь нэг хэрэг бол, Түүний өмнө сөгдөх нь тэс өөр хэрэг юм. Бид Бурханыг хүндэтгэж байж л жинхэнээсээ мэднэ. Харин бид хүндэтгэхээр бүтээгдсэн юмаа хүндэтгэхгүй бол, сэтгэлгээ маань унтарна. Үүнийг Англи Стандарт Библи дээр хэрэг байхгүй, дэмий, хоосон гэсэн утгаар “*хэрэгцээгүй*” гэдэг. Энэ нь ашиг байхгүй юмуу бүтээх чадваргүй сэтгэлгээг дүрслэн харуулж байна. Харин Мессеж Библи дээр үүнийг “Тэд мэддэг царай гаргав ч, амьдрал дээрээ тас харанхуй юм” гэдэг.

Өнөөдрийн бодит байдлын жин биднийг дарж байна. Өнөөдрийнх шиг их мэдлэгтэй боловч, ямар ч зорилгогүй үе түүхэнд байгаагүй байх аа. Бид эрүүл саруул амьд харилцааны тал дээр жинхэнэ асуудалтай болжээ. Бид жинхэнэ амьд харилцаагаа золиослоод, виртуал хүмүүстэй харилцаа хөгжүүлдэг. Бид явах ёстой цаг хүртлээ нэг газраа удаан тогтохоосоо илүүтэй нэгээс нөгөө рүү үсчиж сурсан. Хүндэтгэхийн тулд амсхийгээд, төвлөрч тунгаах урлаг алдагдсан.

Харин Бурханыг хүндэтгэхээс татгалзаж, өөр зүйл дээр өөрийгөө үрэх үед юу болдгийг Ром ном цааш нь хэлжээ:

үл муудагч Бурханы алдрыг мууддаг хүн, шувууд, дөрвөн хөлт амьгад хийгээд мөлхөгчидтэй адил дүрээр сольжээ. Иймд Бурхан тэднийг зүрхнийнх нь хүсэл тачаалын бузар юмстай зөнд нь орхиж, тэд бие махбодоо өвөр хоорондоо гутаажээ. Учир нь, тэд Бурханы үнэнийг худал хуурмагаар сольж, Бүтээгчээс илүүгээр бүтээлд нь мөргөн, зарагджээ.



ХҮНДЭТГЭХИЙН
ТУЛД
АМСХИЙГЭЭД,
ТӨВЛӨРЧ
ТУНГААХ УРЛАГ
АЛДАГДСАН.

Бурхан бол үүрд магтагдах Бүтээгч мөн. Амен. (Ром 1:23-25)

Манай Барууны соёл мөнхийн ертөнцийн алдрыг худалдаж авч болох, хүрч болох, хянаж болох дөт тааллаар сольжээ. Бид өөрсдийг маань өндөр өргөж чадах Бүтээгчийг бөөнөөрөө түлхэж, оронд нь биднийг уруудан доройтуулах бүтээлийг нь шүтэх болсон юм. Бид амбици, шуналын шүтээн рүү зүрхээ хандуулснаараа, өөрсдийгөө бэлгийн ёс бус байдлаар завхруулжээ.

Энэ өчүүхэн хэсгээс яаран дүгнэлт гаргахаасаа өмнө зохиолч Престон Спинклийн “Хүмүүс хайрлуулах ёстой” гэдэг номоос иш татъя: “Бэлгийн цэвэр бус байдал” гэхээр дан ганц ижил хүйсийн харилцаагаар ойлгож болохгүй. Үүнд гэрлэлтээс гадуурх бэлгийн харилцаа, завхайрал, хүчин зэрэг ижил хүйстнүүдийн болон жирийн хүмүүсийн үйлддэг бүх төрлийн бэлгийн нүгэл багтана.”¹

Энэ дунд миний нүгэл ч явж байна. Манайхан бараг л удам судраараа шахуу гэрлэлтээс өмнөх садар самуунд оролцсон улс байлаа. Үнэнийг хэлэхэд бүх төрлийн порно, завхрал маш алдартай болжээ. Барууны ертөнц гахайн хороонд сэрэхдээ, яаж яваад тэнд оччихсноо гайхдаг.

Бид Бурханаас эргэх үед Бурхан бидний дээрээс хориглогч мутраа авч, биднийг дураар маань тавьжээ.

Энэ нь цөлөөр аялаж явсан Израилийн хүүхдүүдэд тохиолдсон явдлаас нэг их ялгаагүй юм. Тэд манна хэмээх Бурханы гайхамшигт хангамжаас татгалзаж, мах шаарджээ. Тэд мах тамир тэнхээг нь сэлбэнэ гэж бодсон болтой. Бурхан тэдэнд бөднө шувууг илгээсэн нь тэдний сэтгэлийг сул дорой болгожээ. Бид өөрийнхөөрөө шаардахдаа, өөрийгөө гээдэг. Паул энэ

тухай хэлдэг:

—◆—
Бид
өөрийнхөөрөө
шаардахдаа,
өөрийгөө
гээдэг.

Ийм учраас Бурхан тэднийг гутамшигт хүсэл тачаалтай нь зөнд нь орхиж. Тэдний эмэгтэйчүүд ч бэлгийн төрөлх харьцааг төрөлх бусаар сольцгоожээ. Түүнчлэн эрчүүд ч эмэгтэй хүнтэй бэлгийн төрөлх харьцаатай байхаа орхиод, нэг нэгэндээ тэмүүлэх хүсэлдээ шатаж, эрчүүд эрчүүдтэйгээ

ичгүүрт зүйлийг үйлдэж, өөрсдийн алдааны зохих цээрлэлийг өөрсдөдөө хүртэж байна. (Ром 1:26-27)

Энэ ишлэл маш олон зүйл хэлсэн боловч, үндсэндээ Бүтээгчийнхээ цэц ухаанаас салсан хүн “хүн байх” ухаанаа алддаг тухай хэлжээ. Бурханы мэдлэг дотроос л бид хүн байх учраа олдог. Бурханы мэдлэг л биднийг завхайрал, шунал, харгислал, садар самуун зэрэг бүх төрлийн гутамшгаар өөрийгөө бузарлахаас хамгаалдаг.

Гэтэл манай үе энэ үндэс суурийг мартжээ. Дийлэнх Америк кинонууд хүчирхийллийг магтан дуулдаг - тэгээд дараа нь бид гэр, сургууль, гудманд хүчирхийлэл харахаараа нүдээ эргэтэл гайхдаг. Зурагтын хөтөлбөр - суртчилгааны талаар бүр хэлэх ч хэрэггүй - тэнд бүх төрлийн бэлгийн харилцааг суртчилдаг. Бид хэр хэмжээнээсээ хол хэтэртлээ элдэв зүйлд илчлэгдэх болсон тул өмнөх үеийнхэнд маань өдөр тутам тулгардаггүй байсан асуудал биднийг бөмбөгджээ.

Манай боловсролын систем юугаа ч мэдэхгүй насан дээрээ яваа дунд сургуулийн хүүхдүүдийг өөрийнхөө хүйсийг шийдэхийг тулган шаардаж байна. Дунд сургуулийн нас чинь ямар хүнд байдаг билээ? (Олон жилийн өмнөх явдал боловч, тэр үе миний хувьд ямар хөндүүртэй байсныг би санаж байна)

Хэрэв намайг дунд сургуульд байхад, өөрийгөө тодорхойл гэсэн бол, би өөрийгөө ганц эвэрт л гэж хэлэх байсан. Тэр үед чинь би өөрийнхөө биеийн учрыг олохгүй тэвдэж бас яагаад надад мөөм ургахгүй байгаа учрыг олох гэж цөхөж байсан нас шүү дээ. Тэр үед надад хөвгүүдийг шохоорхох ухаан байхгүй - хувцас солих өрөөнд байхдаа бусад охидын бие минийхээс юугаараа өөр байгааг мэдэх гэж сэм сэм бүлтгэнэдэг үе байлаа шүү дээ.

Тийм насанд ижил хүйсийнхээ хүнийг ажиглах нь хэвийн зүйл юм. Яагаад гэвэл хүн бүр өөрийнхөө биеийн учрыг олох гэж хичээдэг. Гэтэл өнөөдөр бид яагаад энэ үе шатыг хамгаалахгүй байна? Яагаад бид хүний залуу насыг хүйсчилнэ вэ?

Хөвгүүнээс эрэгтэй хүн, охиноос эмэгтэй хүн рүү шилжиж байгаа хүмүүсээс ямар хүйстэн болмоор байна, өөрийгөө тодорхойл гэж шаарддаггүй юм. Үр хүүхдийг маань хүйсчилж, шилжилтийн насыг нь завхруулахыг бид сургуулийн систем,

соёлд зөвшөөрөх гэж үү? Зарим сургууль бүр охин нь охиноо, хүү нь хүүгээ үнсэх гэх мэт ижил хүйсийн харилцааг үзүүлэн болгож, харж байгаа зүйлдээ хариу мэдрэмж үзүүлж байгаа бол, чи ижил хүйстэн гэх зэргээр заадаг болсон.

Үгүй шүү. Бурхан хүнийг бэлгийн харилцаанд сэрэл мэдрэмжтэй бүтээсэн учраас л, тэдэнд сэрлийн мэдрэмж төрж байгаа нь тэр юм. Бид бэлгийн холбогдолтой зүйл харах үед биед маань сэрэл мэдрэмж төрдөг. Гэрлэсэн, ганц бие, жирийн, ижил хүйстэн, хөгшин залуу хамаагүй - бүх хүн адилхан. Тэглээ гээд мэдээж өөр хүнтэй унтана эсвэл хань ижлээ араар нь тавина гэсэн үг биш л дээ.

Гэрлэлтийн гэрээ дотор эрэгтэй, эмэгтэй хоёр хүний хоорондох янаглал нь хүндэтгэлтэй явдал юм. Гэрлэлтээс гадуур бол энэ

хүндэтгэл нь ямар ч хүндэтгэлгүй явдал болж хувирна. Тиймээс л завхайрал, садар самууныг гэрээг зөрчсөн явдал гэж үздэг. Үүнээс гадна Библи олон орчуулга дээрээ төрөлх бус, гутамшигтай гэж дүрслэсэн тачаа хүслүүд бий. Эдгээрт: ижил хүйсийн явдал, цус ойртох, бага насны хүүхдийг хүчирхийлэх, мал адгуустай явалдах зэрэг нь багтана. Би яг одоо түр зогсмоор байна.

Ром 1 дээр бүгд нүгэл үйлдсэн гэдэг. Шунал, гүтгэлгэ нь завхайрал, ижил хүйсийн явдал шиг л гашуудмаар зүйлс юм.

Бид юу
хийсэн,
хэнтэй
хийсэн нь
хамаагүй.

Нүглийн төлөөс

Ийм сэтгэлгээг хүлээж авсан хүмүүсийн ял, шийтгэлийг Ром 1:27 дээр хэлжээ. Гэхдээ үүний төлөөсийг хэзээ ч Бурхан бидэнд тулгадаггүйг би тодруулмаар байна. Бурхан биднийг үхэл, хараалыг бус, харин амь ерөөлийг сонгох өөрчлөлт рүү урьдаг. Бурхан амьдралаа сүйтгээд, гахайн хороонд сэрсэн, тэнэмэл биднийг нөмрөг, бэлзэг, найраар угтахаар хүлээн суугаа Аавдаа ир гэсээр урьдаг. Тэр бол *одоо* ч биднийг “Хүрээд ир, тэгээд хэлэлцье... Хилэнц нүгэл чинь час улаан мэт байвч цасан адил

цагаан болно. Хүрэн лугаа улаан боловч ноос лугаа адил болно” (Исаиа 1:18) хэмээн урин суугаа Бурхан. Бид юу хийсэн, хэнтэй хийсэн нь хамаагүй. Тэр биднийг аварна.

Харин бид амьдралаа шүтээн мөргөл, бэлгийн нүгэл, шуналын хорт бодисоор босгосоор байвал, эцэстээ амьдрал маань нурж, дэндүү их гарз хохирол үзнэ. Хэрэв бид “намайг өөр хүн, өөр хүйс, өөр эм, өөр машин, өөр байшин, өөр донтолт хангана” гэсээр явбал, нэг мөр сүйрнэ. Манай үеийн эвдэрхий хүмүүс бүрэн бүтэн болохын төлөө цөхрөнгөө барахдаа, хүний санаанд багтамгүй эрсдэлтэй юмс үйлдэх болжээ. Гэтэл үүний нэг шалтгаан нь бид өөрчлөлтөө харуулж чадахгүй байгаагаас тэр юм.

Ром ном цааш нь:

“Тэд Бурханыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан тул тэднийг Бурхан завхарсан сэтгэл болон хийх ёсгүй үйлдэлд нь орхижээ” (Ром 1:28) гэж байна.

Бид алдуурч яваа хүмүүс ажээ. Бид хайртай Аавынхаа зоогийн газраас зугтаад, гинжлэгдэж дуусдаг. Бид хэн дуртай нь юугаа ч хамаагүй хийж байсан, Израилийн хүүхдүүд шиг л болжээ. Бурханы аль нэг хориггүй хүмүүс ямар байдгийг Ромын дараагийн хэдэн ишлэл хэлжээ:

Тэд элдэв зүй бус, хилэнц, шунал, бузар булайгаар дүүрэн агаад агаа жөтөө, аллага, хэрүүл, заль мэх, хар санаагаар дүүрсэн, хов жив яригч, гүтгэгч, Бурханыг үзэн ядагч, дээрэлхүү, их зантай, сагсуу, хорон мууг санаачлагч, эцэг эхдээ дуулгаваргүй, ухваргүй, найдваргүй, үл хайрлагч, өршөөл үзүүлдэггүй хүмүүс ажээ. (1:29-31)

Бурханыг хүндэтгэж, Түүнд мөргөхөөс татгалзсан соёл ямар байдгийг харуулсан жагсаалтынхаа дараа Паул өөрийн өгсөн дүрслэлээ 32- аар ишлэл дээр дүгнэсэн байна:



Бид хайртай
Аавынхаа
зоогийн
газраас
зугтаад,
ГИНЖЛЭГДЭЖ
ДУУСДАГ.

Ийм зүйлсийг үйлдэгч нь үхвэл зохино гэсэн Бурханы зарлигийг тэд мэддэг хэрнээ өөрсдөө үйлдээд зогсохгүй, бусдыг үйлдэхэд нь ч сайшаадаг байна.

—◆—
**Бидэнд
шүүх ямар ч
байр суурь
байхгүй.**

Үнэндээ бид бүгдээрээ үхэх ёстой байсан юм. Гэхдээ бид саяхныг хүртэл урьдын сүйрчихсэн амьдралынхаа сонголтыг (шунал, ёс бус байдал, бардамнал, хов жив, атаархал гэх мэт) бусдаар хүлээн зөвшөөрүүлэн батлуулах юмуу тэр бүү хэл шан харамж хүсэх талаар хэзээ ч санаж явсангүй. Христийг хүлээн авах үед нигүүлсэл биднийг

Бурханы уур хилэн дор тавьсан эдгээр үйлдлийг ардаа орхих хүчтэй болгожээ. Бид нигүүлслийн талаарх Бичээсийн хэсгээр урьдын явдлаа өмгөөлөн дэмжиж болохгүй. Үүгээр өнөөдрийн бодит байдлын талаарх яриагаа дуусгая. Харин одоо хамгийн чухал адамант хэсэг.

Бидний бодит байдал

Үнэндээ бид энэ үеийн хүүхдүүд биш, харин өнө мөнхийн хүүхдүүд юм. Тиймээс өөрсдийнхөө талаарх үнэнийг танин мэдэхдээ, хэн байгаагаас хэн болж болох руу хөдөлцгөөе. Ром 2:

Тиймээс шүүдэг хүн бүр ээ, танд шалтаг байхгүй. Учир нь бусдыг шүүдгээрээ та өөрийгөө ялладаг. Учир нь шүүдэг та мөн л эдгээрийг үйлддэг шүү дээ. Ийм зүйлсийг үйлддэг хүмүүс дээр буух Бурханы шүүлт нь үнэний дагуу байдгийг харин бид мэднэ. Ийм зүйлсийг үйлддэг хүмүүсийг шүүдэг атлаа өөрөө мөн л тэдгээрийг үйлддэг хүн ээ, та Бурханы шүүлтээс мултарна гэж бодож байна уу? (1-3)

Шалтгаан байхгүй

Дахиад л хэлж байна. Бидэнд шүүх ямар ч байр суурь байхгүй.

Хэзээ ч байгаагүй. Бид өөрчлөгдсөн амьдралаараа Есүсийг өргөмжлөхийн оронд олон жил Бурханыг алдаатай амьдралаасаа саатуулсаар иржээ. Бурхан ганцаараа бүгдийн Шүүгч. Бид өөр өөр нүгэл үйлдсэн байж болох ч, энэ нь Бурхан бидэнтэй хариуцлага тооцохгүй гэсэн үг биш юм. Бид бэлгийн нүгэлд оролцоогүй байж болох ч... бусад жагсаалтын хувьд яах вэ? Гүтгэлгэ, атаа, тэмцэл, хов жив, бардах, шуналын хувьд яах вэ? Эдгээр нь чуулганд байхгүй юу?

Бидэнд бүгдэд маань нигүүлсэл хэрэгтэй - тиймээс нигүүлслээ тэлье.

Бидэнд бүгдэд маань хайр хэрэгтэй - тиймээс хайраа тэлье.

Бидэнд бүгдэд маань найдвар бас биднийг ирээдүйд хэн болох хүчин чадлыг маань олж харах хүмүүс хэрэгтэй. Хайрладаг, нигүүлслээ сунгадаг хүмүүс биднийг өөрчлөлтөд зэхдэг.

Паул цааш нь өөрчлөлт хэрхэн өрнөдөг талаар өгүүлрүүн:

Эсвэл Бурханы энэрэнгүй чанар өөрийг чинь хөтлөн гэмшилд хүргэдгийг та мэдэлгүй, Түүний энэрэл, хүлцэл ба тэвчээрийн баяныг басамжлах уу? (2:4)

Бурханы зөөлөн зан бидний нүглийг дэмждэг биш, харин ямагт үнэн рүү дууддаг. Си. Эс. Люис “Бурханы хатуу нь хүний зөөлнөөс уяхан бөгөөд Бурханы ятгалга нь бидний чөлөөлөлт юм” гэжээ. Бурхан биднийг үнэний замаар эрх чөлөө рүү бат дагуулахыг хүсдэг. Есүс үхлээс амилуулагдсан нь биднийг хайхрамжгүй зангаа хаяад, Өөрийнх нь тахилыг хүндэтгэх замаар амьдруулах гэсэндээ тэр юм. (Үйлс 17:30-31)

Тэгэхээр лав хөтлүүлээд, эрс тэс өөрчлөлт рүү очих тухай ярья. Энэ нь таны хувьд юу гэсэн үг болохыг би мэдэхгүй болохоороо, Бурхан миний гараас лав атгасан тэр өдрийн тухай ярьмаар байна.

◆

Бурханы
зөөлөн зан
бидний
нүглийг
дэмждэг
биш, харин
ямагт үнэн
рүү дууддаг.

Дахин төрсөн нь

Би 21 насандаа Пердюд зуны сургалтад суухаар гэртээ ирээд байхдаа дахин төрсөн юм. Тэр хүртэл амьдрал маань Ром ном дээр хэлсэнтэй адил тас харанхуй цагирган гулгуур шиг л байв. Би маш хатуу, дураараа, замбараагүй, тэрслүү охин байлаа. Тэгтэл нэгэн орой яваандаа Библи судлал болж хувирсан зугаалга дээр нүдний минь хайрс унасан юм. Шал солгой мөртлөө гараа дээшээ өргөөд л дуулж байгаа хүмүүсийн дунд зогсож байхдаа, би хаашаа харахаа ч мэдэхгүй байлаа. Тэдний чин сэтгэлээсээ царай, өргөсөн гараас дайжихын тулд би гартаа барьсан дууныхаа цаас руу л ширтээд байлаа. Тэгээд дараагийн дууны үгийг түрүүлж уншив: “Зөвт байдлын нөмрөг” гэнэ үү?” Тэр дууны нэг мөрөнд Бурхан намайг харахдаа, намайг биш, Есүсийг хардаг гэсэн утгатай үг байлаа.

Яг тэр эгшинд Ариун Сүнс надад “Би чамайг харахгүй” гэж шивэгнэсэн юм. Би тэр үгийг уншихдаа, Есүс бол надад хэрэгтэй байсан тэр нөмөр нөөлөг болохыг ухаарсан юм. Тэр хүртэл би өөрийнхөө үйлдэл, сонголтыг хар мянган шалтаг, буруутгалаар зөвтгөдөг байлаа.

Тэр орой би дахин төрөхийн төлөө залбирч, Бурханы Ариун Сүнсний удирдамжид амьдралаа өгсөн юм. Намайг дотуур байрандаа эргэж ирэхэд, өрөөнд маань миний шинэ амьдралтай огт нийцэхгүй юмс байгаа юм шиг санагдав. Тэгээд тэр даруй бүгдийг нь хамаад доод талын хогийн савд хийчихэв.

Надад хэн ч ингэ гэж хэлээгүй боловч, Бурханы Сүнс намайг дүүргэх үед би урьд өмнө хэзээ ч мэдэрч байгаагүй зүйлсээ мэдэрсэн юм. Өмнө нь зүгээр л санагддаг байсан үйлдэл, үг, зан авир маань одоо муухай, заримдаа бүр гашуудмаар санагддаг болов. Энэ нь ичгүүр юмуу ялын мэдрэмжийн түрлэг байсангүй. Энэ нь Ариун Бурханыг ухааран мэдэх шинэ мэдрэмж, нөлөөний оршихуй байв.

Жон (миний ирээдүйн нөхөр) надад юм л бол элч Паулын тухай ярьдаг байлаа. Бүр Коллежийн зүгээс надад зориулж Шинэ гэрээний Зам гэдэг хэвлэлийг өрөөнд маань тавьж өгч билээ. Тэр шөнө би тэр Паул гэдэг хүний номыг нилээд уншив. Би Библиэ нуруугаар нь дэлгэж тавиад, Паул гэдэг хүний номыг гаргаж

ирэхийн төлөө залбирч билээ. Гэтэл хуудас нь хуваагдсаар, 2Коринт 5:17 гэсэн хэсгийг гаргав:

Тиймээс хэн нэг нь Христ дотор байвал тэрээр шинэ бүтээл мөн. Харагтун, хуучин нь өнгөрч, шинэ болсон байна!

Энэ үг нь Паулын үг болохыг мэдэхдээ, би түүний бичсэн ганц бүлгийг яг олоод уншчихлаа гэж бодов! Тэгээд сүүлийн арван жилд анх удаагаа ер бусын амгалан нойрсож билээ.

Нэг юм болж дээ

Маргааш нь би өглөө эрт сэрээд, сүнсээ амьд байхыг мэдрэв. Тэгээд давхар орон дээрээсээ гулгаж буугаад, болсон явдлыг ээждээ хэлэхээр явлаа. Тэгтэл яг тэр эгшинд: “Өнгөрсөн шөнө юу ч болоогүй. Чиний юу ч өөрчлөгдөөгүй” гэх жихүүн үг сонсдов. Би айдаст автан хөшив. Тэгээд өөртөө эргэлзэж эхлэлээ. Би хэнийг хуураад байна аа? Над шиг хүн Христэд итгэнэ гэж үү? Тэгтэл би урьд шөнө мэдэрсэн амар тайвнаа, архи уулгүйгээр анх удаа унтсанаа, залбирах үедээ гэдсэнд маань зангилаа тайлагдаж, Бурханы эдгэрлийн халуун дулаан биед маань нэвтрэхийг яг бодитоор мэдэрснээ саналаа.

Тэр үед би тэр дууг танив.

Тэр бол сүйтгэгчийн дуу байлаа.

Энэ дуу намайг буруу хооллох донтолт руу хөтлөдөг байв. Энэ дуу намайг айдас, аюулаар сүрдүүлдэг байв. Энэ дуу намайг тусгаарлаж, ялладаг байв. Энэ дуу намайг нүгэлд уруу татдаг байв.

Энэ дуу намайг Христэд итгэгч биш гэж хэлж байсан удаа бий юу? Хэзээ ч үгүй. Энэ дуу хоолой миний мөнхийн байр суурийн талаар ямар нэг юм хэлж байсан удаагүй. Тэр эгшинд би худалч, хулгайч нар нь бидэнд байдаггүй зүйлийг авахаар ирдэггүй болохыг би ухаарсан юм. Энэ бол миний аврагдсан амьдралын анхны өглөө байсан учраас, эргэлзээний шивнээнүүд иржээ.

Гэхдээ тэр үгс надад шал эсрэг үр нөлөө үзүүлсэн юм. Эдгээр нь намайг өнгөрсөн шөнө болсон явдалд эргэлзүүлэхийн оронд

харин ч бүр үнэнийг батлаад өгөв.

Нэг юм болж дээ! Би золтой л инээд алдчихсангүй. Дайсны оролцоо миний Бурханыг бодитой болохыг илчлээд өгөв.

Би буцахын аргагүй өндөрлөгт гарчээ. Миний амьдралд яг юу өөрчлөгдсөнийг би хэлж мэдсэнгүй. Би тэр дороо л Бурханд хамаг юмаа өргөчихөв. Тэгээд хоёр долоо хоногийн дотор усан баптисм хийлгэсэн юм.

Сарын дараа хичээлийн шинэ жил эхлэж, би хичээлдээ орохоор Аризона дахь хуурай эгч дүүсийнхээ байранд ирээд, зун миний амьдралд юу болсныг хуурай эгч дүүсдээ ярьлаа. Тэгээд мэдээж хэн ч баярлаагүй, хэн ч итгээгүйг хэлэх шаардлагагүй байх.

Хаалга тогшсон нь

Нэг өдөр намайг өрөөндөө Библиэ чангаар уншиж байтал, үүдэн хэсэгт хөлийн чимээ сонсогдоод, дараа нь хаалга тогшив. Намайг хаалгаа тайлтал нэг эгч маань “Чанга уншихаа боль!” гэж хэлэх нь тэр. Тэр өөрийнхөө үгд надаас дутахгүй цочив. Тэр үед би чөтгөр бодитой гэдгийг мэдсэн юм. Би хуурай эгчээ хүндэтгэсэндээ, аюулгүйн шатаар авираад, байшингийнхаа дээвэр дээрээс Библиэ чангаар уншиж эхлэв.

Тэр шилдэг байршлаас би Бурханы амлалтыг кампус, байр, ирээдүй дээрээ тунхаглав. Олон шөнө би үүдэн хэсгээр алхаж, хуурай эгч дүүсийнхээ төлөө залбиран, тэднийг харанхуйн эрхшээлээс гэрлийн хаанчлал руу дууддаг байж билээ.

Тэгтэл удалгүй манай хаалгыг бас нэг хүн тогшив. Гэтэл шинэ оюутан охид надад юу тохиолдсоныг мэдэхийг хүсчээ. Тэд намайг өмнө ямар байсныг сонсоод, харин одоо ямар байгааг хараад, надад байгаа зүйлийг бас авахыг хүссэн юмсанж. Би ч Кампус Крусэйдийн танилцуулгаа шүүрч аваад, тэнд бичсэн үг бүрийг тэднээр нэг бүрчлэн чангаар уншуулав.

Би хуурай эгч дүүсдээ анх удаа номлосноо санаж байна. Ёстой санаандгүй юм болсон доо. Би яагаад ч юм, олон улсын эдийн засгийг их сонирхдог байлаа. Тэгээд эхний хоёр жил их амархан байснаа, гурав, дөрөвдүгээр дамжаанд профессорууд маань тааруухан сурагчдаа хасч эхлэв.

Тэгээд манай ангийн хэд нийлж байгаад шөнөжин хагас улирлын шалгалтдаа бэлдсэн юм. Өглөө нь цайгаа уухаар ширээндээ шахцалдан, бие биеэсээ асуулт асууж суув. Би ч сэргээдэг эм, кофе хоёрын ачаар л сэрүүн байж байтал, уг нь дөрвөн хүүтэй над шиг хүний л сонгох ёстой байсан бага ангийн боловсролыг онож сонгосон нэг хуурай эгч маань бүжсээр хүрч ирэв. Тэр бидэн рүү ганц хараад л, аймшигтай харагдаж байгааг минь хэлэх ёстой гэж боджээ. Бид түүний үгийг нэг сонсчихоод, эргээд хичээлдээ орлоо. Гэтэл тэр юу ч ойлгосонгүй болтой. Тавиуртай хоолоо барьсаар бидэнтэй хамт сууснаа, “Лиза, чи яг л машинд дайруулчихсан юм шиг харагдаж байна” гэсэн утгатай үг хэлэв.

Тэгтэл миний хамаг бие чичрэн, хуучин Лиза гадагшаа гарч ирж байгааг мэдрэв. Тэгээд гэнэт амаар маань сүүлийн хэдэн жил дотроо тээсэн асуулт ойлгодов: “Чи яахаараа хар өглөөгүүр ийм г***й болчихдог юм бэ?”

Цайны газар нам болов. Дахин төрсөн хүн хараал хэлчихлээ! Би итгэхээсээ өмнө зогсоо зайгүй хараадаг байсан бол, шинэ итгэгч болсноосоо хойш ядаж л дотроо харааж сураад байлаа. Гэтэл түмэн амьтны дунд чангаар гаргаад хэлчихдэг. Хуурай эгч дүүс маань яахаа мэдэхгүй тэвдэв. Гэтэл нэг эгч маань босоод, над руу зааснаа “Хэлээгүй юу! Чи хэзээ ч Христэд итгэдэг хүн болж чадахгүй! Чи хэтэрхий муу охин!” гэж хэлчихээд, сэгсгэнээд л гараад явчихав.

Намайг боссон чинь өрөөний маань ялдам охин гараас маань бариад: “Би ч бас тэгж хэлэх л байсан!” гэж хэлэв.

Би түүн рүү инээмсэглээд, босч зогстол, бүх нүд над руу харж байлаа. Тэгэхээр нь би “Намайг уучлаарай! Би зохисгүй юм хэлчихлээ” гэж хэлэв.

Хожим нь олон найз маань надад яг тэр үед л намайг итгэгч гэдгийг олж мэдсэнээ хэлж билээ. Харж байна уу, тэд намайг шүршүүртээ залбирч байхыг, байшингийнхаа дээвэр дээрээс Библиэ чанга уншиж байхыг хараагүй. Тэд намайг шөнө үүдний өрөөгөөр яваад, өөрсдийнх нь төлөө залбирч байхыг хараагүй.

◆

Бид
бүгдээрээ
алдаа
хийдэг ч,
шалтаг
тоочих
эрхгүй.

АДАМАНТ

Гэтэл тэр өдөр тэд намайг өөрийгөө даруу болгож байхыг анх удаа харжээ.

Тэгэхээр бид адамант - бат бэх өөрчлөлтийг харуулах гэж байгаа бол, яг ийм байр суурь - хандлагатай байх ёстой бус уу? Бид бүгдээрээ алдаа хийдэг ч, шалтаг тоочих эрхгүй. Бид хэрхэн илүү сайн хийж болохоо мэдсэн цагтаа л илүү сайн хийж эхлэдэг. Харин буруу хийчихбэл, алдаагаа хүлээн зөвшөөрнө.

Чарльс Спержен:

Нүглээс болж зовж үзээгүй хүн нүглийг яллаж чадахгүй. Гэмшиж үзээгүй хүн гэмшлийг номлож чадахгүй. Итгэж үзээгүй хүн итгэлийг номлож чадахгүй. Жинхэнэ номлол нь артезианы худаг юм. Энэ нь сэтгэлийн гүний гүнээс оргилж гараад, хальдаг. Христ бидний дотор худаг байгуулаагүй бол, биднээс ямар ч урсгал гарахгүй³ гэдэг.

Үнэхээр гоё үг. Номлох нь артезиан буюу амьд усны булаг юм.

*Тэнгэрийн Бурхан Аав минь,
Гараас минь лав атгаад, намайг эрс тэс өөрчлөлт рүү
хөтлөөч. Амьдралын маань хэсэг бүр бусдыг Тан руу
чиглүүлдэг үг байх болтугай. Би хүмүүст юуны эсрэг
зогсдоогоороо биш, харин Та юуны төлөө зогсдогийг
мэдүүлэхийг хүсч байна. Би өөрийнхөө алдаанд цаашид
шалтаг тоочихгүй. Амьдралд маань Таны үйлстэй
сөргөлдсөн зүйл байгаа бол, надад харуулаач. Амень.*

АРИУН БАЙДЛААР АДАМАНТ БАЙХ (АРИУН БАЙДЛААР БАТ БЭХ БАЙХ)

Ариун байдал нь (Бурханы) бусад бүх чанарын төгс илэрхийлэл юм. Бурханы хүч нь ариун, өршөөл нь ариун, цэц ухаан нь ариун. Бурханы ариун байдал л Түүнийг юу юунаас илүү магтаал хүндэтгэлд бүрэн эрхтэй болгодог.

Жерри Бриджес

Би хориод насандаа “*Ариун байдлын араас*” гэдэг номыг уншиж байсан юм. Хуудас бүр нь миний доторх биелээгүй санаашралыг маань өгүүлж байлаа. Би Бурхан ариун гэдгийг ойлгосон ч, би өөрөө ариун байдлыг мөшгих ёстой гэдгийг ерөөсөө мэддэггүй байв. Энэ ухаарлаар хэл яриа маань өөрчлөгдөж, хүндэтгэл магтаалын маань төвлөрөл шилжиж, нөхөрлөх хүнээ сонгохдоо ч болгоомжтой хандах болов. Би өөрийгөө бусдаас дээр гэж бодсон учраас тэр биш л дээ. Үнэндээ би ариун бус бүх зүйлсээс хавьгүй сул дорой бөгөөд тэдгээрийн давалгаанд амархан цохиулдаг байлаа.

Иймээс би Ариун Бурханы надад илчилж өгсөн зүйлс надаар дамжин илчлэгдэхийн тулд эдгээрийг сахин хамгаалахын төлөө асар их зовсон юм шүү. Миний явж байгаа зам бол удаан үхэлд хүргэдэг зам гэдгийг мэдэх хүртлээ би цаанаасаа л нэг зэрлэг амьдрал руу гүйчих гээд байдаг хүн байв. Гэтэл дараа нь хэт их хичээснээсээ болоод, эсрэг туйл руу хадуураад, баахан хууль дүрэм, гадаад үзэмжид анхаарах байдалд орооцолдов. Анхныхаа хүүхдийг төрүүлэх үедээ би хүүгээ нэг мөсөн бүрэн төгс ариун бөгөөд чөлөөтэй төрчихөөсэй гэж үнэн голоосоо хүсч билээ. Тэгвэл миний хүү ээж шигээ зовох хэрэггүй болно.

Бүү ай! Ариун байдлын талаарх ойлголт нь бидний хувьд бас өөр нэгэн хууль дүрэм, хориг цаазын жагсаалт биш юм. Ариун байдал нь харин ч бидний чөлөөлөлт юм. Энэ нь зөв буруугийн асуудал гэхээсээ илүү утга төгс итгэлийн амьдрал гэсэн үг билээ. Ариун байдал нь Бурханы адамант бүрэн дүүрэн байдал руу дуудсан урилга юм. Шотланд теологич Синклэйр Фергюсон:

“Бурхан ариун гэдэг нь Тэрбээр нүглээс ангид гэсэн үг юм. Гэтэл нөгөөтэйгүүр Бурхан доторх ариун байдал нь бүрэн дүүрэн байдал гэсэн утгатай. Бурханы ариун байдал нь Түүний “Бурхан чанар” юм. Бурхан байх гэдэг нь Бурхан байх л гэсэн үг. Тиймээс Бурхантай ариун байдал дотор уулзах нь Түүнийг хүн биш, харин Бурхан гэдгийг нь танин мэдэхдээ бүрэн бишрэх явдал юм.”¹ гэжээ.

Бурхан биднийг нүглээс салгадаг боловч, Христ дотор Бурхан бидэнтэй амьсгал мэт ойрхон байдаг. Бид Бурханы ариун байдал дотор амьсгаа авахдаа Түүнийг биднээс ямар өөр болох илчлэлийг ойлгохын сацуу Тэр биднийг хичнээн хайрладгийг гүнээ ухаарна. Ариунаар амьдрах нь олон талаараа Бурханы өгсөн зөвтгөлийн бэлэгт талархах үйлдэл билээ. Тэр биднийг тансаг сайхан нөмрөгөөр гоёод байхад, бид яагаад бохир хувцсаа буцааж өмсөх ёстой гэж? Бидний тэргүүнийг харанхуйгаас өргөж, Өөрийнхөө гэрэлд байлгах гэж бидний төлөө Хүүгээ зориулсан Хаан биднийг хайрлажээ. Тийм байтал, бид яагаад харанхуй руу эргэх ёстой гэж?

Бурхан ариун, Бурханы үйлс ариун.

Бурханы үйлс шиг Түүний ариун байдал нь ч баг бэх: ялагдашгүй, гатлашгүй, хуваагдашгүй, нэвтрэшгүй, тууштай, гуйвшгүй, тогтуун юм.

Бурханы ариун байдал нь хувирашгүй бөгөөд сэтгэл татмаар юм - учир нь Бурханы ариун байдал нь аймшигтай бөгөөд гайхамшигтай.

Бурхан бол ариун гэрэл. Бурхан бол ариун хайр. Бурхан бол залгидаг ариун гал.

Ариун байдал нь Бурханы ер бусын мөн чанараас салшгүй.

Бурхан бол бидний ариунаар, гайхамшигтай захирдаг бидний ариун Аав юм. Бичээс Хуучин гэрээнээсээ авахуулаад Шинэ гэрээ хүртлээ Бурханы ариун чанарыг тунхагладаг:

Ай ЭЗЭН, бурхдаас хэн нь Тан лугаа адил Ариун нь үлэмжийн, Алдар нь аймшигт, Үйлс нь гайхамшигтай вэ?
(Гэтлэл 15:11)

Өө, Эзэн, Танаас үл эмээх, нэрийг тань эс алдаршуулах хэн байх вэ? Учир нь зөвхөн Та ариун билээ. Бүх үндэстэн Таны өмнө ирж, мөргөнө. Учир нь Таны зөвт үйлс илчлэгдсэн.
(Илчлэл 15:4)

Ариун байдал гэж юу вэ?

Бурханы энэ бат бэх чанараар цааш хөдлөхийн тулд бид эхлээд үүнийг ойлгох ёстой. Ариун гэдэг үгийг “төгс сайн сайхан”, “зөвтгөл” хэмээн хэсэгчлэн тодорхойлж болно. Хамгийн энгийнээр ариун байдал нь хүний нийтлэг зан үйлдлээс хавьгүй ангид бөгөөд дээд, тэс өөр, ер бусын чанар юм. Бурхан ариун учраас, хийдэг бүхэндээ ариун байдаг. Ариун Нэгэний авир үйлдэл нь өөрөө ариун байдал юм. Ариун гэхийг өөрөөр ариусгагдсан, өргөгдсөн, цэвэршсэн, зориулагдсан, бурханлаг, ариун нандин гэж хэлж болно.

Эн.Ти. Врайт “Хүмүүс ариун байдлыг голдуу ёс суртахууны алдаагүй - сөрөг чанар шиг үздэг ч, энэ нь үнэндээ Бурханы дүр төрх дотор байх гэдэг нь юу болохыг үйлдэж сурах үед хүний чанарт үзэгддэг гэрэлтэгч тусгал болох эерэг зүйл юм”² гэжээ.

Би үүнд дуртай. Бид Хамгийн дээд Бурханы хүүхэд шиг амьдарч сурах үедээ ариун байдлыг сурдаг.

Бурхан нигүүлслээр ариун, хүчээр ариун, итгэлээр ариун, хайраар ариун, үнэнээр ариун, мэдлэгээр ариун, шүүхээр ариун. Бидний Бурхан ариун байсан, байгаа, хэзээд байна. Гэтэл Бурхан ариун биш байсан, магадгүй бүр одоо ч ариун биш, ариун байж чаддаггүй биднийг Өөртөө дуудсаар байдаг. Энэ нь хүний сайны хэмжүүрээр оролдож үзээд, бүтэлгүйтээд байдаг дуудлага биш юм. Бид Бурханых болсон учраас, Бурхан бидэнд Өөрийнхөө ариун чанарын хэсэг байх завшааныг олгосон юм.

2Петр 1:3-4:

Алдар ба давуу чанараараа биднийг дуудсан Түүний жинхэнэ мэдлэгээр дамжин бурхан хүч нь бидэнд амь болоод итгэл сүсэгт хамаатай бүхнийг соёрхсон. Үүгээр Тэр бидэнд үнэтэй бөгөөд гайхамшигт амлалтуудаа соёрхов. Ингэснээр та нар энэ дэлхийд тачаалаар байх ялзралаас ангижирснаар бурхан чанарыг хуваалцагч болох юм.

Түүний тэнгэрлэг хүч нь биднийг бурханлаг, ариун чанар дотор алхахад хэрэгтэй *бүхнээр* нигүүлссэн. Юу ч дутаагүй. Бурхан биднийг ариун амьдрахад шаардлагатай *бүхнээр* хангахаа амласан. Христ бидний үлгэр жишээ болохынхоо хажуугаар бидэнд бас амлалтыг авч өгсөн юм. Чарльс Спержен “Бурхан өөр бусад ямар ч зүйлээс илүүтэй ариун байдал дотроо л онцсайн харагддаг. Түүний ариун чанарыг гагцхүү Эзэн Есүс Христ л Өөрийн биеэр давтаж чадсан буюу”³ гэсэн байдаг.

Есүс Аавынхаа ариун байдал дотор илэрхийлэгдсэн. Ариун байдлын тал дээр Есүс бидний үлгэр жишээ ч, тэргүүн тахилч ч болдог. Тэрбээр Аавтайгаа нэг учраас, Есүс Аавынхаа хэлсэн, хийсэн зүйлийг л хэлж, хийдэг байсан юм. Энэ бол бидний даган дууриах ёстой хүндэтгэлийн амьдрал юм.

Тиймээс л Паул:

Бурханы сүм ба шүтээнүүдийн хооронд ямар зөвшилцөл байх билээ? Учир нь бид амьд Бурханы сүм мөн. Бурхан айлдахдаа “«Би тэдний дотор оршино, Би тэдний дунд алхана. Би тэдний Бурхан болно. Тэд Миний ард түмэн болно. Тиймээс тэдний дундаас гарч тусгаар бай» гэж Эзэн айлддаг. «Бузар юманд бүү хүр. Би та нарыг хүлээн авч, Би та нарын Эцэг болж Та нар Миний хөвгүүд, охид болно» гэж Төгс хүчит Эзэн айлддаг” (2Коринт 6:16-18) гэжээ.

Паулын эхний асуултад “байхгүй!” гэж хариулна. Ямар ч холбоо зөвшилцөл байхгүй. Арамей хэлээс хөрвүүлсэн Пэйшн Транслэйшн дээр энэ талаар илүү нарийн хэллэг хэрэглэн, “Бурханы сүм чөтгөрүүдтэй ямар нөхөрлөлтэй байх вэ?” гэж асуудаг. Хариулт нь ч тодорхой юм. “Ямар ч нөхөрлөлгүй!” Паул цааш нь:

“Хайртууд минь, эдгээр амлалт байгаа тул бид өөрсдийгөө махбодын ба сүнсний бүх л бохирос цэвэрлэе. Ингэхдээ Бурханаас эмээж, ариун чанарыг төгс болгоё” (2Коринт 7:1) хэмээн анхааруулжээ.

Би саяхан өнөөгийн Уэслигийн Чуулганы сэтгэлгээг үндэслэн байгуулагчийнх нь сэтгэлгээгээр гэрэлтүүлэн, асуулга тавьсан нэгэн соён гэгээрүүлмээр нийтлэл уншсанаасаа хэсэгчлэн толилуулмаар байна:

Уэсли/Методист уламжлалын Христэд итгэгч нар уучлал (зөвтгөл), ариун байдлын (ариусал) аль нэгийг сонгохоос татгалзах хэрэгтэй. Учир нь Уэсли өөрөө энэ хоёр нь хоёулаа Христэд итгэх итгэлийн амьдралын адамант - бат бэх хэсэг гэж үздэг байсан юм. Зохиолч Диане Леклерк “*Христэд итгэх итгэлийн ариун байдлыг танин мэдэхүй: Уэслигийн ариун байдлын теологийн амин зүрх*” гэдэг номдоо сүүлийн нэг үеийн Уэсличүүд ариун байдлын талаарх энэ үгийн сайн нярвууд байж чадаагүй гэжээ. Тэрбээр ариун байдлыг хүмүүст хэрхэн хүргэхээс үүдээгүй, харин “ариун байдлын

Бурхан
ариун
учраас,
хийдэг
бүхэндээ
ариун
байдаг.

хэрэгжүүлэлтийн дутагдлаас” буюу амаа үдэж суудгаас үүдсэн илүү аюултай хямралыг нэрлэжээ. Тэгээд үүний үр дүнд “нүглийг ялсан ялалтыг” заагч зүү хуульчлалаас гутранги байдал руу гүйжээ” хэмээн Леклерк дүгнэсэн байна. Харамсалтай нь тэд өөрөөр амьдарч мэдэхгүй болтой.⁴

Үүнийг уншиж байхад, миний дотор найдвар амилсан юм. Ариун байдалд зөвтгөл ч, ариусал ч багтах бөгөөд эдгээрийн хослол нь бүрэн дүүрэн байдлыг авчирдаг.

Ариун амьдрах

Үйлдэлдээ ариун байх

Бүх хүнтэй эвтэй байхыг болон ариуслыг мөшгөгтүн. Үүнгүйгээр хэн ч Эзэнийг үзэхгүй болой. Хэн чинь ч Бурханы нигүүлслээс хоцрохгүйн тулд болон аливаа гашуун үндэс урган хор учруулж, түүгээр олноороо бузарлагдахгүйн тулд сэрэмжил. Ууган хүүгийн эрхээ хоолоор арилжсан Есав шиг эсвэл садар самуун, олиггүй хүн болчихгүйн тулд сэрэмжил. (Еврей 12:14-16)

Зөрчил нь ариун байдлыг тэтгэхгүй. Бурханы ариун оршихуй нь холбоогүй, бутархай хүмүүсийн дунд байхгүй. Бурхан ариун байдал дотроо гомдсон, гоморхсон хүмүүсийг ерөөмөөр байсан ч, ерөөж чадахгүй. Бэлгийн ёс бус байдал нь бүх талаараа биднийг тусгаарлана. Есавын өндөр өртгөөр авсан сургамж нь өвийг түргэн зүйл, дур хүслээсээ илүү нандигнаж явахыг зааж өгөх болтугай.

Бурхан үйлс бүхэндээ ариун учраас, биднийг ч бас үйлдэл бүхэндээ ариун байхыг дууддаг.

Бодолдоо ариун байх

Тиймээс би Эзэний дотор үүнийг хэлж, гэрчилье. Харийнхан оюун санааны хоосролдоо явдаг шиг та нар цаашид тэгж явж болохгүй. Тэд ухаан бодолдоо харанхуй болж, дутуу мэдлэг ба зүрхнийхээ хатуугаас болж Бурханы аминаас хөндийрчээ. Тэд ухаанаа алдаж, зүсэн бүрийн бузар булайг шунахайран үйлдэхийн тулд тачаангуй байдалд өөрсдийгөө тушаажээ. (Ефес 4:17-19)

Хэрэгцээтэй болоод хэрэгцээгүй гэдэг нь эсрэг тэсрэг ухагдахуун. Бидний оюун санаа мэдлэг, туршлага дээрээ тулгуурлан ухаж сэтгэдэг. Гэтэл энэ нь өөрчлөлтийн зорилгыг сөрж ажиллах боломжтой юм. Бид Бурханы амьдралыг мэддэггүй байхдаа хөгжүүлсэн амьдралын хэв маяг руугаа эргэж болохгүй. Тэр үед бид шүтээн мөргөл, завхралаас амь амьдралыг олохыг хүссэндээ үүндээ амиа өгч, ингэснээрээ үхэж байсан. Мэдрэлээ алдсан нэг хэсэг нь мэдрэмжийн харанхуй ертөнцөд улам хөл алдаж байв. Ефес цааш нь Есүсийн талаар үргэлжлүүлэн ярьжээ:

Харин та нар ийм замаар Христийг сураагүй. Үнэн Есүс байдагчлан, та нар үнэхээр Түүнийг сонсож, Түүгээр сургагдсан юм бол, амьдралын чинь урьдын хэв маягт хамаарах заль мэхийн тачаалын дагуу ялзарч буй хуучин хүнээ тайлж, оюун санааныхаа сүнс дотор шинэчлэгдэж, үнэний зөвт байдал ба ариун чанар дор Бурханы дагуу бүтээгдсэн шинэ хүнийг өмс. (4:20-24)

Харав уу? Бидэнд шинэ жинхэнэ хүндээ хүрэхийн тулд хуучин хүнээ, хуучин амьдралаа, дагалдах тачаалынх нь хамт тайлж хаяхыг анхааруулжээ. Энэ шинэ хүнийг л Ариун Сүнс бидэнд жинхэнэ зөвт байдал (зөв байр суурь), жинхэнэ ариун байдал дотор (энэ зөвт байдлын гэрэлд хэрхэн ариун амьдрах) илчлэхийг хүсдэг. Үүнийг Эн. Ти. Вraith Паулын шоронгийн захидлын тайлбараараа багладаг:

“оюун санааныхаа сүнс дотор шинэчлэгдэх (23): энэ бол нууц юм шүү дээ. Зүрх зөв байвал, сэтгэлгээгээ зөв болгох цаг болжээ. Тэр цагт танд зан авираа зэрэгцүүлэх сэтгэл хүч хат байна. Хуучнаа цэглээд, шинэтэй яв!”⁵

Тэгвэл оюун санааныхаа сүнсийг яаж шинэчлэх үү? Энэ бол хүмүүс надаас байнга асуудаг боловч, санаандаа хүрсэн хариулт авч чаддаггүй нэгэн асуулт юм. Бидний оюун санаа Бурханы Үгийн үнэнд дуулгавартай байхдаа л шинэчлэгддэг. Энэ чиглүүлгийг агуулгаар нь бататгахын тулд I Петр номыг үзье.

Дуулгавартай байдалдаа ариун байх

Тиймээс та нар оюун санаагаа үйлдэлд бэлтгэж, эрүүл ухаантай байж, Есүс Христийн илчлэл дээр та нарт өгөгдөх нигүүлсэлд найдвараа бүрэн тавь. Дуулгавартай хүүхдүүдийнхээ хувьд, мэдэхгүй байхад чинь та нарт байсан урьдын хүсэл тачаалдаа бүү нийцүүл. Харин та нарыг дуудсан Ариун Нэгэний адил өөрсдийн бүх л зан байдалдаа бас ариун байгтун. Яагаад гэвэл “Би ариун учраас та нар ариун байгтун” гэж бичигдсэн юм. (I Петр 1:13-16)

Би оюун санаагаа үйлдэлд бэлтгэхээр дээрх үүргийг судлаж байхдаа “оюун санааныхаа бүсийг бүслэ” гэдэг үгийг олж харсан юм. Энэ нь найдвараа нигүүлслийн хүчээр бэхжүүлэхийн тулд оюун санаагаа Бурханы Үгээр шинэчилж, хуяглах явдал юм. Энэ нигүүлсэл нь нэгэн зэрэг илчлэлийг ч, Есүс Христийг дагах хүслийг ч авчирдаг.

Дуулгавартай байдал нь биднээс хэнийг, юуг дагахыг маань сонгохыг шаарддаг. Бид дур хүслээ дагах уу эсвэл бидний амьдралыг хэлбэршүүлдэг Бурханы үгийг дагах уу? Бидний сүнс хүсэлтэй боловч, махан бие маань сул дорой бөгөөд нүглээ үргэлжлүүлэн хийсээр л байдаг. Тиймээс бид амьдралынхаа төвшин бүрт зориуд дуулгавартай байхыг сонгох ёстой. Үгийг уншиж байхдаа, амьдралд маань дадал хэвшил, хайхрамжгүй зангаараа хүлцэж байж болзошгүй ямарваа нэгэн тал байгаа эсэхийг Ариун Сүнснээс асууж яваарай.

Мэдэж авсан хүн хэрэгжүүлэх болно.

Би үүнийг чамайг урамшуулахын тулд хуваалцаж байна. Учир нь би дуулгавартай дагамаар санагдсандаа дуулгавартай дагадаг бус, харин Бурханыг хүндэтгэсэндээ л дуулгавартай дагадаг юм. Биднийг дуудсан Нэгэн нь ариун учраас, бид ч бас бүх зан авиртаа ариун байх ёстой гэдгийг л энд бидэнд анхааруулжээ. Бурхан бүх талаараа ариун. Бид ч хийсэн бүхнээрээ ариун байх ёстой. Энэ нь бид бусдыг биднийг үл үзэгдэх Бурхандаа захирагдаж байгаагаар маань үзтэл ариун байх ёстой гэсэн үг юм.

Бурхан ариун... бид ч ариун байна.

Та нар үнэнд дуулгавартай байснаараа сэтгэлээ ариусгаж чин сэтгэлээс ах дүүсээ хайрлах болсон учир бие биенээ зүрхний гүнээс хайрлагтун. Учир нь та нар устах үрээс бус, харин үл устах үрээс буюу Бурханы амьд, оршин буй үгээр дахин төрсөн билээ. (1Петр 1:22-23)

Үнэнд дуулгавартай байх байдал нь бидний сэтгэлийг цэвэршүүлдэг. Энэ цэвэршилт нь зөвхөн сонссоноор биш, харин үйлдсэнээр бий болдог. Би толбогүй Хурганы тахилаар дамжин аврагдсан бөгөөд бидний оюун санаа Үгээр шинэчлэгдэн, бидний сэтгэл үнэнд дуулгавартай байх байдлаар цэвэршсэн. Энэ бол шатлан ахисан үйл явц юм.

Бид үнэнийг дагах үед зүрх маань шинэтгэгдэн, бид бие биеэ илүү гүн гүнзгий хайрладаг. Хайр зүрх сэтгэлийн багтаамжаар л өснө. Бурханы Үг дотор байх нь бидний жинхэнээсээ хайрлах хэм хэмжээ, хүчин чадлыг өсгөдөг. Үнэнийг эсэргүүцдэг зүрх нь зүгээр л өнгөц хайрлана. Усташгүй үр Христ нь бүх үнэний бат бэх Булангийн чулуу болой. Үнэнээс гадуур хайрлах боломжгүй.

Бурханы Үгийн ялзрашгүй үр нь мөнхөн тогтоно. Бурханы Үгээс гадуур ариун амьдрах ч боломжгүй. Үүнийг хүний ойлголтоор гүйцэтгэх боломжгүй. Үг бидний дотор амьдрах үед бид ариун

—◆—
Бурхан
ариун ... бид
ч ариуныг
үйлдэх
ёстой.

бөгөөд үнэн учраас хэзээ ч муудахгүй үр жимсийг ургуулж бас хайрладаг. Заримдаа энэ ертөнцөд үнэнийг дуулгавартай дагах нь яг л үхэл шиг санагдах үе гарна. Гэхдээ найзууд аа, энэ газар дэлхий дээрх бидний амьдрал уур төдий л юм шүү. Бид жинхэнэ амьдралаа дараагийн амьдралдаа сэрэхдээ, олж авна.

Ариун байдал нь мөнхийн үзэл санаатай холбогдох холбоо юм.

Ариун байдал нь өөр ертөнцийн хүн байх явдал юм.

Эдгээр ишлэл нь биднийг Булангийн чулуу руу, амьд Чулууны нэг хэсэг, ариун хүмүүсийн нэг хэсэг байхын утга учир руу эргүүлнэ.

Ариун байдал нь Бурханыг хүндэтгэсэн амьдралыг байгуулдаг

Тиймээс та нар бүх л өс хонзон, заль мэх, хоёр нүүр, атаа жетөө болон гүтгэлэг бүхнийг хаяж, үгийн цэвэр сүүг нялх хүүхдүүд адил хүсэн тэмүүл. Ингэснээр та нар үүгээр авралд хүртэлээ өсөх юм. Хэрэв та нар үнэхээр Эзэний энэрлийг амссан бол тэгэгтүн. (1Петр 2:1-3)

Аврал нь өдөр бүр биднийг өсгөн бойжуулдаг үнэгүй өгөгдсөн бэлэг (бид авралыг олж авахын төлөө юу ч хийгээгүй). Яг л бидний хүн нэг бүрт тавилгагүй, хоосон байшин өгсөн мэт. Бид байшин дотор байгаа (аврагдсан) боловч, өөрсдөө тав тухтай амьдарч, найз нөхдөө урихын тулд байшингаа тохижуулах хэрэгтэй. Бид Бурханы сайныг мэдрэхдээ, сайн сайхан дотор өсдөг.

Эзэнд ир. Тэр бол хүмүүст гологдсон боловч, харин Бурханы өмнө сонгогдсон, үнэт, амьд чулуу билээ. (1Петр 2:4)

Ариун байдал нь биеэ захирна гэсэн үг

Бурханы хүсэл нь та нарын ариусал бөгөөд тэр нь юу гэвэл, та нар садар самууныг цээрлэж, хүн бүр ариусал хийгээд хүндэтгэл дор өөрийн биеэ хэрхэн хянахаа мэдэж,

Бурханыг мэддэггүй харийнхан мэт тачаангуй хүсэлд эс байх нь юм. Мөн хэн ч үүнийг зөрчиж, энэ хэрэгт ах дүүгээ мэхэлж болохгүй. Би та нарт урьд нь хэлж, чухалчлан анхааруулж байсанчлан, энэ бүхний төлөө өшөө авагч нь Эзэн юм. Учир нь Бурхан биднийг цэвэр бусын тулд бус харин ариусалд дуудсан билээ. Тиймд үүнийг эсэргүүцэгч нь хүнийг бус, харин та нарт Ариун Сүнсээ өгдөг Бурханыг эсэргүүцэж байна. (1Тесалоник 4:3-8)

Биднийг авраад зогсохгүй, ариусгах нь Бурханы хүсэл билээ. Бид Бурханыг мэдсэн цагтаа Түүний Үгийг амьдралдаа оруулж, өнгөрсөн амьдралынхаа сурсан зангаар юмуу соёлын үгээр хөдлөхөө больдог. Тесалоникийн хүмүүс дэндүү завхарсан соёл дунд амьдарч байжээ: нууц амраг, ёслолын секс, ижил хүйсийн бэлгийн харилцаанд ороход худалдаж авдаг хөвгүүд, янхан зэрэг нь байдаг л зүйлс байв. Энэ нүглийн тогоон дунд хүчтэй байхын тулд итгэгч хүмүүс бие биедээ бурханлаг чанарын үлгэр жишээ болж байх ёстой байжээ. Ийм соёлоос нь болоод Паул Тесалоникийн итгэгч нарт тавих шаардлагаа хөнгөлөөгүй. Бурханы нигүүлсэл тэдэнд ариун амьдрах хүчийг өгнө гэдэгт Паул итгэдэг байжээ.

Биднийг харж байгаа. Бид амьдралаараа итгэлээ харуулдаг. Бид бусдыг бүдрүүлэх маягаар нүглээр амьдраад байх юм бол, Бурхан тэдний төлөө босох л болно.

Тимотод бичсэн хоёрдугаар захидалд:

Том байшинд зөвхөн алт, мөнгөн төдийгүй мөн мод, шавар сав суулга ч байдаг. Зарим нь хүндэтгэлийн, зарим нь жирийн хэрэглээнийх. Иймд хэн өөрийгөө эдгээр зүйлээс цэвэрлэнэ, тэр хүндэтгэлд зориулагдан ариусгагдсан, Эзэнтэнд хэрэгтэй бөгөөд алив сайн үйлд бэлтгэгдсэн байх болно. Залуу насны

—◆—
Бурханы Үг
дотор байх
нь бидний
жинхэнээсээ
хайрлах хэм
хэмжээ,
хүчин чадлыг
өсгөдөг.

дур хүслүүдээс зугт. Цэвэр зүрхнээс Эзэнийг дуудагчдын хамт зөвт байдал, итгэл, хайр ба амар тайвныг мөшгө (2:20-22) гэжээ.

Бид байшинд байна. Тиймээс гэрийн Эзэнд аль болох хэрэгтэй хүн байвал яасан юм?

Миний амьдралын олон тал урт удаан бэлтгэл үйл явц байсан юм. Жишээлбэл би маш удаан хугацааны дараа л гэрлэлтийн талаар юм ярьж чаддаг болсон. Энэ мэтчилэн олон талбар дээр би бэлтгэлгүй байсан учраас, Эзэнийхээ зорилгод хэрэгцээтэй хүн болж чадахгүй байжээ. Эдгээр талбар дээр би сайн ажилд бэлэн болсон хүн гэхээсээ илүү явц дундаа л байгаа хүн шиг байв. Би арван настай байхдаа л ганц удаа цом авч үзсэн хүн шүү дээ. “Хамгийн мэрийлттэй сурагчийн” шагнал. Тэгээд л тэр, өөр надад гайхуулах юм байхгүй. Гэтэл сайжрах нь ялалт гэдгийг би ихэвчлэн санадаггүй.

Гэхдээ би залуу үеийнхэн маань хурдан бэлэн болоосой гэж үнэн голоосоо хүсдэг. Залуу насныхаа гал сэтгэлээр гүйнэ гэсэн үг. Гүйх гэдэг нь айсандаа хар хурдаараа зугтах үйл явцыг дүрслэдэг. Зугтах нь хангалтгүй. Бид ямар нэг юмыг зорьж гүйх ёстой. Тэгвэл энэ бол бат бэх зөвт байдал, итгэл, хайр, амар тайван руу гүйх цаг юм. Эзэнийг цэвэр зүрхээр дууддаг хүмүүсийн дунд маш олон залуу охид, хөвгүүд байгаасай. Эзэний ариун нэр нь үе үеийн хүмүүсийн хорогдох хүчирхэг цамхаг нь байгаасай.

Ариун байдал гэдэг нь бид Бурхан дээр өөрийнхөө болзлоор биш, Түүний болзлоор очихыг хэлнэ. Манай соёл Бурханы нигүүлслийг аваад, үүнийгээ нүгэл үйлдэх лиценз болгодог болсон. Иүдейн хуульд ёс суртахууны код ч, сайн үйлс ч багтдаг байжээ. Нигүүлслийн гэрээ нь ёс суртахууны кодыг хүчингүй болгодоггүй. Ариун байдал, хайр нь ёс суртахууны кодыг илүү өндөр төвшинд гаргах ёстой. Шинэ гэрээнд эмэгтэй хүнийг зүрхэндээ хүсэхэд л завхайрсан болдог бол, Хуучин гэрээнд нүглийг бодитоор үйлдтэл энэ нь нүгэлд тооцогддоггүй байжээ. Би дахиад л Эн. Ти. Врайтын цэц ухаанаас эшлэмээр байна:

Орчин цагийн ертөнц бэлгийн хүсэл, таалал, үйлдлийг хүмүүс өөрт нь төрсөн эсвэл түүний дотроос өдөөн төрүүлсэн

ямар ч хүслийг илэрхийлэх эрхтэй гэсэн ганц л дүрэмтэй, ямар ч ёс суртахуунгүй, бүгдэд чөлөөтэй зүйл болгон хувиргажээ. Тэгвэл энэ явдал нь ёс суртахууны зав авирыг сургадаг Паул тэргүүтэй Иүдей болоод Христийн багш нарын хувьд яг л атар догшин адуу адгуус хаа хамаагүй давхиж, унасан эзнээ болоод хөндлөнгийн хүмүүсийг аюулд өртүүлэхдээ, хэнд ч ямар ч үр ашиггүй болохтой адил байв.

Христийн дагалдагч хүн хэзээ ч дураараа амьдрахыг зорьж болохгүй. Бид дур, бэлгийн хүсэлдээ захирагдаж болохгүй. Есүс жинхэнэ хүн байсан учраас, бидэн шиг л өдөөгдсөн. Тэрбээр бидний зөрчилддөг бүх санаашрлыг биеэр туулах хүчин чадалтай байсан гэсэн үг. Тийм боловч Есүс нүгэлгүй байсан. Чиний амьдралд ямар ч өдөөлт ирсэн, Есүс үүнийг чинь ялчихсан болохоор нүгэл чамайг захирч чадахгүй юм. Би өдөөлтийг амархан ялна гэж хэлээгүй шүү. Мэдээж хэцүү байна. Гэхдээ авчирдаг эрх чөлөө нь дэндүү үнэ цэнэтэй шүү.

Ариун байдал нь үнэнийг ярина гэсэн үг

Хэрэв ертөнц та нарыг үзэн ядвал та нараас өмнө Намайг үзэн ядсаныг нь мэдэгтүн. Та нар ертөнцийнх байсан бол ертөнц өөрийнхнийгөө хайрлахсан. Харин та нар ертөнцийнх биш, гагцхүү Би та нарыг ертөнцөөс сонгосон юм. Тиймээс ертөнц та нарыг үзэн яддаг. (Иохан 15:18-19)

Бид үймээн самуун дунд босч зогсоод, үнэнийг хэлэх ёстой. Бид өнө мөнхийн үнэ цэнийн талд орсноороо хүмүүст нүд үзүүрлэгдэнэ. Эзэний дотор ариун байна гэдэг нь хүмүүс бидний хэлсэн үг бүрт дуртай байна гэсэн үг биш. Тийм боловч дараагийн ишлэлд Есүс бидэнд даалгавраа дахин сануулжээ:

“Боол эзнээсээ илүү агуу биш” гэж Би та нарт хэлснийг санагтун. Тэд Намайг хавчсан бол та нарыг бас хавчих болно. Тэд үгийг минь сахисан бол та нарынхыг бас сахих болно.

Харин тэд нэрээс минь болж та нарт энэ бүгдийг үйлдэх болно. Учир нь тэд Намайг илгээсэн Нэгэнийг мэдэхгүй юм. (20-21)

Бидэнд алдар нэрийг биш, хавчлагыг амлажээ. Дэлхийн гүйгийг дагах нь алдартай байдаг. Үнэн харьцангуй бөгөөд Библи хуучирсан гэж хэлэх нь алдартай байдаг. Есүс чиний зовлонг ойлгодог гэж хэлэх нь алдартай бол, харин өөрийнхөө ойлголтод найдахын оронд Есүсийн өгсөн хүчээр догонцоод ч болтугай явж чадна гэж хэлэх нь алдаргүй байдаг. Бурханы Үг бол хүний амьдралын туйлын эрх мэдэл юм гэж хэлэх нь алдаргүй байдаг. Хэдийгээр нүгэлд өгөх бидний хариу үйлдэл өөрчлөгддөг ч, Бурхан бол хэзээ ч өөрчлөгддөггүй Бурхан гэж хэлэх нь алдаргүй байдаг.

Зугтах нь
хангалтгүй.
Бид ямар нэг
юмыг зорьж
гүйх ёстой.

Хэрэв Би ирж тэдэнд хэлээгүйсэн бол тэд гэм буруугүй байхсан. Харин одоо тэд нүгэлдээ шалтаггүй болов. (Иохан 15:22)

Бид нүглийг хэвийн зүйлд тооцож, шалтаг тоочсоноороо ялаас мултрахгүй. Бид асуудлын үндэс рүү орж, үүний эх үүсвэр болох ял, ичгүүрийг буюу хуваагдмал зүрхийг суга татах хэрэгтэй.

Христийн дагалдагч нарынхаа хувьд бид хулгайчийн гарыг таслах юмуу завхайрсан хүмүүсийг алах, цус холилдож, хүчин үйлдсэн хүмүүсийг олон нийтийн өмнө шийтгэх үйлдлийг дэмжиж болохгүй. Бид хуулийг гүйцэтгэх биш, Есүсийн замыг заах үүрэгтэй. Христийн дотор бүх нүгэл өршөөгдсөн бөгөөд бид өөрсдийгөө шүүгчийн байр суурьд тавих ёсгүй. Гэхдээ хүнийг хайрлах нь тэдний нүглийг (шунал, шүтээн шүтлэг, мэргэ төлгө, ёс бус явдал) дэмжинэ гэсэн үг биш юм. Энэ нь бид тэднийг хүнийх нь хувьд үнэ цэнийг нь хүлээн зөвшөөрч, ирээдүйд нь хандаж гэрлийг тунхаглана гэсэн үг юм.

Нүгэлгүй хүн байхгүй ч, буруу өөрчлөлтийг зөвтгөх ёс байхгүй. Есүс завхайрч байгаад үйлдэл дээрээ баригдсан эмэгтэйгээс

түүнийг яллах хүн үлдсэн байна уу гэж асуусан явдлыг дахин үзье:

тэр —Эзэн, хэн ч шийтгэсэнгүй гэв. Есүс —Би ч чамайг шийтгэхгүй. Яв. Үүнээс хойш дахин нүгэл бүү үйлд гэлээ.] (Иохан 8:11)

Есүс уучлаад зогсохгүй (Би ч чамайг шийтгэхгүй), дээрээс нь гэмшил, нигүүлслийг нэмжээ (Яв. Үүнээс хойш дахин нүгэл бүү үйлд). Есүс эмэгтэйн завхайрсан амьдралыг дэмжээгүй. Есүс: “Зүгээр ээ, охин минь. Угаасаа чиний бүх ирээдүйн нүгэл уучлагдсан” гэж хэлээгүй. (Уучлагдсан гэдэг нь үнэн боловч) Есүс “Чамд асуудал байгааг Би мэднэ” гэж хэлээгүй, харин “Сүүдрийн амьдралаа орхиод, Миний гэрэлд алх” гэж хэлжээ.

Тэгээд Есүс тэдэнд дахин —Ертөнцийн гэрэл бол Би байгаа юм. Намайг дагадаг хүн харанхуй дотор явахгүй, харин амийн гэрэлтэй болно гэж айлдав. (Иохан 8:12)

Харанхуйг гэрлээр солихын оронд бид үзэл бодлоо өөрчлөөд, харанхуйг гэрэл гэж нэрлэдэг. Бусдыг эрх чөлөөтэй амьдрахад хүчирхэгжүүлэхийн төлөө жаахан сэтгэл гаргаж амьдаръя. Өнгөрсөн амьдралынхаа харанхуйг ардаа орхиж, Есүсийг гэрэл дотор дагах амьдралд бусдыг дуудъя. Ийм яриаг олон нийтийн сүлжээнд биш, харин хувьчлан хийхэд хамгийн сайн байдаг. Тиймээс л би чамтай хоёулханаа ярьж байгаа юм.

Ариун юмыг нохдоод бүү өг. Өөрсдийн сувдыг гахайн өмнө бүү хая. Тэд түүнийг хөл дороо гишгэчихээд, эргэж та нарыг хэсэглэн тасчих вий. (Иохан 7:6)



Харанхуйг
гэрлээр
солихын
оронд бид
үзэл бодлоо
өөрчлөөд,
харанхуйг
гэрэл гэж
нэрлэдэг.

Би өөрөө Бичээсийн оюутан болоогүй байсан бол, чамд ариун байдлын талаар юу хэлэхээ мэдэхгүй байх байлаа. Бурхан бол хайрын Аав гэдэг сууриас нь салгасан Бурханы Үг үнэхээр хатуу харгис сонсогддог. Би чамд юу бодохыг чинь хэлж өгмөөргүй байна. Чамд хэдийнээ үүнийг олон хүн зааж байгаа байх. Чи өөрөө сонсож, өөрөө бод. Тиймээс л эдгээр Бичээсийг судлаж, бидний төлөө хэлсэн Есүсийн залбирлыг өөр дээрээ хэрэгжүүлээрэй:

Би Таны үгийг тэдэнд өгсөн. Би ертөнцийнх бус лугаа адил тэд бас ертөнцийнх бус тул ертөнц тэднийг үзэн ядсан юм. Тэднийг Та ертөнцөөс аваач гэж Би гуйхгүй, харин муу муухайгаас хамгаалахыг гуйж байна. Би ертөнцийнх биш адил тэд бас ертөнцийнх биш. Үнэнээр тэднийг ариусгаач. Таны үг үнэн мөн. Та Намайг ертөнцөд илгээсний адилаар Би мөн тэднийг ертөнцөд илгээв. Тэд бас үнэнээр ариусгагдахын тулд Би Өөрийгөө тэдний төлөө ариусгана. (Иохан 17:14-19).

*Тэнгэрийн Бурхан Аав минь,
Намайг Үгээрээ ариусгаж, үнэн дотор ариун болгооч. Алив харанхуйг ардаа орхих хүч хайрлаач. Би Таны замын гэрэлд амьдарч, хайрламаар байна. Таных болохоо хүмүүст харуулахын тулд хийсэн бүхэндээ ариун байхад минь туслаарай.*

БИ БОЛ АДАМАНТ (БИ БОЛ БАТ БЭХ)

Адаманын хэлбэр, галт сэтгэл
Аюул түүнийг айлгахгүй, ажил хөдөлмөр ч
зүдрээхгүй.

Самуел Жонсон

Адаманын эрэлд гарсан аялал маань арваад жилийн тэртээс эхлэсэн билээ. Нарийндаа бол миний нэг номыг эрхлэн гаргах гэж байсан хэвлэлийн газрын хөлслөсөн бие даасан хянан тохиолдуулагчтай утсаар хийсэн хатуу ярианаас эхлэсэн юм. Бид хоёр номынхоо агуулга дээр баахан урагшаа хойшоо болж, хэдэн янз болов. Хамгийн муухай нь би түүний хянан тохиолдуулсан хэсгээс өөрийнхөө дуу хоолойг огтхон ч олж сонсохгүй байлаа. Гэхдээ өөртөө жаахан итгэлгүй байсандаа, би түүнд намайг хананд тултал хойшоо түлхэхийг зөвшөөрчихжээ. Тэгээд би гарцгүй болсноо мэдрээд, цаашид түүний хэлсэн зүйлийг бичиж чадахгүй гэдгээ ухаарав.

Энэ ном бол Бурханаас надад даалгасан мандат үг гэдгийг би л

мэдэж байсан учраас, гүйцэтгэлийг нь би л хариуцах байв. Ном гэдэг зүгээр нэг цаасан дээрх үгийн цуглуулга биш. Номд зохиолчийн дуу хоолойн өнгө, хандлага агуулагддаг. Номыг хэрхэн уншиж, сонсох нь уншиж байгаа зүйл шигээ л чухал гэдэгт би итгэдэг. Зөв зүйлийг буруу маягаар хэлбэл, уншигч хүнд хүрэхгүй.

Ямар нэгэн шалтгаанаар тэр хянагч миний дуу хоолойг уур хилэн, миний хандлагыг дарангуйлал болгочихсон байв. Харин би үүнийг тэвчихгүй. Сэдвийн тухайд гэвэл, би та нартай л адилхан суралцаж яваа Бичээсийн оюутан. Би ээж, эгч, одоо бол эмээ хүнийхээ зүгээс л ярихыг хүснэ. Гэхдээ би дотроо чамайг номынхоо турш намайг найзаа гэж бодоосой л гэж хүснэ.

Гэтэл хянан тохиолдуулагч маань үүнтэй санал нийлэхгүй байв. Тэрбээр хатуу үзэл санаатай, хүчирхэг, авъяаслаг эмэгтэй байлаа. Уг нь би санаагаа ахин дахин хэлсээр байсан боловч, тэр намайг сонсохгүй байв. Тиймээс тэр дуудлагаар бүх сэжүүр маань төгсгөл болсон юм. Би өөрийнхөө санааг тодорхой хэлээд, түүний ажлыг үг үгээр нь, өгүүлбэр өгүүлбэрээр нь тулган уншиж байхыг Жон хүртэл сонсчихсон байв.

Би утсаа тавиад, гүн амьсгаа авлаа. Энэ ярианы дараа би маш их ядарсан байлаа. Би Жоны ажлын өрөөний өөдөөс хардаг зочдын өрөөндөө номоо бичиж байсан юм.

Гэтэл Жон: “Ноцтой яриа юу?” гэж асуулаа.

- “Харин тийм ээ.”

- “Бүтэх янз байна уу?”

- “Харин ээ, мэдэхгүй нь.”

Хянан тохиолдуулагч бид хоёрын урьд урьдын хэд хэдэн яриаг Жон мэдэж байлаа.

“Тэгэхдээ, өнөөдөр чи ёстой “атаман” (адамант - бат бэх) байлаа шүү!” хэмээн Жон итгэл дүүрэн хэлэв.

Би ч толгой дохилоо.

Гэтэл гэнэт түүний үг миний дотор нойрсож байсан нэг зүйлийг сэрээчих шиг л болов.

Би босоод Жоны үгийг батлан: “Би бол адамант!” гэж хэллээ.

Тэгээд энэ тунхагийг илүү ойртуулахын тулд Жоны ажлын өрөө рүү явж ороод: “Би бол адамант!” гэж хэлэв.

Жон ч зөвшөөрөн толгой дохилоо. “Тэгэхээр, ажилдаа ордог хэрэг ээ!”

Би дотроосоо амилаад л явчихав.

Би компьютерынхаа ард суугаад, хэдийнээ хаячихсан байсан бүлгүүдээ дахин сэргээгээд, номдоо өөрийнхөө дуу хоолойг дахин сэргээлээ. Номд маань хандсан Бурханы алсын харааны гал дахин ноцох шиг санагдав. Намайг бичиж байтал, хурууны маань үзүүрээр янз бүрийн үг гараад байх шиг л санагдаж байлаа.

Үдээс хойш нь туслах маань надад нэг хайрцагтай илгээмж авчирч өгөв.

Тэрбээр: “Та ч ер бусын бэлэг хүлээн авч дээ!” гэж хэлээд, илгээмжийг маань ширээн дээр гаргаж тавьлаа. Тэгээд намайг онгойлгоод яахыг маань харах гэсэн шиг ажиглан зогсов.

Тэндээс алтан булантай, хар өнгийн хайрцаг гарч ирэв. Хайрцгийг онгойлготол, тагных нь дотор талд гоёмсог шилэн бөмбөлөг дүүжлээтэй байлаа. Харин хайрцагны дотор тал нь алтан шаргал хилэнгээр бүрээтэй байсан бөгөөд голд нь ганц цаас байв. Үгүй ээ, цаас гэвэл үл тоосон хэрэг болно. Энэ нь эрдэнийн чулуу шиг өнгө өнгөөр туяарсан үзүүртэй, илгэн хуудас байв. Бичгийнх нь үсэг гэвээс яг л найр хуримын урилга, гэрчилгээ дээр бичдэг шиг хээ угалз болсон ганган бичмэл үсгүүд байлаа. Огноо нь 2005 оны 12-аар сарын 12-ны өдөр гэсэн байх бөгөөд тэр бичиг дэхь алмаз гэдэг үгийн дээр “Миний адамант, миний адамант Лиза” гэсэн хүндэтгэлийн ёсолгоо намирч байв.

Миний хамаг бие зарс хийгээд л явчихав. Хэдэн цагийн өмнө миний өөрийгөө нэрлэсэн тэр нэр дахин батлагдав. Би хөшсөн чигээрээ суугаад гарт маань байгаа захидал жирийн бус захидал болохыг гадарлалаа. Би гүн амьсгал аваад, амьсгалаа гаргаад цааш нь уншив.

Гарт маань намайг хайрласан Бурханы хайрын талаарх найраглал байлаа. Өгүүлбэр бүр нь “Би бол...” гэсэн үгээр холбогдсон байв. Энэ ганц хуудас дээр адамант - бат бэх гэдэг үг таван удаа гарсан байлаа. Үг бүр нь яг л Аав минь хэлж байгаа мэт дотно байв. Хуудсын төгсгөлд нэр байсангүй. Би эргүүлж харлаа. Юу ч байхгүй.

“Хэнээс ирсэн юм бол?” гэж намайг асуутал, туслах маань:

“Мэдэхгүй. Ямар ч буцах хаяггүй, энгийн л нэг боодолтой илгээмж байсан” гэж хариуллаа.

Өөртөө эргэлзэж, ном бичих гэж чадан ядан байгаа намайг огт

мэдэхгүй нэгэн хүн Бурханыг сонсоод, надад зориулж энэ үгийг бичсэн гэхээр би үнэхээр чин сэтгэлээсээ мэхийлээ. Би үүнийг нь гар бичмэлээ баримтлан, замаасаа хазаахгүй байж, айх юмгүй бичиж, эгч дүүсдээ Бурхан тэднийг асуудлаар дүүрсэн дэлхийд хариулт болгохоор илгээснийг хэлээрэй гэсэн тэмдэг, баталгаа гэж үзэв.

Тэр илгээмжийг хэн илгээснийг би одоо хэр олж мэдээгүй боловч, тэр захидал хайрцагтайгаа миний ширээн дээр тавиатай бий. Энэ бол эргэх цэг байсан юм. Тэдгээр үг нь миний Бурханы надад айлдсан, хэрхэн айлдсан Үгийн тал дээр адамант - бат бэх, ялагдашгүй, хөдлөшгүй байхаар шийдсэн эгшинг тэмдэглэж байсан юм. Цаашид ч би буулт хийлгүй, эрх мэдэл дотроо зогсох болно.

Жилийн дараа би захидлуудаа хайрцагт хийв (Санаж байна уу?) Тэдгээр нь голдуу миний номоор ерөөгдсөн залуу охид, эмэгтэйчүүдийн гэрчлэл байлаа. Хайрцаг маань том биш учраас, хурдан дүүрэв. Тэгээд бараг арваад жил нэг ч онгойгоогүй, тоосонд дарагдсаар байлаа.

Алмаз

Би саяхнаас хаашаа л харна - алмаз хардаг болов. Эдгээр нь миний бүтэн жил заасан конференцуудтай холбоотой болж таарсан юм. Үнэнийг хэлэхэд, би алмаз, адамант хоёр холбоотой гэдгийг ч мартчихаж. Манай дэлхийн нөхцөл байдлыг харгалзаж үзбэл, миний хувьд үйл ажиллагааг алмаз гэдэг санаатай холбох нь хэт гял цал бөгөөд жаахан өнгөц санагдаж байлаа.

Гэтэл миний заахаар ирсэн ээлжит газар маань бас л нэг “алмазан” конференц болж таарав. Жаахан залхсаныг ч хэлэх үү, би хичээлийн завсраар зочид буудалдаа гарчгийнх нь талаар гомдоллосоор байж байтал сүнсэнд маань “Би чамайг миний алмаз, миний адамант” гэж дуудах үед чи баярласан шүү дээ” гэх шиг болов.

Би зог тусаад, нөгөө найраглалыг саналаа. Тэгээд суугаад Айпад дээрх Библиэ гаргаад, алмаз, чулуу гэсэн хэсгүүдийг хайж эхлэв. Тэгээд 1Петр 2 дээрх: “Эзэнд ир. Тэр бол хүмүүст гологдсон боловч, харин Бурханы өмнө сонгогдсон, үнэт, амьд чулуу билээ”

(и4) гэсэн хэсгийг уншихдаа, би өөрийгөө эрдэнэсийн эрэлд гарснаа мэдсэн юм.

Долоо хоногийн дотор *адамант - бат бэх* гэдэг үгтэй эртний бичвэрийн хэсгүүдийг олов. Яг ийм утга бүхий нэгэн гар бичмэл бүр 1600-гаад оны үед бичигдсэн байлаа. Тэнд Езекиел 3- аар бүлгийн хэсэг гарч байсан бөгөөд Бурхан хэрхэн Хүний Хүүгийн нүүрийг адамант - бат бэх болгосон шигээ, Езекиелийн нүүрийг ч ингэхээр амласан тухай хэлсэн байв.

Биднийг амьдруулахын тулд Өөрийнхөө нүүрийг чулуу (адамант) мэт болгон үхсэн бидний Христийн талаарх энэ хэсгийг хараад би инээмсэглэлээ.

Тэгээд зохиолч нь адамантыг бидний сайн мэддэг ойлголтоор дүрслэн тайлбарлаж эхлэсэн юм. Адамант бол хамгийн хатуу чулуу - үүнийг галаар шатааж чадахгүй, өрмөөр нэвтлэж чадахгүй, алхаар хагалж чадахгүй, усаар уусгаж чадахгүй гэжээ. Адамант агшихгүй, айхгүй бас хувирахгүй, тууштай.” Тэгээд тэрбээр энэ эргэцүүллээ “Сайн ухамсар нь Христэд итгэдэг хүнийг бат бэх болгож, сараалжин нэхээстэй даавуу мэт ялагдашгүй, хувирашгүй болгоно”¹ гэсэн дүгнэлтээр төгсгөсөн байлаа.

Бидний хамтын аян удахгүй төгсөх учраас, би чамтай нөгөө өөрийнхөө хүлээж авсан найраглалын хэсгээс заавал хуваалцах ёстой байх. Учир нь энэ шүлэгт бидний өөр хоорондоо заавал хуваалцах ёстой амлалт бий. Мөр бүр нь бидний хүн нэг бүрт хандсан дотно бөгөөд онцгой үгс юм.

Миний адамант - бат бэх,
БИ чамайг бодохдоо мишээдэг.
Чи миний дуу хоолойг сайн сонсож, сайн таньдаг.
Чи Миний аугаа чанарт баясдаг.
Миний адамант, чи үнэхээр хүчтэй шүү.
Чиний зүрхийг би савлуулж болох уу?
Чамд үнэхээр хайртайгаа
хамгийн эелдгээр хэлье.
Чи яг л БИ. МИНИЙ сэтгэл хөдлөж байна.



Тэр чамайг
зүрхэндээ
СИЙЛСЭН.

Би чамайг зүрхэндээ сийлсэн.

Хөөрхөн мишээл, хүчирхэг зүрхээрээ Намайг хүндэтгэ,
Миний адамант.

Хайрлагдсан бүсгүй минь, инээмсэглэ. Чи Бурханы зүрхэнд сийлэгдсэн. Тэр чамтай эелдэг зөөлнөөр ярьдаг. Зоригт бүсгүй минь, Түүнийг насан турш, хамаг зүрхээрээ хүндэтгэ. Түүний адамант хайрыг бусдад хэл. Чиний амьдрал дээр байгаа Түүний мутрыг, Үгийг нь эрх мэдлээр, Ариун Сүнснийх нь тосолгоогоор хүндэтгэ.

—
Бурхан
ТЭДНИЙГ
АСУУДЛААР
ДҮҮРСЭН
ДЭЛХИЙД
ХАРИУЛ
БОЛГОХООР
ИЛГЭЭСЭН.

Нэгэнт шүлэглэсэн болохоор, бүлгийнхээ эхэнд иш татсан Самуел Жонсоны мөртүүдийг бас чамд зориулан хэлмээр байна. Христийн доторх найз минь:

Чи адамантын хэлбэртэй
Гал сэтгэлтэй
Аюул чамайг айлгахгүй
Дайсан чамайг улам өргөнө.

Бидний адамант - бат бэх хэлбэр тунгалаг, гэрэлтсэн, соронзтой, туяарсан боловч алмаз мэт хатуу. Биднийг Христийн сүйрэшгүй үйлс ороосон. Христийн Сүнс бидний Адамант Христийн дотор байсан шигээ бидний дотор бий. Харин одоо гал сэтгэлийн талаар хэлье:

Иохан бүгдэд —Би та нарт усаар баптисм хүртээдэг. Харин надаас илүү хүчирхэг Нэгэн ирж байна. Би Түүний шаахайн үдээсийг ч тайлах үнэ хүндгүй. Тэр та нарт Ариун Сүнс хийгээд галаар баптисм хүртээнэ. (Лук 3:16)

Бид Ариун Сүнс дотор, ариун галаар баптисм хийлгэсэн. Иоханы баптисм нь бидний дотор үйлдсэн Есүсийн ажлын гадаад сүүдэр байв. Биднийг дахин төрөх үед бидний амьгүй зүрх Бурханы мөнхийн хайрын галт гялбаанд чичирхийлжээ. Бидний ариун галын Бурхан биднийг хайрлах, биднээр дамжуулж хайрлах

Өөрийнх нь хайрын илэрхийллийг бууруулах сүүдрийн хальсыг залгидаг. Түүний хайр биднийг залгидаг.

Зехариа 2:5 дээр “Би хотыг хүрээлэн галт хана болно. Би түүний дундах алдар нь байх болно” гэдэг. Мессеж Библи энэ гал нь Бурханы гэрэлт оршихуйг тээдэг гэдэг. Энэ ишлэл нь Иерусалим, Сион хоёрын хоёулангийнх нь тухай ярьж байгаа гэдэгт би итгэдэг. Бурхан Израильд ханддаг шигээ л бидэнд ханддаг. Үүнтэй адилхан Бурхан биднийг ч хамгаалагч галт оршихуйгаараа хүрээлдэг. Давид энэ тэнгэрийн айлчлалын талаар Дуулал 104:4 дээр “Салхинуудыг элчээ, Галын дөлийг Та үйлчлэгчээ болгодог” гэжээ.

Зехариа 13 дээр гал нь цэвэрлэх багаж зэмсэг болсон байна:

Гурав дахь хэсгийг нь Би гал дундуур гарган, Мөнгийг цэвэршүүлдэг шиг тэднийг цэвэршүүлж, Алтыг тунгаадаг шиг тэднийг тунгаана. Тэд Миний нэрийг дуудаж, Би тэдэнд хариулах болно. «Тэд бол Миний ард түмэн» гэж Би хэлнэ. «ЭЗЭН бол миний Бурхан» гэж тэд хэлнэ” гэв. (9)

Гал дунд бид дуудаж, Тэр хариулдаг. Тэнд л Тэр биднийг Өөрийнхөө хэмээн дуудаж, бид Эзэн бол бидний хувийн аврал гэдгийг ухаардаг.

Эхлэл 15:17 дээр бидний итгэлийн эцэг Абрахам тахилынх нь дундуур галт бамбар, утаат зуух явж өнгөрөхийг харжээ. Бурхан биднээс тугал, ямаа, хуц, шувууд алаад хуваагаад аль гэж гуйгаагүй. Тэр биднээс Өөрийнх нь ариун байдлын галд зүрхээ өргөхийг л хүсдэг.

2Тимот 1:6 дээр Бурханы бидэнд өгсөн бэлэгийг байнга өрдөж, ноцоож байх ёстой гал мэт ярьжээ. Найз минь, ноцоогоод бай. Дуул, бүжиглэ, унш, залбир, нөхөрлө, гэрчил, судлалын бүлэгт хамрагд, зөвлөх хүнийг ол. Энэ бүхэн чинь алмазнаас ч илүү үнэтэй шүү. Цэцэрлэгээс ч илүү харж ханд. Хайхралгүй хаялгүй, цаг гаргаад харж ханд.

Шүлгийн маань дараагийн үг нь “Аюул чамайг айлгахгүй” гэдэг үг юм. Бид гаднаасаа хамгаалагдсан, дотроосоо цэвэршүүлэгдсэн. Ингэж харбал, үнэндээ хэн биднийг айлгах вэ? Тийм ээ, цочиж,

мэгдэж болно. Гэхдээ сэрэмжтэй байдаг бол, айж сандрах нь амьдрах арга зам биш, харин ирээд өнгөрөх эгшин зуурын явдал болдог.

Сүүлийн мөр нь: “Дайсан чамайг улам өргөнө.” Үүнийг дүрслэн харуулахын тулд би чамд шинэ найзынхаа нэгэн түүхийг ярьж өгье.

Би чамд хэлээгүй байх аа. Гэхдээ би кофенд дэндүү дуртай. Нарийндаа бол эспрессод ухаангүй. Миний бодлоор Итали ген маань л эспрессогийн хар урхинд татагдаад байдаг болтой!

Бурхан чиний дуртай зүйлээр дамжуулж чамд үгээ ойлгуулдгийг чи мэдэх үү? Тэгээд магадгүй чи явагийн төрлийн кофенд дургүй байсан ч, одоо миний ярих кофе шопны талаарх түүх чамд таалагдах байх аа.

Би саяхан Техасын Амариллогийн төвд зочилсон юм. Би тэнд эмэгтэйчүүдийн конференц дээр номлонгоо бүтэн сайны цуглаан дээр нь бас үлдэж номлов. Би зочид буудалд орох бүрийдээ хамгийн ойрхон кофе шоп хаана байдгийг лавладаг юм л даа. Гэтэл миний зол болоход зочид буудлаас маань холгүй Палас Кофи Компани гэдэгт алдарт ер бусын кофе шоп байж таарав.

Би тав дахь өдөр нилээд оройтож очсон ч, тэр сайшаал магтаалыг сонсоод, сэрүүлгээ хагас сайны өглөө бэлэн байх ёстой цагаасаа бүтэн цагийн өмнө тааруулав. Тэгээд гар утас маань дуугарахад, би орноосоо босоод, шүдээ угаачихаад, бэлтгэсэн хувцсаа өмсөөд, хамгийн дуртай нисгэгчийнхээ хар шилийг зүүж аваад, тэр шидэт газар руу нь явлаа.

Үнэндээ би догдлосон гэвэл дэндүү багадсан хэрэг болно. Тэр газраас яг л миний дуртай Техас уур амьсгал хан хийж байлаа. Би энд нэг хүүгээ төрүүлж байсан бас энэ нутгийн бэртэй хүн шүү дээ. Би ундааных нь цэсийг нэг хараад л толгой эргэв.

Тэгээд миний ээлж болоход, би тэр хөөрхөн бариста бүсгүй рүү нь тонгойс хийгээд - магадгүй бүр гараас нь ч барьсан байж мэдэх: “Нэрийнхээ ундаанаас санал болгооч” гэлээ.

“Манайд микро хөөстэй капучино байна.”

“Сайн байна.” Би тэр нь юу болохыг огт мэдэхгүй учраас, цааш нь: “Өөр юу байна?” гэж асуулаа.

“Миний дуртай лавандагийн латте байна.”

Би ч түүний үгийг сонссоноо хүлээн зөвшөөрөөд, “Окэй” гэж толгой дохиод, оволзож байгаа баяр хөөрөө дарж ядан: “Өөр юу

байна?” гэлээ.

“Манайд бас инжир, зөгийн балын латте байна.”

“Ай даа!” гэж ирээд л би бараг түүнийг тас тэвэрчихмээр санагдсан боловч, биеэ хянаад: “Гурвууланг нь авъя! Капучиногоосоо эхлэж авъя. Гэхдээ мөнгийг нь одоо төлье” гэлээ. Би нэрээ хэлээд, төлбөрөө төлөөд, лангууны булан руу очиж суув.

Гэтэл дараа нь үнэхээр санаанд оромгүй зүйл болох нь тэр. Тэр хүн миний ард зогсоод байсныг би анзаараагүй юу эсвэл ундаандаа болоод тэр хүнийг анзаараагүй юу мэдэхгүй, ямар ч байсан араас: “Та эндхийнх үү?” гэсэн эрэгтэй хүний дуу сонсдов.

Эргээд харгал эрдэм номын дүр төрхтэй, цагаан сахал, үстэй, царайлаг жентельмэн зогсож байлаа. “Үгүй ээ, би энэ кофе шопын талаар сонсоод” хэмээн би бувтнав. Учир нь би кофеинаасаа өмнө хүнтэй ярилцах дургүй л дээ.

Гэтэл нөгөө хүн: “Би саяхан ийшээ нүүж ирсэн юм” гэв.

Тэгээд би нөгөө микро хөөстэй кофеогоо гартаа бариад, шанцай, цэвэр чихэр авахаар хөдлөлөө.

Нөгөө хүн надаас: “Та хаанаас ирсэн бэ?” гэж асуув.

Би ундаагаа хутгангаа: “Би Колорадогаас ирсэн” хэмээн хариулаад, түүний хариуг хүлээлээ.

“Ямар ажлаар ирэв?”

“Би олон мянган эмэгтэйчүүдийн конференц дээр илтгэл тавьж яваа юм.” Тэгээд би тэднийг энэ үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгосныг нь сайшаан ярьлаа.

“Бид яагаад энэ тухай бичдэггүй билээ?”

Би түүний хэлсэн үгийг ойлгоогүй учраас, өөдөөс нь “Мэдэхгүй. Ингэхэд та хэн билээ?” гэж асуув.

“Би эндхийн орон нутгийн сонины шинэ эрхлэгч байна. Та надтай жаахан ярилцахгүй юм уу? Суугаач.”

Тэгэнгүүт би жаахан тэвдэж эхлэв. Би чинь судсаар маань кофеин гүйгээгүй байхад, хүнтэй дуугардаггүй хүн. Гэтэл бүр ярилцлага өгөх гэж байдаг? Тэгээд гүн амьсгаа авлаа. Тэр хүний нүд нь тун эелдэг зөөлөн байсан учраас, би ч суув. Тэгээд тэр хүн намайг асуултаар бөмбөгдөх үед би кофеогоо очиж суулаа.

◆

Бэлэг
авьяасаа
хэзээ ч бүү
үл тоо.

“Тэгэхээр, ямар төрлийн конференц билээ? Хаана болж байгаа билээ?”

Тэрбээр миний үгээс ямар нэгэн зүйл хайх нь нэг л онцгой сэтгэгдэл төрүүлж байлаа.

Би түүнд энэ бол миний бичсэн номууд (*Lioness Arising*) дээр тулгуурласан конференц бөгөөд намайг үйлчлүүлэхээр урьсан тухай хэлэв. Тэгээд чуулганы нарийн хаяг байршлыг нь энэ тухай сайн мэддэг бариста бүсгүйгээс лавлалаа.

“Та газар доорх байгууламжийн малтлагын талаарх нийтлэлийг уншсан уу?”

Би түүнд уншаагүй гэдгээ батлан хэллээ.

Тэгтэл шинэ найз маань Ромд хийгдсэн малтлагаар эртний чуулганы дүр зургийг дүрслэн харуулсан усан будгийн уран зураг олдсон тухай ярив. Би ч кофегоо оочоод л, сонсоод л байлаа. Тэр зураг дээр эрчүүдтэй хамт мөр зэрэгцэн үйлчилж явсан Присхилла зэрэг эмэгтэйчүүдийг тодорхой дүрслэн харуулсан байжээ.²



Найз минь,
Бурхан чиний
бүрэн төгс
амилалд
саад бологч
бул чулууг
зайлуулах
ажлаа
хийсээр
байна.

Би ч толгой дохиод л, тэр эрхмийн ярианд автаад л сууж байлаа. Тэгтэл гэнэт нэг зүйл болов. Тэр хүн арагшаа налаад, латте дээгүүрээ эргэлдэж байгаа намайг ажиглаж байснаа, хуруугаараа заагаад: “Та бол тэр эмэгтэйчүүдийн нэг!” гэж тунхагласан юм.

Түүний үг миний нойрмог цээжийг улаа бутартал нэвт харван, гүний гүнд маань тусаад, тэндээсээ эд эс бүрт маань цангинав. Би сэв сэрүүн болчихов. Тэр хүн надад хэрхэн нөлөөлснөө өөрөө мэдсэн эсэхийг мэдэхгүй. Тэгээд би юу хийж байгаагаа ухаарч ч амжаагүй байтал, бид хаягаа солилцож, тэр хүн надад тус нийтлэлийг илгээж байв.

Тэгээд тэрбээр: “Би өнөөдөр орой энд байж чадахгүй. Гэхдээ би маргааш өглөө гэхэд ирчихнэ. Бас би танай үйл ажиллагааг сурвалжлуулахаар хүнээ илгээнэ” гэж хэлсэн юм.

Дараа нь би латтегаа аваад, буцаад суулаа. Би түүнийг амьдрал,

гэр бүлийнхээ талаар жаахан жаахан ярихыг нь сонсоод, би ч бас өөрийнхөө амьдралаас жаахан жаахан хуваалцаж суутал, нэг мэдсэн миний конференцдээ бэлтгэхээр зочид буудалдаа эргэж очих цаг болсон байлаа. Тэгээд буцах замдаа би “Сая юу болоод өнгөрөв өө?” хэмээн эргэцүүлж явав.

Хожим нь тэр хүний яриа нь зөвхөн надад хандсан үг бус, харин амьдралын газар доорх төөрдөг байгууламжид булагдсан эмэгтэйчүүдэд хандсан Бурханы үг болохыг ухаарсан юм.

Найз минь, Бурхан чиний бүрэн төгс амилалд саад бологч бул чулууг зайлуулах ажлаа хийсээр байна. Бурхан чулуу, шороог цэвэрлэсээр байна. Чиний алдагдаад алга болсон гэж бодож байсан тэр бүх эвдэрхий, хагархайг цуглуулан эвлүүлж байна. Бурхан тэдгээрийг чинь чиний амьдралын мозаик болгохоор ашигласныг тэргүүнээ өргөөд хар даа, хөөрхөн минь. Чи газар ширтэн, өөрийнхөө бий болгосон хогон овоог харсаар яваад, амьдралын чинь дээгүүр намирч байгаа “Чи бол тэр эмэгтэйчүүдийн нэг!” гэсэн туг далбааг харахгүй байна.

“Тэгвэл та нар Намайг Хэнтэй адилтгаж, хэнтэй харьцуулах вэ?” гэж Ариун Нэгэн айлдаж байна. Хараагаа өндөрт өргөн Тэдгээрийг хэн бүтээснийг харагтун. Түг түмдийг нь тоо ёсоор авчирч Бүгдийг нэрээр дууддаг нь Тэр юм. *Агуу их хүч, сүр жавхлангийнх нь улмаас Тэдгээрээс нэг нь ч алдагдаагүй.* (Исаиа 40:25-26)

Юу ч алдагдаагүй, юу ч талаар болоогүй, ширхэг ч хэлтэрхий алга болоогүй. Хэдэн төө зузаан тоос, шороо, чулуун бүрхүүлийн дор түүхийн маань цоо шинэ нэгэн хуудас байж л байгаа.

Би тэр нийтлэлийг өөрөө уншихдаа, хоёр гараа дэлгэн урьсан, нөмрөгтэй эмэгтэй хүний мозаик зургийг үзэв.

Булш ухагч нарыг таг март. Чамайг амьдаар чинь булшлах гэж шороо, чулуу, нуранги овоолдог хүмүүсийн талаарх бодлоо тас эсэргүүц. Тэднээс нүүр буруулаад: “Дайсан миний юуг оршуулахыг хүсч байна?” гэж асуу.

Үр чинь найдвар, мөрөөдөл, залбирал, амлалт, тэр бүү хэл нулимс шиг хэлбэртэй байж болно. Тэр үр сүнсний чинь гадаа

АДАМАНТ

байж болох боловч, Бурханы бодлоос гадуур гэж хэзээ ч бүү бодоорой.

... тарьдаг чинь үхэхгүй аваас амилахгүй (1Коринт 15:36).
Зовлон бэрхшээл бэлтгэл болдог.

Христийн үзэсгэлэнт сүйт бүсгүйн түүх олон талаараа завхруулагдсан байдаг шиг, Бурханы охидын түүх газар сайгүй, янз янзын байдлаар оршуулагдсан байдаг. Тийм боловч хайрлагдсан нэгэн минь, нэг л өдөр далдлагдсан бүхэн ил болно гэдгийг бүү мартаарай. Малтлагаар газар доорх байгууламжийг илрүүлсэн шиг, сүйт бүсгүйн түүх дахин гэрэлд гарах л болно.

Бид бол тэр эмэгтэйчүүд.

Бид бол Түүний сүйт бүсгүй.

Түүний алмаз.

Түүний үнэлэшгүй эрдэнэс.

Тэр бол бидний Адамант, Зангуу, Үнэн.

Тэр бол хүн нэг бүрийг цөлөөр дагаад явдаг Хад.

Амьдралаа өргөөд, чамайг гаргаж авсан тэр Чулууг хүндэтгэ. Чамайг хайрын итгэмжтэй чанараараа бишрүүлэхийг хүсдэг, хөдлөшгүй, ялагдашгүй, нэвтлэшгүй, адамант - бат бэх Булангийн чулууныхаа гайхамшиг дотор амьдар. Санал бодлын энэ ертөнцөд Түүнд үнэнч бай. Учир нь чи бол өнө мөнхийн ертөнцийн тэмдэгтэй хүн билээ.

НЭГДҮГЭЭР ХАВСРАЛТ

ЗУРГАДУГААР БҮЛЭГТ ЗОРИУЛСАН НЭМЭЛТ БИЧЭЭС

Өөртөө зориулан шүтээн бас дээр тэнгэр дэх, доор газар дахь, газрын доор усан дахь ямар нэг дүрсийг бүү хий. Тэдэнд чи бүү мөргө, бүү үйлчил. Учир нь чиний Бурхан ЭЗЭН хартай Бурхан бөгөөд Намайг үзэн ядагчдын хувьд эцгүүдийнх нь хилэнцийн шийтгэлийг гурав, дөрөв дэх үеийн хүүхдүүдэд нь хүртэл Би буулгадаг. Харин Намайг хайрлаж, Миний тушаалыг сахигчдад мянган үед нь хүртэл хайр энэрэлээ үзүүлдэг. (Гэтлэл 20:4-6)

Миний зарлигуудыг та нар хэрэгсэлгүй, сэтгэл чинь шийдвэрүүдийг минь жигшсэнээр та нар Миний бүх тушаалыг биелүүлэлгүй, гэрээг минь зөрчих аваас Би та нарт үүнийг үйлдэх болно. Нүд ширгээж, сэтгэл туйлдуулах сүрьеэ өвчин, халуурал, гэнэтийн аймшгийг Би та нарт оноох болно. Дайснууд чинь бүгдийг идэж дуусгах

тул та нар үрийг дэмий суулгана. Би нүүрээ та нарын эсрэг хандуулах бөгөөд та нар дайсныхаа өмнө цохигдон унана. Үзэн ядагч өстнүүд чинь та нарыг захирах бөгөөд хэн ч мөшгөөгүй байхад та нар зугтах болнов.
(Леви 26:15-17)

Үзмэрч Хананигийн хүү Иехү түүнийг угтахаар гарч ирээд, Иехошафат хаанд —Та гэм буруутнуудад туслан ЭЗЭНийг үзэн ядагчдыг хайрлана гэж үү? Үүнээс чинь болоод ЭЗЭНээс ирэх уур хилэн өөр дээр чинь буув. Гэвч та энэ газраас Ашеротыг зайлуулан, зүрх сэтгэлээ Бурханыг эрэлхийлэхэд хандуулсан сайн зүйлс бас бий гэв.
(2Шастир 19:2-3)

Гэм бурууг Та үл таалдаг Бурхан тул
Муу муухай нь Тантай хамт эс оршино.
Сагсуурагчид мэлмийн тань өмнө үл зогсоно.
Ёс бусыг үйлдэгчдийг Та үзэн яддаг.
Та худал яригчдыг устгадаг.
Цус урсгагч, залилж мэхлэгчдийг ЭЗЭН жигшдэг.
Харин би Таны бялхам хайр энэрлээр Таны өргөөнд би орж,
Таны ариун сүмд Таныг мэхийн хүндэтгэнэ.
(Дуулал 5:4-7)

Алдар нь Таны авралаар дамжаад агуу их юм.
Та түүний дээр алдар, Сүр хүчийг өмсгөсөн.
Учир нь Та түүнийг Мөнхөд ерөөлтэй болгодог.
Та түүнийг Өөрийнхөө оршихуйд
Баяр баясгалантай болгодог.
Учир нь хаан ЭЗЭНд түшдэг бөгөөд
Хамгийн Дээд Нэгэний
Хайр энэрлээр тэр ганхахгүй.
Чиний гар бүх дайснаа олно.
Чиний баруун гар
Чамайг үзэн ядагчдыг олж илрүүлэх болно.
(Дуулал 21:5-8)

Бишрэлтнүүдийнхээ амийг хамгаалдаг.
ЭЗЭНийг хайрлагч та нар, буруу мууг үзэн яд.
Тэр тэднийг гэм буруутны гараас авардаг.
Зөвт хүнд гэрэл,
Чигч шударга зүрхтэй хүнд баяр хөөр таригдсан.
Зөв шударга та нар, ЭЗЭНд баярлаж,
Түүний ариун дурсамжийг талархагтун.
(Дуулал 97:10-12)

Үгийг тань сахин биелүүлэхийн тулд
Бүх буруу муу замаас би хөлөө татсан.
Та Өөрөө надад заасан учир
Таны тогтоолуудаас би гажаагүй.
Таны үг амтлахад минь ямар чихэрлэг вэ!
Миний аманд зөгийн балаас ч илүү чихэрлэг!
Таны тушаалуудаас би ухаарлыг авдаг.
Тиймээс би худал хуурмаг явдал бүрийг үзэн яддаг билээ.
(Дуулал 119:101-104)

Иймээс би Таны тушаалуудад
Алтнаас ч, шижир алтнаас ч илүүгээр хайртай юм.
Тиймээс би аливаа тогтоолуудыг зөвд тооцдог бөгөөд
Би аливаа худал хуурмаг явдлыг үзэн яддаг юм.
(Дуулал 119:127-128)

Их олз олсон хүн шиг
Би Таны үгэнд баясдаг.
Би худал хуурмагийг үзэн ядаж жигшдэг,
Харин хуулийг тань би хайрладаг.
(Дуулал 119:162-163)

Учир нь тэд Таны эсрэг баширыг ярьж
Таны эсрэг нүглийн учир өөрсдийгөө өргөмжилдөг.
Аяа ЭЗЭН, Таныг үзэн ядагчдыг би үзэн яддаггүй гэж үү?
Таны эсрэг босогчдыг би жигшдэггүй гэж үү?

Би туйлын үзэн ядалтаар тэднийг үзэн яддаг.
Тэд дайснууд минь болов. (Дуулал 139:20-22)

Гэмгүй нэгнийг зөвт байдал нь өмгөөлөх.
Гэм буруу нь нүгэлтнийг хөмрүүлэх.
(Сургаалт үгс 13:6)

Надтай хамт байдаггүй нь Миний эсрэг байна. Надтай хамт
хураалцдаггүй нь тараагч нэгэн мөн. (Матай 12:30)

Харин сонсогчдод Би хэлж байна. Дайснуудаа хайрла, та
нарыг үзэн ядагчдад сайныг үйлд. (Лук 6:27)

Есүстэй хамт үй олон хүн явж байв. Тэр эргэн тэдэнд —
Хэрэв хэн нэг нь Над дээр ирж, өөрийн эцэг эх, эхнэр хүүхэд,
ах эгч дүүсээ төдийгүй өөрийн амийг хүртэл үл ойшоохгүй
бол тэр Миний шавь байж чадахгүй. (Лук 14:25-26)

Иймээс та нарын хэн нь ч байгаа бүхнээсээ эс татгалзваас
Миний шавь байж чадахгүй. (Лук 14:33)

Мөнгөнд дурлагч фарисайчууд энэ бүхнийг сонсоод Түүгээр
доог тохуу хийж байлаа. Тэр тэдэнд —Та нар хүмүүсийн
өмнө өөрсдийгөө зөвтгөгчид юм. Гэвч Бурхан та нарын
зүрхийг мэднэ. Хүмүүсийн эрхэмлэдэг зүйлс нь Бурханы
өмнө жигшмээр юмс байдаг. Хууль ба эш үзүүлэгчид нь
Иоханыг хүртэл л агаад тэр цагаас хойш Бурханы хаанчлалын
сайнмэдээ дэлгэрч, хүн бүр тийшээ орохоор хүчлэн байна.
Гэвч хуулиас ганц зураас алга болохоос тэнгэр газар өнгөрөн
одох нь илүү хялбар билээ. (Лук 16:14-17)

Тэгэхэд нь Есүс тэдэнд —Миний цаг хараахан болоогүй.
Харин та нарын цаг үргэлж бэлэн байдаг. Ертөнц та нарыг
үзэн ядаж чадахгүй. Харин ертөнцийн үйлс муу муухай
гэдгийг Би гэрчилдэг тул Намайг үзэн яддаг. (Иохан 7:6-7)

ХОЁРДУГААР ХАВСРАЛТ

СУРГААЛТ ҮГС,
НОМЛОГЧИЙН ҮГС
НОМЫН СУРГАМЖ

Үглээд байлгүй, сурамгай бай

Мэргэн зүрх тушаалыг хүлээж авна.
Чалчаа мунхаг сүйрнэ. (Сургаалт үгс 10:8)

**Үг нь амийг сэрээж, сэргээх юмуу далд оруулж
чадна**

Зөвтийн ам нь амийн ундарга. Буруутын аманд хүчирхийлэл
нууцлагдах. (Сургаалт үгс 10:11)

Ам хэлгүй, арилж одох хөөрхийсийн төлөө амаа нээ.
(Сургаалт үгс 31:8)

Амаа нээж, зөв шударгаар шүү Ядуус ба зүдрэгсдийг шүүн
өмгөөл. (Сургаалт үгс 31:9)

Мэргэн ухаанаар амаа нээж, Энэрлийн сургаалыг хэл нь сургамжилна. (Сургаалт үгс 31:26)

Үзэн ядалт тогоог дэвэргэдэг бол, хайр нь тогоог тагладаг

Үзэн ядалт эвдрэлцлийг төрүүлэх. Хайр бүх гэмт үйлдлийг далдлах. (Сургаалт үгс 10:12)

Басамжлагчид хотыг ноцоох Мэргэд уур хилэнг зайлуулах. (Сургаалт үгс 29:8)

Газар дээрх ядуусыг, Хүмүүсийн дундах үгээгүйчүүдийг залгих Илд мэт шүдтэй, хутга шиг араатай хүмүүс ч бас бий. (Сургаалт үгс 30:14)

Тэнэг хүн дарвагараасаа болж асуудалд орно

Ухаарагчийн амнаас мэргэн ухаан олдоно. Ухвар мөчдийн нуруунд саваа зориулагдана. (Сургаалт үгс 10:13)

Мэргэд мэдлэгийг хуримтлуулна. Мунхгийн ам сүйрэлд ойртоно. (Сургаалт үгс 10:14)

Худалч уруул үзэн ядалтаа нууцлах. Мулгуу хүн базаахгүй үг тараах. (Сургаалт үгс 10:18)

Ухаант мэргэдийн амнаас гарах үг нь нигүүлсэл, Мунхгийн уруул харин өөрийгөө залгих аж. (Номлогчийн үгс 10:12)

Түүний ярианы эхлэл нь тэнэг байдаг бол төгсгөл нь балмад солиорол аж. (Номлогчийн үгс 10:13)

Мунхаг нэгэн олон үгтэй. Юу болохыг хүн эс мэднэ. Түүний араас юу ирэхийг хэн түүнд хэлж чадах билээ?
(Номлогчийн үгс 10:14)

Бүү зөвшөөр

Мунхгууд уураа даруй үзүүлэх.
Хэрсүү нь басамжлалыг үл хэрэгсэх.
Үнэнийг яригч нь зөвийг.
Хуурамч гэрчлэгч заль мэхийг.
Бодлогогүй яриа нь илдээр дүрэх мэт.
Харин мэргэн хүний хэл илааршлыг авчрах.
(Сургаалт үгс 12:16-18)

Үнэн ямагт худлыг давна

Бодлогогүй яриа нь илдээр дүрэх мэт.
Харин мэргэн хүний хэл илааршлыг авчрах.
Үнэнч уруул үүрдийг авах.
Худалч хэл хормыг л давах.
(Сургаалт үгс 12:18-19)

Элч буруут аваас гай зовлон.
Элч нь итгэлт болбоос илааршил.
(Сургаалт үгс 13:17)

Гэнэн хүн үг бүхэнд итгэх.
Хэрсүү хүн алхмаа ухаарах.
Мэргэн нь эмээж, ёрын муугаас зайлсхийх.
Мунхаг нь догширч адгах.
Цочмог ууртай нь мулгууг үйлдэх.
Баширыг сэдэгч үзэн ядагдах.
(Сургаалт үгс 14:15-17)

Эелдэг хариулт уурыг зайлуулах.
Эвгүй үгс хилэнг хөдөлгөх.
(Сургаалт үгс 15:1)

Мэргэдийн хэл мэдлэг тараах.
Мулгуучуудын ам мунхаглал оргилуулах.
(Сургаалт үгс 15:2)

Амарлингуй хэл амийн мод.
Хазааргүй хэл сүнсний бусниулал.
(Сургаалт үгс 15:4)

Дээдсийн үг хэллэг мунхагт эс тохирох.
Худал хэлэх нь захирагчид бүр ч үл нийцэх.
(Сургаалт үгс 17:7)

Алдаат үйлдлийг уучилваас хайрыг татах.
Аливаа хэргийг эргэн сөхвөөс андаа алдах.
(Сургаалт үгс 17:9)

Дуугүй байваас мунхаг ч мэргэнд тооцогдох.
Амаа хамхиваас тэрээр ухаалаг мэт харагдах.
(Сургаалт үгс 17:28)

Хүмүүний амны үгс гүн ус мэт.
Мэргэн ухааны ундарга урсах горхин лугаа адил.
(Сургаалт үгс 18:4)

Мулгуу нэгний уруул хэрүүл авчрах.
Ам нь зодуур дуудах.
Мулгуу нэгний ам өөрийг нь сүйтгэх.
Уруул нь сэтгэлийг нь урхидах.
(Сургаалт үгс 18:6-7)

Хов яригчийн үгс амтат идээ мэт
Ходоодны мухарт ч хүрнэ.
(Сургаалт үгс 18:8)

Сонсохоосоо өмнө хариу хэлэх нь мулгуу агаад ичгүүртэй.
(Сургаалт үгс 18:13)

Эвдрэлцлээс зайлсхийх нь хүндэтгэл.
Хэрүүлд ухасхийх нь мунхаглал.
(Сургаалт үгс 20:3)

Цуу тарааж явагч нууцыг задруулах тул
Хагархай амтантай бүү орооцолд.
(Сургаалт үгс 20:19)

Аав ээжийгээ зүхэгчийн дэнлүү
Тас харанхуйд бөхөх. (Сургаалт үгс 20:20)

“Ёрын муугийн хариуг өгнө дөө, би” гэж бүү ярь.
ЭЗЭНийг хүлээ, Тэр чамд тусална.
(Сургаалт үгс 20:22)

Ам хэлээ захирдаг хүн
Амь юугаа зовлон шаналангаас сахих.
(Сургаалт үгс 21:23)

Басамжлагчийг холдуулваас хэрүүл зайлах.
Зарга болон зүхэл ч зогсоно.
(Сургаалт үгс 22:10)

“Хийснийг нь би ч мөн түүнд хийх болно,
Үйлийнх нь дагуу хариу хүртээнэ дээ” гэж бүү хэл.
(Сургаалт үгс 24:29)

Сонсогчоо мэд

Мунхгийн чихэнд юм бүү ярь
Мэргэн үгсийг чинь тэрээр басамжилна.
(Сургаалт үгс 23:9)

Тэнэг хүнд анхаарал, цагаа бүү зориул

Мунхаглалаар мунхагт бүү хариул

Адил болуузай.

Түүнд мунхаглалынх нь хариултыг өг

Нүдэндээ тэд мэргэн болуузай.

(Сургаалт үгс 26:4-5)

Мэргэн хүн мунхаг хүнтэй заргалдахад

Ухаарлыг бус хилэгнэл элэглэл хураах.

(Сургаалт үгс 29:9)

Өөрт хүртээлгүй үйл явдалд бүү оролц

Бусдын хэрүүлд хөндлөнгөөс оролцох нь

Хажуугаар өнгөрөгч нохойг чихнээс нь зулгаахтай адил.

(Сургаалт үгс 26:17)

Хов жив чамайг шатааж, дотрыг чинь муутгана

Түлээгүйд гал унтарна

Хов зөөгчгүйд эвдрэлцэл намжина.

Нүүрс цогшиж

Мод гал болдог лугаа адил

Хэрүүлч хүн хэрүүл өдөөх.

Дүрэлзэх уруул, ёрын муу зүрх болбоос

Мөнгөний хольцоор өнгөлсөн шавар сав суулга мэт.

(Сургаалт үгс 26:20-23)

Худалч хэл хэлмэгдэгчээ хүртэл үзэн ядах.

Ховч ам сүйрлийг бэлдэх (Сургаалт үгс 26:28)

Бүү гайхуул

Чамайг магтагч нь

Ам чинь бус өөр хүн байг,

Уруул чинь бус харь хүн байг.
(Сургаалт үгс 27:2)

Хайлуур нь мөнгөнд, зуух нь алтанд
Хүний зүрхэнд магтаал шалгуур юм.
(Сургаалт үгс 27:21)

Мунхгийн уур тэсрэмтгий
Мэргэн нь түүнээ тэвчимтгий.
(Сургаалт үгс 29:11)

Өөрийгөө өргөмжилж мунхагласан эсвэл ёр мууг сэдсэн бол
Гараа аман дээрээ тавь. (Сургаалт үгс 30:32)

НОМЫН ЗҮҮЛТ

Бүлэг 1 Адамонт (Бат бэх)

1. N. T. Wright, *Matthew for Everyone, Part 2: Chapters 16–28* (London: Society for Promoting Christian Knowledge, 2004), 80.

2. Anthony C. Thiselton, *The First Epistle to the Corinthians: A Commentary on the Greek Text*, New International Greek Testament Commentary (Grand Rapids: Eerdmans, 2000).

3. Matthew G. Easton, *Easton's Bible Dictionary*, 1893.

4. John Muir, *My First Summer in the Sierra* (New York: Houghton Mifflin, 1911), 20.

Бүлэг 2 Дотно Адамонт (Дэндүү дотно)

1. Babylonian Talmud, Chagigah 15.1: And the Spirit of God **hovered [merachefet: from the Hebrew root “rachaf” (in the feminine form)]** over the face of the water—like a dove which hovers over **her young** without touching.

2. C. S. Lewis, *Prince Caspian* (New York: HarperCollins 1951), 233.

Бүлэг 4 Хайрын Адамонт (Хайраар бат бэх)

1. 2 Corinthians, The Passion Translation (Racine, WI: BroadStreet Publishing, 2017).

2. Composition/Song Title: Reckless Love. Written by Cory Asbury, Caleb Culver, and Ran Jackson © 2017 Bethel Music Publishing (ASCAP) /Watershed Publishing Group (ASCAP) (adm. by Watershed Music Group)/ Richmond Park Publishing (BMI). All Rights Reserved. Used by Permission.

Бүлэг 5 Бие биеэ хайрлахдаа адамант (Бие биеэ хайрласан шиг хайрлах)

1. C. S. Lewis, *Mere Christianity* (New York: HarperCollins, 1952), 132.

Бүлэг 6 Үзэн ядалтад Адамант (Үзсэн ядсан шиг үзэн ядах)

1. Lewis, *Mere Christianity*, 112.

2. Gene Veith, “Sex as Sacrament, Abortion as Religious Ritual,” *Cranach: The Blog of Veith*, June 24, 2016, <http://www.patheos.com/blogs/geneveith/2016/06/sex-as-sacrament-abortion-as-religious-ritual/>.

3. Charles H. Spurgeon, *The Complete Works of C. H. Spurgeon*, Vol. 44: Sermons 2459–2602 (Delmarva Publications, 2013).

4. “Study Finds That 1 Out of 3 Women Watch Porn at Least Once a Week,” *New York Times*, October 22, 2015.

5. Alexis Kleinman, “Porn Sites Get More Visitors Each Month Than Netflix, Amazon, and Twitter Combined,” *Huffington Post*, May 3, 2013, http://www.huffingtonpost.com/2013/05/03/internet-porn-stats_n_3187682.html.

6. “How Many People Are Watching Porn Right Now? (Hint: It’s A Lot.)” *Fight the New Drug*, September 11, 2017, <http://fightthenewdrug.org/by-the-numbers-see-how-many-people-are-watching-porn-today/>.

7. Charles H. Spurgeon, *The Complete Works of C. H. Spurgeon*, Vol. 60: *Sermons 3387–3349* (Delmarva Publications, 2013).

8. <https://www.leadershipresources.org/blog/the-best-charles-spurgeon-quotes/>.

9. “Charles H. Spurgeon on Discernment” *Apologetics 315*, www.apologetics315.com, Feb 3, 2013.

Бүлэг 8 Үгээр Адамант байх (Үгээр бат бэх байх)

1. Shaena Montanari, “Plastic Garbage Patch Bigger than Mexico Found in Pacific,” *National Geographic*, July 25, 2017, <http://news.nationalgeographic.com/2017/07/ocean-plastic-patch-south-pacific-spd>.

2. Leonardo da Vinci, *Notebooks* (Oxford: Oxford University Press, 1952), 23.

Бүлэг 9 Адамант өөрчлөлт (Бат бэх өөрчлөлт)

1. Preston Sprinkle, *People to Be Loved* (Grand Rapids: Zondervan, 2015), 88.
2. C. S. Lewis, *Surprised by Joy: The Shape of My Early Life* (Orlando: Harcourt Brace & Company, 1955), 221.
3. Tom Carter, compiler. *Spurgeon at His Best: Over 2200 Striking Quotations from the World's Most Exhaustive and Widely Read Sermon Series* (Grand Rapids: Baker Books, 1988), 160.

Бүлэг 10 Ариун байдлаар Адамант байх (Ариун байдлаар бат бэх байх)

1. Sinclair Ferguson, *A Heart for God* (Carlisle, PA: Banner of Truth, 1987), 82.
2. N. T. Wright, *Paul for Everyone: Galatians and Thessalonians* (London: Society for Promoting Christian Knowledge, 2004), 117–18.
3. Carter, compiler. *Spurgeon at His Best*, 100.
4. Kevin M. Watson, “Forgiveness and (Not Or) Holiness,” *Vital Piety* (blog), August 26, 2013, <https://vitalpiety.com/2013/08/26/forgiveness-and-not-or-holiness/>.
5. N. T. Wright, *Paul for Everyone: The Prison Letters: Ephesians, Philippians, Colossians, and Philemon* (London: Society for Promoting Christian Knowledge, 2004), 53.
6. Wright, *Paul for Everyone: Galatians and Thessalonians*, 118–19.

Бүлэг 11 Би бол Адамант (Би бол бат бэх)

1. Charles H. Spurgeon, *Treasury of David Vol. 3* (New York: Funk & Wagnalls, 1886), 278.
2. Ellie Zolfagharifard, “Vatican Unveils Frescoes Hinting That Women Held Power in the Early Church,” *Daily Mail*, November 20, 2013.

Лиза Бивэр бол гуч гаруй жил нас, насны эмэгтэйчүүдэд өөрийгөө болоод зорилгоо олоход нь туслаж, тэднийг бэхжүүлж яваа хүн. Тэрбээр Нью-Йорк Таймсын шилдэг зохиолч, олон улсад танигдсан номлогч билээ. Түүний “Fight Like a Girl”, “Lioness Arising”, “Сэлэмтэй охид” “Өрсөлдөгчгүй” зэрэг ном нь даян дэлхийн сая сая хүний гарт хүрээд байна. Лиза нөхөр Жонныхоо хамтаар байгаа газраа өөрчилж чаддаг Христийн няцашгүй дагалдагч нарыг сурган боловсруулах зорилготой “Мессенжер Интернэйшнэл” байгууллагыг үндэслэн байгуулсан болно.

ГЭРЛЭЛТИЙН ТҮҮХ

Гэрлэлтээ авар



ЭРТ УРЬДЫН ЦАГТ ... Гэрлэлт бол үүрд мөнхийн зүйл. Энэ нь нэг эрэгтэй, нэг эмэгтэйг холбож зангидаг гэрээ бүхий харилцаа юм. Энэ холбоос тэднийг анх бүтээгдсэн зорилгоор нь хөглөж, хүчирхэгжүүлнэ. Тэд тусдаа биш, хамтдаа байхдаа л хүчтэй. Харин энэ бүхний эхлэл нь хурим юм. Хурим нь амар сайхандаа жаргахын төлөө амьдралын босгыг давж буй нандин үйл явдал билээ. Энэ амьдралын төлөөх сонголт бүр, үйлс бүр чухал. Зүрхээрээ нийлж, гараараа хөтлөлцсөн нөхөр, эхнэр хоёр тааж мэдэх аргагүй ирээдүйг чиглэн Бүтээгчийн хайраар амьдралаа босгоно.

Гэхдээ бид энэ хайрын түүхээс хагацжээ. Тэгвэл “Гэрлэлтийн түүх” номоороо Жон, Лиза хоёр гэрлэлтэд хандсан Бурханы анхны төлөвлөгөөг дэлгэж байна. Та гэрлэсэн байна уу, ганц бие байна уу, сүй тавьсан байна уу – Бурханы их хайрын түүхийн нэгээхэн хэсэг билээ.

ӨРСӨЛДӨГЧГҮЙ

Эргэлзээ, харьцуулалтын энэ эрин цагт өөрийгөө болон зорилгоо олж мэдэх



Бид бусдыг ямагт өрсөлдөгчөө хэмээн үзэж, өрсөлдөөн харьцуулалтаар өөрийгөө боомилдог нь цаанаа шалтгаантай юм. Үүний цаана биднийг өөр хоорондоо хэвэнд цутгагдчихсан мэт ялгарашгүй байлгахаар оюун санаа, хүсэл, сэтгэл мэдрэмж рүү маань байнга халдан довтлож байдаг дайсан бий. Бид энэ тойрогт орохдоо дотно харилцаа холбооноосоо тасарч, өөрийгөө хэн болоход эргэлзэж, зорилгоо гээдэг.

Өрсөлдөөнийг өөртөө ашигтайгаар эргүүлж, өөрийнхөө шилдгийг гарга. Өөрийнхөө тухай ярианаас бүү зугт. Эмэгтэйчүүд таарахгүй, тэнцэхгүй, гэнэдүү, гэнэн гэдэг маргаанд хариу барь. Хүйсийн өрсөлдөөнийг шийдвэрлэж, эрчүүдтэй мөр зэрэгцэн ажиллахыг сур. Өрсөлдөгчгүй амьдрах цаг иржээ!



Мессенжер Интернэйшнэл нь Бурханы өөрчлөгч хүчийг хувь хүн, гэр бүл, чуулган, үндэстэнд ухааруулж, бодитоор харахад нь туслах зорилготой байгууллага болно.

Энэ ухаарал нь хүчирхэгжсэн амьдрал, өөрчлөгдсөн нийгэм, дэлхий дээрх шударга бус зүйлст хариу барих эрч хүчтэй үйлсийг дагуулдаг.

Cloud Library нь даян дэлхийн пастор, удирдагч нарт зориулагдсан, төрөлх хэлээрээ танилцаж болох онлайн дижитал сургалтын сан юм.

CloudLibrary.org хаягаар орж, Жон, Лиза Бивэрийн 90 гаруй хэл дээрх сургалтын материалтай танилцаарай!

Цахим ном, видео, аудио, сургаал, сонсдог ном, Библи, сонсдог жүжиг гэх мэт...



**CLOUD
LIBRARY**



Дэлгэрэнгүйг эндээс авна уу:

СЭЛЭМТЭЙ ОХИД

Загалмайгаа жинхэнэ баатар шиг үүрье



Бурханы Үг болох илдний тухай судлах нь илдийг сугалж хэрэглэхээс амархан бөгөөд таатай байдаг. Охид бид тэнгэрийг газартай холбох цаг болжээ. Дэлхий даяар эмэгтэйчүүд алив гадуурхал, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлийн бай болсоор байна.

Лиза Бивэр энэ номдоо эмэгтэйчүүдийн өнгөрснийг биш, харин ирээдүйг өгүүлжээ. Тиймд Бурханы дайчин охид оо, эр зоригтойгоор босоод, ялгах чадвараа ашиглан, уучилж, мэргэн байж сэлмээ эргүүлэн баатарлаг үйлсийг бүтээгээрэй.

Лизагийн бусад материалыг дараах хаягаас татаж авч болно:

www.CloudLibrary.org

Түүнчлэн Youtube, Youku тэргүүтэй олон нийтийн сүлжээний бүх хэрэгсэл дээр бий.

“Юутай чухал, жинтэй үг вэ! Лиза Бивэр хэзээд үнэний төлөө мятрашгүй зогсдог.”

- Пэйшн Конференцийн үндэслэн байгуулагч Луи, Шелли Гиглио

ҮНЭН ГЭЖ ЮУ ВЭ?

Энэ бол манай цаг үеийн тодорхойлогч асуулт. Хүн бүр өөрийн гэсэн санал бодолтой бөгөөд үнэнийг олох улам л хэцүү болсоор байна. Үүний шалтгаан нь магадгүй бид хэнийг хайх ёстой байтал, юуг хайгаад байгаагаас тэр биш үү?

ҮНЭНД НЭР БИЙ.

Үнэн нь цаг хугацаанаас урт, энэ эгшнээс илүү бодитой бөгөөд соёлын урсгалыг дагаж мяралздаг гол биш, харин хөдлөшгүй, ялагдашгүй, доргишгүй хад - бид бүгдийн болохыг хүсдэг булангийн чулуу юм.

Гүн гүнзгий теологийн шинжтэй атлаа сэтгэлд дэндүү дотно бичигдсэн “Адамант” ном нь олон санаагаар хуйларсан энэ ертөнцөд зангуу чинь болж, зүг чигээ алдсан энэ дэлхий дээр чамд тодорхой зүг чиг харуулах болно.

Лиза Бивэр бол гуч гаруй жил нас, насны эмэгтэйчүүдэд өөрийгөө болоод зорилгоо олоход нь туслаж, тэднийг бэхжүүлж яваа хүн. Тэрбээр *Нью-Йорк Таймсын* шилдэг зохиолч, олон улсад танигдсан номлогч билээ. Түүний *“Fight Like a Girl”*, *“Lioness Arising”*, *“Сэлэмтэй охид”* *“Өрсөлдөгчгүй”* зэрэг ном нь даян дэлхийн сая сая хүний гарт хүрээд байна. Лиза нөхөр Жонныхоо хамтаар байгаа газраа өөрчилж чаддаг Христийн няцашгүй дагалдагч нарыг сурган боловсруулах зорилготой *“Мессенжер Интернэйшнэл”* байгууллагыг үндэслэн байгуулсан болно.



MESSENGER
INTERNATIONAL
MessengerInternational.org

Энэ ном нь танд зориулсан зохиолчийн
бэлэг бөгөөд худалдахыг хориглоно.

Дэлгэрэнгүйг
эндээс

